

iea

Иймонн Батлер
Али Салмон өмнөх үгийг бичив.

ЧӨЛӨӨТ НИЙГМИЙН ҮНДЭС



ЧӨЛӨӨТ НИЙГМИЙН ҮНДЭС

Иймонн Батлер

ННА 87.22

ДАА 121

Б-336

Foundations of a Free Society

Eamonn Butler

Copyright © The Institute of Economic Affairs 2013

Чөлөөт Нийгмийн Үндэс

Иймонн Батлер

Энэ монгол орчуулгын анхны хэвлэл: 2024 он

Англи хэлнээс орчуулсан: Намхайнямын Жаргал

Редакторлосон: Догмидын Сосорбарам

Пүрэвжавын Цэнгүүн

Монгол орчуулгын эрхийг © 2024 Алтан Тариа ХХК эзэмшдэг.

Бүх эрхийг хуулиар хамгаалсан болно.

Эдийн Засгийн Хэрэг Явдлын Хүрээлэнгийн зөвшөөрлөөр орчуулан
хэвлэв.

Хавтасны гэрэлзургийг Н. Жаргалын цомгоос авав.

ISBN: 978-9919-0-2879-4

ИВЭЭН ТЭТГЭСЭН:



ГАРЧИГ

<i>Зохиогчийн тухай өгүүлбээс</i>	1
<i>Өмнөх үг</i>	2
<i>Талархал</i>	5
<i>Утгын хураангуй</i>	6
1 Оршил	10
Энэ номын зорилго	10
Энэ номыг хэрхэн эмхлэв	11
2 Эрх чөлөөний ёс суртахууны болон эдийн засгийн ач холбогдол	13
Чөлөөт нийгэм	13
Эрх чөлөө гэж юу гэсэн үг вэ?	13
Эрх чөлөө, төр засгийн үүрэг нөлөө	15
Эрх чөлөөг дэмждэг ёс суртахууны гаргалгаа нотолгоо	17
Эрх чөлөөний оюун санаа болон соёлын уг үндэс	18
Итгэлцэх, хамтран ажиллах соёл	19
Өөрийн-тусыг бодох, ёс журам	21
Санал нийлсэн ёс журмын дагуу хамтран ажиллах	23
Шударга ёс, хууль ёс	25
Эрх чөлөөг дэмждэг эдийн засгийн гаргалгаа нотолгоо	27
Амьжиргааны төвшин ихээр өсөв	27
Эрх чөлөө, буяны үйлс	29
Эрх чөлөө ялгаварлан гадуурхах явдалтай тэмцдэг	30
Чөлөөт хүмүүсийн бүтээлч байдал	32

Хөрөнгө бүтээх	33
Өмч болон хөгжил дэвшил	35
Хэний ч хүч хөдөлмөрөөр бус өөрөө эд баялаг бүтээх	37
Чөлөөт нийгэм бол тэжээврийн капитализм биш	38
Эрх чөлөөний мандан бадрал	40
3 Чөлөөт нийгмийн институтууд	41
Төргүй нийгэм	41
Эрх чөлөө, соёл	41
Хэнд төр засаг хэрэгтэй вэ?	42
Төр засгийн яагаад хязгаарлах ёстой вэ?	44
Төр засаг юу хийх ёстой вэ?	44
Яагаад ерөөсөө төр засагтай байх ёстой гэж?	46
Хувийн болон эдийн засгийн эрх чөлөөний талаархи үзэл бодлууд	47
Яагаад хувь хүний сонголт хэрэгтэй гэж?	50
Олон янз байдал хөгжил дэвшлийг тэтгэдэг	51
Интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдлын сүйрүүлэгч нөлөө	52
Хэдхэн хүний гаргадаг шийдвэр	55
Патерналист буюу халамжлагч шинжтэй гаргалгаа нотолгоо	56
Төр засгийг хязгаарлах арга зам	58
Ардчилал	58
Олон нийтийн шийдвэр гаргах үйл явц	59
Сонгогчийн өөрийн-тусыг бодох явдал	61
Улстөрчийн өөрийн-тусыг бодох явдал	62
Эвсэл, харилцан наймаалалцах	63
Ёс журам тогтоох	64
Үндсэн хуулийн гэрээ	64
Шалгуур-хангасан олонхи	67

Барьцаалагдсан олон нийт	67
4 Тэгш байдал, тэгш бус байдал	69
Чөлөөт нийгэм дэх тэгш байдал	69
Тэгш байдлын төрлүүд	70
Ёс суртахууны тэгш байдал	71
Хуулийн өмнөх тэгш байдал	72
Улстөрийн тэгш байдал	72
Боломжийн тэгш байдал	75
Позитив буюу эерэг ялгаварлан гадуурхалт	77
Негатив буюу сөрөг ялгаварлан гадуурхалт	79
Гарах үр дагаврын тэгш байдал	79
Орлогын тэгш бус байдлын талаархи тоо мэдээлэл	80
Орлогын эсвэл эд хөрөнгөний тэгш байдал уу?	81
Дахин-хуваарилалтын механик ажиллагаа	84
Тэгш байдал болон шударга ёс	85
Шударга ёсны хоёр утга	85
‘Нийгэмд оруулсан үнэ цэнэ’	86
Гавьяа зүтгэлд үндэслэсэн хуваарилалт	88
Хэрэгцээнд нь тулгуурласан хуваарилалт	89
Эгалитарианизмийн өөр нэг нэмэлт хор урхаг	90
Материаллаг хүсэл байсаар л байна	91
Баячуудын үүрэг нөлөө	91
Хөрөнгө устгах	93
Татварлах явдал, халамж	94
5 Чөлөөтэй аж ахуй эрхлэх, худалдаа арилжаа хийх	95
Чөлөөт зах зээлийн эдийн засаг	95
Хамтын ажиллагааг дэмждэг ёс журам	95
Сайн дурын солилцооны ашиг тус	96

Арилжаа худалдаа хэрхэн үнэ цэнэ бүтээдэг вэ	97
Ядуус хамгийн их тус хүртдэг	98
Хэрхэн баян болж томрох вэ	99
Үйлдвэрлэгчид хэрэглэгчид үйлчлэх ёстой	99
Эдийн засгийн хүч чадалд бүү найд	101
Ажил хэрэгч байдал	102
Ашиг болон аз сорих үйлдэл	104
Ажил хэрэг болон харилцаа холбоо	106
Зах зээл хэрхэн ажилладаг вэ	107
Үнийн мэдээлэл дамжуулах тогтолцоо	107
Зах зээл төгс байх боломжгүй	109
Төвлөрсөн төлөвлөлт хэрэгжих боломжгүй	110
Төрөөс-санхүүждэг аж ахуй	112
Олон-улсын худалдаа	114
Арилжаа худалдаа юу эсвэл протекционизм уу	114
Протекционизм бол хог	116
Бодит байдал дээрхи чөлөөт худалдаа	117
6 Хөгжил дэвшил, шударга ёс	119
Хувийн өмч	119
Өмч гэж юу вэ	119
Өмч ба хөгжил дэвшил	121
Өмч болон бусад эрх	122
Өмчийн ёс суртахууны ашиг тус	123
Нийгэм дэх хувь оролцоо	124
Шударга ёсны ёс журам	125
Шударга ёсыг эрж олох	125
Шударга ёс бол хууль, ёс суртахуун эсвэл тэгш байдал биш	127
Шударга ёсыг албадан хэрэгжүүлэх	128

Шударга ёсонд учрах аюул занал	129
Жам ёсны шударга ёс	130
Хууль ёс	133
Хууль ёсны утга учир	133
Хууль ёсыг хамгаалах	134
Шударга ёсыг хэрэгжүүлэх	136
Шударга ёс болон эдийн засгийн хөгжил цэцэглэлт	137
Хууль ёсонд учирдаг аюул занал	138
Хүмүүний эрх	139
Хүмүүний эрхийг тодорхойлох	139
Эрх чөлөө, эрх, үүрэг	141
7 Өөрөө-бүрэлддэг нийгэм	143
Тушаалаар тогтоодоггүй дэг журам	143
Ёс журам-удирддаг нийгэм	144
Сарниж тархсан мэдлэг, эрх мэдэл	146
Хүлцэхүй	147
Хүлцэхүйн утга учир	147
Хүлцэхүй, нийгмийн нэгэн жигд бус байдал, сонголт	149
Хүлцэхүйд учирдаг суурь аюул занал	150
Улстөрийн-хувьд зөв өнцөг	151
Хүлцэхүй, үнэний эрэл	152
Хориглох явдал	155
Олон нийтийн болон хувийн үйл хөдлөл	159
Алтруизмын зовлон бэрхшээл	160
Бусдад туслах явдалд ямар ч дүрэм байдаггүй	161
Алтруизм зөрчил тэмцэл үүсгэдэг	161
Өөрийн-тусыг бодох, зардал ашиг	162
Зах зээлийн ёс суртахуунт байдал	164

Байгууллагын нийгмийн хариуцлага	165
8 Хувьчлал, даяарчлал	167
Цагаачлал, технологи	167
Дэлхий ертөнц нээлттэй болж байна	167
Үзэл санааны солилцоо	168
Өсөж томорч буй чөлөөт нийгэм	168
Дээрээс доош хэрэгждэггүй капитализм	168
Дороос дээшлэх эрх чөлөөний хөдөлгөгч хүч	169
Ажиллаж буй өмчийн эрх	170
Перү дэх өмчийн эрх	170
Шинэчлэлийг дэмжих	172
Хөдөө аж ахуйн шинэчлэл	174
Усны эрх	176
Хувьчлалын механик явц	177
Зах зээлийн зарчмыг таниулж нэвтрүүлэх	178
Зөв хэрэгжүүлэх	179
Төр засгийн оролцоогүй нийгмийн үйлчилгээ	180
Төр засгийн оролцоогүй боловсрол	181
Төр засгийн оролцоогүй эрүүлмэндийн үйлчилгээ	183
Төр засгийн оролцоогүй халамжийн үйлчилгээ	185
Буяны буюу сайн санааны салбарыг дахин амилуулах	187
Даяарчлал, арилжаа худалдаа	189
Даяарчлалын ач тус	189
Шинэ Зиланд нээлттэй болсон нь	190
Соёлын ялгарах шинж	191
Эв найрын ач холбогдол	194
9 Гаргалгаа нотолгоогоо товчхон дурдвас	197
Эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоо	197

Хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг	198
Илүү их тэгш байдал	198
Чөлөөт эдийн засаг	199
Шударга ёс, хууль ёс	200
Өөрөө-бүрэлддэг нийгэм	201
Эрх чөлөөний ертөнц	202
Уншигчдадаа санал болгож буй бүтээлүүд	214

ЗОХИОГЧИЙН ТУХАЙ ӨГҮҮЛБЭЭС

Иймонн Батлер тэргүүлэх судалгааны байгууллага болох Адам Смит Хүрээлэнгийн захирал билээ. Тэрбээр эдийн засаг, философи, психологийн ухааны эрдмийн зэрэгтэй бөгөөд 1978 онд Гэгээн Эндрюс Их Сургуулиас PhD авсан. 1970-аад оны дундуур Батлер АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимд ажиллаж, мөн Мичиганы Хиллсдэйл Коллежид философи зааж байв. Дараагаар нь НХУ^[1]-д ирж Адам Смит Хүрээлэнг байгуулалцжээ. 2012 онд түүнийг Эдинбүргийн Бизнесийн Сургуулиас Hon DLitt гэдэг шагналаар шагнав. Тэрбээр одоогийн Мон Пелерин Нийгэмлэгийн Нарийн Бичиг билээ.

Тэрбээр Милтон Фрийдмэн, Ф. А. Хаек, Лүдвиг фон Мизэс зэрэг тэргүүлэгч эдийн засагч нарын тухай ном, Эдийн Засгийн Ухааны Австри Сургуулийн цагаан толгойг бичсэн. ЭЗХЯХ-д зориулж Адам Смит, Лүдвиг фон Мизэс, олон нийтийн сонголтын онолын талаархи цагаан толгойг бичжээ. Тэрбээр цалингийн түүх, үнийн хяналтын тухайн, мөн IQ-гийн тухай цуврал номын хамтран зохиогч юм. Түүний сүүлийн үеийн алдартай бүтээл Зах зээлийн тухай хамгийн сайн ном, Британийн Илжирсэн Төр, Өөр Нэг Хувилбар Тунхаг^[2] нь хүмүүсийн сонирхлыг их татсан бөгөөд тэрбээр номын хэвлэл, өргөн нэвтрүүлэгт байнга оролцдог.

¹ *УК-Нэгдсэн Хаан Улс-өмнө нь Нэгдсэн Вант Улс гэдэг байсан.*

² *The Best Book on the Market, The Rotten State of Britain, The Alternative Manifesto*

ӨМНӨХ ҮГ

Эдийн засаг, улстөрийн хямралын үеэр голдуу эрх чөлөө рүү дайрцгаадаг. АНУ-ын Аугаа Хямралын үеэр дэлхийн голлох бүх эдийн засагт тариф өсгөх замаар хязгаарлалт тогтоов. Иймэрхүү рефлексийн-шинжтэй хариу үйлдэл^[1] зөвхөн л гео-улстөрийн хурдацмал байдлыг бүр гааруулж, эдийн засгийн хүндрэлийг улам л нэмэгдүүлсэн. Тэр үед радикал социалист дэглэм үүсэж гарах болсноор дэлхийн тэн хагаст иргэний, улстөрийн, эдийн засгийн эрх чөлөө бүрэн хумигдлаа.

Бүр саяхан 9-р сарын 11-ны аллага хядлага, түүнд үзүүлсэн хариу үйлдэл болгон АНУ аюулгүй байдлаа нэмэгдүүлэх гэж оролдоход эрх чөлөөг солигт гаргах бодлого хөдөлгөөнд орлоо. Үүний адилаар 2008 онд эхэлсэн, АНУ-д үндэслэж соёолсон дэлхийн дахний санхүүгийн хямралаар хяналт, зохицуулалт, [тарифын] хамгаалалт нэмэгдэв. Чөлөөт зах зээлийн бүтээлчээр устгах зарчим^[2]д найдахын оронд Атлантын далайн хоёр эрэгт байгаа төр засгууд “татвар төлөгчдийн асар их мөнгө”-ийг хямарч буй бизнесийг аврахад ашиглажээ.

Эрх чөлөөнд аюул заналхийлсээр байна. 25 жилийн өмнө Зөвлөлт Холбоот Улсын “ил тод байдал”-ыг халуун дулаанаар хүлээн авч, дараагаар нь Берлиний Хана нурахад баяр хөөр болж байв. Гэвч шинэ сорилт Европ дахь нео-национализм, Ойрхи Дорнодын радикализм хэлбэрээр одоо өсөж өндийж байна. Энэ хоёр хандлага хэрэв түүнийг анхаарч хянахгүй бол эрх чөлөөг хумих болно. Европт национализм руу, бүр расизм руу ингэж

1 knee-jerk-өвдөгний нүд хавьцаа цохиход хөлийг урагш савлуулдаг рефлексийг хэлнэ. Үүнтэй жишиж хэлжээ.

2 creative destruction principle

эргэж буцаж буй явдал хэдий улстөрийн эрх чөлөө харьцангуй сайн төвшинд байгаа, мөн ардчилал ажилласаар байгаа ч өрнөсөөр л байна. Ойрхи Дорнодод шашны радикализм өсөж өндийх явдал тэнд зах зээл ч ардчилал ч тийм сайн байдаггүй тул нэг их гайхахаар зүйл биш.

Эдгээр зовлон бэрхшээл байгаа ч гэсэн 21-р зууны хувь хүмүүс олон талаараа өмнөх зуунуудын өвөг дээдсээсээ илүү эрх чөлөөтэй байна. Мэдээлэл, харилцааны холбооны технологийн хувьсгал бүх төрлийн саад тотгорыг үгүй болгов. Жишээлбэл Хятадын Ли Ченгпенг алдартай зохиолч, бас нийгмээ шүүмжлэгч билээ: түүний Шина Вейбо гэдэг блог нь ойролцоогоор зургаан сая дагагчтай. Арабын Хавар^[3]ын үеэр нийгмийн сүлжээ улстөр, нийгмийн өргөн далайцтай дэвшил гарахад дэм болсон. Мэдээлэл бол чадал учраас мэдээллийн технологи хувь хүнийг чадавхжуулжээ. Газарзүйн хил хязгаар хэвээр байгаа боловч ийм хил хязгаар улам бүр л хэрэгцээгүй зүйл болж байна.

Энэ агуулгаар Иймонн Батлерын нэг сэдэвт энэ бүтээл цагаа олоогүй байна гэж үү? Чөлөөт Нийгмийн Үндэс гэсэн энэ ном бол эрх чөлөөний талаархи орчин үеийн сурах бичгийн цомогтоо таатай нь аргагүй нэмэх бүтээл юм. Батлерын гаргуун чадвар нарийн нийлмэл, маш нөлөөтэй үзэл санааг жирийн Англи хэлээр илэрхийлэх түүний авьяаст бий. Мөн тэрбээр өөрийнх нь үзэл санааг дэлгэж харуулдаг, бас онолын төвшний гаргалгаа нотолгоог нь дэмждэг бодит жишээгээр шүүмжлэгчид, эсэргүүцэгчдийн гаргалгаа нотолгоог тун амжилттай няцааж чаддаг.

Тиймээс энэхүү Онцгой Бүтээл бол чөлөөт нийгмийн үндсэн зарчмыг ухаж ойлгох гэсэн хүмүүст зориулсан, түүний үндсийг тайлбарласан маш сайн сурах бичиг юм. Энэ ном ялангуяа эдгээр зарчмыг бараг үл мэдэх тэр улсуудад эрх чөлөөг дэмжихэд, мөн уламжлалт эрх чөлөө дайралтад өртсөн тэр газруудад эрх чөлөөг хамгаалахад маш тустай бүтээл болжээ.

Али Салман

Зах Зээлийн Эдийн Засгийн Бодлогын Судалгааны Хүрээлэн
(PRIME),

Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал

Пакистан, Исламабад хот

2013 оны 9-р сар

Энэхүү монограф буюу нэг сэдэвт бүтээлд илэрхийлсэн санаа, ЭЗХЯХ-ийн бүх хэвлүүлсэн зүйлд байдагчлан энэ Хүрээлэн (байгууллагын гэх үзэл байдаггүй), түүнийг удирддаг итгэмжлэгдсэн хүмүүс, Шинжлэх Ухааны Зөвлөх Зөвлөлийн гишүүд эсвэл ахлах ажилчдынх биш харин энэ зохиогчийнх болно. Лекц хэвлүүлэх зэрэг зарим оролцооноос гадна, ЭЗХЯХ-гийн бүх монографийг тухайн салбарынх нэр нь үл мэдэгдэх мэргэжилтэн болох дор хоёр эрдэмтэн эсвэл судлаач нягталж шалгадаг.

ТАЛАРХАЛ

Чөлөөт Нийгэмд зориулсан Зарчмууд гэдэг номоос нь олон санаагаа авсан Найжел Ашфордод тусгайлан талархъя. Өөр бусад хэрэгтэй эх сурвалжид Н. В. Acton's *The Morals of Markets*, J. S. Mill's *On Liberty*, Madsen Pirie's *Freedom 101*, Richard Wellings's *A Beginner's Guide to Liberty*, Ernest Benn's *Why Freedom Works* and Tom Palmer's *The Morality of Capitalism* зэрэг бүтээл орно.

УТГЫН ХУРААНГУЙ

- Эрх чөлөө хөгжил цэцэглэлтийг бүтээдэг. Эрх чөлөө хүмүүний авьяас, зохион бүтээх чадал, шинэ санааг суллан тавьж өмнө нь огт байгаагүй эд баялгийг бүтээдэг. Эрх чөлөөг халуун дулаанаар хүлээн авсан нийгэм өөрөө баян хангалуун болдог. Ингээгүй нийгэм ядуу дорой хэвээр үлддэг.
- Чөлөөт нийгэмд амьдардаг хүмүүс баяжихдаа эрх чөлөө багатай улсуудын элит буюу дээд давхаргынхан шигээр бусдыгаа ашиглаж мөлждөггүй. Энэ хүмүүс бусдыг ядууруулж өөрөө баяжиж чадахгүй. Тэд зөвхөн бусдад хүсэж буй зүйлийг нь өгч, бусад хүмүүсийн амьдралыг илүү таатай болгох замаар л баян болдог.
- Чөлөөт нийгмийн эдийн засгийн динамизм^[1]ийн гол ашиг тусыг ядуус хүртдэг. Чөлөөт нийгэм эдийн засгийн хувьд чөлөөт бус нийгмээсээ илүү тэгш байдалтай байдаг. Хамгийн чөлөөт нийгэмд амьдардаг ядуус өөрсдөө хэдхэн жилийн өмнө л мөрөөдөж ч чадахгүй байсан, мөн чөлөөт бус улс орны эрх мэдэлтэй дээд давхаргынхан л зөвхөн таашаан эдэлдэг тансаг зүйлсийг одоо эдэлж хэрэглэж байна.
- Олон-улсын арилжаа худалдаа ажил хэрэгч хүмүүст зах зээлийн шинэ бололцоог нээж өгч, сүүлийн хорин жилийн дотор тэрбум хүнд үгээгүй ядуу байдлаасаа гарахад нь тус болжээ. Эрх чөлөө бол хүмүүний түүхэн дэх хамгийн ашиг тустай, хамгийн бүтээлч хүчний нэг юм.

1 *dynamism*-байнгын хөдөлгөөнд оршдог байдал

- Төр засаг эд баялаг эсвэл орлого тэгшитгэх гэж оролдох нь хорлонтой зүйл. Ийм оролдлого шаргуу хөдөлмөрлөх, ажил хэрэгч байх санаачилгыг устгаж, нийт нийгмийн үр өгөөжийг асар ихээр нэмэгдүүлдэг, хүмүүс хөрөнгө хуримтлуулах явдлыг урамгүй болгодог.
- Чөлөөт нийгэм бол өөрөө-тогтдог нийгэм^[2] юм. Ийм нийгэм хувь хүмүүсийн үйлдлээс, эв найртай хамтын ажиллагааг дэмждэг ёс журам дагаж мөрдөх явдлаас бий болно. Ийм нийгмийг дээрээс, улстөрийн засаг захиргаанаас тулгаж хэлбэржүүлдэггүй.
- Төр засаг чөлөөт нийгэмд маш хязгаарлагдмал эрхтэй байдаг. Ийм төр засаг шударга ёсыг сахин хамгаалж, түүнийг албадан хэрэгжүүлэн иргэдээ хохирохоос нь сэргийлдэг. Ийм төр засаг материаллаг тэгш байдлыг тулгаж хэрэгжүүлэхээр оролддоггүй, мөн зарим хүмүүс санал үл нийлдэг учраас эсвэл доромжилсон зүйл гэж үздэг учраас л үйл ажиллагааг зүгээр л хориглодог байх ёсгүй. Удирдагчид нь өөрийн ашиг тусын төлөө иргэдээ тонон дээрэмддэггүй, өөрсдийн нөхдөдөө ашиг тус хүртээдэггүй, эсвэл эрх мэдлээ дайсан буюу өрсөлдөгчдийнхөө эсрэг хэрэглэдэггүй байх ёстой.
- Чөлөөт нийгэмд төр засгийг хууль ёс^[3]оор хязгаарладаг. Чөлөөт нийгмийн хууль хүн бүрд тэгш үйлчилдэг. Бүх тохиолдолд хуулийн зохих үйл ажиллагаа^[4]г хэрэглэх ёстой. Үүний хажуугаар хувь хүн шударга шүүхээр шүүлгэж, шүүхийн шийдвэргүйгээр удаан хоригдох ёсгүй. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хүмүүст гэмтэй гэдэг нь батлагдах хүртэл гэм буруугүй гэж хандах ёстой бөгөөд хувь хүмүүсийг нэг ижил гэмт хэрэгт олон удаа буруутгаж шийтгэх ёсгүй.

2 *spontaneous society*

3 *rule of law*

4 *due process of law*

- Бусад хүмүүсийн үзэл санаа, амьдралын хэвмаягийг хүлцэн тэвчих явдал нийгэмд ашиг тустай. Үнэн үргэлж ил харагддаггүй; үзэл санаануудын тэмцлээс үнэн ургаж гардаг. Зөвхөн буруу үзэл санааг дарж хаадаг утга санааны шүүлтүүр буюу цензүрт бид итгэх учиргүй. Ийм шүүлтүүр ирээдүйд нийгэм ач тусыг асар ихээр хүртэж болох үзэл санаа, үйл хийх арга замыг буруугаар ойлгож дарж хаадаг ч байж болох юм.
- Харилцаа холбооны технологиос болж авторитари буюу ганцаар дарангуйлдаг төр засаг үйл ажиллагаагаа дэлхий нийтээс нуухад хэцүү болжээ. Үүний үр дүнд улам л олон улс орон арилжаа худалдаа, аялал жуулчлалд нээлттэй болж, шинэ үзэл санаа түгэн тархаж байна. Улам л олон хүн эдийн засаг, нийгмийн эрх чөлөөний ашиг тусыг ойлгож, тэдгээрийг шаардах болжээ.

ЧӨЛӨӨТ НИЙГМИЙН ҮНДЭС

1 ОРШИЛ

Энэ номын зорилго

Энэ номд чөлөөт нийгмийг тодорхойлж харуулдаг суурь зарчмуудыг дэлгэж үзүүлэх болно. Ингэх хэрэгтэй болсны шалтгаан бол хувь хүн, нийгэм, улстөр, эдийн засгийн жинхэнэ эрх чөлөө бүр өөрсдийгөө эрх чөлөөтэй гэж боддог улс оронд ч гэсэн маш ховор байгаа явдал юм. Хэдийгээр аливаа улс оронд хүмүүсийн нийгэм болон эдийн засгийн амьдралыг албан тушаалтан болон улстөрчид илүү ихээр эсвэл арай бага хэмжээгээр хориглож хорьж эсвэл хянаж байдаг ч гэлээ хамгийн эрх чөлөөтэй болон хамгийн бага эрх чөлөөтэй улс орнуудын хооронд мэдээж маш том ялгаа бий. Иймэрхүү хязгаарлалт, хяналт маш урт хугацаанд бидний эргэн тойронд байсаар байсан, мөн бидний өдөр тутмын амьдралыг маш ихээр хязгаарладаг тул эдгээр нь бидний соёлын нэг хэсэг болчихжээ. Хүмүүс зүгээр л ийм зүйлсийг амьдралынхаа нэг хэсэг, жам ёсны зүйл, гарцаагүй эд гэж үзэцгээдэг.

Үр дүнд нь бүр тэд чөлөөт нийгэмд амьдардаг гэж итгэдэг байсан ч дэлхийн хүн амын дийлэнхи нь жинхэнэ эрх чөлөө гэж юу болохыг төсөөлж ч чадахгүй болжээ – өнөө ч гэсэн чөлөөт нийгэм ямар байдалтай байх, яаж ажиллах боломжтой талаар бид бага зүйл л мэддэг.

Гэлээгээд ихэнхи хүмүүс эрх чөлөө хүсдэг. Хүмүүс тоо томшгүй зөвшөөрөл авалгүйгээр арилжаа худалдаа хийх боломжтой байхыг хүсдэг. Улстөрчид булаан авах, сүйрүүлэх эрсдэлгүйгээр гэр орон, аж ахуй, урлангийнхаа өмчлөлийг баталгаажуулахыг тэд хүсдэг. Тэд албан тушаалтны тушаасан зүйлийг хийхээс илүүтэй өөрийнхөө гэр бүлийн төлөө юу хийвэл хамгийн сайн

болохыг өөрөө шийдэхийг хүсдэг. Тэд цагдаа, захиргаадалтын ажилтнууд¹ад өөрийг нь бүү оролд гэж хахууль өгөхгүйгээр өөрөөрөө амьдрахыг хүсдэг.

Ийм л учраас нийгэм болон эдийн засгийн эрх чөлөөний цөм зарчмуудыг зураглаж гаргах маш чухал ажээ. Эрх чөлөө гэж юу болох, энэ нь хэрхэн ажилладаг талаархи тов тодорхой төсөөлөл бол хүмүүс жинхэнэ чөлөөт нийгэм цогцлоож чадах суурь юм.

Энэ номыг хэрхэн эмхлэв

Энэ номын 2-р бүлэгт чөлөөт нийгэмд амьдрахын *эдийн засгийн* ашиг тусыг тайлбарлаад зогсохгүй бас эрх чөлөөг дэмждэг *ёс суртахууны* жишээг тайлбарлалаа. Чөлөөт эдийн засаг, чөлөөт нийгэм гүн гүнзгий утгатай үнэт зүйлд тулгуурладаг – эдгээр үнэт зүйл нь ёс суртахууны бусад тогтолцоотой зөрчилддөггүй харин тэдгээрийг дэмждэг, бэхжүүлдэг, улам тодруулдаг үнэт зүйлс байдаг. Эрх чөлөө бол бүх хүнд [хамаатай] зүйл юм.

3-р бүлэгт хүн бүрд хүчирхэг удирдагч юу хийхийг нь тушаах ямар ч шаардлагагүйгээр хэрхэн чөлөөт нийгэм хүмүүсийн хэрэгцээг жигд тасралтгүй, үр ашигтайгаар хангах боломжтой болохыг тайлбарлав. Үнэндээ энэ бүлэгт төр засгийг яагаад хийх ажил, эрх мэдлээр нь *хязгаарлах* ёстой болохыг тайлбарласан бөгөөд чөлөөт нийгэм ямар байдалтай байдаг, хэрхэн энэ нь ажилладаг болохыг үзүүлсэн болно.

4-р бүлэгт *эрх чөлөө* болон *тэгш байдлын* хоорондох илэрхий хурцадмал байдлын талаар өгүүллээ. Энэ бүлэгт илүү их эрх чөлөөнөөс хэрэгтэй бүх газартаа тэгш байдал илүү ихээр үнэндээ үүсдэг болохыг батлан өгүүлэв. Гэвч үр дүнд нь гардаг ийм тэгш байдлыг нийгэмд хүчээр тулгах гэж оролдвол энэ нь эрх чөлөөний зарчмыг ганхуулж, урт хугацааны хор хохирол учруулна.

5-р бүлэгт зах зээл төрийн хяналтаас сул чөлөөтэй байвал хөгжил цэцэглэлтийг дэмжиж, түүнийг түгээн тархаадаг

1 *bureaucrats*

болохыг тайлбарлаж, чөлөөт нийгмийн эдийн засгийн бүтцийг ерөнхийлж харууллаа. Энэ бүлэгт энэ үйл явцыг жигд тасралтгүй явуулахад бидний дагаж мөрддөг ёс журам хэрэгтэй болохыг, мөн хүмүүний хамтын ажиллагааг дэмжиж тэтгэхэд чөлөөт худалдаа амин чухал болох талаар тайлбарлав.

6-р бүлэгт *өмч, шударга ёсны* зарчмыг нягталж харууллаа. Энэ бүлэгт албадлага, мөлжлөгийг хумьж багасгах гэвэл чөлөөт нийгмийн хуулийг яагаад бүх нийтээр-дагадаг^[2] байх ёстойг, бас хууль засаг захиргаанд байгаа хүмүүст ч, жирийн иргэдэд ч үйлчилдэг байх ёстойг тайлбарлалаа. Түүнд мөн чөлөөт нийгэм хүмүүний суурь эрхийг хэрхэн хүндэлдэг болохыг тайлбарласан болно.

7-р бүлэгт илүү дэлгэрэнгүйгээр чөлөөт нийгэм хэрхэн засаг захиргаанд байдаг хүмүүсийн тушаалын хэрэгцээгүйгээр ажилладаг болохыг тайлбарлалаа. Энэ бүлэгт сайн ажилладаг ч нийгмийн чөлөөт дэг журмыг үүсгэж тогтоодог *ёс суртахууны* болон *зан суртлын суурь ёс журм*^[3]ыг дүрсэлж харуулав. Түүнд *хүлцэхүй* хэрэгтэй болохыг дурдаж, алтруизм^[4]д тулгуурласан нийгмийн бэрхшээл зовлонг тайлбарласан болно.

8-р бүлэгт хаана ч байхгүй чөлөөт нийгмийг хэрхэн цогцлоох тухайд анхаарал хандуулав. Энэ бүлэгт өдөр тутмын амьдралд гарах санаачилгыг дэмжих явдлын ач холбогдлыг, мөн шийдвэр дагахыг хүмүүст дээрээс тулгах явдлын тэнэг байдлыг харуулсан болно. Түүнд бас төр засаггүйгээр бүр амин чухал үйлчилгээг хэрхэн үзүүлэх боломжтойг харууллаа. Энэ бүлэгт *чөлөөт худалдаа, эв найр*^[5]ын ач холбогдлыг өгүүлэв.

2 *general*

3 *moral and behavioural rules*

4 *altruism-бусдын төлөө өөрийгөө золиослохыг шаарддаг үзэл*

5 *peace*

2 ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЁС СУРТАХУУНЫ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Чөлөөт нийгэм

Эрх чөлөө гэж юу гэсэн үг вэ?

Эрх чөлөө (эсвэл эрх чөлөөт байдал^[1] – энэ хоёр үгийг Англи хэлэнд сэлгэж хэрэглэдэг) бол зүгээр шоронд хоригдохгүй, эсвэл боолчлогдохгүй байхаас ч илүү өргөн зүйл юм. Эрх чөлөө бол бусдаас, үүн дотроо засаг захиргаанаас тулгасан дарлаж дарангуйлах хязгаарлалтгүйгээр үйл хийх, ярьж хэлэх, бодож сэтгэх эрх билээ. Энэ байдал хувь хүн, гэр бүл, нийгмийн амьдрал, мөн улстөрийн үзэл санаа, бусадтай хийдэг эдийн засгийн хэлцэлд ч хамаатай.

Чөлөөт нийгэм бол эдгээр идеалийг баримтлахыг зорьдог тийм нийгэм юм. Түүхэндээ ч, өнөөдөр ч эрх чөлөө эд баялаг үүсгэж, иргэдэд түгээн тархаахдаа маш гарамгай болохоо баталсан, батлан харуулсаар байна. Эрх чөлөө хүмүүн төрөлхтөний хамгийн бүтээлч, хамгийн өгөөжтэй хүч болохоо батлав. Эрх чөлөө хүмүүсийн амьдралыг, ялангуяа ядуусын амьжиргааг дэлхий даяар сайжруулжээ.

Эрх чөлөө бол танд юу ч саад болохгүй, өөрийн сонгосноороо хүссэн зүйлээ хийхийг тань хорих зүйл байхгүй гэсэн үг юм. Бусад хүн албадахгүй, тушааж зааварлахгүй, заналхийлэхгүй, эрүүдэн шүүхгүй, тулгаж хүчлэхгүй, дарлахгүй, хөндлөнгөөс оролцохгүй эсвэл зааварлаж удирдах ёсгүй. Энэ нь гаднаас халдаж дайрах, хуурч мэхлэх, дээрэмдэх, эсвэл хохироож гэмтээх аюулгүйгээр амьдрах боломжтой гэсэн үг билээ. Чөлөөт нийгэмд эрх чөлөөний зарчим ижил тэгш үйлчилдэг учраас ийм

1 freedom (or liberty)

байдаг. Бидний хэнд нь ч хүмүүсийн эрх чөлөөг үгүйсгэх, бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох, саад болох эсвэл тэднийг хохироох эрх байдаггүй.

Бусад хүмүүсийг гэмтээж хохироохгүй гэж л бидний эрх чөлөө оршдог. Та нарын нударгаа савчих эрх миний хамрын үзүүр хүрээд төгсөнө. Хэрэв та бусдад заналхийлж, дээрэмдэж, халдаж, эсвэл алж буй бол тэр тань эрх чөлөөгөө элдэж буй хэрэг биш. Үүний эсрэгээр үйл саадгүйгээр хийх тэдний эрх чөлөөг та нар хязгаарлаж байна гэсэн үг. Дараахь зүйлийг “үл хохироох” зарчим гэдэг: та нар бусдад хор хохирол учруулахгүй бол юу хүссэнээ дураараа хийх эрхтэй.

Үүний адилаар та нар тэдний түрэмгийллийг эсэргүүцэх нь хэн нэгний эрх чөлөөг хязгаарлаж буй хэрэг биш. Эрх чөлөө болон үл хохироох зарчим^[2] бусад хүмүүс таныг болон танд эрхэм хүмүүсийг хохироохоос сэргийлэх боломж танд олгодог. Мөн бусад хүнд, үүн дотроо чиний танихгүй хүнд хор хохирол учруулах гэхэд нь хэдийгээр бусад иргэдийг хамгаалах энэ функцийг голдуу цагдаа, хуульзүйн засаг захиргаа^[3]нд орхидог ч гэлээ та нар хөндлөнгөөс оролцвол түүнийг тань зөвтгөнө.

Гэвч үл хохироох зарчмыг бусад хүмүүст учруулсан хор хохиролд л зөвхөн хэрэглэдэг. Энэ зарчим танд өөрийн бие, өөрийн өмчөө энэ үйл явцын үеэр бусдын эрх чөлөөнд халдахгүй бол л юу хүссэндээ ашиглах боломж олгодог. Жишээлбэл та нар өөр нэгнийг гэмтээж хохироохгүй л бол бүх өмчөө бусдад тараан өгөх, аюултай зүйл хийж эрсдэл гаргах, өөрийн биеэ гэмтээх боломжтой. Хэдийгээр бусад хүмүүс ингэж өөрийгөө гэмтээх хохироох үйлдлийг тань зогсоохоор чармайж оролдож болох ч гэлээ хэрэв энэ үйл өөрийн тань зориудын сонголт бол тэд таныг жинхэнээсээ зогсоож чадахгүй.

2 *no-harm principle*

3 *legal authority*

Эрх чөлөө, төр засгийн үүрэг нөлөө

Бүр тэдний сайн сайхны төлөө энэ нь байсан ч бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох эрх чөлөө бидэнд байхгүй гэж хэлэх нь хэрцгий санагдаж болох юм. Гэвч бидний хэн нь ч бусдын ашиг сонирхолд юу жинхэнээсээ нийцэж байгааг үнэнээсээ мэдэж чадахгүй. Хувь хүмүүс сайн сайхан байдал нь юу болохыг хамгийн сайн мэддэг. Тэд нар өөрийн үнэ цэнэ, нөхцөл байдал, хэрэгцээ, хүсэл, айдас, итгэл найдвар, зорилго, хүсэл тэмүүлээ бусад хэн нэгнээс хамаагүй илүү ойлгодог. Хүмүүс зорилго, үйлдлээ хамгийн сайн үнэлж цэгнэдэг.

Хөндлөнгийн хүмүүс бусдыг хэрхэн дүгнэж цэгнэх тухай ерөөсгөл бодолтой байх боломжтой. Хэрэв бид хүмүүст бусдынхаа эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрвөл энэ хүмүүс бусад хүмүүсийн төлөө гэхээсээ илүүтэй өөрсдийнхөө ашиг тусын төлөө ийм үйлдэл (ухамсартайгаар эсвэл санаандгүйгээр) хийж болно. Энэ байдал бол жинхэнээсээ чөлөөт нийгэмд дор хаяж тухайн хэрэг явдалд илүү объектив буюу бие даасан байж чадах цагдаа, шүүхэд яагаад бусдыг хязгаарлах талаархи шийдвэр гаргах явдлыг үлдээдгийн шалтгаан юм.

Бид хэн ч байлаа гэсэн эрх чөлөөтэй байдаг нийгэмд амьдрах явдал л хувийн зорилгодоо хүрэхээр тэмүүлэх бидний явдалд хамгийн их тус болно. Ийм нийгэм дэх төр засгийн үүрэг бол бусдын хүчирхийлэл түрэмгийллээс бидний эрх чөлөөг хамгаалах, мөн бүрэн хэмжээгээр байхгүй газар нь эрх чөлөөг өргөжүүлж тэлэх, гүйцэт бус байгаа газарт нь гүйцээж нэмэх явдал юм. Хүмүүс хамтдаа цуглаж төр засгаа эсвэл тэдний дээр орших өөр бусад аливаа засаг захиргааг байгуулахдаа дараахь зүйлийг боддог: энэ нь тэдний эрх чөлөөг хязгаарлаж хумихгүй харин түүнийг хамгаалж, өргөжүүлж тэлнэ гэсэн бодол билээ.

Гээд төр засгаа хэт олонхи тохиолдолд энэ байдлаар байгуулдаггүй. Энэ төр засгийг хүн амд эрх мэдлийг хүн бүрийн эрх чөлөө өргөжүүлж тэлэхэд биш харин өөрийн ашиг тусын төлөө ашиглахыг хүсэж зорьж буй бүлэг хүн тулгаж

зөвшөөрүүлдэг. Иймэрхүү эзэрхийлэх явдал өөрөө цөөнхөө мөлжиж ашиглаж ашиг хүртдэг олонхийн бүрэн дэмжлэгээс гардаг. Гэвч эрх чөлөөнд тоо хэмжээ хамаагүй: эрх чөлөө ямар нэг утга учиртай байхын тулд түүнийг нийт хүн ам тэнцүү хүртэх ёстой.

Бүр бүх нийтийн ашиг сонирхол тээсэн төр засаг ч үл хохироох зарчмыг бүрэн ухаж ойлгодоггүй эсвэл хүндэтгэдэггүй, бас төр засаг хөндлөнгөөс оролцох явдлаас гардаг хор хохирлыг харж ухаардаггүй учраас голдуу л эрх чөлөөг хумьдаг. Жишээлбэл төр засаг тодорхой бодол санаа илэрхийлж, үг хэлэх эсвэл зураг олон нийтэд дамжуулахыг эдгээр нь олон нийтийг доромжилж байх боломжтой гэж итгэн хориглож болох юм. Гэвч энэхүү үйл явц авьяаслаг зохиолч, жүжигчин, найруулагч, сэтгүүлч, бусад хүмүүсийг үзэл бодол болон үг хэлэх эрх чөлөө^[4]г нь хумьж, мэргэжлийн замналд нь саад хийж, хөдөлмөр, бүтээлч байдал, оюун ухааныхаа үр шимийг хүртэхийг нь хорьж хохироодог. Төрийн үзэл суртлын шүүлтүүрийн зарчмыг нэгэнт хүлээн зөвшөөрчихвөл төрийн эрхэнд буй хүмүүс төр засгийн талаархи элдэв шүүмжлэлийг хориглож, жишээлбэл эсвэл аюул занал гэж санагдах аливаа санаа бодлыг дарж дарангуйлан үүнийгээ өргөжүүлж тэлэх явдал хялбар болох болно.

Сайн санаатай засаг захиргаа дахиад л хэдий энэ нь татвар төлөгч өөрийн өмчөө таашаан эдлэх эрх чөлөөг жирийн хулгайч юм хулгайлдагчлан булаан авах болно гэдгийг үл тоомсорлож орлого тэгшитгэх зорилгоор татвар ногдуулж болно. Жирийн хулгайч лугаа адилаар ингэж өмч хураах гэсэн заналхийлэл хүмүүс эд хөрөнгөө хадгалж хураах, түүгээрээ хөрөнгө оруулах явдлыг хорьж саатуулдаг – энэ нь эргээд нийт хүн амын аюулгүй байдал болон хөгжил цэцэглэлтэд муу хортой нөлөө үзүүлэх болно.

Ийм төр засаг олон нийтийн ашиг сонирхлын төлөө үйл хийж байна гэж мэдэгдэж чадах ч гэлээ олон нийтийн ашиг сонирхол

4 *freedom of thought and expression*

юу болохыг хэн мэдэх билээ? Өөр өөр хувь хүн ондоо ондоо, голдуу хоорондоо өрсөлдөхөөр ашиг сонирхолтой байдаг. Эдгээр хоорондоо өрсөлдөж буй ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх нь боломжгүй зүйл. Гэвч хувь хүмүүс өөрийн ашиг сонирхлоо мэдэх, түүндээ тааруулж үйл хийхдээ өөрийнхөө төлөө албаны эрх мэдлийг ашигладаг хол хөндий байгаа албан тушаалтныг бодвол илүү сайн байдаг.

Албадлага бол хортой зүйл юм. Хэдийгээр зарим албадлага, үүн дотроо халдан түрэмгийлэгч этгээдийг хорьж хазаарлах зэрэг албадлага хэрэгцээтэй хортой зүйл байж болох ч гэлээ бид албадлагыг аль болох бага болгох боломжийг эрэлхийлэх хэрэгтэй. Эрх чөлөөний олон хамгаалагч хүн бүх хүмүүн төрөлхтөн төр засгийн бидний дээр байх эрх мэдлийн хязгаарлалтыг тогтоодог амьдрах эрх^[5], хувийн өмчтэй байх эрх зэрэг “жам ёсны эрхтэй” гэдгийг батлан өгүүлдэг. Бид бусад иргэд биднийг дээрэмдэж, эсвэл цагдаж хориглохыг зөвшөөрдөггүй тул бид яагаад ингэхийг нь төр засагт зөвшөөрөх ёстой гэж?

Гэвч хүмүүн төрөлхтөний түүхийн ихэнхид хүмүүс эрх чөлөөгүй байжээ. Төр засгийг хувь хүмүүсийн сайн дурын гэрээгээр байгуулаагүй харин хүч хэрэглэхийг хүссэн хүмүүс тэдэнд тулгаж зөвшөөрүүлсэн байв. Гэвч ямар нэг засаг захиргаа эсвэл албан тушаалтан хүчээр амьдралыг нь шийддэг хувь хүн бол бүтэн хүн биш. Хэрэв тэд сонголтоо өөрийнхөөрөө хийж байвал л хүмүүс ёс суртахууны хувьд зөвхөн бүрэн гүйцэт байдаг. Харин хэрэв тэдний өмнөөс хэн нэгэн сонгодог бол тэдэнд үнэ цэнэтэй гэмээр ёс суртахуун байхгүй болно. Тэр үед тэд бүрэн бүтэн хүмүүн төрөлтөн^[6] бус харин хэрэггүй зүйл болох ажээ.

Эрх чөлөөг дэмждэг ёс суртахууны гаргалгаа нотолгоо

Эрх чөлөө хүмүүст өөрсдөдөө таарна гэж бодсоноор зөвхөн зогсохгүй мөн гэр бүлдээ, тэдэнд ойр дотно хүмүүстээ нийцнэ гэж

5 *right to life*

6 *human beings*

бодсоноороо авьяас, ур чадвараа ашиглаж бүрэн бүтэн хүмүүн төрөлтөн болох боломж олгодог. Чөлөөт нийгэм бол салангид оршдог, өөрийн-тусыг боддог хувь хүмүүсийн бөөгнөрөл биш; энэ бол бүрэн бүтэн, нийгмийн хүмүүн болсон бие хүмүүсийн сүлжээ юм. Бүх хүмүүн төрөлхтөнд туслах хувь хүний чадвар чөлөөт нийгмийн ёс суртахууны хэмжээсийг тодосгодог.

Эрх чөлөөний оюун санаа болон соёлын уг үндэс

Нобелын шагналт эдийн засагч Амартия Сен эрх чөлөө бол универсал үзэл санаа^[7] юм гэдгийг цохон тэмдэглэсэн.^[8] Эрх чөлөө Исламаас авахуулаад Буддизм гээд бүх шашин, Азиас Өрнөдийн гэх бүх соёлд хүчтэй үндэслэжээ. Энэтхэгийн эзэн хаан Ашока хоёр мянган жилийн тэрээ эрх чөлөө, улстөрийн хүлцэхүйг шаардаж байлаа. Арванзургаадугаар зуунд Могулын эзэн хаан Акбар Европд шашны тэрс үзэлтнүүдийг Залхаан Цээрлүүлэх Газар^[9] хавчин мөшгөж байхад сонгодог хүлцэхүйг дагаж мөрдүүлж байв. Ислам бүр эртнээсээ л Өрнөдийн соёлд хүндэлдэг болохоос ч өмнө эдийн засаг болон аж ахуй эрхлэх эрх чөлөөнд нээлттэй хандаж байсан. Туркийн эзэн хаад^[10] голдуу л хүлцэхүйг Европын хаад^[11]аас илүү дэмжиж байжээ.

Өөрөөр хэлбэл эрх чөлөө дэлхий дээрхи бүх аугаа соёл болон шашинтай төгс нийцсэн байдаг. Энэ бол ялангуяа Өрнөдийн үзэл санаа ч биш, бас материаллаг үзэл санаа ч биш, мөн нийгмийн хүчтэй үнэт зүйлд тулгуурладаг нийгэмтэй тэрсэлдэг ч үзэл санаа биш. Үнэндээ чөлөөт нийгэм хохироох гэмтээх, хууран мэхлэх, мөлжиж ашиглах, эрх мэдлээ буруугаар ашиглахыг хориглодог дундын хэм хэмжээг хүслээрээ хүлээн зөвшөөрдөг

7 *universal idea-хаа сайгүй газар бүр тархсан үзэл санаа*

8 *Amartya Sen, 'Universal truths: human rights and the Westernizing illusion', Harvard International Review, 20(3), 1998, pp. 40–43-БАТЛЕР (орчуулагчийн эшлэлээс Иймонн Батлерынхыг ялгах гэж ингэж бичлээ)*

9 *Inquisition*

10 *emperor*

11 *monarchs*

хүмүүст суурилдаг – энэ хэм хэмжээ бол хүмүүс зэрэгцэн амьдрах, хамтран ажиллах боломжтой нийгмийн эв зохицолтой дэг журмыг бүтээхэд тусалдаг ёс журам юм. Өргөн хүрээнд эрх чөлөө хүмүүс өөрийн үнэ цэнээ тогтоох, өөрийн соёлоо сахин хамгаалах, өөрийн шашны заншлаа дагаж мөрдөх боломж олгодог. Соёл, заншил, төрийн ямар нэг засаг захиргааны арга ажиллагааг хүлээн зөвшөөрүүлэхээр тэднийг албадаж хүчилдэггүй.

Итгэлцэх, хамтран ажиллах соёл

Чөлөөт нийгэм эрх мэдэл, эрх дарханд суурилж ажилладаггүй харин итгэл, хамтын ажиллагаанд үндэслэж ажилладаг. Чөлөөт нийгмийн эд баялаг сайн дурын солилцоогоор, мөн хүмүүс хэрэгтэй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бусадтайгаа арилжих явдлаар бий болно. Эд баялаг эрх мэдлээ олон нийтээс татвараар дамжуулж сордог, эсвэл монополь байдал болон давуу эрх өөрсдөдөө болон гэр бүлийнхэндээ, амин найзынхаа бизнес^[12]т баталгаажуулж өгдөг эзэрхэг дээд ангийнхны хулгайлж-булаах тактикаар бий болдоггүй. Хүмүүний түүхийн туршид ихэнхи улсад дийлэнхи эд баялаг албадлагын хүчинд тулгуурласан мөлжлөгөөр дамжин үүссэн байж болох юм. Чөлөөт нийгэм үүний оронд сайн дурын хамтын ажиллагаа болон солилцоо хийх хамаагүй эрүүл сэдэлд тулгуурладаг.

Сайн дураараа хамтран ажиллах, солилцоо хийхэд итгэлцэл хэрэгтэй. Хэн ч шуналтай луйварчид гэж бодож байвал, тэгэхийг нь албадаж хүчлээгүй бол эсвэл өөр сонголт (жишээлбэл төр засаг, эсвэл тэдгээрийн амин найзын бизнес, үйлдвэрлэлийн хяналтаас өөр зүйл)-гүй бол тэр хүмүүстэй худалдаа арилжаа хийхгүй. Чөлөөт нийгэмд хүмүүст сонголт байдаг бөгөөд тэд өөрсдийн бизнесээ хаа нэгтээ явуулах нь чөлөөтэй байдаг тул үйлдвэрлэгчид өнөөгийн болон гарч ирж болох ирээдүйн хэрэглэгчдэдээ хоёуланд нь өөрсдийгөө шударга гэж итгүүлэх

12 cronies-тэжээвэр гэдгээс илүү оновчтой санагдав.

ёстой. Тэд заавал амлалтаа биелүүлэх ёстой эсвэл тэд нэр төрөө гээж, бизнесээ алдах болно. Ихэнхи хүмүүсийн хувьд нэр төрөө алдах, амьдрах зуршлаа өөрчлөхөөс аргагүй болох нь ноцтой санаа зовоосон бэрхшээл байдаг.

Чөлөөт нийгмийг хүч ашиглаж дээд анги нь дээрээс чиглүүлж удирддаггүй. Энэ нийгэм жирийн хүмүүсийн сайн дурын харилцаагаар дамжин жам ёсоороо, өөрөө-өрнөх байдлаар^[13] л ажилладаг. Ийм харилцан үйл хийх явдлыг найдвартай, чин шударга байх соёл тэтгэдэг. Энэхүү өөрөө-өрнөдөг хамтын ажиллагааг хөдөлгөдөг ёс журам, хэм хэмжээ хүмүүс тэдгээрийн тухай бүр бодох ч хэрэгцээгүй байхаар чөлөөт нийгэмд жам ёсны зүйл болсон байдаг ажээ. Ямар нэг засаг захиргаа хүмүүст чин шударга, ашиг тустай байх, эсвэл шаргуу хөдөлмөрлөх, бусадтай хамтран ажиллахыг хэлэх хэрэгцээ байдаггүй. Хүмүүс өдөр бүр зөнгөөрөө үүнийг хийцгээдэг.

Чөлөөт нийгэмд итгэлцэл болон хамтын ажиллагаа хэрэгцээтэй байдаг явдал эрх мэдлээр-удирддаг нийгэмд байдаг ийм харилцаанаас хувь хүмүүс болон бүлэг хүмүүсийн хоорондохь харилцаа холбоог хамаагүй чухал болгодог. Оюун санааны үнэт зүйл, гэр бүл, нөхөрлөл, хүмүүсийн хүрээлэл, өв уламжлал, хөршийн холбоо, хүмүүс эвлэлдэн нэгдэх явдлын холбоо сүлбээ улам бүр чухал болдог. Чөлөөт бус нийгмийн олон төр засаг иймэрхүү эвлэлдэн нэгдэх явдлыг эрх мэдлийнх нь аюул занал гэж үздэг бөгөөд эдгээрийг сулруулах, сүйтгэж ганхуулах эсвэл үгүй хийхийг эрэлхийлдэг. Тэдгээр төр засаг ийм бүлгүүдийг ихэвчлэн далд нууц байдалд оруулж л чадна. Сайн дураараа эвлэлдэн нэгдэх явдал төр засгийн засаг захиргаанд үнэнч байх явдлаас хамаагүй хүчирхэг байж хүмүүст маш чухал зүйл болсон байдаг.

13 spontaneously

Өөрийн-тусыг бодох, ёс журам

Чөлөөт нийгэмд дээрээс ирэх тушаалын хэрэгцээ байхгүй. Жирийн хувь хүмүүс өөрийн төлөвлөгөө болон үйлдлээ бусад хүмүүсийн төлөвлөгөө болон үйлдэлтэй тааруулж нийцүүлэх явдалд тулгуурлаж ийм нийгэм ажилладаг. Тэдэнд ийм зүйл хийх боломж олгодог зүйл бол бүгдээрээ дагаж мөрддөг, өөр өөр ашиг сонирхолтой ондоо ондоо хүмүүсийн дунд зөрчил гарахаас сэргийлдэг, чин шударга зан, хүчирхийлэл үл хэрэглэх байдал зэрэг ёс журам, үнэт зүйлийн энгийн бүрдэл юм.

Иймэрхүү суурь ёс журам, бүгдэд нь байдаг үнэт зүйлийн нөлөө хүмүүс эв найртай амьдрах боломж олгохоор дуусдаггүй. Харилцан-холбоотой ашиг сонирхл^[14]оо гүйцэлдүүлэхийн тулд хүмүүс чөлөөтэй хамтран ажиллах боломж мөн олгодог. Жишээлбэл чөлөөт нийгэмд хүмүүс хоёр тал хоёулаа ашигтай гэж үзсэн хэлцэл хийж нэг нэгтэйгээ арилжаа худалдаа хийх нь чөлөөтэй. Ямар нэг засаг захиргаа хүмүүст юу тустай байх боломжтойг шийдэхгүй, бас тэдний өөр өөр ашиг сонирхлыг хэрхэн тэнцвэржүүлэхийг шийдэхгүй, мөн тэдний ашиг сонирхолд тааруулж юу хийхийг шийдэхгүй, тэгээд бас тэр төлөвлөгөөгөө дагаж мөрдүүлэхээр хүмүүсийг албадаж хүчлэх ёсгүй. Чөлөөт нийгэмд хүмүүс өөрсдөө тэдний ашиг сонирхолд юу нийцэхийг, мөн бусад хүмүүстэй хамтран ажиллаж тэдгээр ашиг сонирхлоо хамаг сайнаар хэрхэн гүйцэлдүүлэхээ сонгож мэддэг. Тэд үйл явцынх нь үеэр өөр нэгэн хохирохгүй байсаар байх хүртэл өөрийн сонгосноороо ямар ч гэрээ хэлцэл чөлөөтэй хийнэ.

Нийтийн зорилгоо сонгож авч, тэр зүйлдээ хүрэхээр бүх иргэдээ ажиллахыг үүрэгжүүлэхгүйгээр хэрхэн нийгэм ажиллах, хөгжиж цэцэглэх боломжтойг зарим шүүмжлэгч ухаж ойлгож чаддаггүй. Тэд чөлөөт нийгэмд хувийн холын бодол буюу амбицуудын байнгын, үр өгөөжгүй, зэвүү хүргэм зөрчилдөөн л байх болно гэж эмээдэг. Тэднийхээр бол ийм амбиц буюу холын

14 *mutual interests*

бодлыг нь олон нийтийн ашиг сонирхол ноёлж байхын тулд дарж дарангуйлах ёстой аж.

Энэ бол буруу зүйл юм. Чөлөөт нийгэм хүмүүс өөрийн-тусыг боддог^[15] байхыг хүлээн зөвшөөрдөг. Гэвч энэ нийгэмд хялбархан дарж үгүй хийх боломжгүй хүчирхэг сэдэл гэж өөрийн-тусыг бодох явдлыг бас хүлээн авдаг. Албан тушаалтан, улстөрчдийн тодорхойлсон “нийтийн ашиг сонирхол” өөрсдийнх нь ашиг сонирхлыг бодвол чухал хэрэгцээ, ач холбогдол хамаагүй багатай зүйл хүмүүс гэж үздэг. Бид өөрийн-тусыг бодох бол жинхэнээсээ хэрэгтэй, чухал зүйл юм гэдгийг санах ёстой: хэрэв хувь хүмүүс үндсэн хэрэгцээ (хоол хүнс, уух ундаа, орон сууц, хувцас хунар)-гээ үл тоомсорловол тэдний амьдардаг нийгэм нь хэр их өгөөмөр буян үйлдэмхий байсан ч хамаагүй тэд удаан хугацаанд амьд явахгүй.

Чөлөөтнийгэмөөрийн-тусыгбодох^[16] явдлыгүрөгөөжтэйгөөр чиглүүлдэг. Өөрийн-тусыг бодох явдлыг ямар нэг утопи зүйл бүтээх гэсэн хоосон найдвараар дарж дарангуйлдаггүй. Ёс журмын бүрдэл хүмүүсийг холын бодлоо бусад хүмүүст тулгахгүй байхыг л зөвхөн шаарддаг. Хүмүүс бусдынхаа ийм зүйл хийх эрх чөлөөг хүндэтгэж хүндэлсээр байх хүртэл өөрсдийнхөө ашиг сонирхолдоо бие дааж, эсвэл бусадтай хамтран хүрэхээр чөлөөтэй тэмүүлнэ. Тэд өөрсдийнхөө тодорхой зорилгоо хүлээн зөвшөөрүүлэх, түүндээ үйлчлүүлэхээр бусдыг хүчилж чадахгүй.

Энэ нийгэм хоорондоо өрсөлдсөн ашиг сонирхлын мөнхийн тулааны талбар байх болно гэсэн чөлөөт нийгмийн шүүмжлэгчдийн айдсыг харьцангуй чөлөөт нийгэм хөгжиж цэцэглэдэг, хяналт дор оршдог нийгмээсээ бараг үргэлж илүү сайн хөгжиж цэцэглэдэг гэсэн бодит байдал няцаадаг. Бусад хүмүүсийнхээ эрх чөлөөг хүмүүс хүндэлдэг тэр жирийн ёс журмын бүрдлийг ашиглаж энэ хүмүүс өөрийн-тусыг бодох

15 self-interested

16 self-interest

явдлаа өгөөжтэй хамтын ажиллагаа, хамтран ажиллах явдал^[17] тийш чиглүүлдэг.

Чөлөөт нийгэмд хувь хүмүүс зөвхөн өөрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх тухай бодох болно гэсэн айдас дээрхийн адилаар буруу зүйл. Хүмүүн төрөлтөн бол нийгмийн бодгаль юм. Тэд үйл хийхдээ ашиг сонирхлыг нь анхаарч үздэг гэр бүл, найз нөхөд, хөршүүдтэйгээ цаанаасаа л ойр дотно байдаг. Хүмүүс найз нөхдийнхөө хүндлэл, сайхан сэтгэлийг машид хүсэмжилдэг, сайн хөрш гэсэн нэр нүүртэй байхыг эрхэмлэдэг. Тиймээс тэд сайн дураараа ингэж бусадтайгаа сайн харилцаатай байхын тулд өөрийн ашиг сонирхлоо дарж номхруулдаг. Ингэх үед нь энэ улс тэдэнд туслах улам их магадлалтай болох учраас тэдний ийм анхаарал халамж эргээд өгөөжөө өгөх болно.

Бид эрх чөлөө илүү ихтэй нийгэм^[18]д ийм зүйл гардаг болохыг харах боломжтой. Хувь хүний сайн санааны үйлээр дамжуулан бусдад, бүр огт танихгүй хүнд тусламж өгөх явдал эрх чөлөө илүү ихтэй нийгэмд эрх чөлөө багатай нийгмээ бодвол хамаагүй их байдаг – энэ байдал эрх чөлөө илүү ихтэй нийгэм нь зөвхөн илүү эд баялагтай байдаг учраас биш бас чөлөөт нийгэмд тулгаж ногдуулсан, нийгмийн үүрэг хариуцлагыг гэхээсээ илүүтэй сайн дурын үйлсийг илүү чухалчилдаг учраас гардаг ажээ.

Санал нийлсэн ёс журмын дагуу хамтран ажиллах

Бусадтай амжилттай хамтран ажиллахын тулд бид өөрсдийнхөө үйлдлийг урьдаас таамаглахуйц, итгэл даахуйц болгох хэрэгтэй. Хэрэв хүмүүс байнга л бодлоо өөрчилж, гэнэтийн байдлаар үйл хийж, амлалтаасаа буцдаг байвал хамтын ажиллагаа байх боломжгүй. Чөлөөт нийгэм бусдыг гэмтээж хохироохгүй л бол хувийн амьдралдаа өөрийн хүссэнээрээ үйл хөдлөл хийх боломж хүмүүст олгодог. Гэвч нийгмийн хамтын ажиллагаанд амин чухал

17 cooperation and collaboration

18 more-free societies

байдаг, үйл хөдлөл^[19]ийн зарим нэг төрлийг энэ нийгэм тууштай дэмждэг.

Жишээлбэл чөлөөт нийгэмд өмчлөл, өмчийн хяналт болон бусдад шилжүүлэх тухай хуульзүйн ёс журам^[20] бий. Энэ ёс журам хүмүүст өмч олж авах, үндсэн хөрөнгөд, жишээлбэл ирээдүйд амьдралыг нь сайжруулах, үйлдвэрлэлийг хялбар, хямд болгох амины орон сууц, үйлдвэр, тоног төхөөрөмжид бусад хүмүүст эсвэл албан тушаалтнуудад ашиглуулж мөлжүүлэхгүйгээр эсвэл дээрэмдүүлж тонуулах аюулгүйгээр хөрөнгө оруулах боломж олгодог. Эдгээр ёс журам ('өмчийн эрх')-ыг төр засаг зохиомжилж гаргаагүй харин тэдгээр нь зүгээр л [өөрөө-урган гарч] зуун зуун дамжин боловсорч хөгжжээ. Хүмүүсийн бусадтай харьцах явдлыг нь илүү аюулгүй болгож, үүнээс улбаалаад хамтын ажиллагааг илүү хялбар, илүү өгөөжтэй болгодог байхаар хуулийн бүтэц, арга ажиллагаа^[21]г бий болгож тоо томшгүй шүүх хурлаар хязгааргүй олон маргаанаар энэ ёс журмын хүч чадлын хязгаарыг шалгажээ.

Эрх чөлөө илүү ихтэй нийгэмд мөн нийгмийн эв зохицолтой хамтын ажиллагаанд мөн л амин чухал бусад олон ёс журам, хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх болдог. Ёс суртахууны ёс журмаар нийгмийн харилцаа холбоог хүн бүрд илүү хялбар болгодог хязгаарлалтуудыг тогтооно. Мөн хүмүүний харилцаанаас урт хугацаанд аажмаар ургаж хөгжсөн, зан харьцаа, найрсаг байдал, бизнесийн сайн дадал болох нийгмийн үйл хөдлөлийн нийтээр дагадаг стандарт^[22] гэж бий. Эрх чөлөө илүү ихтэй нийгэмд жирийн зүйл байдаг иймэрхүү өгөөжтэй хэм хэмжээг эрх чөлөө багатай улсад төр засаг нь дуурайн хуулбарлах хэцүү эсвэл боломжгүй ч байх бололцоотой.

19 *behaviour*

20 *legal rules*

21 *body of law and practice*

22 *general standards of social behaviour*

Чөлөөт нийгмийн иргэд мөн иргэний тодорхой суурь эрхтэй байдаг. Эдгээр эрхийн нарийн тодорхой хэлбэр янз бүр байж болох ч гэлээ хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр хэм хэмжээнд албадан хөдөлмөр эрхлэх, боолчлолоос ангид байх эрх чөлөө, гэмт үйлийнхээ төлөө эрүүдүүлэн шүүлгэхгүй буюу яргалуулж тамлуулахгүй эсвэл нийцээгүй шийтгэл хүлээхгүй байх эрх чөлөө багтана. Эдгээрт оюун санаа болон итгэл үнэмшл^[23]ийн эрх чөлөө багтдаг – энэ бол шашин шүтлэг, улстөрийн талаар өөрийн гэсэн үзэлтэй санаатай байх эрх чөлөө, аюул заналхийлэл, эсвэл мөрдүүлж мөшгүүлэхгүйгээр өөрийн шашныхаа зан үйлийг хийх эрх чөлөө, улстөрд оролцох эрх чөлөө юм. Тэдгээрт үг хэлэх эрх чөлөө^[24], өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө, өөрийн хүссэнээрээ мэдээлэл хийх, тайлбар хэлэх харилцаа холбооны буюу мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө^[25] (радио, зурагт, сонин, интернет үйлчилгээ) ордог. Эдгээрт өөрийн хүссэн хүмүүстэйгээ хурж цуглах, эвлэлдэн нэгдэх^[26] эрх чөлөө багтана. Тэдгээр эрх чөлөөнд хувь хүний нууц, бусад хүмүүс, ялангуяа засаг захиргаанаас нууцаар тагнаж мөрдөх, хянаж дагах явдлаас ангид байх эрх чөлөө багтдаг. Товчхондоо бол чөлөөт нийгэмд иргэд нь хүмүүсийн үзэл бодол, итгэл үнэмшил, амьдралын хэвмаяг, үйлдлийг хүлцэн тэвчдэг, мөн тэр хүмүүсийн амьдралд хөндлөнгөөс оролцохгүй, үл хохироох ёс журмыг сахиж мөрдөх болно.

Шударга ёс, хууль ёс^[27]

Чөлөөт нийгэмд мөн шударга ёсны ёс журам^[28] бий. Бусад хүмүүсийг гэмтээж хохироох, мөн биед учруулах гэмтлээр

23 *conscience and belief*

24 *freedom of speech*

25 *freedom of the communications media*

26 *freedom to assemble and associate*

27 *Justice and the rule of law* - Хууль + ёс журам = хууль ёс (СЭХ-сондгойруулахгүйг Эрхэмлэх Хууль)

28 *rules of justice*

зогсохгүй бас хууран мэхлэлт, бусад хор хохиролд шийтгэл оногдуулдаг. Магадгүй хамгийн чухал зүйл чөлөөт нийгэмд хууль ёсыг баримталдаг явдал байх боломжтой. Улстөрийн зохион байгуулалтын гол зовлон бэрхшээл бол хэрхэн удирдагчаа сонгох биш харин дараа нь хэрхэн тэднээ хязгаарлах вэ гэсэн асуудал юм. Удирдагчаа сонгох нь хялбар байх болно. Чөлөөт нийгэмд төр засгийн засаг захиргааны үүрэг, эрх мэдлийг нарийн чанд хязгаарласан байдаг. Энэ байдал засаг захиргаанд өгсөн, иргэдийг гаднын халдлагаас хамгаалах, муу үйлийг шийтгэх эрх мэдлийг дур зоргоороо ашиглах, эсвэл ийм эрх мэдэлтэй хүмүүс өөрийн-тусын төлөө эдгээрийг ашиглахгүй байх явдлыг баталгаажуулдаг.

Чөлөөт нийгэмд албаны эрх мэдлийг хязгаарлахын тулд сонгуулийн хууль, үндсэн хууль, эрх мэдлийг зааглаж хуваах^[29] зэрэг олон янзын төрөл бүрийн механизм хөгжүүлдэг. Гэвч удирдагчдадаа ашиглуулж мөлжүүлэхээс иргэдийг хамгаалах хамгийн гол арга зам бол хүн бүрд хууль тэгш үйлчлэх явдлыг баталгаатай болгох явдал юм. Үүнийг хууль ёс гэдэг. Энэ зарчим дор төр засаг тодорхой овог аймагт таатай зүйл эсвэл давуу эрхийн төлөө, жишээлбэл бас нийгмийн тодорхой бүлэгт татвар ногдуулах талаар санал хураах боломжгүй. Хуулийг төр засагт ч мөн олон нийтэд ч хэрэглэнэ.

Эдгээр хуулийг албадан хэрэгжүүлэх явдалд үүнтэй ижил зүйл хэрэгжинэ. Шүүх эрх мэдлийг ялгаварлалгүйгээр ашиглах, дур зоргоороо ашиглахгүй байх явдлыг бататгахын тулд шударга ёсны ёс журмыг чөлөөт нийгэмд ижил тэгш хэрэглэдэг. Шүүх тэдэнтэй ижил тэгш харьцах, мөн шүүхийн зохих арга ажиллагаа^[30]г авах эрх иргэдэд бий. Үүнд нь дур зоргоор баривчлагдахгүй байх, шүүх ажиллагаагүйгээр хоригдохгүй байх, баримт нотолгооны ёс журм^[31]ын дагуу шударгаар шүүгдэх^[32], томилогдсон албан

29 *separation of powers*

30 *equal treatment and due processes of justice*

31 *rules of evidence*

32 *fair trial*

тушаалтан гэхээсээ илүүтэй жирийн иргэдийн төлөөлөгчд^[33] өөр цэгнүүлж дэнслүүлэх, нэг ижил гэмт хэрэгт дахин дахин шийтгүүлж татагдахгүй байх явдал багтана.

Улстөрч, албан тушаалтан, шүүгчдэд тавьсан энэ бүх хязгаарлалтын үр нөлөө засаг захиргааны эрх мэдлийг буруугаар ашиглах явдлыг сарниулж хүчгүй болгох, тусгай давуу эрхийг ганхуулах, албадлагын муу үйлийг бууруулах явдал байх болно. Эцсийн эцэст чөлөөт нийгэм дэх төр засгийн үүрэг нөлөө хувь хүмүүсийн эрх чөлөөг хумьж багасгах бус харин эрх чөлөөг нь өргөжүүлж тэлэх явдал байдаг.

Эрх чөлөөг дэмждэг эдийн засгийн гаргалгаа нотолгоо

Амьжиргааны төвшин ихээр өсөв

1750-аад он хүртэл хүмүүний амьдралд нэг их өөрчлөлт гарсангүй. Бараг хүн бүр л гадаа газар тариаланд ажиллаж, хүнс тариалах хүнд хүчир, тогтворгүй, цаг агаараас хамаарсан үйл ажиллагаанд л оролцож байлаа. Тэр цагийн хөдөө аж ахуйд хэрэглэдэг арга барил бүр дээр үеийн фараоны үеийнхтэй л адилхан байв. Ихэнхи хүмүүст хувцас зэрэг тансаглалд зориулах илүү мөнгө байсангүй. Хэдхэн нь л мах идэхтэйгээ байлаа. Баян хүмүүс нь эд баялагт умбан төрсөн цор ганц хүмүүс л байсан. Тэр эд баялаг өөрийн ашиг тусын төлөө тариачин хүн амаа татварлах эрх мэдлээс эсвэл тэр эрх мэдэлтэй хэн нэгний шадар туслах эсвэл найз нөхөд байх явдлаас үүсэлтэй байв.

Ихэнхи хүмүүс үгээгүй ядуу амьдарч байлаа. Эдийн засагч Дийрдр МакКлоски^[34] 1800 онд дэлхийн дундаж иргэний орлого өдрийн \$1-ээс \$5-ийн хооронд, өнөөгийн дэлхийн ихэнхи нийслэлүүдийн аяга кофе ч хүрэхгүй байсныг тооцоолжээ.^[35]

33 *jury of ordinary citizens*

34 *Deirdre McCloskey*-Чикаго дахь Иллинойсын Их Сургуулийн эдийн засгийн ухааны профессор (1942 онд төрсөн)

35 *Deirdre N. McCloskey*, 'Liberty and dignity explain the modern world', in *Tom G. Palmer (ed.), The Morality of Capitalism, Students for Liberty and Atlas*

Одоо дэлхийн дундаж орлого өдрийн бараг л \$50 болсон. Энэ бол хөгжил цэцэглэлтэд гарсан асар том дэвшил юм.

Гэвч энэ бол зөвхөн дэлхийн дундаж хэмжээ бөгөөд энэ нь зарим улсын хүрч чадсан, үлдсэн улс нь хүрч чадаагүй хөгжил цэцэглэлтийн өнгийг л харуулдаг. Дэлхийн эрх чөлөө хамгийн багатай улсын нэг болох Тажикстанд дундаж орлого өдрийн \$7-оос дөнгөж илүү гарч байна. Гэвч дэлхийн хамгийн их эрх чөлөөтэй улсын нэг болох Америкийн Нэгдсэн Улсад энэ нь одоо өдрийн \$100-оос их байна. Америкчууд өнөөдөр Тажикчуудаас арвандөрөв дахин баян, 1800 оны өвөг дээдсээсээ 20-оос 100 дахин баян байгаа нь эрх чөлөөний үр өгөөж билээ. Эдийн Засгийн Эрх Чөлөөний Дэлхийн Тайланд дэлхийн хамгийн эрх чөлөөтэй улсуудын дунд бүгд байдаг Швейцар, Австрали, Канад, Нэгдсэн Хаант Улсад дундаж орлого өдрийн \$90-оос их байдаг. Эрх чөлөө, хөгжил цэцэглэлт хамтдаа л явдаг аж.^[36]

Тийм учраас хүмүүс ядуу, эрх чөлөө багатай улсуудаа орхин, баян, эрх чөлөө илүү ихтэй улс руу цагаачилдаг. Жил бүр эрх чөлөө хамгийн багатай 20 улсад 1000 хүн тутамд ногдох тухайн улсад ирж амьдарч байгаа хүмүүсийн тооноос гадагшаа явж амьдарч буй хүний тоо 1.12-ээр илүү байгааг харах болно. Үүнээс ялгаатай нь эрх чөлөө хамгийн ихтэй 20 улсад 1000 хүн тутамд ногдох гадагшаа явж буй хүмүүсээс тэдгээр улс руу ирж амьдарч байгаа хүний тоо 3.81 хүнээр илүү гарч буйг харах болно.^[37] Эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй тэдгээр 20 улсад цэвэр цагаачлал хамгийн их байгааг харах болно. Дунджаар эрх чөлөөний хэмжих хуваарийн доод хагас дахь улсууд иргэдээ алдаж байхад харин дээд хагаст нь байдаг улсууд цагаачид хүлээн авч байв.

Foundation, Arlington, VA, 2011.-БАТЛЕР.

36 *Fraser Institute, Economic Freedom of the World 2012 Annual Report, Fraser Institute, Vancouver, BC, 2012.-БАТЛЕР-Статистик мэдээллийг 1000 хүнд ногдох тоогоор илэрхийлэх ёс бий.*

37 *Gabriel Openshaw, 'Free markets and social welfare', Mises Daily, 4 October 2005, http://www.mises.org/daily/1915#_edn2.-БАТЛЕР*

Өөрөөр хэлбэл хүмүүс хөлөөрөө эрх чөлөөний төлөө саналаа өгч байна. Чөлөөт бус улсууд хүмүүсээ гадагш цагаачлахаас нь сэргийлэхээр, харин илүү их эрх чөлөөтэй улсууд цагаачилж ирэх явдлыг хамаг сайнаараа хориглохоор оролдож буй ч тэд гадагш цагаачилсаар л байна.

Эрх чөлөө, буяны үйлс

Өөрийн ядуусаа мөлжиж ашиглах явдал чөлөөт улс орнуудыг баян болгоогүй. Оросын ёс суртахууны философич Леонид Никонов хамгийн их эрх чөлөөтэй болон хамгийн бага эрх чөлөөтэй улсын хүн амын хамгийн ядуу 10 хувьд очих үндэстний орлогын дундаж хувь хэмжээ бараг л адилхан байсныг ажиглаж мэдсэн байдаг (дурдсан дарааллаар 2.58 хувь, 2.47 хувь байжээ). Гэвч баян улсад ядуу (хамгийн ядуу 10 хувь нь дунджаар өдрийн \$23 олж байв) байх нь ядуу улсад ядуу байх (хамгийн ядуу хамгийн 10 хувь дөнгөж өдрийн \$2.50 олж байв)-аас хамаагүй дээр байсаар л байгааг судалж гаргажээ.^[38]

Эрх чөлөөт, баян улсуудын эд баялаг хүмүүст илүү их нээлттэй байдаг. Энэ улсуудын хамгийн ядуу иргэд ч баян болж чадна – энэ нь чөлөөт бус улсад зөв гэр бүл, каст, арьстан эсвэл шашинтай бол, эсвэл улстөрийн бүлгийн-гаралгүй биш л бол баян болох боломжгүй байдагтай адилгүй зүйл юм. Эрх чөлөө илүү ихтэй улсуудад нийгмийн шилжилт хөдөлгөөн^[39] хамгийн их байдаг. Дэлхийн хамгийн баян хүн, Майкрософтыг үндэслэгч Билл Гейтс гараждаа програмын бизнесээ эхлүүлсэн.

Одоо Гейтс өөрийн бүх хөрөнгөө сайн үйлсэд өгөхөөр зорьж байна. Дараахь зүйл бүхэлдээ ижилхэн байдаг: хувийн буяны үйлс илүү баян улсад хамаагүй их байдаг. Барклэйс Вэйлф гэсэн газраас явуулсан судалгаанд хамгийн баян Америкчуудын 40

38 Leonid Nikonov, 'The moral logic of equality and inequality in market society', in Tom G. Palmer (ed.), *The Morality of Capitalism, Students for Liberty and Atlas Foundation, Arlington, VA, 2011.* -БАТЛЕП

39 social mobility-энэ нь нийгмийн анги хооронд шилжих явдлыг хэлдэг

хувь мөнгөө зарцуулахдаа чухалчилж үздэг гурван зүйлийн нэг нь буяны үйлсэд өгөх явдал гэж тайлагнажээ.^[40]

НХУ-ын Чаритис Эйд Сангийн судалгаагаар мөнгө болон өөрийн цагаа буяны үйлст зориулах хамгийн магадлалтай таван улсад, бүгд эрх чөлөөгөөр хамгийн дээд зэрэгтэй байдаг Австрали, Ирланд, Канад, Шинэ Зиланд, Америкийн Нэгдсэн Улс оржээ.^[41] Эдгээр улс ядуу, эрх чөлөө илүү багатай улсуудаа бодвол бусдад өгөх илүү их эд баялагтай.

Эрх чөлөө ялгаварлан гадуурхах явдалтай тэмцдэг

Чөлөөт бус улсад ялгаварлан гадуурхах явдал өргөжин тэлдэг. Хэрэв та нар зөв нийгмийн анги, каст, шашин, хүйс, эсвэл гэр бүлд байгаагүй бол сайн ажил олоход хүнд байх боломжтой. Гэвч чөлөөт зах зээлийн эдийн засаг ялгаварлан гадуурхах явдлыг шахан зайлуулна. Чөлөөт нийгэм дэх үйлдвэрлэгчид хэнтэй арилжаа хийх эсвэл хэнийг ажилд авахаа шийдэх үедээ ялгаварлан гадуурхах үйл явуулж дийлэхгүй.^[42]

Жишээлбэл ажил олгогчид цагаачдад, ялангуяа тэр цагаач өөр соёл, арьстан эсвэл шашинтай бол дургүй байх боломжтой. Гэвч хаа сайгүй байдагчлан цагаачдын бүлэг нэг ижил ажлын төлөө илүү бага цалин авч үүнд нь хариуг нь голдуу барьдаг. Тэр үед зөвхөн уугуул иргэн ажилд авч ялгаварлан гадуурхдаг ажил олгогч өөрийгөө өрсөлдөөнд ялагдсан^[43] мэт санана. Тэдний цалингийн цэс цагаачдыг ажилд авахыг хүсдэг өрсөлдөгчдийнхөөсөө илүү их байх болно. Тэдний ашиг багасаж, эсвэл тэд их үнээр бараагаа зарж, худалдаагаа алдах эрсдэлтэй болно. Энэ байдал

40 *Barclays Wealth, Global Giving: The Culture of Philanthropy, London, 2010.*-БАТЛЕР

41 *Charities Aid Foundation, World Giving Index 2012, Charities Aid Foundation, West Malling, 2012.*-БАТЛЕР

42 Энэ санааны сайн тайлбарыг Milton Friedman and Rose Friedman, *Capitalism and Freedom, University of Chicago Press, Chicago, IL, 1962* гэсэн бүтээлээс харна уу..-БАТЛЕР

43 *competitive disadvantage*

бизнес т муу зүйл. Ажил олгогчийн арилжааны ашиг сонирхолд ялгаварлан гадуурхах явдал зүгээр л үл нийцнэ.

Гарах асуулт: Чөлөөт нийгэм зүгээр л мугуйд, материалист шинжтэй байдаг бус уу?

Үгүй. Эдийн засгийн эрх чөлөө хүмүүст сонголт, бололцоо өгдөг. Энэ эрх чөлөө хүмүүсийн суурь хэрэгцээг, хоол хүнс, гэр орон, хувцас хунараар бусад өөр зүйлээс хамаагүй илүү хангадаг. Энэ нь хүмүүст чөлөөт худалдаа, зах зээл өндийж босохоос өмнө зүүдлэх ч боломжгүй байсан бололцоо олгодог. Хүмүүсийг насаараа хүнд хөдөлмөр эрхлэх, дорд ажил хийж зовохын оронд энэ эрх чөлөө хүмүүст аялал жуулчлал, урлаг, соёл, нийгмийн арга хэмжээ зэрэг илүү сэтгэл сэргээсэн гэж үздэг зүйлсээ эдэлж таашаах боломж олгодог. Энэ эрх чөлөө хүмүүст эрүүлмэндийн зохих үйлчилгээ^[1] авах, илүү сайн боловсролтой болох боломж олгодог.

Эд баялаг бол бид жинхэнээсээ үнэлж цэнэдэг, зөвхөн бидний материаллаг тав тухаар зогсохгүй бас соёлын болон нийгмийн хувьд үнэлж цэнэдэг зүйлтэй болох зүгээр л багаж хэрэгсэл юм. Энэ бол яагаад илүү баян, эрх чөлөө-илүү ихтэй улсад илүү олон спортын стадион, концертын танхим, театр, их сургууль, номын-сан, музей байдгийн шалтгаан юм.

1 *proper healthcare*

Бүр дотоодын ажиллах хүчээрээ чөлөөт зах зээлийн эдийн засаг ялгаварлан гадуурхах явдлыг шахан зайлуулдаг. Жишээлбэл эмэгтэйчүүд ажил хийхийн эсрэг соёл байдаг нь тэднийг ажил олоход хэцүү болгодог байж болно. Гэвч эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхдаг ажил олгогч ингэдэггүй өрсөлдөгчдөө бодвол найдвар тавих цөөн авьяастантай байх болно. Өөр нэг сонирхолтой жишээ бол Энэтхэгийг хуваадаг кастын тогтолцоо юм. Хидерабад зэрэг өндөр-технологийн төвүүд үүсэж хөгжсөн

явдал Энэтхэгийн доод-кастын ажилчид ажил эрхлэх хэтийн төлөвийг улам таатай болгожээ. Өрсөлдөөнтэй энэхүү салбарын ажил олгогчдод уураг тархи болсон хүмүүсийн хэрэгцээ их байдаг. Тэд каст эсвэл бусад аливаа соёлын шалгуурт үндэслэж ялгаварлан гадуурхаж зүрхлэхгүй. Олон арван жил ялгаварлан гадуурхахын эсрэг хуулиар хийж чадаагүй зүйлийг бизнесийн хүмүүсийн өөрийн-тусыг бодох жирийн явдал л хэдхэн жилийн дотор амжуулав.

Чөлөөт хүмүүсийн бүтээлч байдал

Эрх чөлөө-илүү ихтэй эдийн засгууд яагаад илүү баян байдгийн нэг шалтгаан бол ийм эдийн засаг байгаа бүх авьяас чадвартай хүмүүсээ ашигладаг явдал юм. Шахан зайлуулах учиртай ялгаварлал гадуурхалт бага байхад чөлөөт нийгмийн бүх иргэд ухаанаа шавхах, чадвараа ашиглах нь чөлөөтэй байдаг. Хэрэв тэд бусад хүмүүсийн амьдралыг сайхан болгох бараа бүтээгдэхүүн бүтээж, сайжруулж, ханган нийлүүлж байвал тэр хүмүүс бараа бүтээгдэхүүнийг нь худалдан авч тэднийг шагнах болно. Тиймээс л чөлөөт нийгэм илүү бүтээлч, илүү их шинийг санаачлагч, үүнээс улбаалаад илүү хурдан хөгждөг.

Эдийн засгийн эрх чөлөө хүмүүсийн өөрийн-тусыг бодох явдлыг нийгмийн хувьд үр өгөөжтэй байх чиглэл рүү хандуулдаг. Та бүхэн бусад хүмүүсийн хүсэж байгаа, түүнийхээ төлөө танд мөнгө төлөхөд бэлэн байгаа зүйлийг нь үйлдвэрлэж мөнгө олно. Та нар тэднийг илүү ихийг буцаж ирж аваасай, та бүхний хэр сайн болохыг бүх найздаа хэлээсэй гэж хүсэх болно. Энэ байдал үйлдвэрлэгчдийг өөрсдөдөө гэхээсээ илүүтэй хэрэглэгчдэдээ маш их анхаарал тавихад хүргэдэг. Эрх чөлөө илүү ихтэй нийгмийн бизнесийн ихэнхи алдартай хүмүүс тэд бизнесээ хэрэглэгчдээсээ аль болох их ашиг салгаж авахыг оролдох гэлгүй харин хэрэглэгчдийнхээ хүсэл, хэрэгцээнд илүү анхаарал хандуулж амжилттай босгосон гэж хэлцгээдэг.

Энэхүү бодит байдал чөлөөт эдийн засгийн талаархи “нохой нохойгоо барьдаг”^[44] гэсэн хошин зургаас маш ондоо зүйл юм. Жинхэнэ чөлөөт эдийн засаг албадлага дээр биш харин чөлөөт хүмүүсийн сайн дурын арилжаа худалдаа, солилцоонд үндэслэсэн, маш ихээр хамтран ажиллуулалттай тогтолцоо ажээ.

Хөрөнгө бүтээх

Шинэ санаа шинэчлэл болон хэрэглэгчдэд үйлчлэх явдлыг тэтгэж сайжруулахаас гадна чөлөөт эдийн засаг бүтээлч хөрөнгө^[45] бүрдүүлж бий болгох замаар баян болдог. Загас гараараа барихаас тороор барих хамаагүй илүү хялбар ч энэ нь та нар тороо хийх үедээ цөөхөн загас барина гэсэн үг юм. Хэрэглээгээ багасгаж байж^[46] та нар хөрөнгө бүрдүүлнэ, ирээдүйн үйлдвэрлэлийг илүү үр ашигтай болгож чадна.

Энэ байдал бол капитализмын үндэс юм. Хүмүүс амьдралыг нь хөнгөвчлөх, хөдөлмөрийг нь илүү бүтээлч болгох байр сууц, үйлдвэр, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийг бий болгодог (голдуу хамаагүй илүү бүтээлч байдаг: тариалангийн газарт трактороор тариа ногоо тарих хүчин чармайлт болон гар анжсаар тарихын хоорондох ялгааг бодож үзнэ үү). Энэ үйл явц хурааж хуримтлуулалттай үйл явц^[47] байдаг: бүтээлч технологид ямар нэг зүйл нэмэгдэх, сайжрах бүрд үйлдвэрлэл улам бүр өргөжин хурдсаж, [гаргах] хүчин чармайлт нь буурна.

Чөлөөт нийгэм ийм бүтээлч хөрөнгийг хуримтлуулж чадах бөгөөд энэ нийгэм хүмүүст улс хураан авах, эсвэл бусад хүн хулгайлан авах айдасгүйгээр байр сууц, үйлдвэр, тоног

44 *Dog eat dog*-Энэ хэллэгийг бусад хүн амжилтад хүрч болох нөхцөл таалагдахгүй байгааг, мөн амжилтад хүрэхийн тулд бусад хүмүүсийг хохироохыг хүсэж буйг илэрхийлэхэд ашигладаг.

45 *productive capital*

46 *forgoing consumption*

47 *cumulative*

төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө өмчлөх бололцоо өгсөн учраас л үр бүтээлч байдлаа, хөгжил цэцэглэлтээ нэмэгдүүлсээр байдаг. Энэ нийгэмд хүмүүсийн өмчийг хураан авах явдлаас хамгаалдаг, мөн хулгайлах явдлыг бараг боломжгүй болгодог өмч өмчлөх явдалтай холбоотой ёс суртахуун болон хуульзүйн ёс журам^[48] бий.

Хууль болон соёлоор дамжуулж өмч өмчлөх явдлыг хамгаалах энэхүү хамгаалалт бол чөлөөт нийгэм болон чөлөөт зах зээлийн маш чухал хэвшинж юм. Эцсийн эцэст хэрэв ургацыг нь дээрэмчид хулгайлж булаан авах магадлалтай гэж тэд бодож байвал хэдхэн тариаланч л үр тариа суулгаж, тарьж ургуулан, соёолуулж, хөрсөө арчлах болно. Үүний адилаар хэрэв тэдний орлогын ихэнхийг нь татвараар авчихдаг бол тэдний хэдхэн л ажиллах болов уу. Гэр бүлүүд хэрэв инфляц буюу үнийн хөөрөгдлийн далд татвараар мөнгийг хууран авчихдаг бол мөнгөө хадгалж хураахгүй. Ажил хэрэгч хүмүүс хэрэв эд хөрөнгийг нь ямар нэг нөхөн төлбөргүйгээр улсад хураан авч нийгэмчлэх^[49] боломжтой бол бизнестээ хөрөнгө оруулах нь юу л бол. Тал засдаг хэдхэн элит буюу дээд ангийнханд ашиг тус хүртээн зах зээлийг муутгаж гажуудуулдаг давуу эрхээс болж өөр хэн нэгэн хүн шинэ бизнес эхлүүлэхээр оролдох магадлал буурдаг.

Хулгайч дээрэмчид эсвэл төр засгийн ийм мөлжлөг шамшигдуулалт илүү их байх тусам хөдөлмөрлөх, хадгалж хураах, хөгжиж дэвжих явдлыг эсэргүүцдэг саатуулж хоригч хүчин зүйл асар их байна. Арвандөрөвдүгээр зууны Исламын эрдэмтэн, хуульч Ибн Халдун^[50] энэхүү санааг маш сайн ойлгож байжээ. Тэрбээр дараахь зүйлийг бичсэн:

48 *moral and legal rules*

49 *nationalised*

50 *Ibn Khaldun - Энэ хүн Араб үндэстэн, социологич, философич, түүхч. Дундад Зууны нийгмийн ухааны аугаа эрдэмтний нэг бөгөөд түүнийг хистографи, социологи, эдийн засаг, демографийн судалгааг үндэслэгч гэж үздэг.*

Хүмүүсийн өмч рүү халдах явдал өмч олж авах,
өмчтэй болох хүсэл тэмүүллийг унтраадаг гэдгийг
мэдвэл зохино. Тэр үед хүмүүс өмчтэй болох зорилго,
цор ганц хувь тавиланг нь тэднээс булаан авлаа гэж
бодох болно. Өмч олж авах, өмчтэй болох хүсэл
санаачилга алга болоход хүмүүс өмчтэй болох
ямар ч чармайлтгүй болно. Өмчийн эрхийг зөрчиж
халдаж буй хэмжээ далайц, цар хүрээ нь тухайн
улсын харьяатуудын өмчтэй болох хүчин чармайлтыг
сулруулах далайц, цар хүрээг тодорхойлдог.^[51]

Өмч болон хөгжил дэвшил

Гэвч өмч өмчлөх эрхийг тань баталгаажуулах явдал ирээдүйнхээ эзэн, гэр бүлийнхээ бас ирээдүйн эзэн нь байх боломж өгдөг. Жишээлбэл хэрэв та нар олон улсад ихэнхи иргэд эдэлж чаддаггүй өөрийн гэсэн гэр орон өмчлөх боломжтой байвал өөрийн амьдралаараа амьдрах аюулгүй ямар нэг газар оронтой байх болно. Баян элит буюу дээд ангийнхны өршөөл ивээлд үргэлж байхын оронд бизнесээ эхлэхийн тулд зээл авахад хэрэглэх, мөн бүтээлч хөрөнгө цуглуулж бий болгоход хэрэглэж болох хөрөнгө мөн та бүхэнд байна. Энэ өмч танд шинэ зүйл турших, жишээлбэл ажлаасаа гарч шинэ ажил хайх, эсвэл шинэ бизнесийн ажлаа санхүүжүүлэх боломж олгодог санхүүгийн хамгаалалт болно.

Өмчийн баталгаатай өмчлөл^[52] хүмүүний бүтээлч байдлыг нэмэгдүүлж улмаар эд баялаг өсгөдөг, бас мэргэжил төрөлжиж нарийн болох явдал, арилжаа худалдааг тэтгэдэг. Бидний амьдрал хэрэв бид өөрөө өөрсдийнхөө бүх зүйлийг хийдэг байсан бол, идэх хоол хүнсээ ургуулдаг, усаа өөрөө гаргаж авдаг, хэрэглэх түлээ түлшээ бэлддэг, өмсөх хувцсаа өөрөө урлаж оёдог, өөрийн гэр орноо өөрөө барьж бүтээдэг эсвэл бусдын дайралтаас өөрөө

51 Ibn Khaldun, *Muqaddimah: An Introduction to History*, 1377.-БАТЛЕП

52 *Secure property ownership*

өөрийгөө хамгаалдаг байсан сан бол маш ядуу байх байлаа. Бидний хэдхэн л энэ бүх зүйлийг хийх авьяас чадвартай бөгөөд бидэнд энэ бүгдийг хийхэд хялбархан ашиглах, үр өгөөжтэй зөв багаж зэмсэг хэрэгтэй болно. Гэвч хэрэв хүмүүсийн өмч өмчлөх эрхийг хүндэлдэг бол бид бүх зүйлийг өөрөө хийх шаардлагагүй. Хүмүүс нэг ажлыг маш үр дүнтэй хийхэд тэдэнд шаардлагатай тусгай багаж хэрэгслийг бүтээж чадах бөгөөд энэ бараа бүтээгдэхүүнээ үлдсэн бид бүгдэд дараагаар нь зарна. Өөрийн аж ахуй эрхлэгч тариаланч анжис, трактор авахад хөрөнгөө зарах бол харин байшин барьдаг хүн шат, хүрз авахад, оёдолчин даавуу болон оёдлын машин авахад хөрөнгө оруулалт хийнэ. Тэр хүмүүс бүхнийг хийж өөрийгөө болгодог сонирхогч хүн өөрийгөө болно гэж найдаж ч байгаагүйгээр өөрийн мэргэжилдээ улам бүр чадварлаг болох, мөн үйлдвэрлэлийнхээ илүү сайн менежер болох боломжтой. Хөдөлмөрийн энэхүү төрөлжилтөөр дамжин бид улам бүр л чанартай бараа бүтээгдэхүүнийг илүү бага үнээр авч илүү элбэг сайхан амьдардаг.

Гэвч дахиад хэрэв бүтээлч хөрөнгө бүрдүүлж бий болгох, арилжаа худалдаанд оролцох, өөрсдийг нь дээрэмдэхгүй эсвэл хуурч мэхлэхгүй гэдэгт итгэлтэй байхаар хангалттай аюулгүй байдалд хүмүүс байвал л энэ бүхэн боломжтой байдаг. Ингэж чадахгүй бол амьдрал баргар л байна. Ибн Халдун дараахь байдлаар үргэлжлүүлэн өгүүлжээ:

‘Хүмүүс амьжиргаагаа болгох гэж ажил хэргээ үйлдэхээ болчихвол, тэд бүх үр өгөөжтэй үйл үйлдлээ зогсоочихвол иргэншлийн үйл хэрэг унаж, бүх зүйл нурна. Хүмүүс өнөөгийн төр засгийнхаа хамрах хүрээ^[53] ний гадна үлдэж идэш хоол хайн хаа сайгүй тарж бэдэрнэ.’

Энэ байдал бол чөлөөт-бус улсаас эрх чөлөө илүү ихтэй улс руу урсаж буй цагаачлалаас тод харагддаг тэр зүйл юм.

53 jurisdiction-

Хэний ч хүч хөдөлмөрөөр бус өөрөө эд баялаг бүтээх

Зарим хүмүүс хэн нэгэн хүний өмч зөвхөн өөр нэг хүний хүч хөдөлмөрөөс үүсдэг гэж төсөөлдөг. Энэ нь үнэндээ тийм биш. Чөлөөт эдийн засаг хөгжил цэцэглэлт цогцлоож, одоо буй өмчийн үнэ цэнийг нэмдэг.

Үнэ цэнэ бол аливаа зүйлийн бодит чанар биш. Энэ нь хүмүүс тэр зүйлийн тухай юу гэж бодож буй байдал юм. Бараа үйлчилгээ худалдагч хүн эдгээрээ хэрэглэгчийн бэлэн мөнгөнөөс илүү бага үнэлж буй учраас тэдгээрээ зарж тэдгээрээсээ хагацдаг. Хэрэглэгч харин худалдаж авч буй бараа бүтээгдэхүүнээ эдгээрийн төлөө төлж буй мөнгөнөөсөө илүү үнэлж буй учраас бэлэн мөнгөнөөсөө салдаг. Бүр сургуулийн хүүхэд ч нэг бүр уйдсан зүйлээрээ хүсэж буй зүйлээ солилцох нь ашигтай байна гэж тооцсон учраас тоглоомоо хоорондоо солилцдог. Тэдний солилцоо үнэ цэнэ бүтээжээ. Хэн ч иймэрхүү арилжаа худалдаанаас сэтгэл дундуур үлдэхгүй: үнэндээ аль нэг тал нь хэрэв тэд үүнээс алдаж хохирох болно гэж бодвол энэ хэлцлийг хүлээн зөвшөөрөхгүй.

Үүнтэй адилаар хэрэв хэн ч өмнө нь ингэж байгаагүй газарт үр суулгаж, тариа ногоо ургуулбал, бас бусад хүмүүс тэр бараа таваарыг нь худалдаж авахыг хүсэж байвал энэ ногоо тарьсан хүмүүс өмнө нь өгөөжгүй байсан ямар нэг зүйлээс шинэ үнэ цэнэ гарган авч буй нь тэр. Эд баялаг бүтээж бий болгосон ч хэнийг ч дээрэмдэж тоносонгүй.

Дахиад хэрэв ажил хэрэгч хүн хүмүүсийн худалдаж авахыг хүсэж буй гутал, эсвэл хувцас, эсвэл машин эсвэл ямар нэг шинэ бүтээл үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулаад тэр үйл ажиллагаанаасаа мөнгө олбол тэр хэн нэгнийг дээрэмдчихэж байгаа хэрэг үү? Тэд асар их баялаг хуримтлуулах боломжтой ч тэд хэнээс ч юуг нь ч дээрэмдсэнгүй, булаасангүй. Үүний эсрэгээр тэд өмнө нь байгаагүй үнэ цэнэ бүтээж, бий болгон, тарааж түгээжээ.^[54]

54 Энэ санааг НХУ-ын бизнесмэн Эрхэм Эрнест Бенн дараахь бүтээлд

Чөлөөт нийгэм бол амин найзуудын капитализм^[55] биш

Зарим хүмүүс капитализмд баян корпорацын ашиг сонирхол ядуусыг ашиглаж мөлждөг, харин улстөрчид бизнесийн найз нөхдөдөө монополь байдал, давуу эрх, баталгаа олгох, татаас олгох замаар олон нийтийн эд баялгийг ашиглаж шамшигдуулдаг гэж батлан өгүүлдэг.

Гэвч жинхэнээсээ чөлөөт нийгэмд мөлжиж ашиглах явдал, “амин найзуудын капитализм” байх боломжгүй. Бизнес оршин тогтнох явдал хэрэглэгчдээс нь хамаардаг. Хэрэв тэд нар сайн үйлчилгээ үзүүлэхгүй бол хэрэглэгчид нь өөр нийлүүлэгчид рүү явах болно. Чөлөөт нийгмийн төр засагт монополь байдал үүсгэх, тодорхой компанийг хамгаалах, эсвэл хүмүүсийг шинэ бизнес үүсгэж байгуулахаас нь хориглох эрх мэдэл байдаггүй учраас ийм нийгэмд үргэлж байж болох тооны ханган нийлүүлэгч байх болно. Жинхэнэ чөлөөт нийгэмд өрсөлдөөн үргэлж байна: компаниуд хэрэв хүмүүсийн хүсэж буй бүтээгдэхүүнийг, үнэ-чанар нь нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй бол бизнесээс арчигдах болно. Зарим компаниуд, жишээлбэл, маш их хөрөнгө оруулалт шаардлагатай хөнгөн тэрэг үйлдвэрлэх салбарт нилээд том хэмжээтэй болох боломжтой. Гэвч тэд илүү сайн зүйл хийж чадна гэж бодсон бусад том хөрөнгө оруулагчдаас үзүүлэх бодит эсвэл байж болох өрсөлдөөнтэй нүүр тулах болно. Асуудал бэрхшээл засаг захиргаа өрсөлдөөнийг үгүй хийх, шинэ өрсөлдөгчийг орж ирэх явдлыг хэцүү хүндрэлтэй болгох эсвэл орж ирэхээс нь сэргийлэхэд л эхлэх болно.

Мэдээжээр жинхэнээсээ нээлттэй өрсөлдөөнийг сахин хамгаалах хэцүү. Бүр өнөөгийн дэлхийн хамгийн их эрх чөлөөтэй нийгэмд ч улстөрчид голдуу санамсаргүйгээр өрсөлдөөнийг бууруулж, улмаар хэрэглэгчид үйлдвэрлэгчдийг захирдаг эрх мэдлийг сулруулдаг ёс журам, дүрэм журам гаргадаг.

сайн тайлбарласан: Why Freedom Works, Sir Ernest Benn Ltd, London, 1964.-БАТЛЕР

55 crony capitalism-тэжээврийн капитализм гэхээс дээр санагдав.

Үйлдвэрлэгчид бүгдээрээ ийм байдал үүсгэх гэж хэт олон удаа далдуур хуйвалдацгаадаг. Жишээлбэл нэгэнт үүсэж тогтчихсон компаниуд ямар зүйл үйлдвэрлэх, хэрхэн үйлдвэрлэх талаар тусгайлан заасан бүтээгдэхүүний чанарын талаархи зохицуулалт, үйлдвэрлэх стандарт гаргуулахаар улстөрчдийг хүчилж шахаж болно. Эдгээр ёс журам олон нийтийг муу чанартай бараа бүтээгдэхүүнээс хамгаалахад шаардлагатай гэж тэд батлан өгүүлж ч болно. Гэвч жинхэнэ санаа нь өөрсдийнхөө бизнесээ дүрэм журамд жагсаан бичээгүй шинэлэг арга замаар шинэлэг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж магадгүй шинэ эсвэл илүү жижиг нийлүүлэгчдээс хамгаалах явдал байдаг. Эсвэл дахиад л улстөрчид олон нийтийн мөнгийг дотоодын ажлын байрыг хамгаалах ёстой гэж батлан өгүүлж дампууралд орж буй эсвэл гадаад улсаас ирэх өрсөлдөөний аюулд орсон үйлдвэрлэлийг хамгаалж өмгөөлөх гэж хөндлөнгөөс оролцож болно. Тэр улстөрчид бүр гадаадын импортыг дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах гэж хориглож ч болно. Энэ нь эдгээр үйлдвэрлэлийн салбарт ажилладаг хүмүүст түр зуурын амсхийх чөлөө олгох боломжтой ч үүнийгээ татвар төлөгчид болон олон нийтийн хүч хөдөлмөрөөр хэрэгжүүлнэ. Ингэхдээ тэднийг сонголт багатай, илүү муу чанартай бараа бүтээгдэхүүнд төлөх ёстойгоосоо илүү их үнэ төлөхөд хүргэдэг.

Нийгэм эдийн засгийн эрх чөлөөнөөс улам холдож, оронд нь засаг захиргаанд эдийн засгийн эрх мэдэл улам л их батлан өгөх аваас хүмүүсийг өөрсдийн ашигтусын төлөө ашиглаж мөлжихийн тулд үйлдвэрлэгчид болон улстөрчид нууц хуйвалдаан зохион байгуулах хүрээ хязгаар улам л их болно. Ийм амин найзуудын капитализм^[56]ын ул мөрийг хаа сайгүй олж болох боловч энэ зовлон хамгийн бага эрх чөлөөтэй эдийн засагт хамгийн хүнд байдаг. Голдуу эрх мэдэлд хүрсэн хүмүүс эрх мэдлээ өөрсдийгөө болон гэр бүлээ, найз нөхдөө баяжуулахын тулд ашиглах болно гэдгийг гарцаагүй зүйл гэж үздэг. Хэрэв ийм зүйл хийхгүй бол тэднийг хулчгар гэж хүмүүс бодож ч болно.

56 *crony capitalism*

Гэвч жинхэнэ чөлөөт нийгэмд засаг захиргааг хууль тогтоох эрх мэдэл эсвэл татвар төлөгчдийн санг эдийн засгийн тусгай давуу эрх болгож амин найзуудынхаа бизнест өгөх явдалд ашиглахыг зөвшөөрдөггүй. Хэрхэн эрх мэдлээ ашиглах, олон нийтийн санг хаана зарцуулах тухай нарийн чанд ёс журам тэнд бий. Нэгэнт л ийм таатай зүйл баталгаажуулан олгох эрх дарх тэдэнд байхгүй учраас татаас авах болон хамгаалалттай болохын тулд засаг захиргаанд байгаа хүмүүсийг үйлдвэрлэгчид амжилттай лоббидох ч аргагүй.

Жирийн хүмүүсийг мөлжих ашиглах эрх мэдлийг компани болон улстөрчдөд олгож буй байдал бол эрх чөлөө байхгүй байгаа явдал болохоос энэ нь өрсөлдөөнт капитализмын буруу биш.

Эрх чөлөөний мандан бадрал

Хэдийгээр эдийн засгийн эрх чөлөө бүрэн дүүрэн, арилжаа худалдаа бүрэн чөлөөтэй байх нь ховор байгаа ч гэсэн тэдгээр нь сүүлийн 30 жилийн хугацаанд үгээгүй ядуу байдлаас 2 тэрбум хүнийг ангижруулж өндийлгөсөн гавьяатай билээ. Энэ байдал бол Орос, Хятад, Зүүн-өмнөд Азийн хүчирхэг төр засаг хагас зуун жил чармайсан ч гэсэн хэзээ ч хийж чадаагүй зүйл юм. Гээд арилжааны худалдаа хийх хана хэрэм, саад тотгор сүйрч унаж байгаагийн хэрээр улам л олон улс орон^[57] дэлхий-дэхний худалдааны тогтолцоонд оролцож, эд баялаг түгэн тархсаар байна. Эд баялаг ялангуяа олон-улсын худалдаа^[58]ны шинэ эрх чөлөөг халуунаар хүлээн авсан хамгийн ядуу улс оронд ч түгэн тархжээ. Эрх чөлөөнөөс ондоо илүү таатай сайхан үр дагавартай, бүтээлч зарчим байх боломжтой юу?

57 *more and more countries*

58 *trade internationally*

3 ЧӨЛӨӨТ НИЙГМИЙН ИНСТИТУЦҮҮД

Төргүй нийгэм

Эрх чөлөө, соёл

Чөлөөт нийгэмд хүмүүсийн амьдралын дийлэнхи хэсэг төр засгийн оролцоо бүр байхгүй байхад урсаж өнгөрдөг. Энэ байдал дараахь эртний Энэтхэг ёжлолын жишээ биш: түүнд ‘төр засаг унтаж байхад шөнө л эдийн засаг өсдөг’ тухай өгүүлжээ. Харин илүүтэй ийм нийгэмд хүмүүст жинхэнээсээ амин чухал үйл ажиллагааны ихэнхид төр засаг ерөөсөө ямар ч үүрэг нөлөөгүй байдаг.

Чөлөөт нийгмийн хүмүүс тусгаарлагдсан ганцаардмал хувь хүмүүс биш ажээ. Үүний эсрэгээр тэд нийгмийн бодгаль байна. Тэд бусадтайгаа найзлах нөхөрлөхийг эрэлхийлдэг, бусадтайгаа нийцтэй байхыг оролддог, бусадтайгаа олон янзаар хамтран ажиллаж амьдардаг. Тэд шашны бүлгийн идэвхитэй гишүүд байж болно. Клуб болон нийгэмлэгт тэд өөрсөдтэй нь ижил зүйл хийх дуртай, дуулдаг, ном уншдаг, хоол хийдэг, загасчилдаг, тоглодог, спортын тэмцээн үздэг эсвэл элдэв зүйл цуглуулдаг бусадтайгаа эвлэлдэн нэгдэнэ. Тэд өөрсөдтэйгөө адилхан залуу, хөгшин, сургуулийн найз, шинэхэн эцэг эх, эсвэл ижилхэн тахир дутуу хүмүүс зэрэг бусад хүмүүстэй эвлэлдэн нэгдэж, хүмүүсийн бүлэг үүсгэдэг. Тэд ядуу зүдүү, гэр оронгүй хүмүүст зориулан шөлний газар нээж эсвэл хостел буюу хоноглох байр гаргаж ажиллуулж ч болно. Энэ бол *иргэний нийгэм* гэдэг зүйл юм.

Эрх чөлөө илүү ихтэй нийгэм дэх хүмүүсийн эдэлдэг үйл хийх, шилжиж нүүх эрх чөлөөнөөс гадна тэр нийгмийн иргэд нэг ижил үнэт зүйлс, соёл, уламжлалтай байж тэдгээрээ хүндэлж дагадаг.

Чөлөөт хувь хүмүүс, ялангуяа залуучууд заримдаа хуучны арга замыг сорьж өөрчлөх гэж оролддог бөгөөд үнэндээ энэ оролдлого бол аливаа зүйлийг хамгийн сайнаар хэрхэн үйлдэхийг олж нээх, хөгжил дэвшил гарах арга зам юм. Гэвч эрх чөлөө соёлын дайсан биш. Бүр тодорхой нэг ижил соёлгүй байдаг цагаачид ч хэрэв тэд тухайн нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх гэж буй бол тэнд давамгайлж буй соёлыг дор хаяж хүндэтгэх ёстой. Тэд хэрэв баталгаатай ажилтай больё гэж бодож байвал тэндхийн хэлийг сурах ёстой. Тэр цагаачид анхандаа тэднийг хүлээн авсан улсын уламжлал, ёс суртахууны зарчмыг ухаж мэдээгүй байж болох ч хэрэв тэд доромжлуулж дайралтад өртөхгүй, бас хөгжиж дэвжихийг хүсэж байвал эд бүгдийг хурдан түргэн мэддэг болох ёстой. Тэднийг уйгагүй ялгаварлан гадуурхах учраас ингэх ёстой юм биш: чөлөөт нийгэмд хүн бүртэй адил тэгш харьцдаг. Гэвч уугуул суугуул хүн ам эсвэл өөр бусад хүн ам дотор буй хэн ч гэсэн тэдэнтэй санал үл нийлэх, эсвэл арга замыг нь үл хүндэтгэдэг бусадтай, эсвэл зөв зүйтэй харилцаж үл чадах бусад хүмүүстэй хамтдаа амьдрах гэж чармайх ч ёсгүй.

Хүмүүн төрөлтөн хамтаараа амьдрах хүсэлтэй байдаг бөгөөд боломж бололцоогоо бататгах, өөрсдийн ашиг сонирхлоо гүйцээх арга зам болохынх нь хувьд ингэж амьдрах нь тэдэнд хэрэгцээтэй зүйл ажээ. Тиймээс гаднын хүн байх явдал та нарыг тун ч ашиггүй байдалд оруулна. Чөлөөт нийгмийн хүмүүс бүгдээрээ нэг нэгэнтэйгээ адилхан үнэт зүйлтэй байдаггүй байж болох ч гэлээ хүмүүн гэсэн жирийн ойлголтоор бусдыгаа хүлцэн тэвчих ёстой. Чөлөөт нийгэмд байдаг үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, үйл хийх эрх чөлөө^[1] давамгайлж буй соёл, ёс суртахуунт байдал, уламжлалыг хүндэтгэхийг заавал дам илэрхийлдэг.

Хэнд төр засаг хэрэгтэй вэ?

Энэхүү албан бус харилцан-холбоотой ашиг сонирхол, хамтын ажиллагаа, үүрэг хариуцлага, итгэлцэл, итгэж найдах явдл^[2]ын

1 *The freedom of thought and speech and action*

2 *mutual interest, collaboration, obligation, trust and reliance*

сүлжээ асар ихээр бидний амьдралыг сайжруулж өргөдөг. Гэвч төр засаг ажиллах хэрэгцээ шаардлага үүнд нь байдаггүй. Бид ямар нэг засаг захиргааны оролцоогүйгээр нэг нэгтэйгээ хамтран ажилладаг, янз бүрийн нийгмийн бүлгүүдийн гишүүнчлэлээрээ дамжин хөгжиж дэвшигчдэдэг.

Хэн нэгэн хүн эргэлзээгүйгээр төр засгийн функц гэж үзэх боломжтой хуулийн салбарт ч бид ихэнхи зүйлээ өвөр зуураа өөрсдөө шийдвэрлэдэг. Чөлөөт нийгэм дэх гэрээг төр засгаас зохиомжилж гаргадаггүй, тулгаж хүлээлгэдэггүй харин сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, санал нийлсэн нөхцөлөөр хэрэгжих хүрээ нь гарсан, анхаарал тавьж буй оролцогч талууд зохион гаргадаг. Гэрээнд оролцож буй хүмүүс ихэвчлэн тэдний хоорондохь маргаанаа хувийн хувилбараасаа хамаагүй удаан хөшүүн, хамаагүй илүү зардал чирэгдэлтэй, шударга байдал нь арай муу, төрөөс явуулдаг шүүх гэхээсээ илүүтэй бие даасан арбитороор шүүлгэх буюу нягталж цэгнүүлэхээр санал нэгддэг.

Хүн ам нь нилээд нэгэн ижил бүтэц бүрэлдэхүүнтэй бол тэр нь нийгмийн албан бус, хамтран ажиллах иймэрхүү харилцаа хэлхээ цогцлоход тустай байдаг. Хэрэв ихэнхи хүмүүс нь нэг ижил арьстан, эсвэл шашинтай улс байвал тэд нар нэг ижил үнэт зүйлтэй байх бөгөөд хоорондоо итгэлтэйгээр хэлцэл хийх явдал хялбар байх болно. Олон-улсын хил хязгаарыг дахин зурж тогтоосон, өөр өөр угсаатны бүлгийг хамтад нь багцалсан, колончлолын дараахь эсвэл дайны-дараахь олон-улсын бага хурал ч иймэрхүү харилцаа хэлхээ цогцлоход тус болж байсангүй. Сүүлийн үед зөрчил мөргөлдөөнөөр салж бутарч буй олон улс орон, Сири, Ливи, Ливан, эсвэл Ирак зэрэг улс зуун жилийн өмнө байхгүй байлаа; эдгээр улсыг иргэд нь биш харин улстөрчид байгуулжээ. Британичууд ондоо ондоо овог эсвэл угсаатны бүлгүүдийг засаг захиргааны нэг ижил колонид хамтад нь нэгтгэж Африкт ч, мөн Энэтхэгийн хойг дотор ч үүнтэй адилхан алдаа хийсэн.

Төр засаг нь бүр иргэдийнхээ амь нас, өмч хөрөнгийг хамгаалж чадахгүй байгаа маш олон хэврэг төр улсууд байгаа явдалд гайхах хэрэггүй. Чөлөөт нийгэм, чөлөөт эдийн засаг

бат бөх суурин дээр ургаж хөгждөг. Нэгэнт ганхаж суларсан, мөн бидний хамтын ажиллагаа тулгуурладаг харилцан хүндлэл болон итгэлцлийн холбоо хэлхээс байхгүй бол хамтран ажиллах соёлыг сэргээн тогтооход хэцүү. Бүр нэг нэгтэйгээ зохих ёсоор хамтран ажилладаггүй байсан ч гэсэн зэрэгцэн амьдрах боломж олгох шийдэл хүмүүсийн өөр өөр бүлгүүд гаргаж зохиомжилж чадна гэдэгт итгэж найдахаас ондоо арга алга. Гэвч ондоо ондоо үндэстнүүд зэрэгцэн амьдрах, хамтран ажиллах явдал хэрэв үр дүнд нь харилцан ашигтай байх ирээдүйн төлөв гарахаар чөлөөт нийгмийн нөхцөлүүд үүсэж тогтсон бол үргэлж хамаагүй хялбар байх болно.

Төр засгийн яагаад хязгаарлах ёстой вэ?

Төр засаг юу хийх ёстой вэ?

Өнөөдөр хэдхэн хүмүүс л төр засаг бидний амьдралыг бүхэлд нь хянах хэрэгтэй гэдэгт итгэдэг. Бид бүгдээрээ төр засгийн үүрэг нөлөөг ямар нэг байдлаар хязгаарлах ёстой гэдэгт итгэдэг билээ. Ихэнхи хүмүүс хамтаараа шийдвэрлэх эсвэл хийх ёстой зүйлийг шийдвэрлэх эсвэл хийхэд бидэнд төр засаг хэрэгтэй гэдэг ч төр засаг бид өөрсдөө маш сайн хийж чадах зүйлд хөндлөнгөөс оролцох ёсгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Ихэнхи бодож сэтгэдэг хүмүүс өөрсдийнхөө удирдагчдад эрх дархаа хэтрүүлж давахаас нь сэргийлэх гэж хязгаарлалт тэдэнд тавих хэрэгтэй гэж дүгнэцгээдэг.

Асуудлын гол нь төр засгийн хэмжээнээс ихээр хамаардаггүй харин төр засаг тэнд юу шийдвэрлэх, юу хийх, *хэрхэн* эдгээр зүйлээ шийдвэрлэх, үйлдэх вэ гэдэг явдал байдаг. Нэгэнт л чөлөөт нийгэм, түүний эдийн засаг итгэлцэл дээр тулгуурладаг учраас чөлөөт нийгмийн иргэд ерөөсөө л төр засаг тэднийг хууран мэхлэх, тэднээс хулгайлах явдлаас хамгаалах болно гэж боддог. Гэвч бид засаг захиргаа автобусанд туулайчилсных нь төлөө хүмүүсийг бүх насаар нь хорих, бас хүн бүрийн гэр оронд интернетийн мэдээлэл хуваалцах вэбхуудаснаас дуу хууль бусаар

татаж авсных нь төлөө нууц камер суулгаасай гэж хүсдэггүй. Төр засгийн үйлдэл тухайн асуудалтайгаа таарсан байх ёстой.

Төр засгийг үйл хийх хүрээнд нь яагаад хязгаарлах ёстой гэдгийн өөр нэг шалтгаан бол хувь хүн тодорхой бараа таваар зарах эсэхээ шийдэж буй шийдвэр жишээлбэл цэвэр сайн дурын үйлдэл байдаг явдал юм. Гэвч төр засгаас гаргаж буй шийдвэр жишээлбэл тодорхой бараа таваар хүмүүс зарахыг зогсоох тухай шийдвэрт түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь хүч ашиглах ёстой. Хүч хэрэглэх явдал бүр хэрэв энэ нь заримдаа зайлшгүй хэрэгцээтэй байдаг ч гэсэн муу зүйл байдаг. Бид улстөрийн шийдвэр гаргахдаа ийм шийдвэр үндэслэдэг хүч хэрэглэх явдлаас гарах муу зүйлийг энэ бодлогоор хүрэх ашиг тустай нь дэнсэлж үзэх хэрэгтэй. Бид аюул заналынх нь талаар бодож эргэцүүлэхгүйгээр ашиг тусыг нь үзэх гэж яаран тэмүүлэх ёсгүй.

Өсөж хөгжихийн тулд эдийн засгийн болон нийгмийн амьдралд эрх чөлөө хэрэгтэй. Эдгээр амьдрал багахан хэмжээний алдах онох үйл явцаар аажмаар хөгжиж дэвжинэ. Тоо томшгүй шинийг туршигчид олон янзын санааг, жишээлбэл шинэ бүтээгдэхүүн, эсвэл сургах шинэ аргыг туршдаг. Сайн таардаггүй ажилладаггүй санаа удалгүй гээгддэг бол харин амьдрал сайжруулдаг тэдгээр санааг хүмүүс хуулбарлаж, бусад хүмүүс рүү тархан түгнэ. Гэвч төр засаг эдийн засаг болон нийгмийн институтүүдийг хянах явдал ямар ч төвшинд шинийг санаачлагчийг үгүйсгэдэг: [энэ үед] байнгын боловч аажим явцтай алдах онох үйл явц удааширна.

Цаашлаад төр засаг хөндлөнгөөс оролцвол тэр нь ерөнхийдөө өргөн хүрээнд өрнөдөг. Төр засаг ямар бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл сургах ямар аргыг хүлээн зөвшөөрөх ёстой зэрэг асуудлаар нийт хүнд хүрэх тийм шийдвэр гаргадаг. Энэ нь зайлшгүй шинэчлэл шинэ санаа, хөгжил дэвшлийг мөн л удаашруулдаг. Төр засаг алдаа гаргавал тэр алдаа нь гарцаагүй асар их, сүйрэл дагуулсан аюултай байна.

Яагаад ерөөсөө төр засагтай байх ёстой гэж?

Тодорхой зүйл хийхэд төр засаг хэрэгтэй байдаг үндэстэй учир шалтгаан бий. Бид хэрхэн үйл хийх, жишээлбэл замын аль талаар машин барих, эсвэл бид гэрээгээ хүндэлдэг байх явдлыг бататгах тухай зарим нэг чухал ёс журмын талаар шийдвэр гаргах, тэдгээрийг албадан хэрэгжүүлэхэд бидэнд засаг захиргаа^[3] хэрэгтэй.

Дээр нь нэмээд хүн бүр л тийм зүйл хийхийг сонирхдог ч ямар ч хувь хүн хийж чадахгүй эсвэл (сайн хийж чадахгүй) байж болох зарим нэг төсөл ч байж болох юм. Эдгээр зүйлийг *олон нийтийн бараа үйлчилгээ*^[4] гэж нэрлэдэг. Батлан хамгаалах болон цагдаагийн үйлчилгээ үүний жишээ байж болно: аюулгүй байдал сайжрах явдлаас хүн бүр л хождог бол яагаад аливаа хүн сайн дураараа цэргийн алба хаах ёстой гэж? Өөр нэг жишээ бол хөгжиж буй олон орны хотуудын агаарыг амьсгалах аргагүй болгож буй агаарын бохирдол юм. Дулаан үйлдвэрлэхдээ утаагүй түлш ашиглах, хөнгөн тэргэнд каталитик хувиргуур буюу саармагжуулуур^[5] угсрах, үйлдвэрийн янданд хаягдал хийн шүүлтүүр суулгах явдал энэхүү бэрхшээлийг арилгахад дэм болох боломжтой бөгөөд энэ нь [хүрээлж буй] орчныг илүү таатай сайхан болгоно. Гэвч хүн бүр тэдний өргөлөөр зүгээр л “үнэгүй хүртэх”^[6] боломжтой, тэдний зардлаар хүн бүр илүү цэвэр агаартай болох болно гэдгийг хүмүүс мэдсэн бол тэд үүнийг сайн дураараа хийхгүй. Тиймээс бид иймэрхүү хэцүү асуудал бэрхшээлийг улстөрийн аргаар шийдвэрлэж болох бөгөөд хүн бүрийг бохирдлоо бууруулахыг хүчилж, эсвэл цагдаагийн үйлчилгээ болон аюулгүй байдлын төлөө хүн бүрээс татвар авч үүнийг шийдэж болно. Энэ үеэр зах зээл нийлүүлж

3 *authority*

4 *public goods*

5 *catalytic converters*

6 *free-riding-Туулайчлах буюу тээврийн хэрэгслээр үнэгүй зорчих*

чадахгүй өргөн хүрээтэй үр өгөөж бүтээдэг тийм зүйлийг бид хийж чаддаг.

Бид *либертаричууд* гэж нэрлэж болох, эрх чөлөөний зарим хамгаалагчид ерөөсөө төр засаг хэрэггүй гэж батлан өгүүлэх болно. Тэд нар буяны тусламж бусдад өгөх, эсвэл төлбөрийг нь хийж буй хүмүүст очих ашиг тусыг нь хязгаарлах замаар үнэгүй хүртэх явдл^[7]ыг хэцүү болгох ухаалаг арга бодож олох зэргээр хамтран ажиллах, хүн бүрд ашиг тус хүртээх арга зам олохдоо чөлөөт нийгэм хамгийн гаргуун гэж хэлдэг. Тэд хувь хүмүүс эсвэл хүмүүсийн бүлэг энэ бүгдийг өөрсдөө хангалттай хийж чадна гэж боддог тул бидэнд гэрээг албадан хэрэгжүүлэх, эсвэл гаднын халдлагаас бидний амь насыг хамгаалах, бидний өмчийг хулгай дээрмээс хамгаалахад төр засаг хэрэгтэй гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэй байдаггүй.

Чөлөөтнийгмийн өөр нэг хамгаалагчид, *сонгодог либералчууд* хэдий дараахь эдгээр функцийг хязгаарлах хэрэгтэй байдаг ч гэсэн биднийг хамгаалах, гэрээг албадан хэрэгжүүлэх, олон нийтийн бараа үйлчилгээгээр хангахад дор хаяж улстөрийн зарим нэг шийдвэр гаргах явц, төр засгийн зарим нэг эрх мэдэл хэрэгтэй гэж батлан өгүүлцгээдэг. Гэвч либертаричууд төр засагт ямх чөлөө өгөхөд тэд бээр газар эзлэн сууна гэж айж сэрэмжилсээр л байдаг^[8]: дэлхийн бараг бүх төр засаг өнөөдөр эдгээр гол функцээс хамаагүй давсан үүргийг олон нийтийг золигт гарган өөртөө авч нөлөөтэй болжээ.

Хувийн болон эдийн засгийн эрх чөлөөний талаархи үзэл бодлууд

Төр засгийн үүрэг нөлөөг хэр их өргөжүүлэх ёстой болохыг шийдвэрлэх явдал зүгээр л “зүүн”, “баруун”-ыг сөргөлдүүлэх хэрэг явдал биш. Хүмүүс шийдвэрийг *хувь* хүмүүс гаргах эсвэл *хамтаараа* гаргах эсэх талаар санал зөрөхөөр барах уу, мөн ингэх

7 *free-riding*

8 *an inch they will take a mile*

Асуулт: Мэдээжээр төр засаг батлан хамгаалах зэрэг үйлийг ёстой биш үү?

Үгүй. Мэдээжээр дайн хийх зэрэг хамтаараа *шийдэх* ёстой зарим нэг зүйл байдаг ч гэсэн хувь хувиараа *хийж шийдэх боломжгүй* хэдхэн зүйл бас бий. Олон улс оронд батлан хамгаалахынхаа тээврийн хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, хориглох хамгаалалт барих болон тэдгээрийн үйлчилгээ хийх, хоол хүнс, тээврээр хангах зэрэг дор хаяж зарим нэг функцйг хувийн компаниудад гэрээгээр өгдөг.

Зөвхөн төр засаг л шуудан хүргэдэг, утсан харилцааны тогтолцоог хариуцдаг, төмөрзамын тээвэр эрхлэн явуулдаг, ус, байгалийн хий, цахилгаан эрчим хүчээр хангадаг, автозам, эмнэлэг, шорон барьдаг, эсвэл бүр ган үйлдвэрлэдэг, машин үйлдвэрлэдэг гэж саяхан л бид бодоод хэвшчихсэн байсан. Одоо хувийн пүүсүүд энэ бүх зүйлийг хийж байна. Тэдгээр пүүс өрсөлдөөнтэй нүүр тулж буй тул үйлдвэрлэж буй, эрхэлж явуулж буй зүйлийнх нь чанар улам л сайн болжээ.

нь бидний *хувийн* болон *эдийн засгийн* шийдвэрт хоёуланд нь хэрэгтэй эсэхэд ч санал зөрөлддөг.

Бид дөрвөн ондоо санаа бодлыг ялгаж таних боломжтой. Үүнд:

- Эхний бүлгийг нь бид *индивидуалистууд* гэж нэрлэх боломжтой. Тэд хувь хүмүүс *хувийн* болон *эдийн засгийн* амьдралаа хоёулыг нь өөрөө чөлөөтэй шийдэх ёстой гэдгийг баримталдаг.
- Дээрхийн яг эсрэг үзэлтэй, *хувийн* болон *эдийн засгийн* үйл хөдлөлийг хоёулыг нь хянах хамтын хяналтыг дэмждэг *авторитарич үзэлтэй* хүмүүс^[9].
- Гуравдахь бүлэг нь эдийн засгийн амьдралд хувь хүний эрх

9 *authoritarians*

чөлөөг дэмждэг ч хүмүүсийн хувийн сонголт хийх явдлыг хянах хамтын эрх дархыг дэмждэг хүмүүс юм. Тэднийг *консервативчууд* гэж нэрлэх боломжтой (хэдийгээр энэ хэллэг өөр өөр соёлд ондоо ондоо утгатай байдаг ч гэсэн). Эдийн засгийн эрх чөлөөг нийгмийн хяналттай хольсон нийлмэл зүйл Азийн олон улс оронд нийтлэг хэвшинж байдаг.

- Сүүлийн бүлэгт *эдийн засгийн амьдралыг* хамтын хяналтаар хянахыг хүсдэг ч хувь хүмүүст *хувийн амьдралаа* хөөхийг нь үлдээдэг хүмүүс орно.

Энэхүү сүүлийн бүлэг хүмүүст таарсан нэр олж өгөхөд маш хэцүү байна. Америкийн Нэгдсэн Улсад тэднийг *либералчууд* гэж болох ч гэлээ энэ нь энэхүү үгийг ашиглах явдлыг маш буруу болгодог. Ихэнхи бусад улсад *либерал* гэж *сонгодог либералыг* хэлдэг – энэ бол төр засгийн зарим нэг бүтэц шаардлагатай боловч эдийн засаг болон хувийн ихэнхи шийдвэрийг хувь хүмүүсээр гаргуулахаар үлдээх ёстой гэдэг үзэл санаа юм. Үнэндээ энэ либерал гэдэг хэллэг ойлголтыг хувийн эрх чөлөөнд итгэдэг ч эдийн засгийн амьдралыг хянах төр засгийн илүү их хяналтыг хүсэмжилдэг Америкийн улстөрчид, сэхээтнүүд хулгайлчихсан юм.

Нэг-үгээр илэрхийлсэн энэ бүх тодорхойлолт эдийн засаг болон нийгмийн хурц асуудлын талаархи үзэл бодлын хэлбэлзэх хүрээ буюу спектр үнэндээ чухам ямар байдаг тухай дүрсэлж тодорхойлох оновчгүй арга зам ажээ. Бүр нэг бүлгийн дотор ч өргөн хүрээний үзэл бодол бий. (Жишээлбэл *индивидуалистуудын* үзэл бодол бүрэн эрх чөлөөний төлөө мэтгэлцдэг *либертариичуудаас* төр засгийг хязгаарлагдмал үүрэг нөлөөтэй байна гэж ойлгодог *сонгодог либералчууд* руу хүрсэн өргөн хүрээтэй байдаг. Харин *авторитари үзэлтнүүд* бүхнийг хянах явдлыг дэмждэг *тоталитаричуудаас* хувийн шийдвэр гаргах явдал хязгаарлагдмал үүрэгтэй байдаг гэж ойлгодог *стэйтистууд* рүү хүрсэн тийм хүрээтэй үзэл бодолтой байдаг.)

Гэлээ гээд улстөрийн үзэл бодлыг нийгмийн нилээд ондоо үзэл бодолтой хүмүүсийг хамтад нь багцалж багтаадаг энгийн “зүүн-баруун” гэсэн спектр буюу хэлбэлзэх хүрээгээр дүрсэлж тодорхойлох нь хангалтгүй болохыг ойлгож мэдэх хэрэгтэй. Хүмүүс *эдийн засгийн* болон *хувийн* амьдрал гэсэн хоёр өөр хэсэгт хэр их эрх чөлөө байх ёстой талаар бодож буй байдлаар нь улстөрийн үзэл бодлыг нь харж ойлгох нь илүү дээр байдаг.

Яагаад хувь хүний сонголт хэрэгтэй гэж?

Эдийн засгийн болон хувийн амьдралдаа эрх чөлөөтэй байхыг илүүд үзэх үндэстэй учир шалтгаан бий. Юуны түрүүнд хүмүүс өөрийн хэрэгцээгээ алс холын төр засаг хэзээ нэгэн цагт мэдэж чадахаас хамаагүй сайн мэддэг. Тэд нар итгэл найдвар, айдас түгшүүр, мөрөөдөл, хүсэл, хэрэгцээ, шаардлага, амбиц буюу алсын бодл^[10]оо мэддэг. Хүмүүс өөрсдийнхөө болон хайрлаж хамгаалдаг, туслахыг эрэлхийлдэг найз нөхөд, гэр бүл, хүрээллийнхээ нөхцөлийг хамаагүй сайн ойлгож мэднэ. Тэд тэр хүмүүсийн өмнөх боломж бололцоог, мөн өөр өөр үйлдлээс гарах боломжтой асуудал бэрхшээлийг илүү сайн мэддэг. Тиймээс тэд амьдрал, ирээдүйнхээ талаар шийдвэр гаргахдаа хамаагүй сайн байр сууринд оршдог.

Шийдвэрийг нь тэдний өмнөөс гаргачихдаг бол хүмүүс бүтэн хүмүүн төрөлтөн биш харин боол юм гэсэн ёс суртахууны өнцөг мөн бий. Юу болж буйд хувийн ямар ч хариуцлага хүлээдэггүй тул тэд хэзээ ч амжилт алдаанаасаа суралцдаггүй. Энэ хүмүүс засаг захиргааны явуулсан муу бодлогоос болж хохирч зовж болох ч ийм зүйл дахин болох явдлаас сэргийлэх зүйл бараг хийж чадахгүй. Учир нь ингэхээр оролдох шалтгаан тэд олж хардаггүй. Гэвч амжилтынхаа үр шимийг таашаан эдэлдэг, мөн алдааныхаа горьг амсдаг хувь хүмүүст сайн болсон зүйлийг давтах, муу байсан зүйлээс сэргийлэх гэсэн хүчтэй сэдэл бий.

10 *ambition*

Олон янз байдал хөгжил дэвшлийг тэтгэдэг

Олон янз байдал^[11] мөн давуу талтай. Шийдвэрээ чөлөөтэй гаргадаг хүмүүс зүсэн зүйлийн арга замаар үйл хийх болно. Тэд өөрсдийн нөхцөл байдалд зөв гэж бодсон тэр үйлдлээ хийхээр сонгох авч чадна. Ийм хүмүүс амьдралын өөр өөр хэвмаягийг туршиж үзэх боломжтой – энэ бол Английн философич Жон Стюарт Милл 1859 онд гаргасан, “Эрх Чөлөөт Байдлын тухай”^[12] гэсэн эссэндээ дурдсан ‘амьдрах туршилт’^[13] юм. Эдгээр оролдлогын зарим нь амжилттай бусад нь амжилтгүй болсон байж болно. Гэвч бид бүгдээрээ тэдгээрээс суралцах, мөн болж буй зүйлийг нь илүү их хийж, харин болохгүй зүйлийг нь бага үйлдэж цаашаа өөрөө хөгжиж дэвжих боломжтой.

Авторитари буюу нэг хүний захиргаанд байдаг нийгэмд үүнээс ялгаатай нь хамтаараа шийдвэр гаргадаг учраас аливаа зүйлийг хийх зөвхөн нэг л арга зам давамгайлдаг. Аливаа алдаа хүн бүрийн хувьд сүйрэл байх болно. Бүр хэрэв албан ёсны ийм хандлага болж бүтдэг байсан ч бид бүр илүү сайн болж бүтэх боломжтой аливаа бусад зүйлийг оролдож үзэх эрхгүй байх болно. Шийдвэр-гаргах үйл явц илүү удаан, илүү захиргаадсан шинжтэй байх болно. Ийм ертөнц дэх бидний хөгжил дэвшил удаан, голдуу зовуурьтай хэцүү байх болно.

Чөлөөт эдийн засагт үйлдвэрлэгчид хэрэглэгчдээсээ тасралтгүй хариу үйлдэл^[14] хүлээн авдаг. Өдөр бүр цаг мөч бүрд хүмүүс бусад нэгнээс илүүд үзсэн бараа бүтээгдэхүүнийг сонгож байдаг. Тэр хүмүүс худалдаж авч буй бараа бүтээгдэхүүн бүрийнхээ үнэ, найдвартай байдал, хэмжээ, хэлбэр, өнгө, чанарын бусад оноо үзүүлэлтийг харьцуулж цэгнэдэг. Хүмүүсийн эдгээр илүүд үзэх олон янз байдал агшин зуур юу зарагдаж харин юу

11 Diversity

12 John Stuart Mill, ‘On liberty’, 1859, in John Stuart Mill, *On Liberty and Other Essays*, Oxford University Press, Oxford, 2008-БАТ/ЛЕП

13 experiments in living

14 continual feedback

нь зарагдахгүй байгааг хараачилж буй үйлдвэрлэгч рүү агшин зуур дамжиж хүрдэг. Өрсөлдөгч нар нь нэг ижил зүйл хийж буйг мэдэж ухаарч буй ханган нийлүүлэгч хүмүүсийн хүсэж буй тэр зүйлийг нь ихээр үйлдвэрлэхээр, бага хүсэж буйг нь багаар үйлдвэрлэхээр аль болох хурдан хөдлөх болно. Тэд хэрэглэгчид нь бүр илүү ихээр хүсэх болно гэж бодсон итгэлээр шинэ, ондоо бараа бүтээгдэхүүн тэнд танилцуулж туршилт хийхээр сэдэлжсэн байдаг.

Дахиад л үүнийг засаг захиргаа юу үйлдвэрлэхийг шийддэг эдийн засагтай харьцуулна уу. Ихэвчлэн байдагчлан засаг захиргаа нийт эдийн засгийг хянадаг, эсвэл түүний тодорхой хэсгийг зөвхөн хянадаг эсэхтэй энэ нь энд дахиад ямар ч хамаагүй: юу үйлдвэрлэх, хэрхэн үйлдвэрлэх хэрэгтэй талаар шийдвэр гаргах явдал энд удаан хөшүүн, болхи зүйл байх болно. Хамгийн сайндаа л хэрэглэгчид хэдэн жил тутамд, сонгуулийн үеэр сонголтоо илэрхийлэх боломжтой байж болох юм. Гэвч тэд тухайлсан бараа бүтээгдэхүүн болон чанарын талаар санал өгөхгүй: хэрэв эцсийн эцэст сонголтоо жинхэнээсээ хийхээр болбол тэд батлан хамгаалах, боловсрол олгох, эрүүлийг хамгаалах^[15] аас авахуулаад усжуулах явдал, хөдөө аж ахуй, хөдөө нутгийн тээвэр гээд бүх зүйлийг багтаасан бодлогын бүхэл багц асуудлын талаар санал өгөх болно. Энэ засаг захиргаанд зах зээлийн эдийн засагт хэрэглэгчид нь нийлүүлэгчдэдээ өгдөг байнгын, тэднийг сэдэлжүүлдэг хариу үйлдэл^[16] гэх мэт тийм зүйл ерөөсөө байдаггүй. Ийм засаг захиргаанд шинэчлэл хийх талаар дарамт бага ирэх бөгөөд хэрэглэгчид жинхэнээсээ хүссэн зүйлээ олж авч чадахгүй.

Интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдлын сүйрүүлэгч нөлөө

Өнөөдөр дэлхий дээр төр засаг нь үндэстнийхээ нийт үйлдвэрлэлийг эрхлэн явуулдаг, эсвэл бүр эрхлэн явуулахаар

15 *schooling and healthcare*

16 *incentivising feedback*

оролддог хэдхэн л улс бий: Илүү их тохиолддог зүйл бол төр засаг нь тусгай салбарыг хянадаг, ялангуяа амин чухал гэж төр засаг үзсэн, эрүүлийг хамгаалах, боловсрол, хөдөө аж ахуй, эсвэл цагдаагийн үйлчилгээ^[17] үзүүлдэг явдал – эсвэл бүр ерөнхийлбөл татаас, үнийн дээд хязгаар^[18], бизнес явуулах дүрэм журмаар дамжуулан үйлдвэрийг залж чиглүүлдэг байдал юм.

Төр засаг бүр дөнгөж хэдхэн салбарын ажлыг эрхлэн явуулахыг оролдох үед шийдвэр-гаргах хөшүүн, болхи үйл явцын зовлон ялангуяа хамгийн амин чухал тэдгээр салбарт үлдэж хоцорно. Ийм төр засаг жишээлбэл зөвхөн хүнсний үйлдвэрлэл эрхлэн явуулдаг байж болох юм: гэвч хэрэв хүмүүст хэрэгтэй хүнс хангалттай хэмжээгээр үйлдвэрлэж чадахгүй бол үр дүнд нь нийтийг хамарсан өлсгөлөн гарах боломжтой.

Үүнтэй адилаар төр засгаас илүү ерөнхий байдлаар үйлдвэрлэлийг залж чиглүүлэх гэсэн хүчин чармайлтаас эрэлт нийлүүлэлт хоорондоо үл таарах дээрхитэй адил байдал гарах болно. Жишээлбэл улстөрчид зарим нэг бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үнийг, жишээлбэл хүнс эсвэл эрүүлмэндийн үйлчилгээний үнэ эсвэл зээлийн хүүгийн хэмжээг тэдгээрт дээд хязгаар тулгаж оноох замаар бага байлгасаар байхыг оролдож ч болно. Гэвч үйлдвэрлэгчид эдгээр бараа таваарыг нийлүүлбэл илүү бага мөнгө олох болно. Тэдгээр үйлдвэрлэгчийн авч буй үнэ үйлдвэрлэлдээ зарцуулсан хүчин чармайлтад нийцэхгүй болдог. Тиймээс үйлдвэрлэгчид ийм бараа таваарыг илүү бага үйлдвэрлэх эсвэл тэр салбараас бүхэлдээ гарах болно.

Гарах үр дүн нь хомсдол ажээ. Хуулиар тулгасан хиймэл бага үнээр үйлдвэрлэгч бага л бараа бүтээгдэхүүн нийлүүлэх боловч хэрэглэгч илүү ихийг худалдан авахыг хүснэ. Хоол хүнс албан ёсоор хямд байх ч дэлгүүрийн лангуун дээр юу ч байхгүй; хүүгийн хэмжээ бага байж болох ч зээл олох боломжгүй; эрүүл

17 *policing*

18 *price caps*

мэнд үнэгүй байж болох ч эрүүл мэндийн үйлчилгээ авах гэж дараалалд зогсох хэрэгтэй болно.

Үүнтэй адилхан зовлон төр засаг тодорхой бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээнд татаас өгөх замаар үйлдвэрлэлийг залж жолоодох гэхэд гардаг. Жишээлбэл Европын Холбоо хүнсний хангалттай, тасралтгүй нийлүүлэлтийг баталгаажуулж бататгахын тулд удаан хугацаанд хөдөө аж ахуйдаа татаас өгч хамгаалсаар ирсэн нь үнэндээ тэд Европын үр ашиг муутай фермерүүдээ олон-улсын өрсөлдөөнөөс хамгаалах (улстөрийн хувьд ач холбогдолтой энэхүү бүлгийн дэмжлэгийг худалдаж авах) гэж тэр ажээ. Энэ татаас хэт-үйлдвэрлэлийг, хэний ч хүсэхгүй байгаа цөцгийн тосон “уулс”, борлогдохгүй байгаа дарсан “нуурууд” үүсгэж тэтгэдэг.

Гэвч арай бага анзаарагддаг эдгээрээс ондоо үр дагавар бас бий. Европын хөдөө аж ахуйн татаасын хамгийн том ашиг хүртэгч нар бол ядарсан хамгийн ядуу фермерүүд биш харин хамгийн том газар-өмчлөгч нар^[19] юм. Фермерүүд хэзээ ч үйлдвэрлэж байгаагүй тариа ногооныхоо төлөө татаас авахаар шаардлага тавьж байхад хээл хахууль хэвийн зүйл л байх болно. Дэлхий даяар, үнэндээ дэлхийн түүхэнд үүнтэй адилхан тоо томшгүй жишээ бий: Шотландын эдийн засагч Адам Смит 1776 онд *Үндэстний Баялаг* номдоо май загас^[20] барих онгоцыг илүү их олз барих гэхээсээ илүүтэй авах татаасаа хамгийн их болгох гэж л тоноглодог гэж гомдоллож байлаа.^[21]

Бараа бүтээгдэхүүний аливаа хэлбэрт татаас өгөхөд цаг хугацаа, хүчин чармайлт, хөрөнгийг хамгийн сайнаар ашигладаг бусад салбараас нөөц баялгийг тэр хэрээр тийш нь татан авдаг. Жишээлбэл өртөг зардал ихтэй салхи, нарны эрчим хүчний үйлдвэрлэлд олон төр засаг татаас өгч, хөрөнгө оруулах илүү хэмнэлттэй арга замаар ашиглах боломжтой хувь хүмүүс болон

19 *landowners*,

20 *herring-opos. сельд*

21 *Adam Smith, The Wealth of Nations, 1776, Book IV, ch. V. -БАТЛЕР*

бизнесээс мөнгийг нь тийш татаж байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг арагш нь чангааж, олон нийтийн урт хугацааны хөгжил цэцэглэлтэд дарамт болно.

Хэдхэн хүний гаргадаг шийдвэр

Төр засаг гэхээсээ илүүтэй хувь хүмүүсийн шийдвэр гаргах явдлыг чухалчлахын өөр нэг шалтгаан бол сонголтыг эрх мэдэлтэй хэдхэн хүн биш олон хүмүүс хийдэг явдал юм. Хүн бүрийг төлөөлж шийдвэр гаргадаг засаг захиргаа шийдвэрээ хүчин төгөлдөр болгоход гарцаагүй эрх мэдэлтэй байх хэрэгтэй. Гэвч засаг захиргаа өөрөө мөн л хүмүүн төрөлтнөөс бүрддэг; эрх мэдлээ өөрийн ашиг сонирхлоо, мөн гэр бүл эсвэл найз нөхөд, эсвэл хөршийн холбоо, эсвэл отог овог эсвэл улстөрийн намын ашиг сонирхлоо тэтгэж дэмжихэд ашиглах хүсэл тэмүүлээ дарж хорь гэх нь бүтэшгүй зүйл. Гэрээ, монополь эрхийг өөрсдийн хамтрагчдадаа бэлэглэнэ. Даргалж буй улстөрчдийн төрөлхи дүүрэгт нь хэтийдсэн хэмжээгээр олон нийтийн зардал хуваарилна. Төр засаг, цагдаа, шүүх засагт ажил эрхлэх явдлыг гавьяа зүтгэлд нь тааруулж олгохын оронд харин талтай дуртай хүмүүстээ өгдөг.

Гэвч улстөрийн явцаар багыг шийдвэрлээд харин хувь хүмүүс өөрсдөө илүү их шийдвэрлэдэг болбол энэ төрлийн авилга хээл хахуулийн хүрээ тэр хэрээр бага байна. Гол үүрэг болох албадлага багасгах хүмийн явдалдаа төр засаг анхаарах боломжтой болж албадлагаас ашиг олох гэхээ болино.

Заримдаа иймэрхүү ашиг хонжоо гаргах явдал олж харахад хэт үл мэдэгдэм байдаг. ‘Нэг засгийн газар нөгөө нэгнээсээ’ гэж орчин үеийн эдийн засгийн эцэг Адам Смит бичиж эхлээд “ард олныхоо халааснаас мөнгө саахад суралцах явдал бол магтмаар зүйл биш” гэж дуусгасан байдаг.^[22] Жишээлбэл засгийн газар зээл авч сонгуульдаа ялах, дэмжигчдээ баяжуулах төсөлдөө зарцуулах боломжтой бол үүнийхээ зардлыг бусдад хүмүүст

22 *Ibid.*, Book V, ch. II, Part II, Appendix to Articles I & II.-БАТЛЕП

оноодог. Тэдгээр засгийн газар энэ зардлаа бүр дараагийн үеийнхэндээ ч дамжуулж өвлүүлдэг. Хэрэв өр нь хэт их болбол тэд зүгээр л мөнгө хэвлэнэ, зээлдэгчдээ үнэгүйдсэн валютаар өрөө дарах боломжтой. Гэвч иймэрхүү ил эсвэл далд хулгай хүмүүс хадгалж хурааж эд хөрөнгө бий болгох явдлыг утгагүй зүйл болгоно. Хүмүүс шинэ бизнес эхлүүлэх, бүтээлч хөрөнгө бүрдүүлж хуримтлуулах магадлал буурна, нийт нийгэм илүү ихээр доройтно.

Жинхэнэ чөлөөт нийгмийн төр засагт хэцүү хүнд нөхцөлөөс бусад үед зээл авах нь хориотой байх болно, зээл авах нь ч хязгаартай байх болно. Бас энэ төр засаг валютын монополь эрхгүй, мөнгө хэрэгтэй үедээ илүү их мөнгө хэвлэх ч боломжгүй байна. Чөлөөт нийгэм дэх татвар бага, татварлах суурь нь өргөн байна – татварыг улстөрийн сөрөг хүчин эсвэл “баячууд” зэрэг цөөнхөд уул овоо мэт оногдуулахгүй. Татвар нь энгийн, ил тод, төлөхөд хялбар, урьдаас таамаглахуйц байна. Татвар төлөгчдөөс татаж авах хэмжээг огцом өсгөх ашиг сонирхолтой олон нийтийн эсвэл хувийн байгууллагууд энэхүү татварыг “бөөцийлж маллан эзэн суухгүй”^[23].

Патерналист буюу халамжлагч шинжтэй гаргалгаа нотолгоо

Засгийн эрх барьж буй элит буюу дээд ангийнхны дунд олон нийт хүүхэд адил өөрөө шийдвэр гаргах чадваргүй учраас тэд л түүний өмнөөс бүх шийдвэрийг гаргах хэрэгтэй гэсэн санаа маш их тархсан байдаг. Энэ бол дотоод зөрчилтэй зүйл юм: энэ байдал эрх мэдлээ тэднээс л авдаг гэж үздэг “ард олон”-оо эд дорд үзэж буй болно. Хүмүүс зөв төр засгийг сонгох хамтын хангалттай цэцэн ухаантай ч харин өөрийн амьдралаа авч явах өөрийн ухаан байдаггүй гэж үзэх нь логикгүй буюу утга учиргүй зүйл.

Мэдээжээр хэрэв хүмүүс илүү сайнаар биеэ авч явдаг байвал нийт нийгэм ашиг тус хүртэх тийм тохиолдлууд бий.

23 *farmed*

Асуулт: Мэдээж, бид бүгдээрээ төр засгийнхаа өмнө хариуцлага хүлээдэггүй гэж үү?

Үгүй. Чөлөөт нийгэмд төр засаг бидний өмнө хариуцлага хүлээдэг. Олон газар оронд төр засгийг зөвхөн хүч ашиглаж үүсгэж байгуулсан бөгөөд тэр хүчээр л эрх мэдэлтэй хэвээр байдаг. Энэ бол төр засгийн хуульзүйн дагуухь [бүрэн эрхтэй] хэлбэр биш юм. Чөлөөт нийгмийн төр засаг хамтаараа (батлан хамгаалах зэрэг) эсвэл хүнээс үл хамаарсан байдал (шүүх зэрэг)-аар шийддэг эсвэл хийх ёстой хэдхэн зүйлийг шийдвэрлэх эсвэл хийх үйлдэх байгууллага байдлаар хүмүүсийн байгуулсан зүйл байдаг. Энд төр засаг иргэддээ үйлчлэхээс өөр зүйл хийдэггүй.

Гэвч эдгээрийн ихэнхи нь хуулиар албадан хэрэгжүүлэх хэрэг явдал биш харин ёс суртахууны асуудал байдаг. Бид хүмүүсийг аливаа зүйлийг үйлдэхдээ бусдад тус болохоор ёс суртахуунтай байхыг *ятгах* боломжтой бол харин чөлөөт нийгмийн төр засаг хүмүүсийг ёс суртахуунтай *болгож* чадахгүй. Ийм төр засаг бусдад хор учруулах хохироох явдлаас л зөвхөн сэргийлэх эрх мэдэлтэй байдаг ч бусдад тус бол гэж хүмүүсийг хүчилж албадах эрхгүй. Батлан хамгаалах зэрэг тодорхой, нийтэд хамаатай төсөлд хүмүүсийг хувь нэмэр оруулдаг болгохын төлөө байдаг “олон нийтийн бараа үйлчилгээ”-г дэмждэг гаргалгаа нотолгоо байдаг ч ийм тохиолдол ховор ажээ.

Төрөөс явуулдаг үйлчилгээг хэрхэн хүргэж буй зэрэг асуудлыг хүмүүс голдуу л гайхмаар үл тоодог^[24] нь үнэн. Гэвч юу ч өөрчлөгдөхгүйгээс хойш ингэж гомдоллох явдал бол хийх хоосон яриа гэдгийг тэд мэддэг учраас л ингэж үл тооно. Хэрэв аливаа зүйл хүмүүсийн оролцооны үр дүнд жинхэнээсээ сайжирвал илүү олон хүн түүнд оролцох болно.

24 *surprising apathy*

Төр засгийг хязгаарлах арга зам

Ардчилал

Хамтын шийдвэрээс зайлах аргагүй тийм ховор тохиолдолд нэгэнт л нийт хүн ам гарах үр дүнгийн нөлөөнд автах тул чөлөөт нийгэм нийт хүн амтайгаа зөвлөлдөх болно. Өөрөөр хэлбэл тэнд ардчиллын ямар нэг төрөл оршдог.

Нийт хүн ам шийдвэр бүрийг гаргахгүй байж болно – ингэх нь хэт төвөгтэй, хугацаа авсан ажил байх болно. Ер нь бол өөрсдийнхөө өмнөөс шийдүүлэх гэж нийт хүн ам өөрсдийнхөө төлөөлөгчдөө сонгодог. Иймэрхүү төлөөлөгчид сонгогчдынхоо үзэл бодлыг боол мэт дагаж илэрхийлдэг зүгээр л төлөөний хүн биш; тэд ч өөрсдийн үнэлгээ шүүмжээ энэ үйл явцад нэмж оруулна.

Ардчилал бол популизмтэй адил зүйл биш. Олон нийтийн олонхи шашны эсвэл үндэс угсаатны цөөнхийг алж хядах хэрэгтэй гэдэгт нилээд итгэлтэй байж болох ч чөлөөт нийгмийн төр засаг ийм зүйл хийх боломжгүй. Ийм төр засаг бусдыг хохироохоос сэргийлэх гэж оршдогоос харин ийм явдлыг хөхиүлэн дэмжих гэж оршдоггүй. Эртний шог ярианд ардчиллыг хоёр чоно нэг хонь өдрийн хоолондоо юу идэх тухай шийдэх явдал гэж дүрсэлж тодорхойлсон байдаг. Гэвч чөлөөт нийгэмд цөөнхийг хамгаалахын тулд олонхийн эрх мэдлийг хязгаарлана.

Хамгийн том бэрхшээл зовлон бол төр засгаа хэрхэн сонгох биш харин төр засгаа хэрхэн хязгаарлах вэ гэдэг явдал юм. Төр засгийг зөвхөн хүмүүн л бүрдүүлдэг: тэдний эзэмшсэн тэр эрх мэдэл тэднийг муу амьтан болгодог. Хэрэв эрх чөлөөт найдвартай хамгаалах гэж буй бол удирдагчдаа зайлуулах ямар нэг механизмтай байх ёстой. Чөлөөт нийгмийн сонгууль бол зөвхөн удирдагчаа сонгох явдал биш харин бас тэднээ авч хаях тухай хэрэг явдал юм.

Зарим авторитарич үзэлтэн сонгуулиар хэт ондоо бодлого баримталдаг өөр өөр төр засаг гарч бас буудаг учраас түүнээс тогтворгүй байдал л зөвхөн үүсдэг гэж батлан өгүүлдэг. Гэвч

чөлөөт нийгэмд төр засгийн эрх мэдэл хязгаарлагдмал байх учраас тогтворгүй байдал үргэлжлэх хугацаа, цар хүрээ бага байна. Хэрэв төр засаг хуульзүйн бүрэн эрхтэй гэж харагдаж байвал сүйрүүлэх тогтворгүй байдал нь хуульзүйн-дагуухь бүрэн эрхгүй гэж харагддаг байхаас их биш илүү бага байх болно. Гэлээ гээд зэвсгийн хүчээр хуульзүйн-дагуухь бүрэн эрхгүй^[25] төр засаг удаан хугацаанд эрх мэдэлтэй байх боломжтой; гэвч үүний зөвхөн цор ганц өөр хувилбар бол тогтмол хугацаанд болдог эв найртай сонгууль эсвэл гэнэт гарах цуст хувьсгал л байдаг. Чөлөөт нийгэмд албадлага, хүчирхийллийг хязгаарладаг, мөн өөрчлөлт гарах, хөгжил дэвшил хурдан ирэх боломж олгодог сонгуулийг нь л илүүд үздэг.

Хэрэв сонгуулийг хуульзүйн-дагуу хүчин төгөлдөр гэж үзэх бол тодорхой нөхцөлүүд үүнд шаардлагатай. Жишээлбэл намуудын дундаас жинхэнэ сонголт хийдэг байх ёстой. Хэрэв санал өгөх ганцхан нэр дэвшигч л зөвхөн байдаг бол тэр нь чөлөөт сонгууль биш: чөлөөт нийгэмд үргэлж янз бүрийн үзэл бодол байх болно. Энэ байдал нь ондоо ондоо нэр дэвшигчид үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхтэй байх ёстой бөгөөд бусад нэр дэвшигчид болон намаа шүүмжлэх нь чөлөөтэй байдаг. Хүмүүс өшөө авалтаас айх аюулгүйгээр, өөрийн илүү гэсэн нэр дэвшигчээ сонгох ёстой - иймээс саналын хуудас нь нууц байх ёстой. Зарим улс баян нэр дэвшигч эсвэл намуудад давуу тал олгохгүй байх явдлыг бататгах үүднээс сонгуулийн кампанит ажлын зардалд хязгаар тавьдаг. Олон улс оронд одоо байгаа төр засаг буюу засгийн газраар хэзээ сонгууль явуулах хэрэгтэй болохыг шийдүүлэхгүй гэж сонгуулийн хооронд тогтсон хугацаа [хуульд] тавьдаг.

Олон нийтийн шийдвэр гаргах үйл явц

Чөлөөт бус улсуудын ихэнхийн нь төр засаг эрх мэдэлдээ хүч ашиглаж хүрсэн байдаг. Зарим нэг нь хэдий тэдний олон нь

25 *illegitimate government*

хуульзүйн-дагуухь бүрэн эрхээ ил харагдуулах, жишээлбэл шашны эсвэл соёлын өвийн цор ганц хамгаалагч гэж өөрсдийгөө харуулах зэрэг арга зам олсон ч гэсэн хүчээр л энэ эрх мэдэлтэйгээ үлдэнэ. Үүнээс ялгаатай нь чөлөөт нийгэмд төр засаг маш хязгаарлагдмал зорилгоор, олон нийтийн зөвшөөрлөөр, ө.х. тэдний зөвшөөрсөн саналаар л оршдог ажээ.

Бүр ингэсэн ч гэсэн төр засаг хүнийг хохироох явдлаас сэргийлэх, мөн хувь хүн хийх боломжгүй хамтаараа хийх үйлийг үйлдэх зэрэг зорилгоосоо голдуу л зайлсхийдэг. Жишээлбэл төр засаг олон нийтийн бараа үйлчилгээгээр хангах явдлыг голдуу монополизжуулдаг. Олон нийтийн ямар бараа үйлчилгээ үзүүлэх ёстой болохыг хамтын шийдвэрээр шийдэх боломжтой ч гэсэн эдгээр бараа үйлчилгээг нь бүхэлд нь эсвэл хэсэгчилж хувийн байгууллагууд ч нийлүүлж бас үзүүлэх боломжтой байсаар л байна. Жишээлбэл, буяны байгууллага ядарсан, өвчтэй зовлонтой хүмүүст санаа тавьж тэднийг асарч чаддаг. Бохирдлын нөлөө зэрэг бусдад учирч болох хор хохирлоос сэргийлэх явдлын хувьд хохирол учруулах зэргийг нь хэмжихэд төвөгтэй байх боломжтой бөгөөд төр засаг үүнд хөндлөнгөөс оролцох үндэслэл үнэндээ бүрэн дүүрэн байхгүй ч байж болно.

Хэрэв зарим шийдвэрийг хамтаараа гаргах ёстой бол эдгээр шийдвэрийг гаргах ёс журам нь ямар байх вэ? Бүгд санал нэгтэй байх явдал уул нь идеал буюу төгс шийдэл байх болно: хүн бүр шийдвэр гаргах явцад оролцоно, хүн бүр санал нэгдэхгүй бол шийдвэр гаргахгүй. Нэгэнт хүмүүс тэднийг хохироох болно гэж бодсон хамтын үйлийн төлөө санал өгөхгүйгээс хойш хамтын шийдвэрээр аливаа хувь хүн эсвэл хүмүүсийн бүлгийг хохироох боломж эндээс бага л гарах болно.

Гэвч бүгд санал нэгтэй байх явдал^[26]д хүрэхэд хэцүү. Юуны түрүүнд ийм байх нь хүн бүрд санал бүрийг судлах хугацаа өгөх, түүнд саналаа өгөх зэрэг нь маш их цаг хугацаа авсан ажил байна. Тиймээс л бид үүний оронд төлөөлөгчдөө сонгодог. Аливаа нэг

26 unanimity-орос. единогласие

хүний вето буюу эсрэг санал бүхэл төлөвлөгөөг нураах учраас ямар нэг зүйлд санал нийлэх явдал хэцүү тэмцэл байх болно. Ийм учраас л хамтын шийдвэрийг ард олны сонгууль, санал асуулга, эсвэл хууль тогтоох байгууллага дахь санал хураалтын алинаар нь гаргасан ч байсан ерөнхийдөө л олонхи гаргадаг. Энэ нь жирийн олонхи (50 хувь +1) эсвэл шалгуур-хангасан (жишээлбэл гуравны-хоёр) олонхи^[27] байж болно. Энэ байдал шийдвэр гаргах үйл явцын хүндрэлийг багасгадаг ч бас тухайн шийдвэрийг цөөхөн элит буюу дээд ангийнхан гэхээсээ илүүтэй хүн амын нилээд хэсэг нийлж хамтдаа гаргах явдлыг бататгасаар л байх болно.^[28]

Сонгогчийн өөрийн-тусыг бодох явдал

Дуулаачдын уралдааны тэргүүн байрны оролцогчдын хэн нь түрүүлэхийг шүүлгэхээр асуухад нь нэгнийг нь дуулахыг сонсчихоод хоёрдохь хүн түүнээс муу байх боломжгүй гэсэн үндэслэлээр үлдсэн хүнд нь шагнал өгсөн Ромын эзэн хааны тухай түүх бий. Өнөөдөр хүмүүс чөлөөт нийгэм болон чөлөөт зах зээлийн бүтээдэг зүйлд сэтгэл нь ханахгүй байх тэр үедээ төр засгийн үйлдэл аливаа юмсыг сайжруулах болно гэж бодох хандлагатай байдаг. Хэрэв зах зээл батлан хамгаалах эсвэл халамж зэрэг олон нийтийн бараа үйлчилгээг хангаж чадахгүй бол жишээлбэл төр засаг үүнийг хангах нийлүүлэх ёстой гэнэ. Эсвэл үйлдвэр агаар бохирдуулбал төр засгийн хийх үйлдэл үүнийг зогсооход хэрэгтэй гэлцдэг. Гэвч заавал ингэх хэрэгцээ байдаггүй.

Зах зээл хааяа бидний хэрэгцээг үнэндээ хангаж чадахгүй бүтэлгүйтэх боломжтой. Гэвч бид “зах зээл бүтэлгүйтсэн” гэж ярих үедээ бид *төр засгийн алдаа* ч бас үүнд байгааг заавал санаж байх ёстой. Бүр харьцангуй чөлөөт нийгэмд ч төр засаг

27 *a qualified (say two-thirds) majority*

28 Энэ болон түүнээс урган гаргах гол санаануудыг дараахь бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү: Eamonn Butler, *Public Choice – a Primer*, Institute of Economic Affairs, London, 2012. -БАТЛЕР

объектив биш, болгоомжгүй, хүнээс хамаарсан, олон нийтийн-төлөө-бус байгууллага байна. Өөрийн-тусыг бодох явдал төр засагт хаанаасаа хаалгач хүртлээ тархсан байдаг.

Хүмүүс сонгуулийг “олон нийтийн ашиг сонирхол”-ыг таньж мэдэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам гэж төсөөлдөг. Гэвч чөлөөт нийгэмд олон янзын ашиг сонирхол байдаг, тэдгээр ашиг сонирхол хоорондоо зөрчилддөг. Бага татварыг хүсэж буй сонгогчид олон нийтийн сангийн илүү их зарцуулалтыг хүсэж буй тэр хүмүүстэй санал зөрөлдөнө. Шинэ хурдны замаас ашиг тус хүртэх хүмүүс орон сууцаа нураалгах хүмүүстэй сөргөлдөнө. Сонгуулиар олон нийтийн “энэ” ашиг сонирхлыг тогтоож гаргадаггүй. Сонгуулиар зөвхөн хоорондоо өрсөлдөж буй олон ашиг сонирхлыг л тэнцвэржүүлдэг. Зөрчилдөөнтэй энэ суурь дээр үндэслэж хамтын шийдвэрээ гаргана.

Улстөрчийн өөрийн-тусыг бодох явдал

Өөртөө үйлчлүүлэх өөрийн гэсэн ашиг сонирхол сонгогчдод байдгийн адилаар л улстөрчдөд ч ийм зүйл бий. Улстөрчдийн олон нь албан тушаалаа баян болох эсвэл дайснаа дарах зэвсэг гэж хардаг. Тэд бүр хэрэв албан тушаалаа ингэж ашиглаагүй нэгнээ сүл дорой гэж бодож ч чадна. Бүр эрх чөлөө-илүү ихтэй нийгэмд ч хээл хахууль бэрхшээл зовлон байсаар байх боломжтой.

Бүр хэрэв улстөрчид жинхэнээсээ олон нийтэд үйлчлэхийг хүсвэл тэд эхлээд эрх мэдэлд хүрэх ёстой. Тэд сонгогдохын тулд хангалттай санал цуглуулах хэрэгтэй. Гэвч энэ нь олон нийтийн илүү өргөн хүрээг хамарсан бодол санааг илэрхийлэх ёстой гэсэн үг биш юм. Тэд цөөн хүнтэй, төлөөлөл байхгүй цөөнхи рүү хандаж илүү их саналаар ч сонгогдож болно.

Хүчтэй ашиг сонирхолтой цөөн хүнтэй бүлэг тэд нар таатай бодлого гаргуулж авах, өөрсдийн салбартаа татаас авах зэрэг зарим нэг тусгай тодорхой бодолтой байдаг учраас улстөрийн үйл явцад давамгайлдаг. Цөөн хүнтэй, маш дайчин тууштай

байснаараа тэд маш хурдан зохион байгуулалтад орж, кампанит ажилд оролцох, лоббидохдоо илүү их хүчин чармайлт гаргадаг. Гэвч арай тодорхой үзэл бодолгүй хэрэглэгчид эсвэл татвар төлөгчид зэрэг илүү өргөн хүрээг хамардаг хүмүүсийн бүлгийг зохион байгуулалтад оруулахад хэцүү. Тухайн үйлдвэрлэлийн татаас зэрэг бодлогын зардал тэдэнд бүгдэд нь жигд маш бага хэмжээгээр очдог учраас эд [иймхэн зүйлийн төлөө] зүтгэх сэдэл багатай байдаг.

Эвсэл, харилцан наймаалалцах^[29]

Цөөнхийн үзэл бодол давамгайлах явдал ашиг сонирхлын бүлгүүд бусадтайгаа саналынхаа хүч чадлыг нэмэгдүүлэх гэж саналаа багцлахаар хоорондоо гэрээ байгуулбал бүр илүү нэмэгддэг. Тухайн нэр дэвшигчийг орхино гэж бүгдээрээ заналхийлж айлгаж буй ашиг сонирхлын хэд хэдэн бүлгийн эвсэл ганц нэгээрээ буй сонирхлын бүлгээсээ уг нэр дэвшигчид илүү их нөлөөтэй хөшүүрэгтэй байдаг.

Тусгай ашиг сонирхлыг худалдан авах ийм явдал хууль тогтоох явцад ч гардаг. Өөрийн дүүрэгтээ олон нийтийн сангийн зарцуулалтын төсөл хэрэгжүүлэхийг ихээр хүсэж буй улстөрчид мөн өөрсдийнхөө дүүрэгт бусад төсөл хэрэгжүүлэхийг бас л ихээр хүсэж буй хүмүүстэй саналаа наймаалцаж болно. Гэвч *харилцан наймаалалцах* гэж хэлдэг, эдгээр ‘чи миний арга хэмжээнд саналаа өгнө, бид чиний арга хэмжээнд саналаа өгнө’ гэсэн зохицуулалтын хэлцэл бол үр дүнд нь иймэрхүү олон санал санаачилга амжилт олдог, мөн тэр хэрээрээ хүн бүрийн жинхэнээсээ бодсон хэмжээнээс илүү ихээр төр засгийг томруулж данхар болгодог зүйл юм.

Эдгээр хууль хүчин төгөлдөр болж ирэхэд өөрийн-тусыг бодох явдал илүү олноороо тоглолтод оролцож эхэлнэ. Тэдгээр төслийг удирдаж захирах гэж төлөөлөгчөөр явсан албан тушаалтанд ч гэсэн өөрийн гэсэн ашиг сонирхол бий. Тэдний

29 Logrolling

статус, болон цалин хөлс нь олон ажилтантай байхаас нэг талаар хамаардаг бөгөөд тэд санаатайгаар эсвэл санамсаргүйгээр захиргаадалтын үйл явцыг олон ажилтантай байгаагаа зөвтгөх үндэслэлтэй болгох гэж илүү нарийн хэцүү төвөгтэй болгож ч болно - үүнийг нь *эзэнт улс байгуулах*^[30] үйл явц гэнэ. Дахиад л ард нийт гэхээсээ илүүтэй цөөн хүнтэй ашиг сонирхлын бүлэг илүү ихээр тэднийг лоббидох тул тусгай ашиг сонирхолд эд нар ч илүү их автах бөгөөд бүр тэднээс хахууль ч авч магадгүй.

Ёс журам тогтоох

Дүгнээд хэлэхэд төр засгаа сонгох, хууль гаргах, хуулийг хэрэглэх хэрэгжүүлэх^[31]эд сарниж тархсан үзэл бодолтой олонхиос илүүтэй бөөгнөрсөн нэгдмэл ашиг сонирхолтой цөөнх илүү их нөлөөтэй байдаг ажээ. Улстөрийн аргаар гаргадаг шийдвэр олон нийтийн өргөн хүрээний үзэл бодлыг тусгахдаа тун тааруу. Хүмүүсийн ихэнхи хүсдэгээс, мөн учир утгатай байхаасаа, бас чөлөөт нийгмийг сахин хамгаалахад шаардлагатайгаас илүү их болж үнэндээ эрх чөлөөг ганхуулж сулруулах тэр цэг хүртлээ данхар болдог төрөлхи хандлага төр засгийн салбарт бий.

Эрх чөлөө-илүү ихтэй нийгэм эдгээр асуудлыг хязгаарлахаар оролдож янз бүрийн ёс журам, дүрэм журам баталж гаргадаг. Сонгууль бол үүний амин чухал хэсэг юм. Гэвч сонгууль улстөрчид, албан тушаалтнуудыг хязгаарлах хүч муутай хязгаарлалт байдаг. Сонгууль ховорхон болдог, түүнд том намууд голдуу л давамгайлдаг нь өөрчлөлтийг удаашруулдаг ажээ. Үүнээс хүчтэй хязгаарлалтыг тэдэнд тавих хэрэгтэй.

Үндсэн хуулийн гэрээ

Улстөрийн үйл явцыг хязгаарлах их тархсан арга зам бол хүн бүрийн санал нийлсэн, эсвэл дийлэнхи олонхи^[32] санал нийлсэн,

30 *empire building*

31 *administering laws*

32 *overwhelming majority*

сонгууль явуулах, улстөрийн шийдвэр гаргах ёс журмыг тогтоож гаргасан үндсэн хууль батлан, түүнээ хэрэглэх явдал юм. Хэрэв хүн бүр ёс журам ямар байх талаар санал нэгдэх ёстой байдаг бол төр засаг өөрийн ашиг сонирхлын төлөө зохиомжилж гаргасан, жишээлбэл сөрөг хүчнийхээ нэр дэвшигчийг хориглох, эсвэл сөрөг хүчний сонгогчдод зохих байдлаас давсан татвар оногдуулах зэрэг ёс журам түүнд тулгаж хүлээн зөвшөөрүүлэх ямар ч боломжгүй болно.

Улстөрийн үйл явцыг *эрх мэдлийг зааглаж-хуваах*^[33] замаар улам цааш нь хязгаарлах боломжтой. Нэг хүн эсвэл нэг байгууллагыг хууль-гаргах эрх мэдлээр бүрэн зэвсэглэхийн оронд засаг захиргаа^[34]г өөр өөр институтэд хувааж-салгах, нэг бүр нь бусдынхаа хийж чадах зүйлийг блоклох, өөрчилж засах эсвэл хязгаарлах боломжтой байх нь эрх мэдлийг зааглаж-хуваахын гол санаа юм. Энэ үндэслэлээр үүнийг заримдаа *харилцан-хянах, эрх мэдэл-тэнцвэржүүлэх* тогтолцоо^[35] гэдэг.

Хэрэв улстөрийн товчоо эсвэл хууль тогтоох зөвлөл зэрэг нэг байгууллагад бүх эрх мэдэл байвал улстөрийн олонхи, баг болсон ашиг сонирхлын бүлгүүд тэр байгууллагыг өөрийн ашиг тусын төлөө булаан авахаар мэдээж оролдох болно. Гэвч хэрэв үндсэн хуулиар төр засгийн эрх мэдлийг хоёр ондоо танхимд хуваавал сонирхлын бүлэг эрх мэдэл булаан авах явдлыг илүү хэцүү болгоно. Хэрэв энэ хоёр танхимыг өөр өөр байдлаар сонгодог бол нэг баг болсон нэг ижил ашиг сонирхолтой бүлгүүд тэр хоёрт хоёуланд нь давамгайлахад бүр л хэцүү байх болно. Хэрэв аль ч танхим нь нөгөө нэгнийхээ гаргасан шийдвэрийг зогсоож блоклох, өөрчилж засах боломжтой бол харилцан наймаалалцах^[36] үйл хийх, цөөнхийг ашиглаж мөлжих явдал бүр л хэцүү байсаар байх болно.

33 *separation of powers.*

34 *authority*

35 *system of checks and balances*

36 *logrolling*

Харилцан-хянах болон эрх мэдэл-тэнцвэржүүлэх энэ тогтолцооны түшиц газар^[37] болгож эрх чөлөө-илүү ихтэй нийгмийн олон үндсэн хуулинд мөн ерөнхийлөгчийг нийт ард олны төлөөлөгч болгож томилдог - энэ ерөнхийлөгч (тэдний итгэдгээр) улстөрийн тэмцлийн дээр зогсож, цөөнхийг хохироож буй тогтоол шийдвэрт вето буюу хориг тавьж чадах ажээ.

Ашиглалт шамшигдуулалтын эсрэг байх өөр нэг түшиц газар бол *бие даасан шүүх тогтолцоо*^[38] юм. Шүүх тогтолцоо чөлөөт нийгэмд амин чухал. Шүүгчид улстөрийн чиг баримжаатай байх ёсгүй, үндсэн хуулийн бус хуулийг болон цөөнхийг ашиглаж мөлжсөн хуулийг өөрчлөх хүчингүй болгох чадалтай байх ёстой – мөн ингэхдээ улстөрчид тэднээс өшөө авах явдлаас айх аюулгүйгээр үүнийгээ хийх боломжтой байх ёстой.

Заримдаа үндсэн хууль төр засгийн үйл ажиллагаанд тэнцвэртэй төсөв зэрэг бусад хязгаарлалт тавьдаг – тэнцвэртэй төсөв гэдэг нь уг төсөв тодорхой зарим нэг хугацаанд тэнцвэржсэн байх ёстойг (жишээл гурваас таван жилийн хугацаанд), мөн жилд зээлэх хэмжээ, олон нийтийн нийт өрийн хэмжээнд *төсвийн хязгаарлалт* тогтоох зэргээр тулгаж шаардсан байдаг. Заримд нь бүр төрөлхийн данхар болж томрох хандлагыг нь хорьж багасгахын тулд төр засаг зарцуулж болох үндэстний нийт орлогын хувийн хязгаар тавьдаг. Дээр нь нэмээд улстөрч албан тушаалд олон жил үлдэх боломжгүй байхаар *хугацааны хязгаар* тавьж болно, мөн төр засгийн байгууллага өөрийн хэрэгцээтэй байдлаа сунгаж уртасгахаас нь сэргийлэх^[39] *үйл ажиллагаа дуусгавар* болох заалт^[40] ч оруулж болно.

37 *longstop-крикет гэдэг спорт тоглоомд жижиг босоо шоны ард зогсож бөмбөг хаадаг байршилийг хэлнэ. Үүнийг зүйрлэсэн утгаар хэлснийг ингэж буулгалаа.*

38 *independent judiciary*

39 *to prevent government agencies outliving their usefulness*

40 *sunset clauses*-Олон нийтийн бодлогод тухайн хуулийг тодорхой заасан хугацааны дараа, түүнийг нь хууль тогтоох үйлдлээр сунгаагүй бол үйлчлэл нь дуусгавар болохыг заадаг заалтыг хэлнэ.

Шалгуур-хангасан олонхи

Цөөнхийг хамгаалах нэмэлт арга зам бол шалгуур-хангасан олонхийн санал авах явдал^[41] юм. Жишээлбэл хэрэв засаг барьж буй засаг захиргаа үндсэн хуулийн ёс журмыг хууль тогтоох явцын энгийн санал хураалтаар өөрчлөх боломжтой байсан бол эрх чөлөө аюулд орж, баталгаатай бус байх болно. Тиймээс чөлөөт нийгэмд үүнээс давсан их хориг саад тавьдаг – энэ нь хоёр танхимын гуравны-хоёрын саналаар, дээр нь бүх нийтийн эсвэл бие даасан муж эсвэл төр улсын нийтийн санал асуулгын маш өндөр хувийн хязгаар тавих явдал байж болно.

Цөөнхийг хамгийн ихээр хохироох арга замаар ашиглаж мөлжих явдал хялбар байх боломжтой асуудлын талаархи шийдвэрийг олонхийн саналын маш өндөр хувиар шийдвэрлэх ёстой. Жишээлбэл тодорхой бүлэг хүнд маш их хэмжээний татвар оногдуулах боломжтой татвар зохиомжилж оноох хялбар байдаг. Тийм учраас бүр олонхи нь бүр маш олуулаа байсан ч гэсэн цөөнхийг хамгаалахын тулд татварын хэмжээг тогтоолгүйгээр харин хэн ямар татвар төлөх ёстой болохыг заасан татварын ёс журмыг бүх хүний санал 100 хувийн санал^[42]аар шийдвэрлэх ёстой гэдгийг чөлөөт нийгмийн зарим хамгаалагчид шаарддаг.

Барьцаалагдсан олон нийт

Зах зээлийн эдийн засагт хэрэв арилжаа хийж буй хүн та нарыг хуурч байна эсвэл танд бага ханш өгч байна гэж үзвэл та нар өөрийн бизнесээ хүссэн газартаа очиж эрхлэх нь чөлөөтэй байна. Гэвч хэрэв төр засаг чинь та нарыг хуурвал эсвэл ашиглаж мөлжвөл хаашаа ч явах арга үгүй. Та нар магадгүй улс орноо орхиж болох юм – гэвч тэндхийн байгаа хэлний болон бусад саад тээг ихэнхи хүмүүсийг ийм зүйл хийх аргагүй болгодог. Энэ байдал бол албадлагад зориулсан жор юм – энэ байдлаас

41 *qualified majority voting-qualified majority (55% of member states, representing at least 65% of the EU population-Тодорхой нөхцөл заасан олонхийн санал*

42 *decided unanimously*

болж хүн амын эрх чөлөөг хадгалж үлдэх, тэлж өргөжүүлэхэд шаардлагатай байхаар л төр засгийн үүрэг нөлөө, үйлдлийг түүний бүх хэсэгт нямбайлан тусгаж өгч, чандлан хязгаарладаг байх явдал илүү чухал болдог.

4 ТЭГШ БАЙДАЛ, ТЭГШ БУС БАЙДАЛ

Чөлөөт нийгэм дэх тэгш байдал

Олон хүн чөлөөт нийгэмд тэгш бус байдал маш их байна гэж төсөөлцгөөдөг. Эцсийн эцэст ийм нийгэм л хүмүүс ихэд баялгийн төлөө тэмүүлж, түүнийг асар ихээр хуримтлуулах боломж олгодог. Энэ байдал (энэхүү гаргалгаа нотолгоо харуулдагчлан)-аас заавал эдийн засгийн асар их тэгш бус байдал үүсэх ёстой ажээ.

Гэвч энэ гаргалгаа нотолгоо буруу. Бидний харсанчлан чөлөөт болон чөлөөт бус улс орнуудын орлогын ялгарал хоорондоо бараг л адилхан. Ямар ч тохиолдолд эрх чөлөө-илүү ихтэй нийгэмд аливаа зүйл бага зэрэг илүү тэгш байдалтай байдаг.

Цаашилбал чөлөөт бус нийгэмд эрх чөлөө-илүү ихтэй нийгэмд байдаггүй бусад, санхүүгийн биш тэгш бус байдал бий. Чөлөөт нийгмийн иргэн бүр өөрийн эд хөрөнгө болон орлогоо илүү сайн ажилд орох, эсвэл ашиг хүртэж болох санхүүгийн үйл ажиллагаанд оролцох замаар нэмэгдүүлэхээр тэмүүлэх боломжтой. Чөлөөт бус нийгэмд ийм зүйл ерөөсөө хийх боломжгүй. Энд төр засгийн ажил зөвхөн засгийн эрх барьж буй намыг дэмждэг хүмүүст, эсвэл засгийн эрх барьж буй хүмүүсийн найз нөхөд болон хамтрагч нарт л нээлттэй байж болно. Хууль, эсвэл тогтчихсон хэвшмэл үзэл^[1] эмэгтэйчүүд, угсаатны цөөнх, эсвэл бусад бүлгийг тодорхой мэргэжлээр ажиллахыг нь хорьдог ч байж болно. Тодорхой арьсны өнгөтэй хүмүүс эсвэл нийгмийн кастын хүмүүсийг хамгийн хар муу ажил хийхээр хязгаарлаж

1 *prejudice*

болно. Мөн цагаачдад бизнес эрхлэх, өмч өмчлөх эсвэл бүр банкны данстай байхыг нь ч хориглодог байж болох юм.

Бүр ажилд орсон хүмүүсийн дунд ч тэгш бус байдал байнга л оршсоор байдаг. Жишээлбэл Зөвлөлтийн үеийн Москва хот дахь Улаан Талбайн ГУМ тусгай их дэлгүүр зөвхөн хатуу-валюттай жуулчид болон Намын дээд албан тушаалтнуудад л нээлттэй байсан. Сүүлд нь дурдсан тэр хүмүүс л Зил лимүзинээр зорчихоор мөрөөдөх эсвэл тэднийг явуулахын тулд замын хөдөлгөөн зогсоох, эсвэл ой модтой эмчилгээний сувилалд сарын турш амрах эрх эдлэх боломжтой байлаа. Найз нөхдөдөө илүү сайн орон сууцаар тал засаж ирсэн засаг захиргааны ажилтнууд орон байр, амралтын өдрийн зусланг олгож байв.

Энэ бүх тэгш бус байдлаас зайлах ямар ч аргагүй: эдгээр тэгш бус байдлаас хохирдог хүмүүс санал өгөх эрх байхгүй эсвэл тэр хуулийг өөрчлүүлэхээр кампанит ажил зохион байгуулах ч эрх байхгүй. Үүнээс ялгаатай нь чөлөөт нийгмийн бүх гишүүд дор хаяж л сайн ажилтай болох эсвэл бизнес эхлүүлж эрхлэх, эд баялаг болон орлого олохоор мөрөөдөж тэмүүлэх боломжтой байдаг. Тэр хүмүүс бүгд ингэж чадахгүй байж болох ч хэн ч тэднийг ингэхийг нь чөлөөт нийгэмд хориглодоггүй.

Тэгш байдлын төрлүүд

Чөлөөт нийгэм дэх тэгш байдал хүмүүст ижил тэгш эд баялаг эсвэл орлого, эсвэл амьжиргааны төвшин батлан олгох тухай асуудал биш. Энэ нь хүмүүстэй нэг ижил байдлаар хандах явдлыг л баттай болгох тухай яриа байдаг.

Хүмүүстэй ижил байдлаар хандах дөрвөн чухал арга зам бий.^[2] Чөлөөт нийгмийн иргэд ёс суртахууны тэгш байдалтай байдаг: тэд тус бүрдээ өөрсдийнхөө төлөө сонголт хийх, өөрийг нь анхаарч харьцах, бусдаар хүндлүүлэх нэг ижил эрхтэй. Тэнд

2 Эдгээр санааны сайн тайлбарыг дараахь бүтээлээс унших боломжтой: Nigel Ashford's *Principles for a Free Society*, Jarl Hjalmarson Foundation, Stockholm, 2003-БАТЛЕР

мөн хуулийн өмнөх тэгш байдалтай байдаг: хуулиар тэднийг хамгаална, тэдэнтэй арьсны өнгө, шашин, хүйс, эд баялаг, эсвэл гэр бүлийн холбоо хэлхээнээс үл хамаарч яг адилхан хандана. Тэдэнд *улстөрийн тэгш байдал* байдаг: тэд бүгдээрээ улстөрийн албан тушаалын төлөө санал өгөх, мөн албан тушаалд очихоор өрсөлдөх боломжтой. Тэд бас *боломжийн тэгш байдалтай* байдаг: ажиллах, эсвэл боловсрол олж авах, эсвэл өөрийгөө хөгжүүлэхэд нь аливаа нэг дур зоргын саад тотгор байх ёсгүй.

Ёс суртахууны тэгш байдал

Чөлөөт нийгэмд өөрт нь анхаарч харьцах, бусдаар хүндлүүлэх ижил тэнцүү үнэ цэнэтэй гэж өөрсдийгөө хүмүүс боддог. Тэд бүгдээрээ энэ үеэр бусдад хохирол учруулахгүй л бол өөрийн амьдралынхаа талаар сонголт хийх ижилхэн эрхтэй.

Энэхүү үзэл бодол хүмүүн төрөлтний хувьд бид бүгдэд байдаг чухам тэр л зан чанарын талаархи гүнзгий итгэл үнэмшилд тулгуурладаг. Бид бүгдээрээ угсаа гарал, шашин шүтлэг, эсвэл жендер буюу нас хүйснээсээ үл хамаарч өөрийн сонголтоо хийхийг хүсдэг; бид бүгдээрээ бусдын чухам ингэх эрхийг нь хүндлэхийг хүсдэг. Чөлөөт нийгмийн дүрэм ‘тантай яаж харьцаасай гэж хүснэ түүнийгээ үйлд’^[3] байх болно.

Хүмүүс үйл хийхдээ ижил тэгш ёс суртахуунтай байдаг гэж хэлж байгаа явдал биш билээ. Хүмүүс рүү халдаж дайрдаг, эсвэл тэднийг дээрэмддэг хүмүүс ёс суртахуунтай байдлаар үйл хийдэггүй. Зарим нь албаар нийгмийн эсвэл сексийн уламжлалт зүйлс^[4]ийг зөрчдөг. Гэвч ингэсэн ч гэсэн тэдний амь нас үнэ цэнэтэй хэвээр үлдэнэ. Тэдний хууль зөрчих явдал эсвэл ёс суртахуунгүй байдал ял шийтгэлд унах эсвэл гэмт үйлдэлтэй нь тохирсон шийтгэл хүлээх үүдийг тэдэнд нээдэг. Гэвч энэ нь

3 do as you would be done by

4 social or sexual conventions

тэднийг дур зоргын, хэтэрхий харгис, доромжлон гутаах^[5] үүд хаалгыг нээдэггүй.

Хуулийн өмнөх тэгш байдал

Чөлөөт нийгмийн хуулиар хүнээс үл хамаарсан байдлаар хүмүүсийг хамгаалж, бас шийтгэдэг. Гэмт этгээд^[6]эд гэмт хэрэгтэй нь холбоогүй тэдний эд баялаг, холбоо сүлбээ, каст буюу нийгмийн давхарга, жендер буюу нас хүйс, шашин эсвэл угсаатны байдал зэрэг зарим нэг хувийн чанарт үндэслэж цагдаа, шүүх, эсвэл шоронд ондоо ондоо хандах ёсгүй. Зүгээр л засаг захиргаа тэдэнд дургүй учраас иргэд дур зоргын баривчилгаа, эсвэл мөрдөж мөшгөгдөх явдалд өртөх ёсгүй. Хүн бүр хэрэв тэд хохирсон эсвэл бусдад дээрэмдүүлсэн бол өөрсдөө хэн байх, тэдний буруутгаж буй хүн ямар ч алдар нэртэй байхаас үл хамаарч шүүхэд хандах ижил тэнцүү боломжтой байна.

Дэлхий-дэхний шүүхийн байшингийн дээрх хөшөөг шударга ёсны дүр болгож голдуу нэг гартаа жин, нөгөөдөө илд барьснаар харуулсан байдаг. Гэвч энэхүү дүрийн хамгийн чухал хэвшинж бол нүдээ халхалж боосон байдал юм. Чөлөөт нийгэмд шүүх хэрэг нэг бүрийн тохирох баримт нотолгооноос бусад зүйлд сохор харалган байдаг.

Улстөрийн тэгш байдал

Хүмүүн төрөлтөн болохынх нь хувьд хүмүүст байдаг зан чанараас үндэслэж гардаг тэгш байдлын өөр нэг хэлбэр бол улстөрийн тэгш байдал юм. Хүн бүрийн ашиг сонирхол болон үзэл бодол анхаарал хандуулахуйц үнэ цэнэтэй. Тиймээс чөлөөт нийгэмд хүн бүр сонгууль эсвэл бүх нийтийн санал асуулгад санал өгөх эрхтэй бөгөөд хэн ч нэгээс илүү санал өгөх ёсгүй. Энэ байдал л хүн бүрийн ашиг сонирхлыг нэр дэвшигч, мөн сонгогдсон улстөрч анхаарах ёстой болгодог.

5 arbitrary or excessive cruelty and humiliation

6 Offenders

Сонгуульд санал өгөхгүй байх нөхцөл маш цөөн байдаг^[7]. Бид нар хүүхдүүдийг санал өгөх явдлаас хасдаг. Учир нь хүүхдүүд тэднийг болон бусад хүмүүсийг хэрхэн засаглаж удирдах талаар анхаарал хандуулахуйц санал бодол гаргахаар хангалттай боловсорсон насанд хүрээгүй гэж үздэг. Үүнтэй адилаар сэтгэцийн хурц өвчтэй хүмүүсийг санал өгөх явдлаас хасдаг; гэвч иймэрхүү чадамжгүй байдл^[8]ыг эрх барьж буй элитүүд буюу дээд ангийнхан сөрөг хүчнийхээ өрсөлдөгчдөө энэ үндэслэлд тулгуурлаж санал өгөх явдлаас хасахаас нь сэргийлэхийн тулд бие даасан байдлаар үнэлж цэгнэх ёстой.

Гэмт хэрэг үйлдэж шийтгэгдсэн гэмт хэрэгтнүүд санал өгөхийг нь зөвшөөрөх ёстой гэдэг талаар санал хуваагдсан байдаг. Зарим улсад шоронд буй хүмүүс санал өгөх эрхээ хууль ноцтойгоор зөрчсөн хүмүүс хууль бүтээх үйл явцад оролцох ёсгүй гэсэн үндэслэлээр алддаг. Бусад улс оронд хамгийн ноцтой гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө хоригдож буй хүмүүсийг л хасдаг. Гэлээ гээд үлдсэн улс орнуудад гэмт хэрэгтнүүдийг хүмүүн төрөлтөн болохынхоо хувьд бид бүгдэд байдаг тэр зан чанарын үнэ цэнээр санал өгөх бүрэн эрхтэй гэж үздэг.

Улстөрийн тэгш байдлын зарчим гэдэг нь эмэгтэйчүүд эрчүүдийнхээ адилаар санал өгөх эрхтэй гэсэн үг билээ – хэдийгээр бүр харьцангуй чөлөөт нийгэмд ч энэхүү эрхийг зуун жилийн өмнө л гэхэд хүлээн зөвшөөрдөггүй байсан. Шинэ Зиланд анх удаа насан хүрсэн эмэгтэйчүүдэд санал өгөх эрхийг 1893 онд батлан олгожээ. Австрали 1902 онд үүнтэй ижил зүйл хийсэн ч гэлээ 1962 он хүртэл Аборигени буюу уугуул эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийг нь тууштай эсэргүүцэж бас хязгаарлаж байв. Европын ихэнхи улс оронд Дэлхийн Нэгдүгээр Дайны дөнгөж дараахан эмэгтэйчүүд санал өгөх эрхийг нь зөвшөөрсөн бол харин Францад дөнгөж 1944 оны сүүлээр, Швейцарт бүр 1971 онд зөвшөөрчээ.

7 *exceptions*

8 *incapacity*

Санал өгөх эрхийг хориглох явдлыг чанд хязгаартай байлгах хэрэгтэй. Чөлөөт бус улс орнуудын засаг захиргааны хувьд өөрсдийн дайснуудынхаа санал өгөх явдлыг тэднийг шоронд суулгах, эсвэл сэтгэцийн хувьд санал өгөх чадамжгүй гэж зарлах, эсвэл бусад хориглох янз бүрийн зүйлээр хялбархан үгүйсгэж эрхээс нь татгалзуулдаг. Энэ байдал бол эрх мэдлээ урвуулан ашиглаж буй явдал юм.

Аль болох боломжийнх нь хэрээр хүн бүрийн саналыг ижил тэнцүү тооцож байх хэрэгтэй. Жишээлбэл төлөөлөгчдийг сонгох сонгуулийн дүүрэг бүр дэх сонгогчдын тоо ойролцоогоор ижил байх ёстой. Илүү том дүүрэг гэдэг нь тэндхийн санал бүр үр дүнд илүү бага нөлөөлнө гэсэн үг. Маш ондоо хэмжээтэй дүүрэгтэй байх цор ганц үндэслэл бол газарзүйн байршлын зайлах аргагүй нөхцөл байдал юм. Сонгуулийн тойргийг хил заагийг эрх барьж буй байгууллага шахаж тулгах аргагүй, бие даасан байгууллага шийдэх ёстой.

Санал өгөх эрхийнхээ хажуугаар хүн бүр албан тушаалын төлөө нэр дэвшиж өрсөлдөх, албан тушаалд суух ижилхэн эрхтэй байдаг. Хууль тогтоох байгууллагад тодорхой нас хүйс, арьстан, эсвэл шашны хүмүүст хориотой ямар ч суудал байх ёсгүй. Сонгуулийн тогтолцоо^[9]гоор жишээлбэл хэн ч, ялангуяа засгийн эрх барьж буй улстөрийн засаг захиргаа буюу эрх мэдэлтний заналхийлэлд орохгүй байх эсвэл мөрдөж мөшгөгдөх айдасгүйгээр албан тушаалын төлөө нэрээ дэвшүүлэн өрсөлдөх боломжийг бататгаж, энэхүү тэгш байдлыг сахин хамгаалах ёстой. Энэ байдал нь тэр хүмүүс кампанит ажлаа чөлөөтэй явуулдаг, үзэл бодлоо чөлөөтэй ярьдаг, хэвлэн нийтэлдэг, нэвтрүүлгээр нийтэд чөлөөтэй цацдаг, мөн бусад нэр дэвшигчдээ шүүмжилдэг, үнэндээ хуулийг болон үндсэн хуулиа чөлөөтэй шүүмжилдэг байх ёстой гэсэн үг юм. Сонгуулийг үзэл санааны уралдаан өрсөлдөөн гэж үздэг бөгөөд хэрэв үзэл санаа, үг хэлэх эрх чөлөө^[10]г дарангуйлж байвал тэнд чөлөөт сонгууль болох

9 *electoral system*

10 *ideas and free speech*

боломж байхгүй. Зарим чөлөөт бус улсад төр засгаа шүүмжлэх нь эрүүгийн гэмт хэрэг байдаг; эрх чөлөө-илүү ихтэй нийгэмд иймэрхүү шүүмжлэл улстөрийн өдөр тутмын хэлэлцүүлэгт ерөөсөө хэвийн зүйл байдаг.

Боломжийн тэгш байдал

Боломжийн тэгш байдал гэдэг нь хувь хүмүүс өөрийн алсын бодолдоо хүрэхээр тэмүүлэх, боловсрол олохоор зүтгэх, ажилд орохоор хүсэх, эсвэл амьдралынхаа бусад хэсэгт амжилтад хүрэхээр тэмүүлэхдээ зохиомол саад тотгортой тулгарахгүй байна гэсэн үг юм. Тэдний арьсны өнгө жишээлбэл сургууль явах эсвэл спортын багт ороход нь саад тотгор болох ёсгүй. Тэдний улстөрийн явдал болон жендер ажлаа солихоос тэднийг зогсоож хориглох нөхцөл байх ёсгүй. Бас ядуу байдал эсвэл нийгмийн анги нь тэднийг өөр нөхцөл байдалтай хэн нэгэнтэй гэрлэхийг нь зогсоож хориглох шалтгаан болох ёсгүй.

Гэвч энэ байдал нь сургууль эсвэл ажил олгогч, эсвэл өөр хэн нэгнийг мэргэжсэн байдлыг нь харгалзаж үзэхгүйгээр хүн ажилд ав гэж албадна гэсэн үг биш юм. Сургууль элсэн орох сурагчдаа элсэлтийн шалгалт давсан хүнээр хязгаарлаж болно, харин ажил олгогч лавлагаа мэдээлэл^[11], туршлага тэднээс шаарддаг ч байж болно. Ганц бие бүсгүй эрэгтэй хүн түүнд зүрх сэтгэлээ өгсөн учраас л түүнтэй гэрлэдэг байх ёсгүй. Боломжийн тэгш байдал гэдэг нь хэн нэгний замд ямар нэг зохиомол саад тотгор тавихгүй, мөн тэднийг хүсэхгүй байгаа зүйлийг нь хүчээр хийлгэх гэж албадахгүй л гэсэн үг юм. Жишээлбэл урьдаас зохион байгуулсан гэрлэлт^[12] зарим соёлд нийтлэг байдаг бөгөөд гэрлэлтийг чөлөөт нийгэмд хос хоёрын хоёулынх нь зөвшөөрсөн саналаар хүлээн зөвшөөрөмтгий байдаг. Гэвч бүр хэрэв тэдний эцэг эх нь ингэхийг шаардсан ч гэсэн хүмүүсийг хүчээр хүслийнх нь эсрэг гэрлүүлэхээр албадах боломжгүй. Чөлөөт нийгэмд

11 reference

12 arranged marriages

Асуулт: Ядуу улс лимүзин худалдаж авах эрх чөлөө байхгүй гэж үү?

Тиймээ, тэд ингэж чадахгүй. Чөлөөт нийгэмд хүн бүр цөөхөн хүн ингэж чадах боломжтой байдаг ч тансаг бараа бүтээгдэхүүн худалдан авах нь чөлөөтэй байдаг. Энэ бол эрх чөлөөний биш харин хүч чадлын хэрэг явдал; илүү ядуу хүмүүс том машин худалдан авах худалдан авах чадваргүй байдаг; гэвч ямар ч хүн эсвэл засаг захиргаа буюу эрх мэдэлтэн том машин худалдан авахыг нь хориглодоггүй. Аливаа хүн мөнгө олохын тулд шаргуу ажиллах, хадгалж хураах эсвэл бүр зээлэх замаар тансаг зүйл олж авахаар тэмүүлэх боломжтой.

Мөн бүр дэлхийн хөрөнгө чинээтэй, хамгийн эрх чөлөөтэй нийгмийн ядуу иргэд ч хэдхэн арван жилийн өмнө л гэхэд тансаг хэрэглээ байсан гэр орны халаалт, гэрэл, эрчим хүч, цэвэр ус зэрэг зүйлийг одоо таашаан эдэлдэг гэдгийг эргэн санана уу. Чөлөөт бус нийгэмд үүнээс ялгаатай нь хүмүүс бүр том орон сууц, эсвэл илүү үржил шимтэй фермийн талбай зэрэг зүйлийн төлөө хэрэв засаг захиргаа нь тэдэнд эдгээр зүйлийг батлан олгоогүй л бол тэмүүлж зүтгэх ч боломжгүй байдаг.

гэрлэхэд хангалттай насанд хүрсэн гэж хэн нэгнийг үзэх нь тэд өөрсдөө сонголттой хийхэд хангалттай эрийн цээнд хүрсэн гэж үзэж буй хэрэг. Бусад аливаа гэрээний адилаар гэрлэлт хэрэв аль нэг хамтрагчийг нь гэрлүүлэхээр албадаж хүчилбэл хүчин төгөлдөр бус болно.

Хэдийгээр хүмүүс амьдралынхаа сонголт хийх үедээ нийгмийн ямар нэг саад тотгортой нүүр тулах ёсгүй байдаг ч гэсэн байгалийн тэгш бус байдалтай мэдээж учирдаг. Дүлий төрсөн зарим хүн хөгжмийн зохиолч эсвэл найрал хөгжим удирдаач болох боломжгүй (гэсэн хэдий ч өтөл насандаа Бетховен ингэж чадсан байдаг). Хөл гаргүй хүн ууланд авирахаар тэмүүлэхгүй.

Гэр бүлийнхээ нөхцөл байдлаас болж хүүхдүүд амьдралаа өөр өөр орчноос эхэлдэг: нэгнийх нь эцэг эх тэдэнд ном худалж авч өгөх, мөн хичээлд нь туслах чадалтай байх бол харин нөгөө нэгнийх нь эцэг эх тэдэнд анхаарал тавьдаггүй байх боломжтой.

Өрнөдийн зарим хүмүүс бүр хэдий хүүхдүүд амьдралаа өөр өөр нөхцөлөөс эхэлдэг ч гэлээ тэднийг насанд хүрэх үедээ, ажилд орохдоо нэг ижил байр сууринд байхыг сургуулиар нь дамжуулан бататгахыг зорих ёстой гэж батлан өгүүлцгээдэг. Үүний дагуу сургууль асар их нөөц баялгийг залруулах боловсрол^[13]д зарцуулахад төвлөрүүлж, “авьяастай” хүүхдүүдийн чадварыг бүрэн нээхийн оронд бусадтай “доош татаж тэнцүүлдэг” байна. Гэвч бодит байдал дээр бид байгалийн төрөлхийн ялгааг нөхөн тэнцүүлж чадахгүй бөгөөд нийгмийн ялгааг нөхөн тэнцүүлэх гэсэн цор ганц арга зам төр эцэг эхээс нь хүүхдийг нь төрөхөд нь авч, яг адилхан байдлаар өсгөнө гэсэн аймшигтай хэтийн төлөвл байх болно.

Позитив буюу эерэг ялгаварлан гадуурхалт^[14]

Зарим улс орон [хүмүүсийн] төрөлхийн ялгааг нөхөн тэнцвэржүүлэх гэж оролддог бөгөөд эерэг ялгаварлан гадуурхалтын хөтөлбөрөөр ийм урьдаас тогтчихсон байдлыг эвдэх гэнэ. Энэ явдалд тодорхой боломж гар хүрэх газарт нь байдаг гэдгийг төсөөлж ч байгаагүй цөөнхи рүү, жишээлбэл хэзээ ч хамгийн нэр хүнтэй их сургуулиуд руу элсэх өргөдөл өгнө гэж бодож байгаагүй авьяастай ухаантай боловч ядуу хүүхэд рүү зүгээр л хүрч нөлөөлж, тэдний ингэж оролдоод үзэх явдлыг хөхиүлэн дэмжих явдал багтаж болно. Иймэрхүү дэмжлэг^[15] болон хөхиүлэн дэмжих явдал зүгээр л хүмүүсийн эдгээр бүлэгт байгаа боломжийг нэмэгдүүлдэг учраас түүнийг муушаах аргагүй.

13 remedial education

14 Positive discrimination

15 outreach

Гэвч эерэг ялгаварлан гадуурхалт цөөнхийн бүлгийг илүүд үзэх явдлын нэг хэлбэр мөн болж болох юм – жишээлбэл цөөнхийн олон горилогч элсүүлэх эсвэл ажилд авахыг хүчлэхийн тулд сургууль болон ажил олгогчид квот тулгаж өгөх явдал байна. Тодорхой цэг хүртэл энэ нь нийцтэй байж болох юм: магадгүй 1960-аад оноос энэ хүртэл АНУ-д үргэлжилж буй позитив ялгаварлан гадуурхалт хар арьстнуудад сургууль болон ажлын байранд ур чадвараа харуулах боломж болгосон байж болох бөгөөд энэ нь мөн тэдний эсрэг хандсан цагаан арьстнуудын тогтчихсон үзлийг эвдэж устгахад дэм болсон байж ч болох юм. Гэвч эерэг ялгаварлан гадуурхалт чөлөөт нийгэмтэй нийцэхгүй. Энэ нь урьдаас тогтчихсон үзл^[16]ийг эвдэхэд тус болж, мөн эрх чөлөөг тэтгэж болох ч гэлээ энэ нь хүмүүстэй ижил тэнцүү харьцахын оронд тодорхой бүлэгт нь л илүү таатай ханддаг.

Зарим хүн цөөнхийн эсрэг хийж асан өнгөрсөн үеийн сөрөг ялгаварлан гадуурхалтынх нь төлөөсийг өгч буй гэсэн үндэслэлээр ингэж бусдаас чухалчилж үзэх, квот олгохын төлөө маргаж мэтгэлцдэг^[17]. Гэвч өнгөрсөн зүйл бол өнгөрсөн зүйл билээ^[18]: өнөөдөр зарим нэг хүмүүст таатай хандах гэж эерэг байдлаар ялгаварлан гадуурхах нь бусад хүмүүс нь энэхүү цөөнхийг өнгөрсөн цаг үед хохироож байсан шударга бус байдлыг залруулахгүй. Ижилхэн сургууль эсвэл ажилд орох боломжтой болохын тулд илүү их төвшинд хүрэхээр тэмүүлэх ёстой болдог олонхийн хувьд иймэрхүү бодлого шударга бус гэж харагдаж ч болно. Цөөнхи давуу эрхтэй шинэ анги болж харагддаг байж болох бөгөөд бүр тухайн бодлого түүнээс ашиг тус хүртдэг цөөнхийн эсрэг дургүйцэл гаарч эсвэл хүчирхийлэл ч гарах нөхцөлийг үүсгэх болно.

16 *prejudice*

17 Ийм зүйл одоо Шинэ Зиландад ид өрнөж байна. Мауричуудад эрт цагт учруулсан хохирлыг өнөө цагийн Европ арьстнууд нь төлөх ёстой, мауричуудад тусгай хангамж үзүүлэх хэрэгтэй гэсэн үзэл гарч байна.

18 *But bygones are bygones*

Негатив буюу сөрөг ялгаварлан гадуурхалт^[19]

Ялгаварлан гадуурхах явдал мэдээжээр үргэлж цөөнхөд туслах зорилготой байж ирсэнгүй. Бүр дийлэнхидээ цөөнхийн бүлэгт олдох боломжгүй тэдгээр эрх, давуу эрх, чухалчилж үзэх явдлыг өөрсдөдөө өгөх хамаатуулахын төлөө санал өгч буй олонхийн хийж буй үйлдэл нь ялгаварлан гадуурхалт байдаг олон тохиолдол бий. Малайз болон Өмнөд Африк бол үүний хоёр илэрхий жишээ боловч дэлхий даяар хуулийн ялгаварлан гадуурхалтыг зөвхөн арьсны өнгө, шашин шүтлэг, хэл, сексийн нэг төрлийн харьцааг чухалчилж үзэх явдал^[20], эсвэл улстөрийн үзэл бодолд нь үндэслэж л цөөнхийн хүн амыг ялгаварлан гадуурхдаг тохиолдол түм бум байдаг.

Дахиад л иймэрхүү ялгаварлан гадуурхалт чөлөөт нийгэмд байх газаргүй: чөлөөт нийгэмд хүмүүс хуулийн өмнө ижил тэгш байдаг бөгөөд тусгай давуу эрхийн төлөө ямар ч бүлэг өөрөө санал өгөх боломжгүй. Хэт дийлэнхидээ ялгаварлан гадуурхалтын энэ төрөл цөөнхийн хүн амыг өршөөлгүй мөрдөж мөшгөх явдал болж хувирдаг. Олонхи нь эдэлдэг тэр эрхүүдээ булаалгасан цөөнхи өөрсдийнхөө нөхцөлийг сайжруулах аргагүй. Тэр цөөнхийг дорд хүмүүс, бараг л хүмүүн төрөлтөн биш гэж ойлгож хардаг болох боломжтой. Хүмүүнлэг чанар^[21]ыг нь үгүй болгочивол тэдний амсаж болох доромжлол харгислалд хязгаар байхгүй болно.

Гарах үр дагаврын тэгш байдал

Ихэнхи хүмүүс тэгш байдлын тухай ярихдаа тэд нар ёс суртахууны тэгш байдал, хуулийн өмнөх тэгш байдал, боломжийн тэгш байдлын зарчим дор хүн бүртэй тэгш харьцах эрхийн тухай боддоггүй. Тэд ингэх үедээ эд баялаг, орлого, амьжиргааны

19 *negative discrimination*

20 *sexual preferences*

21 *humanity*

төвшин зэрэг материаллаг урамшууллын тэгш байдлын талаар л ярьж байдаг. Баянаас нь авч ядууд нь өгөх дахин хуваарилалтын зарим нэг хэлбэрийг олон хүн эдгээр урамшууллыг тэгшитгэхийн тулд л дэмжиж хамгаална.

Орлогын тэгш бус байдлын талаархи тоо мэдээ

Гарах үр дагаврын тэгш байдлыг өмгөөлж хамгаалдаг хүмүүс Жинигийн итгэлцүүр гэдэг статистик мэдээллийг голдуу эшлэдэг. Энэ коэффициентийг Италийн статистикч, социологич Коррадо Жинигийн нэрээр нэрлэжээ. Энэ бол орлого зэрэг тоо хэмжээнд байгаа тэгш бус байдлын индекс буюу илтгэгч юм. 0 гэсэн Жинигийн итгэлцүүр тэнд бүрэн тэгш байдал байгааг хэлдэг бол 1 гэсэн итгэлцүүр нь бүрэн тэгш бус байдал байна гэсэн ажээ (нэг хүн бүх орлогыг авах үед гарах болно).

Дэлхийн Банк, АНУ-ын Төв Тагнуулын Байгууллага зэрэг янз бүрийн институтц улс орнуудын Жинигийн итгэлцүүрийг хэмжихийг оролддог бөгөөд тэгш бус байдлынх нь хувиар эдгээр улсыг эрэмбэлдэг. Иймэрхүү эрэмбэлж дугаарлах явдлаас ихэнхи хөгжингүй орон нь 0,25-0.5-ын хооронд хэлбэлзэх итгэлцүүртэй байна гэж харуулдаг нь тэнд тэгш байдлын зэрэг илүү сайн байна гэсэн үг. Хамгийн их тэгш бус байдал Африкийн улсуудад харагддаг бөгөөд Өмнөд Африк ойролцоогоор 0.7 гэсэн итгэлцүүрээр хамгийн дээр нь байдаг.

Бид иймэрхүү тооцоололд шүүмжлэлтэй сэжиглэнгүй хандсан хэвээр байх хэрэгтэй бөгөөд бүр ийм итгэлцүүр ихтэй улсуудын орлогыг хүчээр бусадтай нь ижилсүүлж тэнцвэржүүлэх ёстой гэсэн санаанд бүр илүү сэжиглэнгүй хандах ёстой. Юуны түрүүнд хэдхэн улс л орлогын талаар итгэж болохоор өгөгдөлтэй байдаг нь энэхүү Жинигийн итгэлцүүрийг улс бүгд ижил тэнцүү итгэлтэй байж болох хэмжээс болгодоггүй (энэ нь үүнийг тооцоолж буй өөр өөр институтцээс яагаад ондоо ондоо тоо гардгийн шалтгаан ч байж болно). Хоёрт нь орлогын их хэмжээний ялгаа нийгмийн жинхэнээсээ эерэг ерөнхий хандлагыг илэрхийлж байж ч болох

юм. Ийм ялгаа шинэ технологийн хурдтай өсөлт эсвэл хөдөө буйдхан газар арай хүрч чадаагүй байгаа хотуудын нэмэгдэж буй хөгжил цэцэглэлтийг харуулж байх боломжтой. Хотын Ай-Ти-гийн ажилчдын орлогыг өөрсдийн амьжиргаагаа болгодог фермерүүд^[22]ийн олдог орлоготой ижилсүүлж бууруулан энэхүү нэмэгдэж буй хөгжил цэцэглэлтийг гацааж зогсоох нь утгагүй зүйл байх болно. Үүнээс илүүтэй бид ядуу хүмүүс энэхүү хөгжил цэцэглэлтээс хүртэх явдлыг тэднийг ийм зүйл хийхээс нь одоо саад болж буй (чөлөөтэй шилжиж нүүхийг хориглосон хязгаарлалт зэрэг) саад тотгорыг үгүй хийх замаар боломжтой болгох ёстой.

Энэ статистик мэдээллийн өөр нэг асуудал бол түүнд хүмүүсийн төлж буй татвар, тэдний авч буй засгийн газрын тусламж (халамж, тэтгэвэр, эрүүл мэндийн үнэгүй үйлчилгээ, г.м.)-ийг үл тооцсон “түүхий” орлогыг харьцуулдаг байдал юм. Нэгдсэн Хаант Улсаас авсан бага зэрэг өөр хэмжээснээс харвал орлого ологчдын орой хэсгийн 10 хувийн боловсруулаагүй орлого суурь хэсгийн 10 хувийнхаасаа ойролцоогоор 30 дахин их байдаг нь харахад асар их тэгш бус байдал мэт харагддаг. Гэлээ гээд хүмүүс татвараа төлсний дараа болон хүмүүс засгийн газрын янз бүрийн халамж тусламж авсны дараа энэ үржвэр илүү дундаж болж ойролцоогоор 6 дахин зөрүүтэй болдог. Хүмүүс одоо ч эхний тоон утгыг дахин хуваарилалтыг улам л үндэслэлтэй болгох гэж эшлэсээр байдаг ч энэ байдал бол статистик мэдээллийг хууран мэхлэхэд ашиглаж буй хэрэг юм.

Орлогын эсвэл эд хөрөнгөний тэгш байдал уу?

Хүмүүс нийгмийн оролцооноосоо ижил тэнцүү орлого урамшуулал авах ёстой гэж үздэг үзлийг *эгалитарианизм*^[23] гэнэ. Гэвч энэхүү хэллэгийг яг нарийн утга санааг тодорхойлж заахад

22 *subsistence farmers*

23 *egalitarianism*.

хэцүү. Энэ нь түүний дотоод зөрчлөөс нь ямар нэг байдлаар болдог.

Эгалитаричууд тэд орлогын тэгш байдал эсвэл эд хөрөнгөний тэгш байдлыг хүсэж буй эсэхээ тодорхой болгодоггүй. Хэрэв тэд орлого тэгш байх ёстой гэж буй бол тэд эд хөрөнгөний тэгш бус байдал их байх явдал оршсоор байх болно гэдгийг мэдээж бараг л хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болдог. Нэг хүн олсон зүйлээ хадгалж, орлогоо ухаалгаар хөрөнгө оруулж, хөрөнгө, эд баялаг хуримтлуулах боломжтой байхад нөгөө нэг нь иймэрхүү орлогоороо мөрийтэй тоглож алдах эсвэл түр зуурын таашаал цэнгэлд үрээд дуусгадаг. Энэ хоёрын эд хөрөнгө ер нь л асар их зөрүүтэй байх болно.

Мөн л хэрэв бүх ажилд ижил тэнцүү цалин олгодог бол хялбар таатай ажлын эрэлт хэрэгцээ хэт их болж, харин хүнд хэцүү ажил хийхийг хүсдэг хүмүүс асар ихээр цөөрөх болно. Залхуу хамтрагч нартайгаа адилхан цалин авдаг бол тэд яагаад шаргуу ажиллаж өөрсдийгөө зовоох ёстой гэж?

Ажил эрхлэхэд материаллаг орлогоос давсан илүү зүйл мөн бий. Эдийн засагчдын *психологийн буюу сэтгэл санааны орлого* гэдэг зүйл байдаг ажээ – үүнд жишээлбэл сэтгэл нийлдэг хамтран ажиллагчтай байх, эсвэл улс орны таатай хэсэгт ажиллах, эсвэл хотынхоо тохитой хэсэг, хангамж сайтай газарт ажиллах зэрэг ордог. Эдгээр байр байдал тэдний хувьд түүнийг таашаадаг хүмүүст асар их ач холбогдолтой зүйл байж болох ч энэ бол ижилсүүлж тэгшитгэх боломжтой зүйл биш.

Хэрэв нөгөө талаас эгалитаричууд *эд хөрөнгийг* ижилсүүлж тэгшитгэх ёстой гэж үздэг бол хүмүүсийн ур чадвар, ажил олгогчийн хүсэл хэрэгцээнээс хамаарч орлогод асар их тэгш бус байдал байсаар л байх боломжтой. Хэрэв зарим хүмүүс орлогоо хадгалж, өөрийн эд хөрөнгөө өсгөдөг байхад бусад нь үүнийгээ үрж, эд хөрөнгөө бууруулдаг байвал тэдний хөрөнгө чинээ удалгүй асар их зөрүүтэй болно. Тэр үед яах вэ? НХУ-д 1950-аад онд алдартай асуулт хариултын уралдааны радио нэвтрүүлэг "*Have a Go*"-гийн нэвтрүүлэгч Вилфред Пиклс оролцогчоосоо

тэдний тухай, алсын бодлыг нь асууж нэвтрүүлгээ эхлүүлдэг байв. Нэг хүн: ‘Миний алсын бодол бол дэлхийн бүх мөнгийг авч, хүн бүрд ижил тэгш хувааж өгөх явдал юм’ гэв. Тэр үед энэхүү сайхан сэтгэлийг дэмжсэн чанга алга ташилт цуурайтлаа. Харамсалтай нь уг оролцогч энэхүү уур амьсгалыг: ‘Би өөрт ногдсон хувиа үрчихвэл бид дэлхийн мөнгийг дахиад л хоорондоо хуваан авах болно’ гэж нэмж хэлэн унтраав. Өөрчлөгдөж буй дэлхийд эд хөрөнгийг ижил тэгш байлгах хэцүү.

Ижил тэгш үр дагавар, энэ нь орлогын эсвэл эд баялгийн тэгш байдал байна уу эдгээр нь хоёулаа жам ёсны зүйл биш, бас тогтвортой зүйл ч биш. Аль алиныг нь тэнцвэржүүлэх, тэднийг ижил болгож тэгшитгэхэд эрх чөлөө болон өмч рүү асар ихээр халдах ёстой болдог. Энэ үеэр хэн нэгэн хүнээс хүчээр эд хөрөнгийг нь авч бусдад өгөх явдал гарах болно – хаа сайгүй бүх зүйлийг бараг ижил тэгш байлгахын тулд үүнийг давтан дахин ингэж хийсээр л байх хэрэгтэй.

Зарим нэг эд хөрөнгийг хувааж, дахин-хуваарилах боломжгүй байдаг: энэ нь нарийн нийлмэл, ажилладаг, эд хөрөнгө бүтээдэг үйлдвэрийг бүрэлдэхүүн хэсэг болох тоосго, машины эд анги болгон түүнийг хуваах боломжтой ч ингэвэл түүгээр юу ч үйлдвэрлэх боломжгүй. Бас мөнгийг нь дахин-хуваарилах гэж энэ үйлдвэрийг зарах ч боломжгүй – ижил тэнцүү эд хөрөнгөний ертөнцөд ямар ч хувь хүнд үүнийг худалдаж авах нөөц баялаг байхгүй.

Иймэрхүү дахин-хуваарилах бодлого албадлага хэрэглэсэн, маш үр өгөөжгүй бодлого байх болно. Ийм бодлого хүмүүс өөрсдийнхөө хөдөлмөрийн үр шимийг хүртэхийг хориглодог, үүнээс улбаалаад ажиллах, хадгалж хураах бүх хүсэл эрмэлзлийг нь устгаж мөхөөдөг. Ийм бодлогоор эд баялгийг дахин-хуваарилах гэхээсээ илүүтэй түүнийг устгаж үгүй хийх болно. Ийм бодлогод үүнээ албадан хэрэгжүүлэхэд нь улстөрийн асар их эрх мэдэл шаардлагатай – ийм эрх мэдэл чөлөөт нийгэмд тохирохгүй зүйл.

Дахин-хуваарилалтын механик ажиллагаа

Өөр нэг бэрхшээл бол энэхүү дахин-хуваарилах үйл явцад хэнийг хамаатуулан оролцуулах ёстой вэ гэдэг асуудал юм. Ерөнхийдөө баян улс орны эгалитаричууд дахин-хуваарилах тухай өөрсдийн саналаа өөрийнхөө улс орны оршин суугчдаар л, эсвэл дор хаяж өөрсөдтэйгөө адилхан бүлгийн улсын иргэдээр л хязгаарладаг. Энэ нь орлого эсвэл эд хөрөнгөө дэлхийн бусад хэсгийнхэнтэйгээ хуваалцана гэдэг нь (бүр хэрэв үүнийг хэрэгжүүлэх боломжтой ч гэсэн) баян улсуудын хүмүүсийн хувьд амьжиргааны төвшин нь асар ихээр буурна гэсэн үг билээ. Энэ бодлого бол эв найртайгаар хүлээн зөвшөөрөх боломжгүй тийм бодлого юм.

Үүнээс ялгаатай нь ядуу улсын эгалитаричууд ерөнхийдөө дэлхийн хэмжээний тэгш байдлын тухай бодолтой байдаг: баян улсуудынхаа эд баялгийг хуваалцах явдал тэдний ядуурсан хүн амд асар их ялгаа авчрах учраас тэд үүнд л зорино. Гэвч энэ бол нэгэнт баян улс орнууд хэзээ ч зөвшөөрөхгүй учраас биелэх боломжгүй мөрөөдөл юм.

Басхүү иймэрхүү дахин-хуваарилалтаар урт хугацааны туршид эд хөрөнгө ядууст бататгаж өгөх жинхэнээсээ боломжгүй. Эд баялаг бол “онооны нийлбэр нь адилхан байдаг тоглоом”^[24] биш. Хэрэв хэн нэгэн хүн ядуу болоход өөр нэг хүн баян болох боломжтой эд хөрөнгөний тийм тогтмол хэмжээтэй сан гэж байдаггүй. Эд хөрөнгийг шинэчлэл шинэ санаа, ажил хэрэгч байдал, арилжаа худалдаа, хөрөнгө босгох зэрэг зүйлээр л бүтээдэг. Хөрөнгөтэй хүмүүсийн бүтээлч хөрөнгийг устгах замаар хөрөнгөгүй хүмүүст туслах ямар ч боломжгүй. Хамгийн сайн арга зам бол ядуу үндэстнүүдийн хүмүүс өөрийн хөрөнгөө хуримтлуулж, цуглуулахад нь саад болдог дайн, хулгай зэлгий зэрэг аливаа саад тотгорыг устгах арилгах явдал юм.

Юуг дахин-хуваарилах вэ, хэнээс авч хэнд өгөх вэ гэдэг талаархи эдгээр асуулт дахин-хуваарилалтын бодлого ямар байх талаар хүмүүс хэзээ ч санал нийлэхгүй гэдгийг ойлгомжтой

24 *Wealth is not a ‘zero-sum game’*

болгодог. Гэлээ гээд дахин-хуваарилалт болж бүтэхийн тулд хүн бүр дагаж мөрдөх тодорхой төлөвлөгөө байх ёстой. Энэ талаар ч санал нэгдэхгүй тул үүнд хүрэх цорын ганц арга зам бол хүчээр үүнийг хийх болно.

Материаллаг тэгш байдалд хүчээр байлгадаг явдал ямар нэг илүү сайн зүйл рүү тэмүүлэх гэсэн аливаа хүний хүслийг бүрэн устгах болно. Нэгэнт л шинэчлэл шинэ санаа, ажил хэрэгч байдал эсвэл шаргуу хөдөлмөрөөр олж авсан аливаа материаллаг өгөөжийг нь хүн аваад явчих юм бол хүн яагаад үүн рүү тэмүүлэн зорих ёстой гэж? Ийм тэмүүлэл эрмэлзлээ гээхээс илүү гарз хохирол хүмүүн төрөлхтөн учрах боломжгүй. Ажил хэрэгч байдал бол бүтээлч зүйл юм: хүмүүс илүү сайн бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлэхээр эрмэлзэж тэмүүлэхдээ хүн бүрийн амьдралыг сайжруулдаг шинэ бүтээгдэхүүн, үйл явц, технологи олж нээдэг. Энэхүү ажил хэрэгч байдал, бүтээлч байдлыг дарж дарангуйлснаар эгалитарианизм нийт дэлхийн материаллаг амьдрал тасралтгүй сайжран хөгжиж дэвжих явдлыг зогсооно.

Тэгш байдал болон шударга ёс

Шударга ёсны хоёр утга

Эд хөрөнгө эсвэл орлого дахин-хуваарилах явдлыг таашааж дэмждэг олон хүн зарим хүмүүс бусдаасаа илүү баян байх нь, цөөхөн нь үгээгүй ядуусаасаа хамаагүй илүү их баян байх нь “шударга бус” гэж батлан өгүүлцгээдэг. Энэхүү ‘нийгмийн шударга бус байдал’ хүмүүсийн эд хөрөнгө “нийгэмд оруулсан үнэ цэнэ”-ийг нь заавал илэрхийлж харуулах албагүй гэсэн бодит байдлаас болж гүнзгийрдэг гэнэ.

Энэхүү гаргалгаа нотолгоо гэвч бидний сайн, хүсүүштэй зүйл гэдэг, хүн төрөлтөн болохынхоо хувьд хүн бүрд байдаг зүйл болох “шударга ёс” гэдэг үгийг барьцаалж авдаг бөгөөд түүнд тэгш байдал эсвэл шударга байх^[25] гэдэг бүхэлдээ өөр утга санаа нааж хамаатуулдаг.

25 *equality or fairness*

Шударга ёс гэдгийн анхдагч утга бид нэг нэгнээсээ гарна гэж хүлээж байдаг зан төлөв ямар болох тухай зүйлд анхаарал хандуулдаг байсан. Хэрэв хэн нэгэн хүн гэрээгээ зөрчвөл эсвэл хулгай хийвэл иймэрхүү зан үйлийг үл хохироох зарчим, бидний хуульзүйн болон ёс суртахууны ёс журмаар хориглодог учраас бид тэднийг шударга бус үйл хийсэн гэж хэлдэг. Өөрөөр хэлбэл шударга ёс гэдэг хэллэгийн *харилцааны шударга ёс*^[26] гэдэг энэ утга санаа бол хүмүүн төрөлтөн хэрхэн үйл хөдлөл хийх тухайд л хамаатай. Шударга ёсыг зөвхөн хүмүүс зориудаар үйл хийхэд л хэрэглэдэг. Хэрэв хэн нэгэн хүн ханиад^[27] тусвал эсвэл тахир дутуу байдлаас болж зовбол энэ нь азгүй явдал л болохоос биш харин шударга бус байдал биш. Учир нь хэн ч энэ үед шударга бус үйл хийгээгүй учраас тэр.

Заримдаа *хуваарилалтын шударга ёс*^[28] гэдэг, “шударга ёс” гэдэг үгийн хоёрдохь хэрэглээ нь хувь хүмүүсийн хоорондохь үйлийн тухай биш харин тэдний дунд эд юмс хуваарилах тухай л ойлголт байдаг. Гэлээ гээд чөлөөт нийгэмд гарч буй эд хөрөнгө эсвэл орлогын хуваарилалт зүгээр л хүн бүр хуульзүйн болон ёс суртахууны ёс журмыг дагаж мөрддөг эдийн засгийн сайн дурын үйл ажиллагааны л *үр дагавар* байдаг. Хэн ч шударга бусаар үйл хийгээгүй учраас энэ хуваарилалт “шударга бус” байх боломжгүй. Гарах тодорхой үр дагавар руу хэн ч зориудаар зорьдоггүй; энэ бол зүгээр л амьдралын бодит байдал юм.^[29]

‘Нийгэмд оруулсан үнэ цэнэ’

“Нийгмийн шударга ёс” гэдэг хэллэгийг ашиглах явдлаас нийгэм гэж эд хөрөнгө болон орлогынх нь байр байдлыг шийдвэрлэх боломжтой нэг төрлийн хүмүүс юм гэсэн алдаа гардаг. Гэвч

26 *commutative justice*

27 *influenza*

28 *distributive justice*,

29 Энэ болон бусад санааны талаар дараахь бүтээл сайн тайлбарласан байдаг: F. A. Hayek, *The Mirage of Social Justice*, University of Chicago Press, Chicago, IL, 1978-БАТЛЕР

“нийгэм”-д өөрийн гэсэн хүсэл зорилго байхгүй: зөвхөн хувь хүмүүс л шийдвэр гаргах, түүнийхээ дагуу үйл хийх боломжтой. Хувь хүмүүс нийгэм болон эдийн засгийн бодлогын хэрэг явдлын талаар санал хүчтэй зөрөлдөцгөөдөг. Яагаад “нийгмийн шударга ёс”-ны үзэл санаанд ийм олон хүн татагддагийн нэг шалтгаан бол яг ямар үр дагавар үүнээс гарах ёстой талаар маш бүрхэг өгүүлдэг, мөн эдгээр зөрөлдөөнтэй байдлаа халхалж нуудаг байдал юм.

Шан урамшуулал олгох “нийгмийн шударга” хуваарилалт ямар зүйл болох талаар илүү тодорхой ойлгомжтой болгохыг оролдоход энэ тухай санал нэгдэх явдал гарах боломжгүй зүйл болох нь илэрхий болж ирнэ. Ихэнхи хүмүүс *орлогын бүрэн гүйцэт тэгш байдал* руу зорих явдал зөв зорилго биш гэдэгт санал нийлцгээдэг. Учир нь тэр үед ямар ч тохиолдолд хэр залхуу эсвэл хэр хойрго байгаагаасаа үл хамаарч хувь хүмүүс ижилхэн шан урамшуулал болно. Шан урамшуулалд заавал хүчин чармайлт, эсвэл ололт амжилтыг тооцож үзэх ёстой гэдэг нь ойлгомжтой зүйл. Тиймээс бүрэн гүйцэт тэгш байдлын оронд шан урамшууллыг хүмүүсээс “нийгэмд оруулсан үнэ цэнэ”-ийн дагуу олгох хэрэгтэй гэсэн үзэл бодол ихэд тархжээ.

Гэвч тэр үед бие хүний “нийгэмд оруулж буй үнэ цэнэ”-ийг хэн тогтоох вэ? Нийгэм бол бие хүн биш, түүнд өөрийн гэсэн үнэ цэнэ байдаггүй. Хүмүүс өөрийн үнэ цэнэ байдаггүй ямар нэг зүйлд “үнэ цэнэ” өгөх боломжгүй. Зөвхөн *хувь хүмүүс* л үнэ цэнэтэй, тэдний үнэ цэнэ маш өөр өөр байдаг бөгөөд үнэндээ голдуу хоорондоо зөрчилдсөн байдаг. Хүмүүсийн нэг бүлэг боксчны ур чадвар гүйцэтгэлийг үнэлж цэгнэдэг байх боломжтой бол бусад нь хийлчийн ур чадварыг илүүд үзэх боломжтой; өөр өөр бие хүний таашаалыг хооронд нь харьцуулах боломжгүй учраас эдгээрийн алийг нь “нийгэмд оруулах үнэ цэнэ”-ээр хамаагүй илүү гэж хэлэх ямар ч боломжгүй. Сувилагч, махны худалдаачин, нүүрсний уурхайчин, шүүгч, далайн гүнд шумбагч, татварын байцаагч, амь нас хамгаалах эм зохион бүтээгч, эсвэл

математикийн ухааны профессорын “нийгэмд оруулах үнэ цэнэ”-ийг бид ер нь тодорхойлж чадах уу?

Гавьяа зүтгэлд үндэслэсэн хуваарилалт

Эгалитаричуудаас гардаг өөр нэг санал бол тухайн шан урамшууллыг “гавьяа зүтгэл”-ээр нь хуваарилах хэрэгтэй гэдэг санаа юм. Гэвч дахиад л янз бүрийн хүмүүсийн харьцангуй “гавьяа зүтгэл”-ийг хүнээс үл хамаарсан байдлаар шийдэж тогтоох, мөн “гавьяа зүтгэл”-ийг хэрхэн шагнаж урамшуулах зохистой арга зам байдаггүй. Хүний ондоо ондоо өвөрмөц чанарууд хэр зэрэг магтууштай болох талаар маш өөр өөр үзэл бодолтой хүмүүс байх боломжтой.

Бүр тэр үед хэр зэрэг гавьяа зүтгэл орсон болохыг тодорхойлж шийдвэрлэхэд бодит бэрхшээл гарна. Олон жилийн туршид хүнд хэцүү ажил хийсэн ч амжилт олоогүй хэн нэгэн хүний “гавьяа зүтгэл”-ийг шагнаж урамшуулах уу эсвэл сая сая хүнд ашиг тусаа хүртээсэн хэн нэгэн хүнийг энэ нь зүгээр л санамсаргүй үр дагавар байсан учраас шийтгэх ёстой юу? Бид үр ашиггүй хүнд хүчир ажлыг хөхиүлэн дэмждэггүй: эдийн засгийн дэвшил бол бидний бүтээж буй зүйлийнхээ үнэ цэнийг өсгөх, түүнд зарцуулдаг золиосолдог хүчин чармайлтаа багасгах л явдал юм. Хувийн золиос хүчин чармайлтынх нь төлөө шан урамшуулал өгнө гэдэг нь тэр золиосыг нь л зүгээр дэмжиж буй болохоос бусдад үйлчлэх явдлыг дэмждэггүй. Ямар ч эдийн засаг иймэрхүү зарчмаар ажиллах боломжгүй.

Зах зээлийн шан урамшуулал үйлдвэрлэгчийн ёс суртахууны болон хувийн гавьяа зүтгэлийг нь илэрхийлдэггүй, бас зах зээлд бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээгээ гаргахдаа гаргасан цаг хугацаа болон хүчин чармайлтыг нь ч мөн харуулдаггүй. Тэдний бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд олон жилийн хүчир хөдөлмөр шаардлагатай байсан эсвэл цэвэр энэ нь азын асуудал байсан нь эсэх нь энд огт хамаагүй. Гэвч зах зээлийн шан урамшуулал тэр хүмүүс бусдад өгч буй таашаал болон үнэ

цэнийг л харуулдаг. Хэрэглэгчид тэд тэр үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг үнэлдэг учраас л тэдний үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний төлөө үйлдвэрлэгчид төлбөр төлдөг. Үнэн хэрэгтээ зах зээлийн шан урамшуулал хүмүүс нийгмийнхээ бусад гишүүдэд өгч буй тэр үнэ цэнээс хамаардаг ажээ. Ийм шан урамшуулал ховор байдал, үйлдвэрлэгчдийн ур чадвар, мөн тэр үйлчилгээг хүсэж буй хэрэглэгчдийн тоо, худалдан авах худалдан авагчдад тэр бараа бүтээгдэхүүн хэр яаралтай хэрэгцээтэй байгаа эсвэл түүний ач холбогдлыг илэрхийлдэг.

Хэрэгцээнд нь тулгуурласан хуваарилалт

Өөр нэг эгалитарич санал бол нөөц баялгийг “хэрэгцээ”-нийх нь хэрээр хуваарилах ёстой гэсэн санаа юм. Гэвч дахиад л юу “хэрэгцээтэй” байгааг хэн шийдэх вэ? Хэрэгцээтэй хүнийг хэрэгцээгүй хүнээс нь салгаж заалгах илэрхий шугам зураас гэж байдаггүй. Хүмүүсийн нөхцөл байдал маш ондоо байдаг; тэд ондоо ондоо эд хөрөнгө, өөр өөр орлоготой байдаг ч энэ ялгаа нь асар их зөрүүтэй хэлбэлзэж болно. Хүмүүс мөн илүү таатай сайхан эсвэл хүнд хэцүү газар амьдарч, бие хүчний болон оюун ухааны янз бүрийн чадвартай байдаг. Тэд өөр өөр хүмүүстэй ондоо ондоо орчинд ажилладаг. Ажлын найрсаг хамт олонтой санаанд нийцсэн ажлаа хийх гэх мэт эдгээр санхүүгийн бус ашиг тусыг тоогоор илэрхийлэх боломжгүй.

Тийм учраас хүмүүст юу “хэрэгцээтэй” эсвэл юу үгүй байгаа эсэх нь үнэлгээ яаж хийхээс л хамаарах бөгөөд өөр өөр хүмүүс ондоо ондоогоор үнэлнэ. Хэрэгцээнд тулгуурлан дахин-хуваарилах явдал зөвхөн хэрэв улстөрийн зарим нэг засаг захиргаа буюу эрх мэдэлтэн тухайн “хэрэгцээг” шийдвэрлэх эрх мэдэлтэй байсан бол, энэ мэдлээрээ ийм үйл хийх боломжтой байсан бол л биелж хэрэгжих бололцоотой. Гэвч чөлөөт нийгэмд хүмүүс ямар ч засаг захиргаа болон эрх мэдэлтэнд ийм эрх олгохыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй. Ийм эрх мэдэл бүх хүмүүсийн амьдралыг мэдэх бүрэн гүйцэт эрх мэдэл байх

болно. Тэр хүмүүс чөлөөт хүмүүс байхаа болино. Тэд засаг захиргааныхаа боол нь болох болно.

Түүнчлэн хэн нэгэн хүнд хэрэгцээ байгаа явдал бусад хүмүүст үүрэг хариуцлага үүсгэдэггүй. Бөөр нь ажиллахгүй байгаа хүнд шинэ бөөр хэрэгцээтэй байх боломжтой. Гэвч энэ байдал хэн нэгэн өөр хүнийг нэг бөөрөө хандивлахыг үүрэгжүүлдэггүй. Ойрын хамаатан нь бөөрөө хандивлах ёс суртахууны болон гэр бүлийн үүргээ мэдэрч байж болох, бүр эсвэл танихгүй хүн тусламжийн гараа сунгаж ч болох юм. Гэвч энэ үйл сонголт хэвээр л үлддэг. Бид иймэрхүү үйлдлийг дэмжиж, алга ташдаг байх боломжтой ч гэлээ чөлөөт нийгэмд хувь хүмүүсийг бусдад тусал гэж золиос гаргахыг нь *албадаж хүчилж* болохгүй.

Чөлөөт нийгэм эд юмсыг ямар ч албадлагаар биш харин худалдан авагчид зах зээлийн эдийн засаг үйлдвэрлэж буй өөр өөр бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнд өгч буй үнэ цэнээр дамжуулан хуваарилж түгээдэг. Хэрэв хүмүүс фермийн үржүүлгийн загаснаас илүү байгалийн загасыг илүүд үзвэл жишээлбэл эсвэл сандаалаас илүү гутлыг илүүд үзвэл тэр үед тэдгээрийг л үржүүлж эсвэл үйлдвэрлэх болно. Чөлөөт нийгэм нөөц баялгийг мөн л хүмүүс бусдадаа өгч буй сайн санааны бэлэг сэлтээрээ илэрхийлж буй үнэ цэнээр дамжуулан хуваарилдаг. Иймэрхүү шийдвэр гаргах явдлыг хувь хүмүүст үлдээдэг: ямар зүйлд дэмжлэг үзүүлэх ёстой болохыг зөвхөн төр мэдэх боломжтой гэсэн үзэл санааг чөлөөт нийгэм үгүйсгэдэг.

Эгалитарианизмийн өөр нэг нэмэлт хор урхаг

“Нийгмийн шударга ёс”-ны хортой муу үр дагавар бол харилцааны шударга ёс^[30]ны жинхэнэ үзэл санаа болон бодит байдлыг халхалж бүрхэгдүүлдэг явдал юм. Хуулийн өмнөх тэгш байдал зэрэг чөлөөт нийгмийг бүтээдэг үндсэн зарчмууд энэхүү шинэ нэр томъёогоор баларч муудаад, үнэ цэнэгүй болдог.

30 *commutative justice*

Дахин-хуваарилалтаас харилцааны тэгш байдал^[31] гэсэн зүйл гарах боломжгүй: бүх хүмүүстэй ижилхэн харьцахын оронд бид [эд баялагт] хувь оруулагч нэг бүрээс өөр өөр хувь хэмжээгээр хураан авч, хүлээн авагч бүрд ондоо ондоо хувь хэмжээгээр тараан өгөх болно.

Материаллаг хүсэл байсаар л байна

Зөрчлийг шийдвэрлэх гэж жинхэнэ шударга ёс оршдог бол “нийгмийн шударга ёс” жинхэнээсээ зөрчилдөөн бий болгож байдаг. Нэгэнт төр засаг гавьяа зүтгэл, эсвэл хэрэгцээ эсвэл нийгэмд оруулсан үнэ цэнэд үндэслэж орлого дахин-хуваарилахаар оролдвол төр засгийг өөрийн шан урамшууллыг өсгөх ёстой гэж бүгдээрээ шаардаж буй олон янзын бүлэг хүмүүс лоббидоход хүрдэг. Нэгэнт л тэдгээрийн дундаас аль нь зөв болохыг шийдвэрлэх бодит арга байхгүй тул улстөрийн энэхүү зөрчилдөөн гэнэтийн санамсаргүй шийдэл рүү түлхдэг. Эцэст нь чөлөөт нийгэмд үл нийцдэг бүдүүлэг дээрэнгүй хүч л аливаа зүйлийг шийддэг болно.

Хувь хүмүүс өөрсдөдөө болон гэр бүлдээ ашиг тус олж авахын тулд энэ тогтолцоог тойрох алгасах арга зам олохоор оролдоно. Энэ байдал бол мэдээжээр хүн амын дийлэнхи олонхи нь амьжиргааныхаа төвшнөө нэмэгдүүлэх гэж ямар нэг төрлийн хууль бус үйл ажиллагаанд оролцож байсан Зөвлөлт Холбоот Улсын тэр сургамжтай жишээ юм. Хүчээр материаллаг тэгш байдлыг үүсгэх нь зүгээр л хууль сахидаг хүмүүсийг гэмт хэрэгтнүүдийн үндэстэн болгодог ажээ.

Баячуудын үүрэг нөлөө

Орлого болон эд хөрөнгөний тэгш бус байдалд мөн эерэг фүнкц бий. Илүү их орлого олох, магадгүй бүр баян болох гэсэн хүмүүсийн хүсэл бол хүчирхэг сэдэл юм. Энэ нь тэр хүмүүсийг

31 equality of treatment

илүү сайн ажил эрж хайх, бусад хүмүүсийн амьдралыг сайжруулах илүү сайн бүтээгдэхүүн зохион бүтээх, үйлдвэрлэх, түгээн борлуулах явдал руу хөтөлдөг. Баян хүмүүс эдгээр шинэ бараа бүтээгдэхүүнийг нь туршдаг туршилтын маш сайн жолоочийн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Ихэнхи шинэ бараа бүтээгдэхүүн зах зээл рүү тансаг хэрэглээ байдалтай орж ирдэг – тийм бүтээгдэхүүнийг өргөн олны зах зээлд гаргахгүйгээр цөөн хэмжээгээр өндөр үнэтэйгээр гаргана. Тиймээс тэдгээрийг илүү чинээлэг иргэд худалдаж авч туршицгаадаг. Энэ хүмүүсийн хариу үйлдэл буюу тэдний санал сэтгэгдэл үйлдвэрлэгчийг тухайн бүтээгдэхүүнийхээ эрэлтийн төвшнийг тогтоох, хаана нь хэрхэн үүнийг сайжруулах хэрэгтэй байгааг олж мэдэх боломж олгодог. Энэ нь үйлдвэрлэгчид алдаатай бараа бүтээгдэхүүнээ их хэмжээгээр үйлдвэрлэхээсээ өмнө үүнийг хийхээ болих, мөн өргөн олны зах зээлд^[32] орохоос нь өмнө бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах боломж мөн олгоно. Энэ байдлаар анхлан хэрэглэгчид болох баячуудын туршлага сургамжаас хүн бүр ашиг тус хүртдэг.

Хөрөнгө чинээтэй, их орлоготой хүмүүс нийгэмд өөр бусад чухал үүрэг нөлөөтэй. Тэд шинэ бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ туршихаар нөөц баялагтай байдаг бөгөөд энэ нь хийх сонголтыг өргөжүүлдэг, [бараа үйлчилгээг] сайжруулах үйл явцыг тэжээнэ. Төр засаг үл тоодог гэж итгэдэг урлаг, боловсрол, судалгааны төслийн ивээн тэтгэгч нь баячууд байх боломжтой. Тэд төр засгийн албан тушаалтнууд маш аюултай зүйл үзэж ойлгох боломжтой улстөрийн шинэ үзэл санааг нэвтрүүлж түгээх замаар дарангуйлж дарлагч төр засгийг эсэргүүцэж эрүүлд дуудах санхүүгийн ар талтай байдаг. Энэ бүгд бол хэрэв бид чөлөөт нийгмийг хадгалж үлдэхийг хүсэж байвал анхаарал хандуулах ёстой чухал зүйл зүйлс юм.

Хөрөнгө устгах

Хүн бүр бүтээлч нөөц баялгаа зохицуулж удирдахдаа ижил тэнцүү сайн байдаггүй. Ажил хэрэгч хүн гэсэн алдар олсон хүмүүс дараахь зүйлийг хийдэг байх ёстой: хэрэв тэд ажил хэргээсээ ашиг олох ёстой бол ажил хэрэгч хүмүүс эрсдэлээ удирдаж, илүү сайн, илүү хямд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд бүтээлч нөөц баялгийг нэг дор хэрхэн цуглуулахаа мэддэг байх хэрэгтэй. Гэвч дахин-хуваарилалтаар ур чадвартай эдгээр чадвартн^[33]ы гараас нөөц баялгийг нь булаан авч эргэн тойронд нь байгаа бусад хүмүүст түгээдэг. Энэ нь хөрөнгө устана, хөрөнгө бий болох явц үгүй болно гэсэн үг юм. Гэвч эдийн засгийг бүтээлч болгодог тэр зүйл хөрөнгө байдаг; хөрөнгө улам бага бий болсноор, мөн нөөц баялгийг зүгээр л илүү [дэмий] их үрснээр нийгмийн урт хугацааны хөгжил цэцэглэлт гарцаагүй буурах ёстой болно. Тэгш бус байдал мөн л эдийн засгийг сайжруулдаг. Амжилттай үйлдвэрлэгчдийн их орлого нь хамгийн их ашиг олох боломжтой газар руу илүү бүтээлч бус газар болон үнэ цэнэ муутай газраас хүн хүч, нөөц баялгийг татаж соронзон мэт ажилладаг. Тиймээс хүмүүс болон нөөц баялаг ирээдүйд орлого хамгийн их нэмэгдэх газар руу татагдаж тийш урсана. Энэ бол үргэлжилсэн, диманик буюу хөдөлгөөнт, өсөж томордог үйл явц юм.

Маш олон хүн эсэргүүцдэг тэгш бус байдал үнэндээ хүмүүс болон нөөц баялгийг хамгийн бүтээлч хэрэглээ рүү залж жолооддог, хаа сайгүй хөгжил цэцэглэлтийг өсгөж нэмэгдүүлдэг маш таатай зүйл байдаг. Хэрэв орлогыг тэгш байдалд зорьж тэмүүлэн дахин-хуваарилбал бид тэрхүү өөртөө татагч хүч^[34]ийг зогсоож, түүний бүтээж үүсгэж чадах ирээдүйн үнэ цэнэ, үр дагавар, өсөлтийг үгүй хийдэг. Маш олон ядуусын амьдрал өсөж нэмэгдэж буй эдийн засгаас хамаардаг тул тэд л хамгийн ихээр хохирох болно. Ийм зүйлийг бид хэрхэн “нийгмийн шударга ёс” гэж нэрлэж болох билээ?

33 practitioners

34 attractive force

Татварлах явдал, халамж

Эд хөрөнгө эсвэл орлогын бүрэн тэгш байдал биелшгүй зорилго байх боломжтой ч боловч олон төр засаг ийм байдалд ойртож очихын тулд баян хүмүүсээс илүү их татвар авдаг шатлан нэмэгдэх татвар ногдуулдаг. Гэвч эдгээр татвар маш их хортой зүйл байх боломжтой. Ажил хэрэгч байдал болон зүтгэлээс гарах шан урамшууллыг бууруулснаар тэдгээр татвар эдгээр үр ашигтай үйл ажиллагааг хэрэггүй зүйл болгож, тэдгээрээс үүсдэг ажил эрхлэлт, бараа бүтээгдэхүүн сайжрах бололцоог үгүй хийдэг.

Үүнээс бүр муу зүйл бол хадгаламж буюу хадгалж хураасан зүйл, хөрөнгөнөөс ийм татвар авах явдал юм. Хадгаламжид ногдуулсан татвар хүмүүсийг нийт нийгмийн хөгжил цэцэглэлтийг өсгөж нэмэгдүүлдэг бизнесийн үйл хэрэгт хөрөнгө оруулах бага мөнгөтэй болгож орхидог. Хөрөнгөд татвар ногдуулна^[35] гэдэг нь бүтээлч үндсэн хөрөнгө бүрдүүлж бүтээхэд багахан нөөц баялаг очих болно, мөн нийт нийгмийн ирээдүйн хөгжил цэцэглэлтийг бууруулна гэсэн үг ажээ.

Чөлөөт нийгэмд арилжаа худалдаа, солилцоо цэвэр сайн дурын шинжтэй байдаг. Үйлдвэрлэгчид зөвхөн бусад хүмүүсийн хүсэж буй, түүний төлөө мөнгө төлөхөд бэлэн байгаа бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг бүтээж л мөнгө олдог. Баян болсон хүмүүс хэнийг ч дээрэмдэж, хэнээс ч хулгай хийдэггүй. Тэд аливаа шударга бус байдалд буруугүй. Бид материаллаг тэгш бус байдлыг бууруулж багасгах болно гэсэн үндэслэл дээр баячуудаас хулгай хийхийг зөвшөөрдөггүй: тиймээс бид яагаад төр засаг ийм зүйл хийхийг нь зөвшөөрөх ёстой гэж?

5 ЧӨЛӨӨТЭЙ АЖ АХУЙ ЭРХЛЭХ, ХУДАЛДАА АРИЛЖАА ХИЙХ

Чөлөөт зах зээлийн эдийн засаг

Чөлөөт нийгмийн эдийн засгийн тогтолцоо бол чөлөөт зах зээлийн эдийн засаг юм. Энэ нь хүмүүсийн хоорондохь бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний сайн дурын солилцоогоор явагддаг – энэ нь заримдаа шууд байдаг ч голдуу мөнгөний орчн^[1]оор дамжин явагдана. Хувь хүмүүс тэд хэзээ хаана хэнд ажиллах, мөнгөө хэрхэн үрэх, хөрөнгө оруулах, хадгалж хураах, арилжиж наймаалалцахаа чөлөөтэй шийддэг. Хэн ч ийм хэлцэл хийхийг нь албадаж хүчилдэггүй.

Хамтын ажиллагааг дэмждэг ёс журам

Чөлөөт зах зээлийн эдийн засаг бол хуульгүй, бусдад учрах үр дагавар юу байхаас үл хамаарсан, хүмүүс юу дуртайгаа хийх боломжтой бүхнийг чөлөөтэй хийдэг газар^[2] биш. Тэнд үл хохироох зарчим давамгайлсаар л байдаг. Өмч олж авах, өмчлөх эрх, өмчөө солилцох, хүмүүсийн хөдөлмөрлөх эрхээ өөрсдөө мэдэх, гэрээг албадан хэрэгжүүлэх^[3] зэргийг хамарсан хуулийн бүтэц хүрээ тэнд бий. Эдгээр ёс журамд хувь хүний үйл хөдлөлөөр зогсохгүй мөн хоршоолол хамтлаг, компани, буяны сан зэрэг хүмүүсийн бүлгийн үйл хөдлөл ч хамаатай байдаг. Төр засгийн үүрэг бол хүмүүсийн өмч, эрх чөлөөг хамгаалдаг, гэрээг албадан хэрэгжүүлдэг ийм ёс журмыг сахин хамгаалах явдал юм.

1 medium of money

2 free-for-all

3 enforceability of contracts

Гэвч энэ үүрэг нөлөө хязгаарлагдмал. Ийм ёс журам арилжаа наймааг чиглүүлж удирдах гэж биш харин түүнийг дэмжих гэж л оршдог. Ёс журам бол дотор нь гал асаж буй зуух юм. Зах зээлийн эдийн засгийн эрч хүчийг хэтийдсэн их ёс журам, зохицуулалтаар боомилдоггүй байх нь [зуухан дахь галыг элдэв зүйлээр халхалж унтраахгүй байхтай адилхан] чухал зүйл юм. Хэдийгээр хүмүүс харилцан ашигтай байх гэж биесээ сонгодог ч гэсэн өмч, солилцоо, гэрээний суурь ёс журмууд итгэлцэл, найдвартай байдал, аюулгүй байдлын үндсэн дээр хамтран ажиллах боломж тэдэнд олгодог. Энэ нь эдийн засгийн хамтын ажиллагааг илүү их тэтгэж, үүнээс ургаж гардаг олон ашиг тусыг олон дахин үржүүлдэг ажээ.

Сайн дурын солилцооны ач тус

Арилжаа наймаанаас зөвхөн худалдаачин л ашиг тус хүртдэг гэж төсөөлөх амар байдаг. Эцсийн эцэст худалдаачин энэ хэлцлээс илүү их мөнгө олж харин худалдан авагч нь бага мөнгөтэй хоцордог гэнэ. Энэ байдал нь зарим хүн худалдаачин нь илүү их шуналтай, өөрийн ашиг сонирхлын төлөө илүү их ашиг олох сонирхолтой, бусад хүнийг боддоггүй гэж бодоход хүргэдэг.

Энэ бол буруу бодол юм. Эцсийн эцэст мөнгө гэж юу юм бол оо? Мөнгийг алт болон мөнгө гэдэг металаар хийдэг байсан үед дор хаяж түүний металыг нь гоёл, чимэг хэрэгсэл болгож хэрэглэх боломжтой байв. Гэвч цаас болон суурь металаар хийсэн мөнгөнд өөр хэдхэн хэрэглээ л бий. Үүгээр хийж чадах хамгийн ашигтай цор ганц хэрэглээ бол өөр бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ худалдаж авах явдал юм.

Өөрөөр хэлбэл мөнгө бол *солилцооны орчин* ажээ. Худалдан авагч мөнгөөр бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ солилцож авдаг; худалдагч нь мөнгөө өөр хэн нэгнээс ондоо бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээгээр дараа нь сольдог. Энэ хоёр хоёулаа энэ хэлцлээс ашиг олсон гэж үзэцгээдэг. Тэд үүнээс ашиг олохгүй байвал хоорондоо санал нийлэхгүй, хэлцэл хийхгүй.

Арилжаа худалдаа хэрхэн үнэ цэнэ бүтээдэг вэ

Нэгэнт хэн ч нэг зүйлийг түүнээс бага үнэтэй өөр нэг зүйлээр солихгүй тул хэрхэн хоёулаа үүнээс хэрхэн ашиг хүртдэг юм бол оо? Үүний учир шалтгаан гоо сайхан зэрэг өмчлөгч^[4]ийнхөө нүдэнд л харагддаг үнэ цэнэ ажээ. Энэ бол жин эсвэл хэмжээс зэрэг шинжлэх ухааны ямар нэг шинж чанар биш. Энэ бол хувь хүн бүр тухайн зүйлийн тухай юу гэж бодож буй тэр зүйл юм. Хур ихтэй газрын хүмүүс аяга усыг тийм ч ихээр үнэлж үзэхгүй; гэвч говь цөлд буй хүмүүс үүнийг амин чухал зүйл гэж үзэх боломжтой. Хувцасны шинэ хэвмаяг тухайн өсвөр настнуудад заавал байх ёстой зүйл байж болно гэвч эцэг эх нь үүнийг нь гаж тэнэг зүйл гэж үздэг.

Энэ байдал нарийндаа бол солилцооноос нэг бүр нь олж авах боломжтой зүйлийг тэд хэрхэн үнэлж цэгнэж буйгаараа хүмүүн төрөлтөн ялгаатай байдгаас л хамаардаг. Зах дээр худалдаачнаас тахиа худалдаж авч буй хэрэглэгч түүний оронд солилцож буй мөнгөө уг тахианаас илүү багаар үнэлдэг. Гэвч худалдаачин нь тахианаасаа мөнгийг нь илүү үнэ цэнэтэй гэж үзнэ. Уг худалдаачин дараа нь өөр зүйл худалдаж авахаар, жишээлбэл талх авахаар тэр мөнгөө зарахдаа өмнөх хэрэглэгчийн адилаар баяртай байх болно. Энэ худалдаачин талхныхаа төлөө талхчин авахыг хүсэж буй өөрийн мөнгөнөөс авах гэж буй талхаа илүү үнэ цэнэтэй гэж үздэг. Энэ гурван хүн гурвуулаа тэр гурав сайн дураараа эдгээр солилцоонд оролцсон учраас ашиг хүртжээ.

Үнэндээ тахиа, мөнгө, талхны талаар тэдний үнэлэмжид гарсан ялгаа асар их байх тусам л тэд тэдгээр зүйлээ солилцож байхдаа илүү их өгөөж хүртэх болно. Тэд бүгдээрээ эд зүйлээ арилжих солилцох ёс журмын талаар санал нэгдсэн байх ёстой—энэ бол чөлөөт зах зээлийн эдийн засгийн бүтцийг бүрдүүлдэг өмч, шударга байдал^[5], гэрээний ёс журам юм. Үүнээс гадна хэлцэл бүрийн оролцогч тал ерөөсөө л өөрийн-тусыг бүрэн

4 *beholder*

5 *honesty*

бодсон байдаг: нэг бүр нь солилцоог бусад хүмүүсийн ашиг тусын төлөө биш харин өөрийнхөө ашиг тусын төлөө хийдэг.

Гэлээ гээд эдгээр ёс журмыг дагаж мөрдсөнөөр хүн бүр Адам Смитийн хэлсэнчлэн “үл үзэгдэгч гар” удирдсан юм шиг⁶ээр санамсаргүйгээр бусдадаа ашиг тус хүртээдэг. Хэдийгээр зөвхөн өөрийн-тусыг бодох явдалд хөтлөгддөг ч гэсэн тэд нэг нэгтэйгээ дуртайяа хамтран ажилладаг.

Мөнгөний орчноор дамжуулан одоо бид бүгд бидэнтэй нэг зах зээлд амьдардаг хүмүүсээр зөвхөн хязгаарлагдахгүй, хэзээ ч зочлон очиж байгаагүй, хэлийг нь ч мэдэхгүй, бүр соёлыг нь улстөрийн бодлогыг нь үл тоож, санал нийлдэггүй улс орнуудын сая сая хүмүүстэй арилжаа худалдаа хийх, хамтран ажиллах боломжтой болжээ. Өдөр тутмын эдгээр тоо томшгүй хэлцлээс хүн бүр ашиг тус хүртдэг. Үнэ цэнэ бүтээдэг. Хүмүүн төрөлхтөн илүү сайхан амьдардаг. Хүмүүн төрөлхтөн хөгжиж цэцэглэдэг.

Ядуус ашиг тусыг нь хамгийн их хүртдэг

Чөлөөт солилцооны тогтолцоо жам ёсны зүйл, бас маш өгөөжтэй тул энэ нь хаа сайгүй тархаж түгдэг. Чөлөөт зах зээлийг идеологийн зүйл гэж үзэж үгүйсгэдэг улс оронд ч энэ нь бүр хууль бусаар эсвэл хүлцэн тэвчиж болох зүйл байдалтай оршино. Иргэддээ хувийн болон нийгмийн хэрэг явдалд багахан эрх чөлөө олгодог олон улс орон (үүн дотроо Азийн хэд хэдэн улсад) эдийн засгийн мэдэгдэхүйц эрх чөлөө иргэддээ олгосон байдаг.

Үнэндээ Исламын ертөнц үүссэн эхэн үе болон хожим нь тархан тэлж байсан он жилүүдэд арилжаа худалдаа түүнд чухал хүчин зүйл болж байжээ. Дэлхийн арилжаа худалдааны зам нээлттэй болсон нь Сэргэн Мандалтын үеийн Европын асар их эд баялгийг бүтээв. Энэ нь эргээд урлаг, соёл, сурч мэдэх явдлыг цэцэглүүлсэн. Америк тив Европ, дараагаар нь Хятадтай хийх худалдааны холбоо хэлхээгээр цэцэглэн хөгжжээ.

6 Adam Smith, *The Wealth of Nations*, 1776, Book IV, ch. II, para. IX.-БАТЛЕР

Гэвч хүмүүний хөгжил цэцэглэлтийн түрж буй давлагаанаас нөхцөл байдал нь хамгийн их дээшилж буй нь баян хүмүүс биш. Хаана эдийн засгийн эрх чөлөө тэлж өргөжнө тэнд ядуусын амьжиргааны төвшин хамгийн ихээр дээшилдэг. Америк эдийн засагч Милтон Фрийдмэний хэлсэн шигээр Ромын Эзэн Гүрний үед гэрийн цэвэр усны сүлжээ төсөөлөхийн аргагүй тансаглал байсан; гэвч Ромын сенаторт түүний хэрэгцээ байсангүй, учир нь тэрбээр зарцаа усанд гүйлгэчихдэг байлаа.⁷ Ромын Эзэнт Гүрний ядуус үгээгүй ядуу амьдарч байв; гэвч орчин үеийн Ром хотын ядуу иргэний хувьд шугам сүлжээний халуун хүйтэн устай байх тансаглал одоо жирийн баталгаатай зүйл болжээ.

Энэхүү нөлөөг Хятад болон Энэтхэг зэрэг улс олон-улсын худалдаанд нээлттэй болсон, зах зээлийн зарчим түгэн тархсан саяхны явдлаас тод сайн харах боломжтой. Гучхан жилийн дотор тэрбум эсвэл түүнээс олон хүн үгээгүй ядуу байдлаас үүний үр дүнд ангижирсан. Сая сая хүн нь дундаж анги болохоор хүсэж тэмүүлэх, мөн гар утас, зурагт, тээврийн хэрэгсэл зэрэг тансаг зүйлийг таашаан эдэлж, үнэндээ бүр гадаа орчинд ямар ч хамаагүй цаг агаарт ажиллах гэхээсээ илүүтэй сэрүүн, тохитой, албан байр болон үйлдвэрт ажиллах боломжтой болов.

Хэрхэн баян болж томрох вэ

Үйлдвэрлэгчид хэрэглэгчдэд үйлчлэх ёстой

Чөлөөт нийгэмд хэрэглэгчид сонгох ёстой. Төр засаг эсвэл тэдний бизнес хийдэг амин найзууд нь эрхэлдэг явуулдаг монополь байгууллага мэт тодорхой үйлдвэрлэгчээс юм худалдан авахуулах гэж тэднийг албаддаггүй. Ханган нийлүүлэгчид үнээ өсгөх гэж хуйвалдахаар оролдож болох ч иймэрхүү хуйвалдаанаа хэвээр хадгалах явдлаа нэгэнт тэдний аль нь ч нөгөөхөөсөө илүү олон хэрэглэгчтэй болохын тулд үнээ буулган бусдыгаа хуурах боломжтой учраас сахин хамгаалахад хэцүү байх болно. Мөн

7 *Milton Friedman and Rose Friedman, Free to Choose, Harcourt Brace Jovanovich, New York, 1980, p. 147. -БАТЛЕП*

энэ үеэр бусад ханган нийлүүлэгчид тухайн зах зээл рүү орох нь чөлөөтэй байж, үнээ их байлгах гэсэн тэр пүүсүүдтэй өрсөлдөх болно.

Тиймээс л жинхэнэ өрсөлдөөнт зах зээлийн эдийн засагт үйлдвэрлэгчид хэрэглэгчдээ ашиглаж мөлжих хүч чадал байхгүй. Хэрэв тэдгээр үйлдвэрлэгч хэрэглэгчдийнхээ хүслийг тэдний хүсэж буй чанартайгаар, тэднийг татах үнээр үйлдвэрлэхгүй л бол тэд удахгүй бизнесээ алдах болно. Хувь хүмүүс корпорацуудын хүч чадлын барьцаанд байдаггүй. Үүний эсрэгээр үйлдвэрлэгчид олон нийтийн өөрчлөгдөж буй эрэлтэд л хариу үзүүлэх маягаар зөвхөн амьдардаг. Компани том байж болно, гэхдээ энэ компани өрсөлдөөнтэй нүүр тулсаар л байх болно. Том пүүс магадгүй олон өөр янзын бүтээгдэхүүн хийдэг байж болох бөгөөд энэ пүүс олон өөр бизнест оролцдог ч байж болно. Гэвч энэ пүүс өөр том компаниудтай өрсөлдөөнд ороод зөвхөн зогсдоггүй. Мөн тэр пүүс тухайн бизнесийн өөр өөр тодорхой хэсэгт өрсөлдөж чадах олон бусад жижиг пүүсүүдтэй өрсөлдөнө. Зарцуулах зардал бага^[8]тай илүү жижиг компаниуд зарим том компаниудын зарим нэг бүтээгдэхүүнийг илүү сайн эсвэл илүү хямд үйлдвэрлэх боломжтой байж ч болно. Шинэ санаа гаргадаг шинэ компаниуд нэг эсвэл түүнээс олон том компанийн бүтээгдэхүүнийг хэрэггүй зүйл болгож хувиргадаг шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж болно.

Тиймээс капитализм илүү том, илүү том компанитай болгодог, мөн аажмаар тухайн компани нэгжийн өртөг бууруулах гэж том болохоор тэмүүлэх гэхдээ монополь компани болдог гэдэг нь худал домог юм. Хэмжээ ч гэсэн мөн өөрийн өртөгтэй: том байгууллагыг залж удирдахад маш хэцүү, тэд удаан урагшилдаг. Үүнийг мэдье гэвэл тавин жилийн өмнөх Өрнөдийн ямар нэг сэтгүүл эргүүлж хараарай. [Түүнээс хойш] хэдхэн компани л одоо ч гэсэн зар сурталчилгаагаа явуулсаар байна. Үлдсэн бүгдийг нь жижиг байсан ч илүү шинийг санаачлагч эсвэл үр ашигтай байсан өрсөлдөгчид нь худалдаж авчээ.

8 fewer overheads

Эдийн засгийн хүч чадалд бүү найд

Тиймээс л үе дамжсан компаниуд ч, бас тэдгээрийг удирддаг хүмүүс ч эдийн засгийн хүч чадлаа хадгалж үлддэггүй. Хувь хүмүүс чөлөөт эдийн засагт баян тарган болох боломжтой ч зөвхөн олон нийтэд үйлчилсээр, хэрэглэгчдийг өөртөө татсаар байх хүртлээ л ийм хэвээр байх боломжтой. Үнэндээ “цамцны ханцуйнаас цамцны ханцуй хүртэл гурван үе гэдэг”^[9] нь илүү чөлөөтэй нийгэмд нийтлэг байдаг үзэгдэл юм: хүмүүс компани байгуулна, өөрсдийн гэр бүлийнхээ мөнгийг хийнэ олно, гэвч ач нарын үе бизнест орж ирэхэд бусад компаниуд тэднийг өрсөлдөөнд гүйцэж түрүүлнэ.

Энэ бол элитүүд нь улстөрийн ч эдийн засгийн ч эрх мэдлийг ч хянадаг, тэд болон тэдний гэр бүл эдгээрийг хянасаар байх явдлыг бататгадаг тогтолцооноос хамаагүй шударга тогтолцоо юм. Чөлөөт эдийн засагт авьяастай, шийдэмгий аливаа хүн бусдад үйлчлэх арга замаар эд хөрөнгө цуглуулж бүтээх боломжтой. Баян тарган болох боломж найз нөхөд, гэр бүл эсвэл эрх мэдэлд буй намаар ч бас тодорхой угсаатны бүлэг эсвэл шашны бүлгээр ч хязгаарлагддаггүй. Үнэндээ чөлөөт нийгмийн хамгийн их хөгжиж дэвшсэн хүмүүсийн зарим нь өөр туршлага дадалтай, үзэл санаатай, хүмүүс худалдаж авахдаа дуртай байдаг шинэ бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ бүтээдэг гаднын цагаач иргэд байдаг.

Давуу эрх анд нөхдөдөө тарааж өгөх боломжтой хүчирхэг төр засагтай байдаг газарт харин бизнесийн хүмүүс ийм давуу эрхийг өөрийнхөө ашиг тусын төлөө ашиглахыг оролддог. Тэд нар өрсөлдөгчдөө тоглоомын гадна байлгах эсвэл өөрсдийгөө бүр бүрэн монополь эрхтэй байлгасаар байх тогтоол шийдвэр буюу хуулийн зохицуулалт гаргуулах арга зам хайж ч болно. Хэдий тэд өөрсдийгөө олон нийтийг чанар муутай бараа

9 from shirt sleeves to shirt sleeves in three generations-юу ч үгүй төрсөн эхний үе нь баян болж, харин ач зээ нарын үед бүх зүйл нь дуусч эргээд юу ч үгүй болдог тухай домог.

Асуулт: Өрсөлдөөн, ашиг, орлого, зар сурталчилгаа хэрэггүй зүйл гэж үү?

Үгүй. Ашиг бол хүмүүс үйл хийх, боломж бололцоо эрж хайх, хүмүүс нилээд дуртай худалдаж авдаг бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг бүтээхэд өдөөж хүргэдэг тэр зүйл юм. Ашиг мөн олон нийт түүхий эдээс илүү үнэлж үздэг бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ үйлдвэрлэж бүтээхэд нөөц баялгаа ашиглаж буйг илэрхийлдэг.

Зар сурталчилгаа шинэ бүтээгдэхүүний талаар, өмнө нь байсан бүтээгдэхүүний сайжирсан байдлыг хүмүүст хэлж өгдөг учраас мөн чухал. Өрсөлдөөн янз бүрийн бүтээгдэхүүний дундаас сонгох сонголт хүмүүст өгч, нийлүүлэгчдэд шинэ зүйл санаачлах, илүү чанартайгаар, илүү бага өртгөөр нийлүүлэх шахалт үзүүлнэ. Өрсөлдөөн байхгүй бол хэрэглэгчид хүч чадалгүй болно. Хэрэглэгчид монополь эрхтэй нийлүүлэгчийн нийлүүлэхээр төлөвлөсөн тэр зүйлийг сонгож авах эсвэл түүнийг хэрэглэхгүй байх хэрэгтэй болдог.

бүтээгдэхүүн хэрэглэхээс нь хамгаалах явдал гэж үүнийгээ зөвтгөхийг оролдож болох ч гэлээ тэдний жинхэнэ санаа сэдэл нь зах зээлийг буланд шахаж хавчих байдаг. Гэвч энэ байдал тэдэнд чөлөөт нийгэмд зохихгүй албадлагын эрх мэдэл өгөх болно. Төр засагт зах зээлийг хавчиж хяхах, монополь байдал тогтоох эрх мэдэл байх ёсгүй; түүний үүрэг илүүтэй эрх чөлөө, өрсөлдөөнийг өргөжүүлж тэлэх явдал байх ёстой.

Ажил хэрэгч байдал^[10]

Хэдий голдуу л амжилтад тус болдог ч гэсэн шаргуу ажиллах явдал чөлөөт нийгэмд гардаг амжилттай үргэлж заавал хамаатай байдаггүй. Бусад хүмүүс хүсэж буй, худалдан авахаар зорьж буй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг та нар нийлүүлэх хэрэгтэй.

Энэ ажилд хүмүүс ямар шинэ бүтээгдэхүүн хүсэх бол гэдгийг таах, олон бусад нийлүүлэгч, ажилчид, түгээгч нар оролцож болох үйлдвэрлэлийн сүлжээг зохион байгуулах зэргээр азаа сорих явдал орно. Харьцангуй цөөхөн хүн л эдгээр эрсдэл хүлээж, хариуцлага үүрэхээр хүсэж тэмүүлж байдаг; гэвч эрэлт хэрэгцээг амжилттай ойлгох явдал болон үйлдвэрлэлийн тогтолцоо, сүлжээ, хүчин чармайлтыг амжилттай зохион байгуулах явдал бол эдгээр *ажил хэрэгч* хүмүүсийн жинхэнэ хувь нэмэр юм. Тэд том эрсдэл үүрдэг бөгөөд хэрэв олон нийт жинхэнээсээ тэдний бүтээгдэхүүнийг худалдан авбал тэд шан урамшуулал сайн авах болно.

Энэ явдал эргээд бүтээлч байдал, шинэчлэлийг тэтгэж урамшуулдаг. Энэ нь хүмүүсийг өмнөх ажил хэрэгч хүмүүс олж авсан тийм эд хөрөнгөтэй тэд ч мөн болох болно гэсэн найдлагаар шинэ, илүү сайн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагааг сэдэж бүтээх явдал руу урин дууддаг. Байнга сайжруулах, шинэ бүтээл бүтээх явдлаас хэрэглэгч, үүнээс улбаалаад нийгэм ч ашиг тусыг нь хүртэнэ. Хүмүүсийн хөдөлмөр хөнгөвчилдөг, эсвэл үгүй бол амьдралыг нь сайжруулдаг шинэ бүтээл зохион бүтээх явдал аливаа төр засгийн халамжийн тогтолцооноос ч илүү сайнаар хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлж, эд хөрөнгө тархааж түгээдэг.

Хэрэглэгчид өөрсдөө хэзээ ч олж чадахгүй байсан эсвэл өөрөө үйлдвэрлэж чадахгүй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнээс ашиг тусыг нь хүртэнэ. Жишээлбэл үйлчилгээ сайтай эм хөгжүүлж гаргах, энэ эмээр хангахад судалгаа шинжилгээ, туршлага нилээд хэрэгтэй. Хувь хүмүүст үүнд шаардлагатай хими, биологи, үйлдвэрлэлийн туршлага^[11] байхгүй – харин мэргэжлийн эмзүйн пүүсэд ийм зүйл бий. Бүр орон нутгийн чадалтай эмзүйч^[12] өөрийнх нь нөөцөд буй таван зуу эсвэл түүнээс олон эмийн хэрэглээ, үр дүнтэй байдал, гаж нөлөөний талаар л тусгай мэдлэг олж хуримтлуулах боломжтой. Хэрэглэгч

11 *expertise*

12 *pharmacists*

иймэрхүү тусгай мэдлэг хуримтлуулах боломжгүй – мэдээжээр өдөр тутмын хэрэгцээтэй зүйлс болох хүнс, ундаа, хувцас, гутал, бусад бүх зүйлийн талаар мэргэжилтэн болж тэд бас чадахгүй.

Ажил хэрэгч хүн эд баялаг хуримтлуулж болно. Гэвч тэд нар үүнийгээ бусад хүмүүсийн хүч хөдөлмөрийг сорж бүтээдэггүй. Тэдний олж буй мөнгө зөвхөн хэрэглэгчдийнх нь сайн дураараа төлж буй төлбөрөөс л орж ирдэг. Ажил хэрэгч хүмүүс хүмүүсээс татвар хурааж эсвэл тэднийг ашиглаж мөлжиж биш харин бусдад туслах замаар баян болцгоодог. Тэд эд хөрөнгөө зөвхөн олон нийтэд тасралтгүй үйлчилсээр байх хүртлээ л хадгалж үлдэх боломжтой. Орлого мөнгө олсоор байхын тулд тэд хэрэглэгчдээ ойлгож мэдэрч, тэдний хэрэгцээг мэдэх ёстой болдог. Тиймээс ажил хэрэгч хүмүүс зарим нэг бүтээгдэхүүний хангагдаагүй хэсэг зах зээлийг үргэлж эрж хайж, түүнийг нь хангахаар эрэлхийлдэг. Энэ бол хэрэглэгчдийнхээ хүслийг нь биелүүлэх гэж байнга оролдож үзэх үйл явц юм.

Ашиг болон аз сорих үйлдэл^[13]

Ашиг олох гэсэн эрэл үйлдвэрлэгчид том жижиг гэлтгүй эрсдэл үүрэх, шинэчлэл шинэ санаа гаргах, зохион байгуулах, бусад хүмүүст үйлчлэхээр ажиллахад хөтөлдөг.

Чөлөөт эдийн засгийн олон шүүмжлэгч “ашиг”-ийн тухай үзэл санааг үзэж чаддаггүй боловч үнэндээ бид бүгдээрээ ашиг хайгч хүмүүс билээ. Бид илүү их үнэлдэг ямар нэг зүйлээ олж авахын тулд зарим нэг зүйлээ золиосолно. Жишээлбэл бид цэвэр, цэгцтэй орон гэртэй байхын тулд цаг хугацаа, хүчин чармайлтаа зарцуулдаг. Бид цэвэр цэмцгэр гэр орныг цэвэрлэгээ хийхээс илүү их үнэлдэг: энэ хоёрын ялгаа бидний ашиг юм. Энэ бол санхүүгийн ашиг биш харин өөр талаараа ажил хэрэгч хүн түүхий эд худалдаж авч, түүнд гаргасан зардл^[14]аасаа илүү үнээр зарагдах ямар нэг зүйл үйлдвэрлэхтэй зүгээр л адилхан

¹³ *profit and speculation*

¹⁴ *inputs cost*

зүйл юм. Нийгмийн эсвэл сайн санааны ажилд, бүр жишээлбэл сургуулийн зөвлөлд ажиллаж байхдаа ч хэдий зорилго нь бүх нутгийнхаа бүх хүүхдүүдийг сайн боловсролтой болоосой гэсэн хүсэл байж болох ч үүнийгээ бид өөрсдийнхөө зорилгын төлөө хийдэг. Энэ зүйл мөн л бидний хувьд (санхүүгийн биш) ашиг байдаг. Гэвч шүүмжлэгчид анзаарч хардаг, бас дургүй байдаг зүйл бол зөвхөн санхүүгийн ашиг юм. Ингэх нь учир зүйгүй, хоорондоо зөрчилтэй зүйл ажээ.

Үүнтэй адил зүйл дамлах явдлыг шүүмжлэхэд ч гардаг. Бодит байдал дээр дамлах явдал зөвхөн санхүүгийн зах зээлээр хязгаарлагддаггүй. Бид бүгдээрээ дамчид буюу аз соригчид. Фермерүүд зах зээлд зарж борлуулахуйц ургац хураан авъя гэсэн итгэл найдвараар үр суулгац тарьдаг. Өөрсдийг маань ажилд авах магадлал илүү их байх болно гэсэн итгэлээр сайн мэргэжил^[15]тэй болох гэж л бид сургуульд явдаг. Эдгээр зүйл бол азаа үзсэн ажил хэрэг юм.

Санхүүгийн ертөнцөд дамлах явдал ч маш их чухал ач холбогдолтой. Усан онгоцнууд хэрэв даатгалын компаниуд, андеррайтер буюу өр бичигч пүүс^[16] аз сорих сэдэлтэй байж, тэдгээр онгоц аюулгүй аялах тухайд эрсдэл хүлээгээгүй бол хэзээ ч далайд хөвөхгүй. Орчин үеийн үйлдвэрлэлийн дийлэнхи нь том хэмжээтэй, урт-хугацаатай, нийлүүлэлтийн гэрээ, эсвэл үйлдвэр барих, засаж сэлбэх тухай гэрээнээс шалтгаалдаг. Бие даасан үйлдвэрлэгчид нийт эрсдэлийг бүхэлд хүлээх боломжгүй. Тиймээс тэд өөрийн аж ахуйнхаа хувьцааг худалдаж авна уу гэж бусдыг урьдаг. Энэ бол аз сорих явдлын нэг хэлбэр юм. Хөрөнгийн биржид дамлаж зарагчид буюу аз соригчид ашиг хийнэ гэсэн итгэл найдвараар хувьцаа худалдан авч, бас зардаг ч гэсэн тэд ингэхийн тулд зарж бас худалдан авч буй пүүсийнхээ, мөн ирээдүйн хөгжил дэвшлийнх нь талаар сайн мэддэг мэргэжилтэн байх хэрэгтэй. Тэрхүү нарийн мэдлэг туршлага^[17]

15 qualifications

16 insurance companies and underwriters

17 expertise

зах зээлд хэрэгтэй мэдээлэл түгээж, тэдгээр пүүсийн үнэ ийм мэдээлэл байхгүй байсан бол хүрэх тэр төвшиндөө хурдан хүрэхэд дэм болдог бөгөөд ингэснээр нийт зах зээлийг илүү хариу үзүүлэмтгий, үр ашигтай болгоно.

Ашиг хийнэ гэдэг нь атгаг шуналтай байна гэдэгтэй адилхан зүйл биш юм. Хүмүүс өөрийн-тусыг бодож л ашгийн төлөө тэмүүлж зорьдог боловч энэ явдал шуналтай адилхан зүйл биш. Хэрэв бид дор бүрдээ бүгдээрээ амьд үлдэх, гэмтэж хохирохоос зайлсхийх, өөрийн биеийг асарч тэтгэх бол түүнд нь өөрийн-тусыг бодох явдлын зарим нэг арга хэмжээ амин чухал байдаг. Гэвч шунал бол хэн нэгэн хүн бусдад хохиролтой байхаар хэтэрхий өөрийн-тусыг бодогч байсныг илэрхийлдэг ёс суртахууны ойлголт юм. Чөлөөт нийгэмд үйлдвэрлэгч өөрийн-тусыг бодох явдлаа бусдад туслах үйлд л зөвхөн үндэслэж гүйцэлдүүлэх боломжтой.

Ажил хэрэг болон харилцаа холбоо

Хэдийгээр маш чухал байсан ч бизнес амьдралын бүх утга учир биш. Чөлөөт нийгмийн бүр хамгийн хөдөлмөрч хүнд ч гэсэн гэр бүлтэй, бас дуртай спорт, хобби зэрэг сонирхол, эсвэл дэврүүн сэтгэл^[18]ээр нэгдсэн хүмүүсийн бүлэг болон нийгэмлэгтэй байдаг. Гэр бүл болон зах зээлийн эдийн засаг хамтдаа ажин түжин амар тайван оршдог гэдгийг ухаж ойлгохын тулд зүгээр л, гэр бүлийн харилцаа маш хүчтэй байдаг Итали зэрэг капиталист улс орнуудыг харахад л хангалттай.

Бизнес эрхэлнэ гэдэг нь бусад хүмүүстэй сэтгэл зүрхгүй хандах явдлыг зөвтгөхгүй, мэдээжээр мөн бусад хүмүүсийг хохироох явдлын үндэслэл шалтгаан ч болохгүй – эдгээрийг үл хохироох зарчим хориглодог. Хамгийн их шан урамшуулалтай харилцааны олон нь жинхэнээсээ ажлын байрныхаа бизнесийн хамтрагчидтайгаа харилцах харилцаа байдаг. Чөлөөт зах зээлийн эдийн засаг өөр байдлаар нийгмийн харилцаа холбоог

18 shared enthusiasms

мөн тэтгэнэ. Энэ эдийн засаг хүмүүст шашин эсвэл нийгэм эсвэл байгууллага, сайн санааны шалтгаан зэрэг бусад ашиг сонирхолд зориулах эд хөрөнгө өгч, цаг хугацаа гаргах боломж олгодог.

Зах зээл хэрхэн ажилладаг вэ

Үнийн мэдээлэл дамжуулах тогтолцоо

Ихэнхи зах зээл мөнгөний орчноор дамжин ажилладаг. Бас мөнгөгүйгээр зөвхөн шууд солилцоо хийх, нэг бол бараагаа бараагаар арилжих эсвэл эд зүйлээ солилцох^[19] боломжтой; гэвч солилцоог мөнгө таатай хялбар болгодог. Худалдагч бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээгээ мөнгөөр солих боломжтой бөгөөд дараагаар нь энэ мөнгөөрөө өөр бүтээгдэхүүн болон үйлчилгээг хамгийн сайн үнээр сольж авах гэж дэлгүүр хэсдэг. Энэ нь өлсгөлөн үсчинд түүнтэй солилцоо хийх хэрэгтэй байгаа талхчин эрж хайх хэрэгцээ гарахгүй гэсэн үг юм.

Үнийг ихэвчлэн мөнгөөр илэрхийлдэг. Үнэ бол үнэ цэнийн үлгэр стандарт биш. Учир нь үнэ цэнэ хэлцэлд оролцож буй хүмүүсийн ухаан оюунд оршдог бөгөөд өөр өөр хүмүүс нэг ижил зүйлийг ондоо ондоогоор үнэлдэг. Гэвч үнэ тухайн бүтээгдэхүүний талаархи хүмүүсийн эрэлт хэрэгцээ, түүний ховор байдлын талаар ямар нэг зүйлийг ил болгоно. Ямар нэг зүйлээ өөр нэг зүйлээр ямар ханшаар солилцоход бэлэн байгааг үнэ харуулдаг.

Ховор байдлын илтгэгч болохынх нь хувьд үнийг давж гарах зүйл байхгүй.^[20] Үнэ зөвхөн хаана эрэлт хэрэгцээ их байгааг ил болгодоггүй. Үнэ их байх нь мөн л нийлүүлэгчдийг тэр эрэлтийг хангахад өдөөдөг. Өндөр үнэ харсан үйлдвэрлэгчид

19 bartering or swapping

20 Эдгээр санааг дараахь бүтээлд сайн тайлбарласан: F. A. Hayek, Individualism and Economic Order, University of Chicago Press, Chicago, IL, 1949. Хураангуй тайлбарыг Eamonn Butler, Friedrich Hayek: The Ideas and Influence of the Libertarian Economist, Harriman House, Petersfield, 2012 гэсэн бүтээлээс харна уу. -БАТЛЕР

энэхүү эрэлтийг хангахын тулд хүн хүч, хөрөнгө зэрэг нөөц баялгаа төвлөрүүлж гарч болох ашгийг хүртэхийн тулд зах зээл рүү нэвтэрч орно. Бага үнэ үүнтэй адилаар эрэлт хэрэгцээ сүл байгааг, нөөц баялгийг өөр хаа нэгтэй ашиглах нь илүү сайн гэдгийг илэрхийлдэг.

Энэ маягаар үнэ чөлөөт нийгэм дэх нөөц баялгийг ийм зүйл хамгийн их хэрэгцээтэй газар руу илүүдсэн газраас нь татаж шилжүүлэн тус болж, чөлөөт нийгэмд амин чухал үүрэг нөлөөтэй байдаг. Үнэ хаягдлаа багасгахад мөн тусалдаг: ашгаа хамгийн их байлгахын тулд нийлүүлэгчид хамгийн зардал багатай хэрэглэгдэхүүн олох хэрэгтэй болдог. Энэ байдал нөөц баялгийг хэмнэж хамгаалах, түүнийг чадахынхаа хэрээр бүтээлч байдлаар ашиглах явдлыг бататгана.

Энэ нөлөө нэг зах зээлээс нөгөө зах зээл рүү нийт эдийн засаг даяар, үнэндээ нийт дэлхийгээр түгж тархдаг. Жишээлбэл цагаантугалганы ямар нэг шинэ хэрэглээ олж нээжээ гэж төсөөлцгөөе. Тэр үед үйлдвэрлэгчид илүү их цагаантугалга шаардаж эхэлдэг. Тэдгээр үйлдвэрлэгчид өмнөхөөсөө илүү их үнэ түүнд төлөхөд бэлэн болцгоох болно. Цагаантугалганы их үнэ уул уурхайн компанийг илүү их цагаантугалга олборлоход өдөөх бөгөөд бөөний худалдаачид илүү ихээр үүнийг нийлүүлэх хүсэлтэй болдог. Гэвч үүнтэй ижил тэнцүүгээр цагаантугалганы бусад хэрэглэгчид түүнд их үнэ төлөхийнхөө оронд түүнийг орлуулах зүйл хайж эхэлнэ. Тэр бусад үйлдвэрлэгчид эдгээр орлуулах бүтээгдэхүүнийг илүү ихээр эрж сурч түүнийг эрэлттэй болгох бөгөөд түүний үнэ ч мөн өснө. Энэ явдал тэр орлуулах бараа бүтээгдэхүүнийг илүү ихээр үйлдвэрлэхээр тэмүүлэхэд хөтөлдөг бөгөөд тэр орлуулагчийг орлуулах илүү их орлуулагч барааг хэрэглэгчид нь эрж хайхад хүргэдэг.

Энэ байдлаар үнэ эдийн засгийн нийт тогтолцоо даяар ховор байдлын талаар мэдээлэл дамжуулдаг. Нобелийн шагналт эдийн засагч Ф. А. Хаек үүнийг байнга л хаана илүүдэл, хаана хомсдол байгааг ил гаргаж байдаг, мөн хүмүүс хаана хүчин чармайлт болон нөөц баялгаа хэрэглэвэл хамгийн сайн болохыг өгүүлдэг,

зах зээлийн “асар өргөн харилцаа холбооны тогтолцоо” гэж нэрлэсэн билээ.

Зах зээл төгс байх боломжгүй

Хэрэв та нар эдийн засгийн ухааны сурах бичиг уншиж байвал та нарт зах зээл яг ижилхэн бүтээгдэхүүн яг ижилхэн хэрэглэгчдэд зарж буй маш олон нийлүүлэгчдийн хоорондохь “төгс өрсөлдөөн” дээр үндэслэдэг юм гэсэн сэтгэгдэл төрж байсан байх боломжтой. Зах зээл ийм байдаггүй. Эдгээр зүйл бол зөвхөн онолын л хийсвэрлэл юм. Бодит байдал дээр зах зээл хүмүүс болон бараа бүтээгдэхүүн ондоо байдаг учраас л зөвхөн ажилладаг, ажиллах боломжтой байдаг.

Хэрэв хүн бүр нэг ижил үнэ цэнэ ямар нэг зүйлд өгдөг байсан бол хэн ч хэзээ ч юугаа ч арилжихгүй байсан. Хоёр тал хоёулаа бараа бүтээгдэхүүнийг адилхан үнэлдэг бол тэдэнд тэдгээрийг солилцох тийм үнэ гэж байхгүй байх болно. Тэдний үнэ цэнэ хоорондоо зөрүүтэй байгаа учраас л хүмүүс солилцоо хийдэг. Дахиад хэлэхэд нийлүүлэгч нэг бүр нь яг ижилхэн барааг, яг адилхан үнээр санаа болгодог бол хэрэглэгчид тэдгээр бараанаас ямар ч сонголт хийх аргагүй болно. Ямар ч нийлүүлэгч өрсөлдөөнд ялагдахгүй, бас илүү их ашиг олох боломжгүй.

Гэвч илүү их ашиг бол ажил хэрэгч хүмүүсийг өрсөлдөгчөө давж гарахад өдөөж хөтөлдөг тэр зүйл юм. Тэд жишээлбэл бараа бүтээгдэхүүнээ хямд болгох замаар, үйлдвэрлэлээ үр ашигтай болгож^[21] илүү их ашиг хийдэг. Гэвч үүнээс илүү чухал нь тэд ингэж үйлдэх үеэрээ тодорхой бараагаа илүү сайн болгодог. Тэдгээр үйлдвэрлэгчид шинийг санаачилж, бараа бүтээгдэхүүнээ олшруулж олон янз болгоно. Тэд хэрэглэгчдэд ямар нэг шинэ зүйл, хуучин хэрэглэж дадсан бүтээгдэхүүнээс нь илүү сайн зүйл өгдөг. Тэд худалдан авагчид үнэндээ бусдынхаас илүү тэдний бүтээгдэхүүнийг илүүд үзэх болно гэсэн итгэл найдвараар эдгээр өөрчлөлтөд илүү их анхаарал хандуулна.

21 streamlining production

Энэ байдал чөлөөт зах зээлийг сурах бичигт дүрсэлдэг эрэлт нийлүүлэлтийн муруй мэт хөдөлгөөнгүй, царцсан, хөдөлдөггүй зүйл биш харин гайхалтай хөдөлгөөнтэй динамик зүйл болгодог. Нийлүүлэгчид байнга олонд таалагдах бүр олон бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэж шинийг санаачилж, шинэчлэл хийж байдаг бөгөөд хэрэглэгчид үргэлж байнга сайжирсан бараа бүтээгдэхүүн үйлчилгээ эрж хайж байдаг ажээ.

Төвлөрсөн төлөвлөлт хэрэгжих боломжгүй

Төр засаг эдийн засгийг залж удирдахыг, мөн хүмүүсийн хүссэн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг оролдох ч гэлээ энэ нь зах зээлийн энэхүү динамизмийг гүйцэхгүй.

Төрийн монопольд шинэчлэгдэхэд хүргэх албадсан дарамт шахалт цөөхөн ирдэг. Бас төр засгийн захиргаадалтын ажилтнууд^[22] олон нийтийн аль гишүүд нь юуг жинхэнээсээ хүсэж, үнэлж үзэж буйг мэдэх боломжгүй. Тэр захиргаадалтын ажилтнууд хааяа хааяа санал асуулга явуулах боломжтой ч гэсэн энэ асуулга нь зах зээлийн байнгын өрсөлдөөнөөс гардгаас дэндүү хол хоцорсон зүйл байх болно. Зах зээлийн ийм өрсөлдөөний үеэр хэрэглэгчдийн худалдан авч буй сонголт үйлдвэрлэгчдэд эрэлт хэрэгцээнийхээ талаар минут тутамд мэдээлэл өгч байдаг.

Амжилтад хүрэхийн тулд ажил хэрэгч хүмүүс хэрэглэгчдээ ойлгох ёстой. Төр засаг сонгуулийн үеэр [багц бодлогын талаархи хүмүүсийн саналыг] авдаг шиг бараа бүтээгдэхүүний нийт багцын талаархи хэрэглэгчдийн санал бодлыг авах гэж үйлдвэрлэгчид олон жил хүлээж чадахгүй. Үйлдвэрлэгчид хэрэглэгчид юу хүсэж буй тухай, нийлүүлэлт болон ашиглах хэрэглэгдэхүүн^[23]ий үнэ өртөг болон олдцын талаар байнга л мэдэж байх хэрэгтэй. Жишээлбэл үл хөдлөхийн зуучлагч тухайн орон нутгийн өмчийн зах зээлд юу болж буйг мэдэх хэрэгтэй байдаг – худалдаж авах бололцоотой худалдан авагч жишээлбэл ямар төрлийн амины

22 *bureaucrats*

23 *input*

Асуулт: Чөлөөт зах зээл байгаль хамгаалахдаа бүтэлгүйтээгүй гэж үү?

Үгүй. Зах зээл бүтэлгүйтээгүй ээ. Хүрээлэн байгаа орчны олон зүйлд зүгээр л зах зээл байдаггүй. Зах зээл эд зүйл ховор байхад, төлбөр үл хийгчийг түүнээс хасах боломжтой байхад ажилладаг ч харин эд зүйл элбэг дэлбэг эсвэл төлбөр үл хийгчийг түүнээс хасах боломжгүй байхад ажилладаггүй.

Хүмүүс гээд байгаль орчны бараа бүтээгдэхүүн¹⁾д ч гэсэн зах зээл байх боломжтой болохыг мөн ухаж ойлгож эхэлж байна. Жишээлбэл далайн загасны нөөцийг устаж дуусах хүртэл нь олборлохыг зөвшөөрөхийн оронд хэд хэдэн улс одоо байгаа тоо хэмжээний тогтвортой байдлыг хангах хязгаар тавьж, нийт нөөцийн тодорхой хувь хэсгийг л барих зөвшөөрөл олгодог. Энэ зөвшөөрлийг зарж арилжих боломжтой бөгөөд бэлэн нөөцийг нь илүү их хэвээр байлгахын хажуугаар үр ашгийг нь дээшлүүлж түүний зах зээл хурдан түргэн үүсэж гарна.

Чөлөөт зах зээлийн эдийн засгийн буянаар хүмүүс баян болж өсөж өндийхийн хэрээр тэд хүрээлэн байгаа орчноо улам бүр л анхаарч хайрлах бололцоотой болж ирдэг. Хятад үйлдвэрүүдийнхээ ноцтой хэцүү бохирдлоосоо болж зовдог боловч хүмүүс нь цэвэр агаарын тансаглалаас илүүтэй эдийн засгийн суурь өсөлтийг тэнд илүү үнэлдэг ажээ. Тэдний өмнө хөгжсөн бүх баян улсын адилаар тэд ч баян чинээлэг болж өсөж өндийхийн хэрээр стандарт нь өөрчлөгдөх бөгөөд Хятадууд үйлдвэрлэлийн одоогоосоо хамаагүй бага бохирдуулах, илүү цэвэр үйл ажиллагааг хэрэглэх чадвартай болох боломжтой.

1 *environmental goods*

сууц сонирхож байгааг, сар сараар нь зогсохгүй бүр өдөр өдрөөр нь, болж өгвөл цаг цагаар нь мэдэж байх хэрэгтэй болно. Ямар

ч төвийн засаг захиргаа буюу эрх мэдэлтэн иймэрхүү хурдтай өөрчлөгдөж буй мэдээллийг цуглуулж авах боломжгүй тул энэ бүх өөрчлөлт дахиад болохоос нь өмнө [энэ цуглуулж ядаж буй, бас аль хэдийнээ хуучирсан мэдээлэл дээр үндэслэж] ямар нэг үйл хийх тухай төвийн засаг захиргаа бодох ч хэрэггүй.

Зарим хүн чөлөөт эдийн засаг түүнийг төвөөс төлөвлөдөггүй учраас түүнийг зах замбараагүй, рационал бус байх ёстой гэж боддог. Үнэндээ зах зээл маш сайн дэг журамжсан байдаг. Санал нэгдсэн, өмч болон солилцооны ёс журмыг дагаж мөрдөх байдлаар хүмүүс арилжаа хийх, хамтран ажиллах, бусдынхаа хийх үйлдлийг урьдаас нилээд тодорхой таамаглах ч боломжтой. Зах зээл мөн илүү рационал байдаг. Өөрийн төлөвлөгөөгөө гаргадаг, бусдын өөрчлөгдөж буй төлөвлөгөөнд өөрийнхийгөө бас тааруулж нийцүүлдэг сая сая хувь хүмүүсийн тухайн орон нутгийн нарийн туршлага, мэдлэгийг зах зээл ашигладаг. Төвлөрсөн удирдлагатай эдийн засгаас илүү их төлөвлөлт чөлөөт эдийн засагт гарч байдаг – эдгээр төлөвлөлтийг төрийн төвшинд хийх гэхээсээ илүүтэй зүгээр л хувь хүмүүсийн хүрээнд энэ бүх төлөвлөлт гарна.

Төрөөс-санхүүждэг аж ахуй

Өнөөдөр хэдхэн улс орон нийт үндэстнийхээ бүхий л үйлдвэрлэх үйл ажиллагаа үр ашигтай өмчилж, зохион байгуулж чадна гэдэгт итгэж байна. Дэлхийн эдийн засгийн ихэнхи нь төр засаг нь зөвхөн зарим үйлдвэрлэлийг л өмчилдөг, мөн бусад үйлдвэрлэлийг нь төлөвлөлт, дүрэм журмын зохицуулалт, татаас, татвар, төрийн эзэмшлийн хувь хувьцаа зэргээр чиглүүлж, удирдаж зохицуулахыг оролддог “холимог” эдийн засаг байдаг.

Хорьдугаар зуунд олон улс орон стратегийн тодорхой ач холбогдолтой гэж үйлдвэрлэлийн салбарыг нийгэмчилж төрд авсныг бид үзсэн бөгөөд өнөөдөр ч олон улс орон^[24] эдгээр үйлдвэрлэлийг өмчилж, хянасаар л байна – эдгээр үйлдвэрлэлд

24 many countries

харилцаа холбоо, тээвэр, банкны үйлчилгээ, хотын үйлчилгээ, уул уурхай, өөр бусад олон зүйл багтах боломжтой.

Харамсалтай нь иймэрхүү үйлдвэрлэлийн төрийн өмчлөл бараг үргэлж төрийн монополь үүсгэдэг. Ийм монополь голдуу хэн нэгэн хүн үр дүнтэйгээр удирдаж залж чадахаас хамаагүй данхар бүтэцтэй байна. Гэвч энэ монополь байгууллага буюу тогтолцоо нь олон нийтийнх эсвэл хувийнх байх эсэх нь асуудлын шалтгаан биш; харин энэ монополь байгууллага гарцаагүй хэт данхайсан, хөшүүн хойрго байх бөгөөд өндөр үнээр муу үйлчилгээ үзүүлдэг.

Үйлдвэрлэлийн эдгээр салбарын стратегийн ач холбогдол өнөө ч яагаад төр тэдгээрийг өмчлөх ёстой вэ гэдгийг учир шалтгаан биш байдаг. Хамгийн баян улс орнуудын ихэнхи банк хувийн өмчлөлд бий: үнэндээ эдгээр банкиг төрийн монополь болгож хувиргавал эдгээр банк, мөн тэдгээрт найддаг бизнес, гэр бүлүүд сүйрэх болно. Төр засгийн нийлүүлэгч байдлаар ажилладаг эсвэл хэрэглэгчидтэй шууд түүний өмнөөс харьцдаг арилжааны компаниуд одоо дэлхийн харилцаа холбоо, тээвэр, хотын үйлчилгээ^[25] ний дийлэнхийг нийлүүлж хангадаг. Олон улс орон эдгээр чухал үйлчилгээг хувийн менежментийн тухай нарийн мэдлэг, хувийн хөрөнгөө авч ирэх боломжтой, хоорондоо өрсөлдөж буй пүүсүүд ханган нийлүүлэх боломжтой гэдгийг ухаарч таниад төрийн-өмчийн компаниудаа хувьчилжээ.

Гэвч төр засаг үйлдвэрлэлийг тэдгээрийг төр өөрөө өмчлөхгүйгээр хянах боломжтой гэдгийг ойлгож мэдэв. Төр засаг зүгээр л (ерөнхийдөө хувийн өмчлөлд байдаг) компанийн чухал хэсгийг худалдан авах боломжтой бөгөөд хувь эзэмшигчийнхээ энэ эрхийг уг компани юу хийхийг хянах, удирдах зөвлөлд хэнийг томилохыг шийдэхэд ашигладаг. Заримдаа тэд гол чухал асуудалд эцсийн үгээ хэлэх боломж олгодог “алтан хувьцаа”-г өөрсдөдөө авна.

25 *utilities* -нийтийн аж ахуй гэж хэвшсэн. гэхдээ яаж гоё орчуулах вэ?

Чөлөөт нийгэмд иймэрхүү гуйвамтгай холбиромтгой хөндлөнгөөс оролцох явдлаас татгалздаг. Энэ байдал төр засаг тухайн үйлдвэрлэлийг худалдаж авахгүйгээр тухайн үйлдвэрлэлийн тухай шийдвэр гаргах боломжтой болгодог тул төрийн өмчлөл, экспроприаци буюу өмч хураан авах^[26]тай дүйцнэ. Өмчлөгчид, үүн дотроо хадгаламж болон тэтгэврээ хөх чипний компаниуд^[27]ад хөрөнгө оруулсан байж болох жирийн хүмүүсийн өмчийг нь бараг л дээрэмдэж авна. Авилгад идэгдэх байдал хаа сайгүй гаарах болно – амин найзуудын бизнесүүд^[28]ээ сааль сайтай зөвлөлийн суудлаар шагнах, үйлдвэрийг нь таатай орон нутагт байрлуулах, мөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нь дэмжигчдээ өөр татахдаа ашиглах боломжтой.

Төр засаг мөн хувийн компаниудыг дүрэм журмаар^[29] дамжуулан үр дүнтэй хянах боломжтой байдаг. Дүрэм журмаар компаниуд хэрхэн ажиллах, юу үйлдвэрлэх, ямар үнээр зарах, хаана тэд хөрөнгө оруулах, хаана ажлын байр бүтээх боломжтой, хэр цалин ажилчдадаа олгох, үүнээс олон өөр зүйлийг зааж хязгаарлах, эсвэл зааж зааварлах боломжтой. Хувийн нөөц баялгийн төрийн хяналтын иймэрхүү төрөл зүйл бүр өөрсдийгөө чөлөөт гэж нэрлэдэг улсуудад ч гэсэн маш их тархсан байдаг – гэвч энэ бол жинхэнэ чөлөөт нийгмийн маш чухал суурь болдог хувийн өмчийн зарчимтай зөрчилддөг, түүний бүрэн эсрэг зүйл юм.

Олон-улсын худалдаа

Арилжаа худалдаа юу эсвэл протекционизм уу

Нэг улсад буй хувь хүмүүсийн хоорондох чөлөөт худалдаанаас ургаж гардаг тэр үр өгөөж олон-улсын хил дамнасан хүмүүсийн

26 *expropriation* - олон нийтийн хэрэгцээ эсвэл ашиг тусын төлөө төр эсвэл засаг захиргаа эзнээс нь өмчийг булаан авах үйлдэл.

27 *blue-chip companies*

28 *cronies*

29 *regulation*

арилжаа худалдаанаас мөн үүсэж гардаг. Худалдаа арилжаа үндэстнүүдийг юу хамгийн сайн хийдгээрээ нарийн мэргэжих боломж олгох болно, мөн илүү гарсан тэр зүйлээ өөр бусад зүйлийг сайн хийдэг бусад улс орон руу илгээх боломжтой. Дэлхийн таримал цэцэг^[30]ийн нилээд их хэсгийг жишээлбэл хөрс болон цаг уур нь цэцэг тарихад сайн тохиромжтой Кени экспортолдог; энэ үед Чили, Австрали, Франц зэрэг улсыг газар нутаг, уур амьсгалын нөхцөл таатай, хурааж хуримтлуулсан нарийн мэдлэг туршлагатай учраас тэдгээрийг дарсны тэргүүлэх үйлдвэрлэгч гэдэг. Харьцангуй хямд ч сайн боловсрол эзэмшсэн [англи хэлтэй] ажиллах хүчтэй Энэтхэг Ай-Ти үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хувьд чухал улс болжээ. Олон-улсын худалдаа^[31] хүмүүс нарийн мэргэжих, мөн бүтээгдэхүүнээ илүү үр ашигтай үйлдвэрлэх багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмж зэрэг хөрөнгө бүтээх боломж олгодог.

Өөр өөр улсын хүмүүсийн аливаа зүйлийг үнэлдэг үнэлэмж^[32] магадгүй бусад улсад буй хүмүүсийнхээс илүү тод ялгарах магадлалтай учраас ийм хил дамнасан арилжаа худалдаанаас гарах харилцан-хүртэх өгөөж^[33] нь хамаагүй их байх болно. Жишээлбэл дундад зууны үед Европын аянчид Энэтхэг, Хятад зэрэг цайны ургамал ургуулахад хялбар, цай элбэг дэлбэг байдаг эсвэл Ойрхи Дорнодод хямдхан байдаг, өргөн дэлгэр хэрэглэдэг байсан халуун ногоо зэрэг бүтээгдэхүүнд асар их үнэ төлдөг байсан. Өнөөдөр хүмүүс өөрийнх нь улсаас тэдгээр газар орон хэр ондоо болохыг нь гайхширсаар Венецийн архитектур эсвэл Тайландын соёлыг үзэх гэж дэлхийн хагасыг туулан нисэцгээж байна.

Чөлөөт нийгэм бүх улсаас ирэх бүтээгдэхүүнд нээлттэй байдаг. Энэ нийгэмд арилжаа худалдаанаас гарах динамик ашиг тус, мөн арилжаа худалдаа хэрхэн хөгжил цэцэглэлт тархаж

30 *cut flower*

31 *international trade*

32 *value-юм үнэлдэг байдал*

33 *mutual gain*

түгэхэд тус дэм болж буйг хүлээн зөвшөөрдөг. Үүний эсрэг хувилбар зүйл бол протекционизм юм; энэ үед улс орнууд өөрийн нийлүүлэгчдээ бусад улсаас орж ирэх импортоос хамгаалах оролдлого хийдэг. Ийм хамгаалалт орон нутгийн нийлүүлэгчдэд [өрсөлдөөнгүй] амар тайван цаг үе бэлэглэнэ. Гэвч энэ нь орон нутгийнхаа хэрэглэгчдийн гадаад улсаас ирэх илүү сайн эсвэл илүү хямд бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ авах боломжийг нь хаадаг. Хамгаалтад буй дотоодын нийлүүлэгчдэд их үнэ төлдөг нутгийнх нь хэрэглэгчид сонголт бага байх, илүү чанар муутай бүтээгдэхүүн авах явдалтайгаа эвлэрэх л хэрэгтэй болно.

Протекционизм бол хог

Улс гадаадад илүү сайн эсвэл илүү хямд үйлдвэрлэх боломжтой ямар нэг зүйл (үүн дотроо байгалийн нөөц баялаг^[34])-ийг дотооддоо үйлдвэрлэх явдал бол нөөц баялгийг хэрэггүй зарцуулж үрж буй хэрэг юм. Адам Смит бүүдгэр сэрүүн Шотландад хүлэмж ашиглан усан үзэм тарих боломжтой ч энэ нь байгалиасаа нарлаг Францад усан үзэм ургуулах зардлаас 30 дахин их зардалтай байх болно гэдгийг цохон заасан байдаг. Яагаад цаг хугацаа, мөнгө, хүчин чармайлтаа, өөр нэгэн хүн илүү сайн эсвэл илүү хямд хийх боломжтой байхад өөрөө түүнийг хийх гэж оролдож нөөц баялгаа үрж зарлагадах ёстой гэж?^[35]

Үр өгөөжтэй үйлдвэрлэгч улсууд бусад улс нь тэдгээрийн бүтээгдэхүүнийг хязгаарлалт, квот, тарифаар дамжуулан тухайн улс руу нэвтрэхийг хориглох гэж оролдоход дургүй байдаг нь гайхмаар хэрэг биш. Тэр улсууд ч өөрийн хориг саадаа өсгөж бусдаасаа өшөөгөө сайтар авч болох юм. Иймэрхүү худалдааны дайнаас хэн ч үл хождог. Энэ хоёр улсын ялангуяа шинэ хямд импортоос хамгийн их ашиг тус хүртэх хамгийн ядуу иргэдийн хувьд бүх саад тотгорыг арилгах явдал, хүмүүс хүссэнээрээ

34 *environmental resources*

35 *Adam Smith, The Wealth of Nations, 1776, Book IV, ch. II.-БАТЛЕП*

арилжаа худалдаа хийх явдлыг зөвшөөрөх нь хамгийн сайн явдал байх болно.

Үүнтэй адилхан зүйл цагаачлалд тохиолдоно. Чөлөөт нийгэмд төр засаг нь улсуудын хооронд хүмүүс шилжиж нүүхэд саад хориг тавьдаггүй. Цагаачид очиж буй улсдаа ашиг тусаа өгөх шинэ эрч хүч, шинэ санаа тээж очдог. Европ болон Хойд Америк руу чиглэсэн цагаачлалын давлагаа жишээлбэл асар их хөгжил цэцэглэлтийг бүтээжээ. Олон арван жил байсан хяналтыг үгүй хийх нь хэцүү байж болох бөгөөд энэ нь магадгүй асар их гэхдээ түр зуурын зовлон бэрхшээл дагуулж болно: гэвч энэ нь чөлөөт нийгэмд итгэгчдийн эцсийн зорилго хэвээр байх ёстой.

Бодит байдал дээрхи чөлөөт худалдаа

Арилжаа худалдаа чөлөөтэй хийх нээлттэй дэглэм бүхий улс орон илүү хурдан өсөж хөгжиж, ийм дэглэмгүй улсуудаа бодвол илүү их хөгжингүй болдог. Хонконг болон Сингапур зэрэг арилжааны жижиг хотуудыг харцгаана уу – эдний аль нь ч тэдэнд тус болох байгалийн баялаггүй. 1960-аад онд энэ хотууд асар их байгалийн баялагтай Африк, Карибын олон улсууд^[36]ын адил ядуу байсан. Өнөөдөр арилжаа худалдаа болон эдийн засгийн эрх чөлөөний тусламжтайгаар тэднээс олон дахин баян болцгоожээ.

Арилжаа худалдаа тэлснээр дэлхийн ядуурал асар их хэмжээгээр буурав. Зарим хүмүүс импорт, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалт дотоодын хүн амыг мөлжиж ашиглах вий гэж айдаг – жишээлбэл гутал эсвэл хувцас үйлдвэрлэдэг ‘хөлслөх байр’^[37] мэтэд ажиллана гэж айцгаана. Хэн ч хэнийг ч үйлдвэрт ажиллуулахаар албадахгүй гэдэг нь үнэн билээ; гэвч ихэнхи

36 *many countries vs international*

37 *sweatshops-Энэхүү хэллэг 1850 оны үед гарчээ. Утра нь хүмүүс бага цалингаар, урт хугацаагаар, ажлын хүнд голдуу агааржуулалт муутай, тэр үедээ их хөлөрдөг байсан газарт ажилладаг гэдэг үг ажээ. Алдарт Томас Соуэлл, Милтон Фрийдман нар эцэг эх нь “хөлслөх газар” л ажиллаж өөрсдийг нь ийм карьерт хүрэх замыг зассан гэгцгээсэн байдаг. Тэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэгчийг эсэргүүцдэг.*

хүмүүс тодорхой бус, багахан шан харамжийн төлөө халуун наран дор талбайд ажиллаж хөдөлмөрлөхийн оронд жирийн цалингаар үйлдвэрт ажиллахыг хамаагүй дээр гэж үзэх болно. Гадаадын хөрөнгө оруулалт орж ирсэн Вьетнам зэрэг улс оронд тэр үйлдвэрт ажиллаж буй ажилчид одоо өмнө нь мөрөөдөж ч байгаагүй моторт скүтер, зурагт, бусад тансаг зүйл хүсэж мөрөөдөж чадахтайгаа болжээ.

Аливаа сүүлийн үеийн нарийн бараг бүх бүтээгдэхүүнд, гар утас эсвэл зөөврийн компьютерт өнөөдөр дэлхий-дэхнээс цуглуулсан нөөц баялаг, ур чадвар, нарийн туршлага оролцсон байдаг. Загвар зохиогч нь Калифорнид амьдрах боломжтой ч харин үйлдвэрийг нь Хонгконг хүмүүс удирддаг, бусдыг нь Хятадад байгаа өөр хүмүүс хийх боломжтой. Тухайн бүтээгдэхүүнд хэрэглэдэг метал, бусад хэрэглэгдэхүүнийг нь Ази, Австрали, эсвэл Өмнөд Америкаас уурхайлж ашигладаг ч байж болно. Уг бүтээгдэхүүнийг нь Грект төвтэй далайн тээврийн усан онгоцоор, эсвэл Нидерландад төвтэй нисэх онгоцоор тээвэрлэдэг ч байж болох юм. Мэдээжээр хэрэглэгчид нь дэлхий даяар тархан амьдарцгаана.

Бусад улс орны хүмүүстэй хүмүүс арилжаа наймаа хийхийн хэрээр тэд тэднийг улам сайн ойлгодог болж, эсвэл дор хаяж тэднийг хүндэлдэг болдог. Наймаачид худалдаачид бусад үндэстэн эсвэл арьстнаас өөрийгөө эрхэм дээд ариун амьтан гэж төсөөлбөл горьг нь амсах болно. Өөрсдөө ашигтай байхын тулд тэр худалдаачид бусад хүмүүстэй нийлүүлэгч эсвэл хамтран ажиллагч, эсвэл хэрэглэгчийн хувиар эв найртайгаар арилжаа хийх хэрэгтэй. Олон-улсын арилжаа худалдаанаас өөрийн гэсэн илүү өргөн хүрээтэй, ач тустай харилцан ойлголцол, эв найр бий болно. Ихэнхи чөлөөтэй болон нээлттэй нийгэм худалдаа арилжаанд хамгийн чөлөөтэй, нээлттэй улсууд байдагт гайхах зүйл алга.

6 ХӨГЖИЛ ДЭВШИЛ, ШУДАРГА ЁС

4-р бүлгээс бид ‘шударга ёс’ маш нарийн тодорхой утгатай, энэ нь үйлийнх нь шан урамшууллыг хүмүүсийн дунд хэрхэн хуваарилах ёстой тухай биш харин хүмүүс бусадтайгаа харьцахдаа хэрхэн үйл хөдлөл хийх хэрэгтэй тухай утгатай болохыг харсан. Гэвч хувь хүмүүс нэг нэгтэйгээ харьцахдаа гаргах үйл хөдлөлийг захирч удирддаг ёс журам нарийн нийлмэл байдаг. Зан үйлийн эдгээр ёс журм^[1]ыг хадгалж үлдэх, албадаж хэрэгжүүлэхэд тодорхой үнэт зүйлс, нийгмийн институтц шаардлагатай – эдгээрт өмч, хууль ёс, бусдын эрхийг хүндлэх зэрэг зүйл ордог.

Хувийн өмч

Өмч гэж юу вэ

Хүмүүс хувийн өмчтэй байх явдал бол чөлөөт нийгмийн үйл ажиллагааны үндэс юм. Өмч өмчлөх^[2] гэдэг нь та нар ямар нэг зүйлтэй байх, түүнийг хянана гэсэн утгатай бөгөөд хамгийн гол нь та нар өмчөөсөө бусад хүмүүсийг хол байлгах эрх дархтай байдаг явдал юм. Та нар түүнээ таашаан эдлэх, зарах, түрээслэх, бусдад өгөх эсвэл бүр үүнээ устгах ч боломжтой гэлээ бусад хүмүүс үүнийг тань өөрийн чинь зөвшөөрөлгүйгээр ашиглах, өөрөөс чинь булааж авч чадахгүй. Таны өмчийг хуульзүйн дагуу танаас булааж авах боломжгүй.

1 rules of conduct

2 Property ownership

Хувь хүмүүс өмчтэй байх боломжтой ч бас гэрлэсэн хос, бизнесийн хамтлаг, корпорац, төр засаг, олон нийтийн байгууллага зэрэг бүлгүүд өмч өмчлөх боломжтой ажээ.

Өмч газрын хэсэг эсвэл байшингийн хэсэг зэрэг ямар нэг биет, хөдөлгөөнгүй зүйл үргэлж байдаггүй. Фермийн амьтад, ачааны машин эсвэл хувцас хэрэглэл гээд ямар нэг шилжих хөдлөх зүйл байх боломжтой. Өмч мөн биет бус ямар нэг зүйл ч байх боломжтой. Та нарын зохион бичсэн эсвэл бичиж бүртгэсэн ямар нэг зүйл эсвэл та нарын зохиомжилж зохиосон зүйлийн зохиогчийн эрх зэрэг барааны тэмдэг эсвэл зохиогчийн эрх зэрэг *оюуны өмч* байж болно. Өмчид компани дахь хувьцаа буюу эзэмшлийн хувь, та нарт хэн нэгэн төлөх өр, эсвэл таны хадгаламж буюу хадгалж хураасан зүйл орох боломжтой. Энэ нь мөн хэн нэгний газрыг тодорхой хугацаанд хөлслөх, түрээслэн эзэмших түрээс эсвэл тодорхой давтамж ашиглах радиостанцын эрх ч байж болно. Тэгвэл өмч заавал ямар нэг хөдөлгөөнгүй, биет зүйл л заавал байх албагүй ажээ.

Өмчийг мөн л *бүтээж бий болгох* боломжтой. Ачааны машин эсвэл хувцас хэрэглэл бол өмчийн шинэ төрлийг бүтээхийн тулд бүрэлдэхүүн хэсгүүдийг цуглуулж бүтээсэн зүйл юм. Фермийн мал амьтдыг өсгөж тэжээж нас биед хүргэдэг. Хүмүүс шинэ ном бичдэг, эсвэл хадгаламжийн шинэ багцыг хөгжүүлж гаргадаг^[3]. Тоон технологи гар утасны асар олон суваг бүтээх боломж олгожээ – энэ бол өмчийн бүхэлдээ шинэ төрөл юм.

Таны өмчид өөрийнхөө биеийг мэдэх таны эрх, өөрийн хөдөлмөрийн үр шимээ таашаан эдлэх эрх багтдаг болохыг хэлэх хэрэгтэй. Чөлөөт нийгэмд та нарыг ямар нэг үндэстэй шалтгаангүйгээр баривчлах, шоронд хорих боломжгүй. Та нарыг хэн нэгэн өөр хүний төлөө ажиллахаар хуульзүйн дагуу албадах боломжгүй. Бас бусад хүмүүс таны ур чадвар, авьяас, мэдлэг эсвэл хүч хөдөлмөрөөрөө бүтээсэн зүйлийг тань хулгайлах явдлыг ч зөвшөөрдөггүй.

3 *people write new books, or develop new savings packages*

Өмч ба хөгжил дэвшил

Хувийн өмчийн институт бол хэдийгээр зарим үед түүнийг хүндэлдэггүй байсан ч гэсэн хүмүүн төрөлхтөнтэй л адилхан эртний зүйл юм. Эртний Спартад хувийн өмчийн үзэл санааг үл тоодог байв. Бүр саяхан Орос, Хятад зэрэг улс оронд ферм болон үйлдвэрийн хамтын өмчлөлийг туршиж үзсэн. Гэвч хувийн өмчийг аажмаар хүлээн зөвшөөрснөөр, түүнийг хамгаалдаг болсноор, орчин үеийн арилжаа наймаа үүсэж хөгжсөнөөр л арилжаа худалдаа хийдэг үндэстнүүдийн эд баялаг сая асар ихээр нэмэгдэв.

Яагаад тэгснийг нь мэдэх их амархан. Экологич Гарретт Хардин ‘жирийн иргэдийн эмгэнэл’^[4]-ийн тухай бичжээ.^[5] Хүмүүс нөөц баялаг өмчилдөг бол ийм зүйл байдаггүй байхаасаа илүү ихээр түүнийгээ хадгалж хамгаалах, харж хандах хамаагүй их сонирхолтой байдаг. Хамтралаараа эзэмшиж фермийн аж ахуй эрхэлдэг газраас хувийн өмчид буй газрыг хамаагүй сайн боловсруулж тарьж арчилна. Орон сууцны байшингийн нийтийн буюу дундын шат, хонгил, газар хэдийгээр хувийн орон сууцыг нь сайхан авч яваа байж болох ч гэлээ голдуу л бохир заваан байдаг. Бусад хүмүүс хэдийгээр тэд ямар ч ажил хийгээгүй байсан ч ашиг тусыг нь нэгэнт хүртэх учраас өөрт нь ямар ч хамаагүй ямар нэг зүйлд яагаад өөрийнхөө цаг хугацаа, хүч хөдөлмөрөө зориулж зарцуулах ёстой болохоо хүмүүс ойлгодоггүй.

Өмчийг хамгаалах, өмчийн өмчлөлийг хүндэтгэх явдал хүмүүст бүтээлч хөрөнгө бүтээж бий болгох боломж олгодог. Фермерүүд хэрэв хураан авах ургацаа тэд ургацаа өмчилдөг бол үр тарьж, ургацаа бөөцийлж ургуулж, мөн трактор худалдаж авна. Ажил хэрэгч хүн хэрэв тэд өмчөө хэрхэн ашиглахаа өөрсдөө

4 the tragedy of the commons-Энэ хэллэг ойлголтоор дундын буюу хэний ч биш учраас байгалийн нөөц баялагийг хэт их ашиглах, үрэх, аажмаар тэр нөөц баялаг дундарч ингэснээр түүнд оролцож буй хүмүүс эрсдэлд орж буй нөхцөлийг анх тайлбарлажээ.

5 Garrett Hardin, ‘The tragedy of the commons’, Science, 162(3859), 1968, pp. 1243–8-БАТЛЕР.

шийддэг, мөн бусад хүмүүс түүнийг нь авах эрхгүй гэдгийг мэдэх боломжтой байвал үйлдвэр, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн сүлжээнд хөрөнгө оруулж эрсдэл илүү их гаргах магадлалтай. Хэрэв өмчийн эрхийг хамгаалдаг, хүндэлдэг бол бүтээлч хөрөнгө хүмүүс хуримтлуулж, улмаар нийт нийгэмд тустай зүйл болох үр ашигтай байдал нэмэгдэнэ. Гэвч хэрэв өмчийг нь бусад хүмүүс хулгайлах, эсвэл устгах боломжтой бол эсвэл өөр хэн нэгэн түүгээр нь үйлдвэрлэсэн зүйлийг булааж авах боломжтой бол хүмүүс ур чадвар, цаг хугацаа, мөнгө, хүч хөдөлмөр, үйлдвэрлэх нарийн туршлагаараа хөрөнгө оруулах ямар ч эрмэлзэлгүй болох бөгөөд нийт нийгэм үүнээс болж хохирдог.

Өмч болон бусад эрх

Чөлөөт нийгэмд хүмүүсийн таашаан эдэлдэг эрх, эрх чөлөө өмчийн институттэй гүн бат холбоотой байдаг. Хувийн өмчгүйгээр ямар ч эрх, эрх чөлөө байх боломжгүй.

Жишээлбэл, хүмүүсийн чөлөөтэй ярих эрх, бусадтайгаа эвлэлдэн нэгдэх эрх, улстөрийн үйл явцад оролцох эрхийг харцгаа. Хэрэв энэ үед хувийн өмч байхгүй байсан бол жишээлбэл зарим төр засаг бүх нөөц баялгийг хянадаг байсан сан бол нэр дэвшигчид хэрхэн сонгуулийн кампанит ажлаа явуулах вэ? Хэлэх зүйлээ санаагаа бусдад дамжуулахын тулд тэд уулзалтын танхим хөлслөх, сурталчилгааны зүйл хэвлүүлэх, үзэл бодлоо өргөн нэвтрүүлгээр дамжуулах хэрэгтэй болно. Гэвч хэрэв тухайн төр засаг хэвлэл болон цаасны бүх хангамж нийлүүлэлтийг хянадаг, өргөн нэвтрүүлгийг явуулдаг бол энэ байдалд [байгаа төр засаг] ямар ч хүний кампанит ажлыг шуудхан зогсоох боломжтой.^[6] (Үнэндээ нэр дэвшигч нь төр засаг эсвэл бодлогод нь маш их шүүмжлэлтэй байдаг бол ийм зүйл болох магадлал маш их байна.) Үүнээс муу зүйл хэрэв хүмүүст өөрт нь өөрийн гэх ямар ч өмч байхгүй бол төр засаг шүүмжлэгчид нараа баривчлах, эсвэл

6 Энэ санааг дараахь бүтээлд сайн тайлбарласан: F. A. Hayek, *The Road to Serfdom*, Routledge, London, 1944.-БАТЛЕР

бүр алах замаар дуугүй болгох явдлыг юугаар ч зогсоох аргагүй байдаг. (Эдгээр жишээ сэтгэл сэртхийлгэм ч бүгд л их нийтлэг байдаг зүйл.)

Өмчгүй бол тэнд шударга ёс байхгүй. Өөрийн бие, хүч хөдөлмөр, эд зүйлээ мэдэх эрхгүй байвал тэдгээрийг тань ямар ч нөхөн төлбөргүйгээр танаас булаан авах болно. Хэрэв танд өөрийн биеийг мэдэх эрх байхгүй бол та нарыг дур зоргоороо баривчилж, шоронд хийж, алах боломжтой; хэрэв та нарт хүч хөдөлмөрөө мэдэх эрх байхгүй бол та нарыг боолчлох боломжтой; хэрэв танд эд зүйл өмчөө мэдэх эрх байхгүй бол та нарыг дээрэмдэх боломжтой. Шударга бус байдлаас та нарыг хамгаалах аргагүй болно.

Өмчийн ёс суртахууны ашиг тус

Өмч, өмчийн эрхийг хамгаалах явдал төр засгийн эрх мэдэл болон бусдын албадлагаас хамгаалах чухал тусгаарлах хоригийг хүн бүрд өгдөг. Өмч өмчлөх явдал хувь хүмүүст бусдын, төр засгийн эсвэл бусад хувь хүмүүсийн дур зоргын хүсэлд захирагдахгүйгээр өөрсдийгөө хамгаалах, өөрийнхөө сонголтыг хийх, өөрийнхөө төлөвлөгөөг өөрийнхөөрөө зохиомжлох, өөрийн алсын бодолдоо хүрэхээр тэмүүлэх, эсвэл үзэл бодлоо илэрхийлэх бололцоо өгдөг.

Өмч, түүнээс ургаж гардаг арилжаа худалдаа болон солилцооны ёс журам мөн л хувь хүмүүст харилцан-ашигтай байхынхаа төлөө эв найртай хамтран ажиллах боломж олгоно. Энэ нь тэдэнд нэг нэгтэйгээ зэрэгцэн амьдрах, санал нэгдсэн ёс журмын дагуу ямар нэг маргаан, хүчирхийлэл, албадлагагүйгээр байгалийн баялаг болон хөдөлмөрийнхөө үр шимийг хамтран эзэмшиж хуваалцах боломж олгодог.

Өмч зөвхөн эв найртай хамтын ажиллагааг дэмжихээр нөлөө нь дуусдаггүй; бас энэ нь өөрийн нөхцөлөө илүү сайн болгохыг хүссэн хүн бүрийн хувьд хамтын ажиллагааг зайлшгүй хэрэгтэй зүйл болгоно. Хүмүүс өөрийн хүссэн зүйлээ хүчээр

авах боломжгүй. Өмчийг зөвхөн эздийнх нь хүсэл зөвшөөрлөөр дамжуулж, зарж, түрээсэлж, хуваалцаж, бусдад түрээслэх боломжтой. Хамгийн их-эрх чөлөөтэй нийгэмд өрөө төлөх, гэрээг хүндлэх тухай ёс журам зэрэг энэхүү чухал эрхийг хамгаалах хүчтэй механизм бий. Чөлөөт хүмүүс үүнийг хүчээр эсвэл хууран мэхэлж булааж авахаас илүү сайн, нөөц баялаг дамжуулах илүү ёс суртахуунтай арга зам гэж үздэг.

Нийгэм дэх хувь оролцоо

Зөвхөн өмч өмчилдөг тэр хүмүүс л ашиг тус хүртдэггүй мөн үүнээс бүгд л ашиг тус хүртдэг. Хөрөнгө оруулалт, хөрөнгө бүтээх явдлыг дэмжсэнээр нийт нийгмээрээ ач тусыг нь хүртэнэ. Жишээлбэл өөрийн гэсэн газаргүй, хотын оршин суугч фермерүүдийн ургацаа тарьж ургуулах, түүнийгээ хэрэглэгчдэдээ сайн дураараа зарах гэсэн хичээл зүтгэлийн тусаар хоол хүнстэй байдаг. Энэ байдал бол фермерүүдийн газраа өмчлөх, тарьсан ургацаа өмчлөх өмчлөлийн эрхийн ач буян юм. Үүнээс гарах үр дүн нь өмчийн эрхийг хамгаалдаггүй улс орнуудаас гайхмаар ялгаатай байдаг – жишээлбэл Роберт Мугабегийн Зимбабвед хэзээнээсээ ажил хэрэг нь тогтчихсон фермерүүдийн газрыг хүмүүс өөрийн юм шиг дураараа эзлэн суух явдлыг дэмждэг. Фермерүүд (голчлон цагаан арьст) зугтаан одоход үр дүнд нь илүү их хөгжил цэцэглэлт гарсангүй харин улам л доройтжээ: газар өмчлөлийн тодорхой ойлгомжтой ёс журам байхгүйгээс болж үйлдвэрлэл асар их хорогдож, хотын иргэд хүнсний хомсдолд орон, гарах гарцгүй болсноо мэдэцгээв.

Тиймээс л чөлөөт нийгэмд хүмүүсийн өмчийн эрхийг хамгаалах явдал төр засгийн чухал үүрэг юм. Энэ үүрэг хувь хүмүүсийг өөрсдийгөө эрүүгийн гэмт хэрэгтнүүдээс, мөн хүч чадалтай эсвэл баян тарган элитүүдийн албадлагаас хамгаалахад нь тус болдог. Хувийн өмчийн институт⁷⁾ хүн бүрд нийгэмд хувь оролцоотой байх боломж өгдөг бөгөөд мөн эв найртай хамтран

7 *institution of private property*

ажиллах сонирхол төрүүлнэ. Бүтээлч хөрөнгө бүтээж бий болгох, түүнийгээ сахин хамгаалах боломж олгож өмчлөгдсөн нөөц баялгийг сайн залж удирдах, үр ашигтай ашиглах явдлыг тэтгэдэг өмчийн эрхээс хүн бүр хождог. Чөлөөт нийгэм дэх өмч өмчлөх явдал бол хэдхэн хүнд зориулагдсан тусгай эрх биш. Энэ бол хүн бүрд нээлттэй, үүнээс хүн бүр ашиг тус хүртдэг зүйл билээ.

Шударга ёсны ёс журам

Шударга ёсыг эрж олох

Шударга ёс гэж шагнаж урамшуулах, шийтгэл оногдуулах ёс журмыг хэлдэг. Үйлдлийнхээ үр дүнд хүмүүс юу хүртэх гавьяатай болох тухай бидний хүмүүний нийтлэг мэдрэмжид шударга ёс үндэслэдэг. Хэрэв хувь хүмүүс жишээлбэл албаар бусдыгаа хохироож гэмтээвэл ихэнхи хүмүүн төрөлтөн тэднээс хохирогчид нөхөн төлбөр олгуулж, гэмт үйлдлийнх нь төлөө тэдэнд шийтгэл оногдуулах ёстой гэдэгт санал нийлэх болно.

Шударга ёсны ёс журам бол^[8] бид өөрсдөдөө зориулж бүтээж цогцлоох боломжтой ямар нэг зүйл биш. Шударга ёс бол бидний байгаа байдлын нэг хэсэг юм^[9]. Зарим хүмүүс дараах зүйлд итгэдэг: ‘жам ёсны хууль^[10]’-ийг бидэнд бидний Бүтээгч өгсөн бөгөөд ийм хуулийг өөрийн шашнаараа дамжуулан бидэнд ил болгож харуулсан гэдэг. Бусад нь Нобелийн шагналт эдийн засагч, философич Ф. А. Хаекийн адилаар эволюцтэй-холбосон үзэл бодол^[11]той байж, биднийг нийгмийн бодгаль болохынхоо хувьд эв найртай хамтдаа амьдрахад минь тусалдаг учраас л шударга ёсны ёс журам бидэнтэй цуг үүсэж хөгжсөн гэж батлан өгүүлдэг. Энэ хоёрын аль нь ч бидэнд цаанаасаа л хамтын ажиллагаа болон хүмүүний төвөггүй ажилладаг

8 *rules of justice*

9 *they are part of our very nature*

10 *natural law*

11 *evolutionary view*

нийгмийг дэмждэг шударга ёсны жам ёсны мэдрэмж^[12] байдаг гэдгийг харуулдаг. Хэрэв бид иймэрхүү сэтгэл мэдрэмж байхгүй, шударга ёс гэдгийг мэдэрдэггүй байсан бол – хэрэв бид жишээлбэл хүмүүс дээрэмдүүлж эсвэл алуулж байхад ямар ч үйл хийдэггүй байсан бол бид нар ингэж удаан хугацаанд оршин тогтносон хэвээр байж чадахгүй.

Тийм учраас чөлөөт нийгмийн хууль тогтоох болон шүүх байгууллага^[13] шударга ёс ямар байх ёстойг зааж зааварлаж боломжгүй. Тэдний бодож гаргах боломжтой аливаа ёс журам бидний байгаа байдлын нэг болсон тэдгээр ёс журмаас илүү сайн ажиллах нь юу л бол. Тэдний хийж чадна найдах зүйл бол шударга ёсны ёс журам юу болохыг л *олж нээх явдал* юм.^[14]

Хэн нэгэн нийтийн хууль^[15] эсвэл тухайн газар орны хуульзүйн тогтолцооны үйл ажиллагаанаас шударга ёсыг харах боломжтой. Хувь хүмүүсийн хоорондохь маргаан, жишээлбэл хөршүүдийн дундахь хашааны хилийн тухай маргааныг шүүх рүү аваачдаг. Тэр шүүх нь тухайн хэрэг явдлын тодорхой нөхцөл байдлаар өгөгдсөн ямар гаргалгаа буюу гарах үр дагавар нь шударга болохыг шийдвэрлэх ёстой. Ийм хилийн тухай хоёрдохь маргаан ямар нэг талаараа өмнөхтэйгөө адилхан байх ч бусад талаараа ижил байхгүй ч байж болох бөгөөд шүүх дахиад л ямар үр дагавар нь шударга байхыг олж мэдэхээр өөр нэг оролдлого хийдэг. Шүүгч дүр зоргоороо шийдвэр гаргадаггүй. Шүүгч удаан хугацаанд хүлээн зөвшөөрөгдсөөр буй зарчмуудыг шинэ нөхцөлд л хэрэглэнэ. Энэ маягаар турших үзэх удаан хугацааны үйл явцаар л хөршүүдийн хоорондохь ямар үйл хөдлөлийг шударга гэж, харин алийг нь шударга бус гэж үзэх тухай нийтлэг ойлголт аажмаар үүсэж гарч хөгждөг ажээ.

12 *natural feelings of justice*

13 *legislature and judiciary*

14 Энэхүү санааг дараахь бүтээлд сайн тайлбарласан байдаг: F. A. Hayek, *The Mirage of Social Justice*, University of Chicago Press, Chicago, IL, 1978.-БАТЛЕР

15 *common law*

Шударга ёс бол хууль, ёс суртахуун эсвэл тэгш байдал биш

Чөлөөт нийгэм дэх шударга ёсны ёс журмын үндсэн хэвшинж бол үүнийг хүн бүрд тэгш хэрэглэх ёстой байдаг явдал юм. Нэг ижил нөхцөл байдалд өөр өөр хүмүүстэй ижилхэн байдлаар хандаж харьцах ёстой.

Хууль болон шударга ёс үргэлж нэг ижил зүйл байдаггүй. Жишээлбэл хуулиар үргэлж бүх хүмүүстэй ижил тэгш харьцдаггүй. Хуулийг найз нөхдөдөө түслах, дайснаа хохироох зорилгоор элитүүд буюу дээд ангийнхан зохион гаргасан ч байж болно. Ийм хууль *шударга бус* хууль билээ.

Бас тэгээд шударга ёс болон ёс суртахуун ижилхэн зүйл биш. Олон хүн гэрлэлтээс өмнөх сексийг маш ёс суртахуунгүй зүйл гэж үзэх боломжтой. Гэвч энэ явдал үүнийг шударга бус зүйл болгодоггүй. Өөр хэн ч иймэрхүү харилцан зөвшөөрсөн^[16] үйлдлээс хохирдоггүй; тиймээс үл хохироох зарчмын ёс журм^[17]аар ийм үйл хийж буй тэр хүмүүсийг шийтгэх нь шударга бус. Дахиад хэлэхэд ийм зүйл хийдэг хууль бол шударга бус хууль юм. Хэрэв хуулиар бусад хүмүүс тэдний үйл хөдлөлийг дайрч доромжилсон гэж зүгээр л үзэж буй учраас хүмүүсийг шийтгэдэг бол тэр үед бидний хэнд ч эрх чөлөө үлдэхгүй.

Үүнтэй адилаар тэгш байдал бол шударга ёстой адил зүйл биш байдаг. Зарим хүн баян бусад нь ядуу байдаг гэсэн бодит байдлаас болж нийгэм шударга бус болчихдоггүй. Тэгш бус байдалтай нийгэм тэгш байдалтай нийгмийнхээ адилаар бүх талаараа шударга байх боломжтой. Хүмүүс өмчөө хуульзүйн дагуу, ямар ч албадлагагүйгээр олж авсан нь тэд бүхэлдээ нийтдээ шударга байдлаар үйл хийсэн гэсэн үг.

Хувийн өмчийг шүүмжлэгч зарим хүн өмч зөвхөн хулгайгаас л үүсэж гарах боломжтой гэж хэлдэг. Энэ бол худал зүйл. Юуны түрүүнд ашиглаж байгаагүй зэлүүд онгон байсан хэсэг газрыг

16 consensual actions

17 no-harm rule

өөртөө авсан байж болох хүмүүс хэнийг ч үл хохироосон байдаг. Хэрэв тэд үүнээ фермийн аж ахуй болгож ашиг тусыг нь тэр үедээ хүртсэн бол эсвэл түүний дороос үнэт метал олж нээсэн бол энэ нь тэдний аз завшааны хэрэг билээ: хэн ч үүнээс нь болж ядуураагүй бас зовоогүй тул тэнд ямар ч шударга бус зүйл болсонгүй. Үүнтэй адилаар хэрэв ажил хэрэгч хүн шинэ бүтээгдэхүүн эсвэл үйлдэх үйл ажиллагаа зохион бүтээгээд, худалдаж авахыг хүссэн хүмүүст үүнийгээ зарж эд хөрөнгөтэй болсон бол үүнээс нь хэн ч үл хохирдог: үүний эсрэгээр энэ шинэ бүтээл санаанаас нь бүр нийт дэлхийгээрээ ач тусыг нь хүртдэг билээ.

Шударга ёсыг албадан хэрэгжүүлэх

Чөлөөт нийгмийн амин чухал гол зорилго бол хүч хэрэглэх явдлыг багасгаж хорогдуулах явдал юм. Гэвч шударга ёсыг ямар нэг байдлаар л албадан хэрэгжүүлдэг. Хэрэв хүмүүс бусдыг хохироодог бол бид тэднийг торгож эсвэл шоронд хорьж шийтгэх болно гэж боддог. Энэ нь тэр эрүүгийн гэмт хэрэгтнүүдэд хүч хэрэглэнэ гэсэн үг билээ. Хэрэв шударга ёсыг давамгайлуулах гэвэл албадлага зайлшгүй хэрэгтэй.

Чөлөөт нийгэм энэхүү дилемма буюу хэцүү сонголтыг иргэний засаг захиргаанд албадлагын монополь эрхийг өгөх замаар шийдвэрлэдэг. Зөвхөн тэд л хүч хэрэглэх боломжтой бөгөөд бүр тэд л зөвхөн шударга ёсыг албадан хэрэгжүүлэх, дотоод болон гадаадын дайснаас иргэдээ хамгаалахад л албадлага хэрэглэх боломжтой. Үүнээс бусад хувь хүмүүс хүч хэрэглэхийг хориглодог.

Хэрэв төр засагт хүч хэрэглэх монополь эрхтэй байх хэрэгтэй бол төр засгийг чанд нарийн хязгаарлах ёстой. Төр засаг хүмүүн төрөлтнөөс бүрддэг бөгөөд ямар ч хүмүүн төрөлтөнд албадлагын эрх мэдэл хэрэглэх явдлыг дураараа итгэл хүлээлгэн олгох боломжгүй. Ийм эрх мэдлийг өөрийн-тусын төлөө хэрэглэх гэсэн хүсэл шунал маш их байдаг.

Үүнээс болж чөлөөт нийгмийн шүүх тогтолцоонд засаг захиргааны албадлагын эрх мэдлийг хязгаарладаг чанд нарийн ёс журмыг нэгтгэдэг ажээ. Жишээлбэл засаг захиргааны мөрдөн шалгах, баривчлах эрх мэдлийн талаар, мөн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар, шийтгэлийг хэрхэн эдлүүлэх тухай хатуу чанд ёс журам байх ёстой. *Арга ажиллагааны* эдгээр ёс журам^[18] шийдвэрийг *хэрхэн* гаргах тухай байдаг бөгөөд харин *юуны* тухай шийдвэр гаргаж болох тухай заадаггүй. Шүүх үйл явцыг үнэн зөв, шударга^[19] гэж үздэг байхын тулд эдгээр ёс журмыг дагаж мөрддөг.

Шударга ёсонд учрах аюул занал

Хэрэв засаг захиргааны албадлагын эрх мэдлээр шударга бусаар хувь хүмүүсийг мөрдөн мөшгөдөггүй байлгах гэвэл энэхүү бүтцийг бат суурьтай болгох хэрэгтэй. Энэ бүтцийг бүр шударга ёсны ашиг сонирхлын үүднээс үйл хийж байна гэж өөрсдийгөө боддог хүмүүс хялбархаан үгүй хийнэ. Жишээлбэл шүүгч заримдаа тэдний ажил бол үйл ажиллагааны буюу процедурын ёс журмыг дагаж мөрдөх гэхээсээ илүүтэй үнэн зөв үр дагавар гаргах явдал гэж боддог. Гэвч иймэрхүү *шүүх ажиллагааны активизм* буюу хэт идэвхийлэх явдал шүүгчийн хувийн бодлыг шударга ёсны дээгүүр тавихад хүргэдэг. Энэ байдал мөн шүүх үйл ажиллагааны үр дагаврыг урьдаас таамаглах аргагүй болгодог: нэг ижил гэмт үйлдэлд ондоо ондоо шүүгч өөр өөр шийтгэл ногдуулах боломжтой болно. Энэ нь эрх мэдэлтэй хүмүүсийг шүүхээс гарах шийдвэрт маш их нөлөөтэй болгодог: хэрэв тэд шүүгчийг хахуульдах эсвэл айлган сүрдүүлэх боломжтой байвал тэд хүмүүсийн шийтгэлийг ч өөрчлөх боломжтой. Гэвч хэрэв хэрэг болгонд баримтлах бат суурьтай арга ажиллагааны ёс журам байдаг бол иймэрхүү нөлөө багасаж хумигдана. Энэ

18 *procedural rules*

19 *fair and just*

байдал шүүхийн өмнө очиж буй хүмүүсийн хамгийн амин чухал хамгаалалт билээ.

Шударга ёсыг хэрэгжүүлэх ажл^[20]ыг ганхуулдаг өөр нэг хандлага бол “нийгмийн шударга ёс”-ны тухай үзэл санаа юм. Эд баялаг болон орлогын илүү тэгш хуваарилалтыг албадмал байдлаар бүтээх явдал нь өмч болон шударга ёсны зарчимтай зөрчилддөг. Ижил тэгш хуваарилалтыг тогтоохын тулд өмчийг зарим хүмүүсээс булаан авч, бусдад нь өгөх ёстой болно. Хүмүүст өмчтэй байх эрх, түүнээ өөрийн хүссэнээрээ зарцуулж зарлагадах эрх өгдөг өмчлөлийн ёс журмыг урвуу харуулж хөмөрнө. Дахиад хэлэхэд нэгэнт бид ийм гулсамтгай холбиромтгой эрх мэдлийг засаг захиргаанд өгвөл хүн бүрийн аюулгүй байдал үгүй болно. Аж ахуй эрхлэх явдал мөн л үгүй болно: хэрэв засаг захиргаа буюу эрх мэдэлтэн түүнийг нь хураан авах боломжтой бол яагаад хэн нэгэн эрсдэл үүрч, өмч олж авахад хүч чадлаа барах ёстой гэж?

Өмчийн өмчлөлд хэрэглэх ёстой нарийн тодорхой ёс журам гэвч үргэлж ойлгомжтой тодорхой байдаггүй. Миний мэдэлд буй хэсэг газрын өмчлөл түүний дор буй эрдэс бодис ашиглаж олборлох эрх надад олгодог уу? Энэ нь миний газар дээгүүр нисэх онгоц нисэж өнгөрөхийг хориглох боломж надад өгөх үү? Надад ойрхон байгаа үйлдвэр миний агаарыг утаат яндангаараа бохирдуулахыг нь би хориглож чадах уу? Эдгээр нарийн ширийн зүйлийг тодорхой болгож тогтоох ёстой.^[21] Чөлөөт нийгэмд эдгээр ёс журмыг шударга ёсны ёс журам жинхэнээсээ юу болохыг л зөвхөн зөв тодорхойлохыг оролддог чин шударга шүүгч шүүхэд тасралтгүйгээр туршиж, үргэлжлүүлэн сайжруулж байдаг.

20 *administration of justice*-төрийн хуульзүйн тогтолцоог хэрэгжүүлэх үйл явц ажээ. Энэ үйл явцын зорилго бол уг тогтолцоо руу ирсэн бүх хүнд шударга ёс үзүүлэх явдал гэж тайлбарласан байна.

21 Энэхүү санааг дараахь бүтээлд сайн тайлбарласан: Milton Friedman and Rose Friedman, *Capitalism and Freedom*, University of Chicago Press, Chicago, IL, 1962.-БАТЛЕР

Жам ёсны шударга ёс

Чөлөөт нийгэмд бүх хууль-гаргах явц, хуулийг албан хэрэгжүүлэх үйл хийхдээ шударга ёсны зарчмыг дагаж мөрдөх ёстой – энэ зарчмууд *жам ёсны шударга ёс*^[22] гэж дууддаг, бидний хүмүүнлэг чанар^[23]т гүн гүнзгий үндэслэсэн байдаг.

Юуны түрүүнд хуулийг бүгд мэддэг, тэр нь ойлгомжтой, тодорхой байх ёстой. Хэрэв хуулийг нууц эсвэл түүнийг нууцаар өөрчилсөөр байвал хувь хүмүүс үүнийг зөрчиж буй эсэхээ мэдэж чадахгүй, үүнээс улбаалаад мөрдөж шийтгэх^[24]ээс өөрсдийгөө хамгаалах боломжгүй.

Хууль урьдаас таамаглахуйц мөн байх ёстой. Хувь хүмүүс хуулийг хаана хэрэглэх, хаана хэрэглэхгүй болохыг, мөн түүнийг зөрчвөл ямар үр дагавартай болох мэддэг байх ёстой. Бүр чөлөөт гэж үздэг нийгэмд ч хууль голдуу нэг л зорилгын төлөө, жишээлбэл терроризм эсвэл зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх гэж гаргадаг бөгөөд тэдгээрийг яваандаа тэс өөр зүйл хэрэглэдэг. Иргэд үнэндээ хөнгөн гэмт үйлдэл байдаг зүйлийн төлөө хүнд хэцүү шийтгэл хүлээж ч болох юм.

Хоёрт нь хуулийг буцааж үл хэрэглэх ёстой. Хуулийг зөвхөн ирээдүйн үйлд л хэрэглэх боломжтой. Үгүй бол хүмүүс үйлдэж байх үед нь бүхэлдээ хуульзүйн дагуухь байсан зүйл үйлдсэнийхээ төлөө мөрдүүлж мөшгүүлэх боломжтой болдог. Дахиад хэлэхэд чөлөөтэй гэж болох нийгэмд ч энэ талаар алдаа гардаг. Жишээлбэл 2008 он Нэгдсэн Хаант Улс^[25]ад өмнө нь байсан тогтоол шийдвэрт тодорхой татвараас зайлсхийх бүдүүвчийг хууль бус гэж нэмэлт оруулан, энэ явдлаараа 3000 хүнийг тэр үедээ ингэх нь хуульзүйн дагуу бус зүйл биш байсан үйлийн төлөө татвар төлөх болгосон байдаг.

22 *natural justice*

23 *humanity*

24 *prosecution*

25 *United Kingdom*

Шударга ёсны гуравдахь ёс журам бол хувь хүмүүсийг нэгэнт энэ байдал мөн л хуулийг зөрчихөөс өөр аргагүй болгох учраас ямар нэг үл биелэх зүйлийг хийлгэхээр шаардах боломжгүй байх явдал юм. Бүр чөлөөтэй гэж хэлдэг улс орон, ялангуяа хуулиуд нь хоорондоо зөрчилддөг улс орон энэхүү шалгуурыг давдаггүй: тиймээс галын дүрэм журамд өмчлөгчийг нь төлөвлөлтийн хуулиар өөрчлөхийг нь хорьсон байшиндаа аюулгүйн гарц байгуулж барихыг шаардаж болох юм – аль ч талаас нь харвал тухайн эзэмшигч хууль зөрчих болдог. Илүү их аюул тарих зүйл бол шударга бус төр засаг үл хэрэгжих хуулийг өрсөлдөгчдөө дарж мөшгөх гэж зориудаар ашиглаж ч болох байдал юм.

Жам ёсны шударга ёсны өөр нэг чухал ёс журам бол *гэмгүй байдлыг эрхэмлэх явдал*^[26] юм. Бүр түүний эсрэг хэрэг нь няцаах боломжгүй мэт харагдаж байж болох ч хэнтэй ч *гэмийг нь батлах* хүртэл гэмтэй хүнтэй хүн шиг харьцах учиргүй. Маш чухал зүйл бол хүмүүс өөрсдөө гэмгүй гэдгээ батлах ёсгүй харин засаг захиргаа тэдний гэмийг батлах ёстой байдаг явдал юм. Энэ байдал төр засаг дайснуудаа зохиомол хэргээр мөрдөж шийтгэх явдлыг улам бүр хэцүү болгодог: хүмүүсийг шийтгэхийн өмнө бүх шийтгэл^[27]ийг нь шүүхэд батлах ёстой ажээ.

Хамгийн сүүлийн чухал зарчим бол шүүгч, шүүх улстөрийн засаг захиргаанаас ангид байх ёстой явдал юм. Хууль гаргадаг болон түүгээр нь хэрэг шүүдэг хүмүүсийн дунд *эрх мэдлийг зааглаж хуваах* хэрэгтэй. Шүүгч зүгээр л улстөрчийн төлөөлөгч байх ёсгүй: шүүгчдийн улстөрийн үзэл бодол тэд хэргийг хэрхэн шийдвэрлэж байгаатай холбоотой байх ч ёсгүй. Хэрэв шүүгч тэдэнд хялбар нөлөөлөх боломжтой эсвэл айлган сүрдүүлэх боломжтой улстөрчтэй ойр дотно байвал тэр үед шүүх тогтолцоо жинхэнэ шударга ёсонд гэхээсээ илүүтэй улстөрийн ашиг сонирхолд л үйлчилдэг болно. Эрх чөлөө-илүү ихтэй нийгэмд шүүгчийг томилдог эсвэл тэднийг бүх насаар нь томилдог тусгай

26 *presumption of innocence*

27 *charge-опос. обвинения*

хороо буюу зөвлөл голдуу байдаг нь улстөрчдөөс шүүгчдэд үзүүлэх дарамт шахалтыг бууруулдаг ажээ.

Хууль ёс^[28]

Хууль ёс гэж юу вэ

Чөлөөт нийгмийг чөлөөт бус нийгмээс хууль ёсноос өөр юу ч ингэж илэрхий ойлгомжтой ялгадаггүй. Хууль ёс бол иргэнийг эзэн хаан, улстөрчийн дур зоргын хүслээр гэхээсээ илүүтэй ойлгомжтой, бүх нийтээр мөрддөг хуулийн зарчм^[29]аар засаглах ёстой гэдэг үзэл санаа юм. Хууль тогтоогч зүгээр л өөрсдийн хүссэнээрээ үйл хийж чадахгүй. Тэдний гаргасан хууль заавал хүнд бүрд, үүн дотроо өөрсдөд нь ч ижил тэгш үйлчилдэг байх ёстой.

Хууль ёсонд хувь хүмүүсийг дур зоргын эрх мэдэл хэрэглэх явдлын золиос болохоос хамгаалах гэсэн зорилго бий. Хэрэв бид төр засагт хүч хэрэглэх монополь эрх өгсөн бол бид энэ хүчийг зөвхөн зориулалтын дагуу, урьдаас таамаглахуйц, хариуцлага хүлээх байдлаар^[30], зарим нэг элитүүдийн төлөө биш харин нийт нийгмийн бүх нийтийн ашиг тусын төлөөх зорилгод зөвхөн хэрэглэх болно гэдгийг бататгах ёстой.

Мөн хууль ёс засаг захиргаанд ажиллаж буй хүмүүс бусад хүн бүрийн адилаар буруу зүйл хийсэн бол ижилхэн эрүүгийн хариуцлага хүлээх болно гэдгийг бататгадаг. Санаа зовмоор олон улс орон өнөөгийн болон хуучны төр засгийн удирдагчдадаа шүүхээр мөрдөн шалгаж болохгүй эрх дархыг батлан өгдөг бөгөөд бас санаа зовмоор олон удирдагч үр дүнд нь шүүхээс зугтсан байдаг. Хэдийгээр олон нийтийн зүтгэлтэн, мөн аливаа бусад хүнийг үндэслэлгүй (эсвэл улстөрийн сэдэлтэй) тарчлааж мөрдөн мөшгөх явдлаас хамгаалах учир шалтгаан байдаг ч гэсэн

28 rule of law

29 clear and general principles of law

30 due accountability

жинхэнэ шударга ёсноос аливаа хүнийг хамгаалах дархан эрх аливаа хүнд олгох ямар ч үндэслэл байдаггүй.

Иймээс л хууль ёс удирдагчдын өөрчлөгдөмхий, дур зоргын шийдвэрт гэхээсээ илүүтэй бүх-нийтээрээ-мөрддөг, урт настай зарчимд үндэслэдэг. Хууль ёс бидэнд хуулийн өмнөх тэгш байдал, хуулийн зохистой арга ажиллагаа^[31], бие даасан шүүх байгууллага, тал тохой үл хардаг шүүх^[32], хабеас корпус (удаан хугацаанд шүүх явцгүйгээр хорихгүй байх)^[33], засаг захиргаанаас ялгаварлан гадуурхагдахгүй байх (жишээлбэл нэг ижил хэрэгт дахин дахин шүүх замаар – хоёр удаа шийтгэл хүлээлгэх гэдэг), гэмгүй байдлыг эрхэмлэх^[34] (жинхэнээсээ нотлох хүртлээ та нартай гэмтэн мэт харьцахгүй байх мэт), хуулийн тодорхой ойлгомжтой байдал, тогтвортой байдал, хэрэгжүүлэхүйц байдал зэрэг зарчмаар дамжуулан бидэнд шударга ёсыг батлан олгодог. Хууль гаргадаг хүмүүс бусад бүх хүмүүстэйгээ адилхан үүрэг хүлээдэг нь маш чухал зүйл. Нийгэм хэрэв зарим хүмүүс хэдий өндөр зэрэгтэй байсан ч үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэггүй бол эрх чөлөөтэй байх боломжгүй.

Хууль ёсыг хамгаалах

Улс орнууд хууль ёсыг засаг захиргаанд байгаа хүмүүс ганхуулж сулруулахаас сэргийлэхийн тулд янз бүрийн арга зам хэрэглэдэг. Эдгээр аргад бичмэл үндсэн хууль, нийтийн хууль^[35] болон

31 *due process of law*

32 *blind justice*

33 *habeas corpus*-Үндсэн хуульд заадаг, хуульгүйгээр, тодорхойгүйгээр шоронд хоригдохоос хамгаалдаг суурь эрх. Латинаар “надад биеийг нь харуул” гэсэн утгатай ажээ. *Habeas corpus* нь түүхэндээ гүйцэтгэх дур зоргын эрх мэдлээс хувь хүний эрх чөлөөг хамгаалах чухал арга хэрэгсэл байсаар ирсэн.

34 *presumption of innocence*

35 *common law*

жишээ хэрэг дээр бүрэлдэж тогтсон шүүх үйл ажиллагаа^[36], жам ёсны шударга ёсонд үндэс сууриараа үнэнч байх явдал ордог.

Бичмэл үндсэн хууль хууль ёсонд бат бөх байдал өгөх чадалтай. Гэвч ийм үндсэн хуулийг тухайн шинэ улс байгуулагдаж төрж буй үед, иргэд нь анх удаа хамтдаа хурахаар ирэх үед бүтээх нь элитүүд болон шунахай ашиг сонирхлын бүлэг^[37] нь эрх мэдлээс зууралдаж, аливаа шинэ үндсэн хуулийг өөрийн ашиг тусын төлөө гажуудуулах магадлалтай байдаг, бие гүйцэн эрийн цээнд хүрсэн улсаас хамаагүй хялбар байдаг.

Мөн хууль ёсыг шүүхэд олон янзын хэрэг авчирч хэлэлцсэнээс хурж цугларсан олон жилийн хугацааны жишээ хэргүүд^[38]ээр дэмжиж бэхжүүлэх боломжтой. Хувь хүмүүс хууль тогтоогч болон албан тушаалтны дүрэм журмыг эсэргүүцэх, шүүхэд түүнийх нь шударга байдал болон хуульзүйн дагуух байдлыг нь шалгуулах боломжтой. Аажимдаа [төр засгийн] албан ёсны эрх мэдлийн хязгаарыг жишээ хэргийн хүрээгээр зурж гаргах болно.

Хууль ёсыг бэхжүүлж сайжруулах гуравдахь арга зам бол шударга ёсны ёс журам болон нийгмийн эв зохицол суурилдаг зарчмын талаархи хэлэлцүүлэг мэтгэлцээнийг дэмжих явдал юм. Хэрэв үг хэлэх эрх чөлөө давамгайлдаг бол, эдгээр үзэл санааг хүн бүр хэлэлцдэг бол засаг захиргааны хувьд эдгээр үзэл санааны ойлголтыг өөрт ашигтайгаар эргүүлэх хувиргах хамаагүй их хэцүү байх болно.

Хууль ёсны талаархи хэлэлцүүлгээс гардаг нэг чухал үзэл санаа бол хэрэв хүмүүс анх удаа хамтаараа цуглаж ямар зарчимд тэд захирагдах ёстойгоо шийдэхээр ирсэн бол тэдний хэн нь ч хулгай эсвэл хүчирхийллийн төлөөх шийтгэлээс бусдаар өөр хүмүүсийн албадлагад өртөж хүчинд автахгүй байх саналтай байх байсан явдал юм – үүнийгээ өөрсдийнх нь урт-хугацааны ашиг сонирхол байсаар ирсэн гэж тэд ойлгох болно. Тиймээс

36 *judicial process built on common law and precedent*

37 *vested interest*

38 *precedent*

бүх чөлөөт нийгэм албадлагыг хязгаарладаг, тодорхой нэг бүлэг хүн бусдыгаа ашиглаж мөлжих явдлаас сэргийлдэг нийтээр-дагадаг ёс журамд тулгуурлах ёстой гэж бид үндэстэй таамаглаж төсөөлж чадна.

Шударга ёсыг хэрэгжүүлэх^[39]

Хууль ёсыг хамгаалахаар ямар ч ерөнхий замыг сонгож авсан ч бай түүнд мэдээжээр туслах зарим нэг тусгай арга хэмжээнүүд бий.

Шүүгчид бие хүн талаасаа, мөн улстөрийн талаасаа бие даасан байх ёстой. Үгүй бол шүүх тогтолцоог үл хүндлэх бөгөөд шударга ёсны нэрийн дор асар их шударга бус байдлыг үйлдэх болно. Олон улс^[40]ад шүүгчид бага цалинтай, хариуцлага үл хүлээдэг, муу хяналттай байдаг^[41]: тиймээс тэд хэргийг хууль гэхээсээ илүүтэй авилгаар шийддэг. Үүний оронд шүүгч зохих ёсны цалинтай, иймэрхүү авилга хэрэгцээгүй бас түүнийг үл хүлцэн тэвчдэг байхын тулд байнга л нарийн хяналтад ордог байх ёстой.

Шүүхийн тогтолцоо^[42]г мөн шүүхийн ажлыг удирдан явуулах байдал^[43]аар дэмждэг байх хэрэгтэй. Олон улсад жижиг маргаан шүүхэд очихоос өмнө хэдэн сар эсвэл бүр хэдэн жил ч болох боломжтой байдаг. Учир нь энэ нь түүнд оролцож буй захиргаадалтын асар их ажил, албан тушаалтнуудын тухайн хэргийг удирдаж явуулах санаачилгагүй байдлаас болдог ажээ. Жишээ хэрэг дээр үндэслэсэн хуульзүйн тогтолцоо^[44]нд өмнөх хэрэг болон шүүсэн шүүхийн шийдвэрийг хурдтай олж үзэх хэрэгтэй байдаг бөгөөд хуучны жишээ хэргийн бүртгэл байхгүй

39 *The Administration of Justice.*

40 *In many countries-энэ нь international буюу олон-улсын гэдгээс ондоо*

41 *unaccountable and poorly monitored*

42 *justice system*

43 *court administration*

44 *legal system*

учраас л одоогийн хэргийг шүүхэд зүгээр хий дэмий байлгахгүй гэж хэрэг нээдэггүй.

Олон улсад цагдаа шийдэл гэхээсээ илүүтэй зовлонгийн нэг хэсэг болсон байдаг. Баривчлах, хорих эрх мэдлээсээ болж цагдаа нар хүмүүсийг асар их шударга бус байдалд оруулах боломжтой, мөн хээл хахууль зэргээр дамжуулан ашиг тус өөртөө олох боломжтой. Цагдаагийн офицер жинхэнэ эсвэл зохиомол замын хөдөлгөөний жижиг гэмт үйлдлийн төлөө жижиг “торгууль” оноож буй явдал бол үүний шинж тэмдэг юм. Энэ байдал нь давамгайлж буй соёлын нэг хэсэг болдог – гэвч нэгэнт авилгын энэ зарчмыг хүлээн зөвшөөрчихвөл үүнээс муу зүйлээс сэргийлэх ямар ч ёс журам гэж үгүй болно. Цагдааг тэдний эсрэг гомдлоор мөрдөж шалгадаг, арга хэмжээ авдаг бие даасан агентлагаас сайтар сургаж бэлтгэдэг, хянаж шалгадаг байх хэрэгтэй.

Үүний адилаар захиргаадалтын албан тушаалтнуудыг улстөрийн танил талаар нь биш гавьяа зүтгэлээр нь томилох ёстой. Тэр хүмүүст зөв зүйтэй хариуцлага хүлээлгэдэг байх ёстой. Улстөрийн эсвэл хувийн ашиг тусын төлөө шийдвэр гаргавал шийтгэдэг байх ёстой.

Хэрэв шударга ёс болон хууль ёс давамгайлдаг байлгахыг хүсвэл сонгуулийг үнэн зөв шударгаар өрсөлдүүлэн явуулах ёстой. Засаг захиргааг шүүмжилдэг нэр дэвшигчид өөрсдийнхөө үзэл бодлыг хамгаалах, түүнийгээ түгээх боломжтой байхын тулд тэнд бас үг хэлэх эрх чөлөө байх ёстой. Мөн нууцаар санал өгдөг, бас сонгуулийн тойрг^[45]ийг үнэн зөв шударгаар зурж тогтоох, сонгууль үнэнчээр явуулах явдл^[46]ыг бататгадаг жинхэнээсээ бие даасан сонгуулийн хороо ажилладаг байх ёстой.

Шударга ёс болон эдийн засгийн хөгжил цэцэглэлт

45 *electoral boundaries*

46 *drawn fairly and elections are conducted honestly*

Хууль ёс нийгмийн хувьд чухал байдгийн адилаар эдийн засгийн хувьд ч чухал. Жил бүр Дэлхийн Банк улсуудыг бизнес эрхлэх хялбар байдлаар нь эрэмбэлдэг. Гадаадаас бизнес болон хөрөнгө оруулалт татаж авч, дотооддоо хүмүүс арилжаа наймаа хийхийг хялбар болгох явдал хүн амын эдийн засгийн хөгжил дэвшил болон хөгжил цэцэглэлтэд мэдээжээр чухал хүчин зүйл байдаг. Энэ индексээс татвар болон тогтоол шийдвэрийн ил тод байдал, албан тушаалтнуудын авилгын төвшин, хүмүүс бизнесээ эхлэх, өмчөө бүртгүүлэх, хил дамнан худалдаа хийх, төлбөрийн чадваргүй болох явдлыг шийдвэрлэх^[47] зэргийг хийхэд хэр хялбар байна гэдгийг хардаг.

Эдийн засгийн хувьд эрх чөлөө-маш ихтэй (гэвч нийгмийн хувьд хамаагүй бага эрх чөлөөтэй) Сингапур долоон жилийн туршид дэлхийн хэмжээний энэ эрэмбийг тэргүүлж, харьцангуй эрх чөлөөтэй Хонгконг, Шинэ Зиланд, Дани, Нэгдсэн Хаант Улс, Америкийн Нэгдсэн Улс араас нь жагсжээ. Дараагаар нь эдийн засгийн хувьд чөлөөтэй ч нийгмийн хувьд илүүтэй хязгаарлагдмал улс болох Бүгд Найрамдах Солонгос улс зогсоно. Энэ жагсаалтын ёроолд нь шударга ёс, хууль ёс атаархахааргүй сул байдаг зарим улс Конго, Венесуэл, Зимбабве, Ирак, Камерун, Болив, Узбекистан бий.

Хууль ёсонд учирдаг аюул занал

Олон улсад, ялангуяа хөгжиж буй улсад шүүхийн янз бүрийн тогтолцоо давамгайлдаг. Төрийн-төвшний хууль болон шүүхийн тогтолцоон дээр нэмээд тэнд голдуу орон нутгийн отог овгийн, эсвэл шашны хуульзүйн тогтолцоо^[48], мөн хувь хүмүүсийн хоорондох хувийн эсвэл гэрээний хууль бий.

Төрийн тогтолцоонд авилгал илүү их байх магадлалтай. Хуульзүйн орон нутгийн, шашны, хувийн тогтолцоо^[49] голдуу

47 deal with insolvencies

48 legal system

49 private legal systems

жам ёсны шударга ёсонд илүү гүн суурилсан байдаг тул тэдгээр нь шударга ёсыг илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүнээс ялгаатай нь төрийн тогтолцоог голдуу шилжин суурьшсан эсвэл эзлэн түрэмгийлсэн улс гүрн^[50]үүд тулгаж хэрэглүүлсэн байдаг. Эдгээр тогтолцоог хэзээ ч тийм ихээр хүлээн зөвшөөрч байгаагүй байж болох ч тэдгээрийн эрх мэдэл болон ивээл өмгөөллийг ашиглах авилгажсан хүмүүс хэзээд бэлэн байна.

Төр засаг болон төрийн шүүх байгууллагад байдаг хүмүүс голдуу төрийн эрх мэдлээ өөртөө ашиглах явдлыг буруу зүйл гэж ойлгодоггүй. Цэрэг, цагдаа, албан тушаалтнууд авилгал авдаг. Улстөрчдийг орон нутгийнхаа хүмүүс эсвэл өөрийнхөө ашиг тусын төлөө хамгийн ихээр төрөөс хулгай хийдэг гэж боддог. Бас хувь хүний амьдралд буруу гэж үздэг зүйлийг олон нийтийн хүрээнд ч гэсэн мөн буруу гэж үзэх хэрэгтэй.

Аялал жуулчлал болон харилцаа холбоо хэцүү байдаг газарт, мөн орон нутгийн асуудал бэрхшээлийг илүү яаралтай шийдвэрлэх эсвэл хамгийн чухал байдаг газарт [шүүхийн] холимог тогтолцоотой байх нь зөв байж болно. Гэвч шүүхийн бүх тогтолцооны хувьд зорилго нь орон нутгийн хуулийн нэр хүнд болон санал нэгдсэн байдал, төрийн хуулийн ил тод байдал болон зарчим, хууль ёс тал тохой татдаггүй байх явдал^[51] байх ёстой.

Хүмүүний эрх

Хүмүүний эрхийг тодорхойлох

Шударга ёсны талаархи иймэрхүү бодрол эргэцүүлээс хүмүүний эрхийн үзэл санаа үүсэж гарчээ.^[52] Энэ бол хүмүүнлэг чанарын үнэ цэнээр^[53]ээ хүн суурь эрх чөлөөтэй байдаг гэсэн үзэл санаа

50 colonial or occupying powers

51 objectivity of the rule of law-объектив байх явдал

52 Энэ санааг дараахь бүтээлээс дэлгэрүүлж үзнэ үү: Nigel Ashford, *Principles for a Free Society*, Jarl Hjalmarson Foundation, Stockholm, 2003.-БАТЛЕП

53 virtue of their humanity

юм – жам ёсны хуулийн адилаар нийгэм жигд саадгүй ажиллах явдлыг эрх тэтгэдэг боловч эрх бол универсал (ертөнцийн хаана ч хүн бүрд хэрэглэдэг), хүнээс салшгүй^[54] (эдгээрийг бусдад өгөх, эсвэл бусдад эдлүүлэхээс татгалзах боломжгүй) гэж тусгайлан хүлээн зөвшөөрдөг зүйл юм.

Эдгээр хүмүүний ‘эрх’-ийг хүмүүний *эрх чөлөө* гэж нэрлэвэл илүү дээр байх сан. Эдгээрт өмч өмчлөх, өөрийгөө-илэрхийлэх, өөрийн бие болон хүч хөдөлмөрөө өөрөө мэдэх, сонгосон газраа амьдрах, өөрийн шашнаа шүтэх эрх чөлөө зэрэг эрх чөлөө ордог. Тэдгээр эрхийн нөлөөгөөр төр хүмүүстэй хэрхэн харьцах боломжтой талаархи хязгаар гарна.

Харамсалтай нь “хүмүүний эрх”-ийг голдуу улстөрийн бүтэц, эсвэл нийгмийн болон соёлын хэм хэмжээгээр олгодог, хуульзүйн эрх^[55]тэй хольж будлидаг. Гэвч хуулиар ажилчинд цалинтай амралт олгох нь жишээлбэл хүмүүний эрх биш юм. Учир нь түүнийг универсал байдлаар хэрэглэдэггүй. Тэдгээрийг зөвхөн ажилчинд л хэрэглэдэг, мөн зөвхөн иймэрхүү тансаглалыг хэрэгжүүлэх боломжтой тийм улсад л зөвхөн хэрэглэдэг. Тэдгээрээс *татгалзах* боломжтой – ажилчин ямар нэг эрх чөлөөгөө алдахгүйгээр мөнгөний төлөө амралтаасаа татгалзах боломжтой. Үүнтэй адилаар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тэгш цалингийн тухай хууль хүмүүний эрх биш. Учир нь энэ бол хүмүүний эрх чөлөөний тухай шаардлага биш харин ажил олгогчид тавих албадсан шаардлага юм.

Бүлэг хүний эрх бол бас л хүмүүний эрх биш. Тэдгээрийг универсал байдлаар ашигладаггүй. Тусгайлан халамжлах хандлага, жишээлбэл Америкийн уугуул иргэдэд өгч буй ийм хандлага бол цэвэр хуульзүйн давуу эрх^[56] юм: бусад хүмүүс үүнийг эдэлдэггүй. Зарим зүйл хэрэв энэ нь хүмүүсийн хүмүүнлэг

54 *inalienable*

55 *legal rights*

56 *legal privileges*

чанар^[57]т нь анхаарлаа хандуулаагүй харин зарим нэг тусгай бүлгийн гишүүн болохынх нь хувьд тэнд анхаарал тавьсан бол “хүмүүн”-ий эрх байх боломжгүй.

Эрх чөлөө, эрх, үүрэг

Иймэрхүү асуудал тов тодорхой байх нь чухал. Хүмүүний эрхийг нийгмийн хэм хэмжээ, хуульзүйн давуу эрхтэй хольж хутгах нь хуульзүйн давуу эрхэд зохиомол эрх дарх өгдөг бөгөөд энэ нь хүмүүний эрхийн үзэл санааг ганхуулж сулруулдаг. Зарим зүйл, жишээлбэл ижил цалин, цалинтай амралт, эсвэл бүр зарим нэг тахир дутуу бүлгийг тусгайлан хүлээн зөвшөөрөх явдал^[58] хүсүүштэй зүйл байж болох ч үнэндээ хүсүүштэй зүйл болгон хүмүүний эрх байдаггүй.

Хүмүүний “эрх” бидний эрх чөлөөг баталгаажуулдаг – тэдгээр эрхээр бусад хэн нэгэнд хүчилсэн албадлагын шаардлага тавьдаггүй. Жишээлбэл үг хэлэх эрх чөлөө^[59] бусад хэн нэгэнд үүнийг хүндлэхээс өөр үүрэг эсвэл хариуцлагаас ондоо үүрэг эсвэл хариуцлага ногдуулдаггүй. Хэн ч та нарт та нарын үзэл бодлыг өргөн нэвтрүүлгээр цацах, бас та нарыг жинхэнээсээ чөлөөтэй ярих боломжид туслахаар, мөн та нарын хэлж ярьж буй зүйлийг тань чөлөөтэй сонсох явдалд туслахаар сонины булан эсвэл радиогийн нэвтрүүлэг өгөх ёстой гэдгийг шаарддаггүй.

Үүнээс ялгаатай нь Нэгдсэн Үндэстний Хүмүүний Эрхийн Тунхаглалд чөлөөтэй боловсрол эзэмших явдлын “эрх”-ийг жагсаан бичсэн байдаг. Гэвч боловсрол чөлөөтэй эзэмших явдал бол бусад хүмүүсийг үүнийг нь төлөх үүрэг ногдуулсныг дам илэрхийлдэг учраас хүмүүний эрх биш. Боловсрол олгоход цаг хугацаа, хүч хөдөлмөр, мөнгө гээд зардал бүгд ордог. Жинхэнэ чөлөөт нийгэмд хэн ч үнэгүй боловсрол олж авах эрхтэй байж түүнийг эдлэхгүй. Учир нь энэ явдал бусад хүмүүст

57 *humanity*

58 *special recognition of some disadvantaged group*

59 *Freedom of speech*

нөөц баялгаараа эдгээр зардлыг хангах үүрэг ногдуулдаг ажээ. (Мэдээжээр олон хүн энэ зардлыг хуваалцахыг хүсдэг байх боломжтой: гэвч чөлөөт нийгэмд ингэ гэж албадах боломжгүй)

Байнга л хүмүүс бусдад оногдуулж буй үүргийг дурдахгүйгээр, эсвэл бүр түүнийг нь таньж мэдэлгүйгээр эрхийн тухай ярьдаг. Энэ үүрэг бол бусад оногдуулсан үүрэг бөгөөд түүнийг албадан хэрэгжүүлэхэд хүч шаардлагатай. Иймэрхүү албадлага өргөн хүрээтэй хохирол гэм учруулдаг.

Дахиад нэг удаа хэлэхэд чөлөөт нийгэмд халамж авах эрх гэж зүйл байдаггүй: хүмүүсийн цор ганц үүрэг бол бусдыг үл хохироох явдал байсаар хүртэл халамж бусад хүмүүс нь нөгөөдүүлээ дэмжих үүрэг хүлээнэ гэдгийг дам харуулдаг. Гэвч энэ байдал ийм нийгэмд ядуу эсвэл тахир дутуу хүмүүс халамжлах соёлтой^[60] газраас илүү муу амьдардаг гэсэн үг биш. Халамж олгох татварын зардал ажил эрхлэх болон аж ахуй явуулах явдлыг тэтгэхгүй байх боломжтой бөгөөд нийт нийгмийг улам ядууруулдаг. Халамжийн тусламж бусдаас хамааралтай байдл^[61]ыг тэтгэдэг байж болно. Баян, чөлөөтэй нийгэмд сайн санааны байгууллага хэрэгцээ туслалцаа хэрэгтэй хүмүүст төр засгийн захиргаадалтын агентлагаас илүү сайн туслах боломжтой билээ.

60 a welfare culture

61 dependency

7 ӨӨРӨӨ-БҮРЭЛДДЭГ НИЙГЭМ

Тушаалаар тогтоодоггүй дэг журам

Чөлөөт нийгэм данхар төргүйгээр өөрийгөө аваад явах боломжтой. Хэдий сонин содон сонсогдож байж болох ч гэлээ хүмүүний амьдралд үүний жишээ элбэг байдаг. Америкийн эдийн засагч Дэниэл Б. Клайн ажигласанчлан та нар гуталдаа дугуй уясан ч дуулга малгайгүй, өвдөгний хамгаалалтгүй эсвэл гулгах ч туршлагагүй ч бүгдээрээ багачуулаас авахуулаад хөгшчүүд хүрсэн хэдэн зуун хүн дугуйт тэшүүрээр өөр өөр хурдтайгаар хатуу шалан дээгүүр нь тойрч гулгацгаах үед тэр гулсах талбай дээр ээлж дараалан ямар нэг байдлаар хоорондоо мөргөлдөх зүйл гарах болно гэж бодож байж болох юм. Гэвч үнэндээ дугуйт тэшүүрээр-гулгагчид энэхүү гулгах талбайгаар тойрон явахдаа бусдаасаа зайтай явж, ямар ч эргэх дохио эсвэл зогсох тэмдгийн хэрэгцээгүйгээр тэшиж чаддаг.^[1] Ямар нэг төлөвлөгч эсвэл бодлого гаргагч байгууллага тэр хүмүүст хаана, хэр хурдтай тэшиж гулгахыг нь хэлж өгөх шаардлага алга. Нэг бүр нь өөрөө өөрийгөө хичээн явж, дээр нь бусдааа бүгдээрээ бага зэрэг эелдэг зан гаргангаа бүгдээрээ хоорондоо мөргөлдөхгүйгээр зугаацаж хөгжилдөх гэсэн харилцан-тустай ашиг сонирхлоо гүйцэлдүүлцгээдэг.

Хэдийгээр ямар нэг засаг захиргаа ухамсартайгаар зохиомжилж бүтээгээгүй ч хүмүүний хэл яриа маш эмх цэгцтэй дотоод бүтэцтэй, маш ач тустай зүйл байдаг явдал бол үүнээс илүү гайхалтай зүйл билээ. Хэл яриа нэвтрэлцдэг хэлзүйн дүрэм бидэнд нэг нэгнээ ойлгох боломж олгосон, бас олгож ирсэн

1 Daniel B. Klein, 'Rinkonomics: A window on spontaneous order', *Online Library of Liberty (Articles)*, 2006.-БАТЛЕР

учраас хэдэн зуун дамнан өөрөө жам ёсоороо үүсэж хөгжсөн байдаг. Би эдгээр ёс журмыг хэдий энэ нь үл анзаарагдах, нарийн нийлмэл байсан ч гэсэн, мөн бид тэднийг бичиж буулгахад хэцүү байсан ч гэсэн дагаж мөрддөг. Ямар ч төр засгийн хороо ийм нарийн нийлмэл, үл анзаарагдам, маш үр дүнтэй ёс журмыг хэзээ ч бүтээж чадахгүй. Хэл яриа бидний хамтаар мөрөөрөө үүсэж хөгжсөн билээ.

Хүмүүний нийгмийн олон хэсэг үүнтэй адилхан байдлаар ажилладаг. Албан тушаалтнуудаар хэрхэн үйл хөдлөл хийхээ заалгах хэрэгцээгүйгээр бид бидэнтэй хамт бидний хүрээлэн байгаа орчинтой цуг үүсэж хөгжсөн хэдэн суурь ёс журмыг дагах байдлаар дэг журамтай, байнга давтагддаг, урьдаас таамаглахуйц арга замаар үйл хийдэг. Эдгээр зарчмыг дагаж мөрдсөнөөр бид асар өргөн хэмжээтэй, асар их ач тустай нийгмийн дэг журмыг бүтээжээ. Жишээлбэл бидэнд хамтдаа эв найртайгаар арилжаа наймаа хийх боломж олгодог энэ энгийн ёс журмаас нийт дэлхийгээрээ хамтран ажиллаж буй олон-улсын зах зээлийн эдийн засаг үүсжээ.

Ёс журам-удирддаг нийгэм

Чөлөөт нийгмийн хүн-хоорондын ёс журам^[2] бидэнд төр засаг-хянадаг нийгэмд бидэнд байхаас хамаагүй илүү их үйл хийх өргөн талбар олгодог. Чөлөөт хувь хүмүүс тусгайлан хориглоогүй олон зүйлийн алийг нь ч хийх боломжтой бөгөөд засаг захиргаа тусгайлан зөвшөөрдөг хэдхэн зүйлээр энэ нь хязгаарлагддаггүй. Энэ байдал нь чөлөөт нийгэм тушаал шийдвэр хүлээдэг гэхээсээ илүүтэй илүү уян хатан, дасан зохицомтгой, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд хялбархан хариу үзүүлдэг гэсэн үг юм.

Зах зээлийн өмчлөл болон өмчийн ёс журам зэрэг эдгээр ёс журам юу ажилладаг, юу ажилладаггүй болох тухай олон жилийн туршид олж нээсэн цэцэн ухааны төрлийг өөртөө шингээсэн байдаг. Нөхцөл байдлын өөрчлөлтөд эдгээр нь

2 *interpersonal rules*

дасан зохицож, өөрчлөгддөг бөгөөд энэ нь олон зуун жилийн хугацаанд хүмүүсийн сая сая харилцаанаас гарсан алдаж онох явдлын туршлагыг илэрхийлж байдаг. Эдгээр ёс журамд бусад хүмүүстэй хэрхэн харьцах тухай үйл хөдлөлийн хэм хэмжээ^[3], жам ёсны хуулийг бичгээр илэрхийлэх гэсэн оролдлого болох хуульзүйн хэм хэмжээ^[4], туршсан маш олон хэргийн шийдвэрээс бүрдэж бүтсэн нийтийн хууль^[5] багтдаг.

Ёс журам-удирддаг, өөрөө-бүрэлддэг нийгэм илүү бүтээлч, илүү дасан зохицомтгой байгаад зөвхөн зогсдоггүй; энэ нь төвөөс удирддаг нийгмээс хамаагүй илүү нийлмэл байх боломжтой. Хэл ярианы адилаар одоо ч гэсэн сайн ажилласаар буй түүний бүх ёс журмыг бидний хэн ч дүрсэлж тодорхойлж чадахааргүй маш нарийн нийлмэл энэ нийгэм байх боломжтой. Зарим нэг засаг захиргааны тушаалд тулгуурласан нийгэм гарцаагүй хэмжээ болон байр байдлаараа, засаг захиргаанд байгаа хэдэн хүний ухаан тоймлож багцаалж чадах хэмжээгээр хязгаарлагдмал байдаг. Гэвч маш өргөн, маш гүн цэцэнд ухаанд суурилдаг ёс журамд тулгуурласан нийгэм хэдэн зуун мянган жилийн туршид сая сая хүмүүний харилцааны үр дүнд үүсэж бүрэлджээ. Төвлөрсөн байдлаар удирддаг нийгэм хэдхэн хүний хязгаарлагдмал цэцэн ухаанд тулгуурладаг; ёс журмаар-удирддаг нийгэм хэдэн зуун мянга дахин олон цэцэн ухааныг өөртөө агуулж байдаг.

Үүнээс үүдэн нийгэм болон эдийн засгийн өдөр тутмын харилцаанаас илүү сайн, илүү ухаалгаар нийгэм эсвэл эдийн засгийг төлөвлөж чадна гэсэн алдаа төр засгийн байгууллага буюу засаг захиргаанаас голчлон гардаг. Энэ ёс журмын нийлмэл тогтолцоонд агуулагддаг цэцэн ухааныг хаяж гээн, уг тогтолцоог гажуудуулснаар [засаг захиргаанд буй] тэр хүмүүс юмс үзэгдлийг гарцаагүй илүү муу болгоно.

3 *behavioural norms*

4 *legal norms*

5 *common law*

Сарниж тархсан мэдлэг, эрх мэдэл

Өөрөө-бүрэлддэг, ёс журам-удирддаг нийгмийн төрөлхи цэцэн ухаан ямар нэг төвд оршдоггүй. Энэ цэцэн ухаан өдөр тутмынхаа амьдралаа авч яваа сая сая хувь хүмүүст бий. Нэгэнт эрх мэдэл сарниж тархсан байх тул тэр хувь хүмүүс амьдралаа авч явах үеэрээ өөрийн, жижиг хэмжээтэй туршилтаа хийх боломжтой. Тэд, тэр хүмүүс хэнд ч аюул занал учруулалгүйгээр өөрсдөө эрсдэлд хүлээж, боломж эрэлхийлэх боломжтой байдаг. Гэвч тэр эрсдэл нь үр ашгаа өгч тэр зүйл нь бүтвэл хүн бүр түүнийг хүлээн авах, ашиг тусыг нь хүртэх бэлэн зүйл болно. Юм турших, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицохыг тэтгэдэг энэ байдал өөрчлөлтийн ертөнцөд асар их амжилтад хүрэх боломж өөрөө-бүрэлддэг нийгэмд олгодог. Үүнээс ялгаатай нь төр засгийн засаг захиргаа хүн бүрийн өмнөөс шийдвэр гаргадаг тул, мөн хүн бүрийн амьдрал, аз жаргалыг эрсдэлд оруулна. Тиймээс ийм засаг захиргаа чөлөөт хувь хүмүүсээс илүүтэй илүү консерватив байдлаар үйл хийдэг – эсвэл асар том алдаа хийх эрсдэлтэй байдалд оршдог. Үр дүнд нь чөлөөт бус нийгэм илүү удаан дасан зохицож, амжилт багатай байна.

Мэдээж өөрөө-бүрэлддэг нийгэм болон эдийн засаг хэзээ ч төгс байх боломжгүй. Эдгээр зүйл бол (хүмүүний төлөвлөсөн бодлын үр дүн биш ч гэлээ) хүмүүний үйлийн үр дагавар бөгөөд хүмүүн төрөлтөн хэзээ ч төгс биш байдаг. Жишээлбэл бид ирээдүйг таамаглаж чадахгүй тул ирээдүйд дасан зохицохыг оролдохдоо алдаа гаргадаг. Бидний нэг бүрийн мэддэг эзэмшдэг мэдээлэл гарцаагүй хэсэгчилсэн, тухайн хэсгийн тухай мэдээлэл байдаг. Гэвч хүмүүний чөлөөтэй харилцааны ертөнцөд энэхүү хэсэгчилсэн, тухайн хэсгийн мэдээлэл л гайхалтай ухаалаг, дасан зохицомтгой нийгэм болон эдийн засгийг урагшлуулж хөдөлгөж байдаг билээ.

Чөлөөт нийгэмд хүмүүс бусад хүмүүстэй өөрсдөө хэрхэн дасан зохицохоо хамгийн сайн мэддэг – тэр бусад хүмүүс нь эргээд хүн бүрийн үйлдэлд дасан зохицох гэж оролдож

байдаг. Хүн бүр олон гарцын аль нэгээр гарахаар явж буй эсвэл тодорхой чиглэлийн галт-тэргэнд суух гэж явахаар олон олон орох хаалга руу явж орж буй хөл хөдөлгөөн ихтэй төмөрзамын буудалтай энэ нийгэм их төстэй. Тэд бүгдээрээ л хэдийгээр явах зам нь ерөөсөө шулуун биш байсан ч хаашаа явахаа хараачилж түүгээрээ явцгаана. Бүгдээрээ л тэдэнтэй адилхан ийшээ тийшээ явахаар хичээж буй бусад бүх хүмүүсийн ар урдуур нь тэдний замд бусад хүн хөндөлсөн орж ирэхэд тойрч гарах болно. Энэ байдал эмх замбараагүй мэт харагдах ч гэлээ үнэндээ хүн бүр ямар нэг зөрчилдөөнгүйгээр зорьсон газраа хүрцгээдэг. Хэрэв ямар нэг засаг захиргаа тухайн галт-тэрэгний буудалд буй хэдэн зуун эсвэл хэдэн мянган хүмүүст яг хаашаа, яг хаагуур явахыг зааж хэлэх болбол тэр хүмүүс зорьсон хаа нэг газраа очих хүртлээ хэдэн цаг ч эсвэл хэдэн өдөр ч болж болно. Энэ явдал төвлөрсөн байдлаар шийдвэрлэхэд хэт нарийн нийлмэл зүйл ажээ. Гэвч өөрөө-бүрэлддэг нийгэмд үүнийг хялбархнаар, гэхдээ тухайн агшин бүрд нь шийдвэрлэдэг.

Хүлцэхүй

Хүлцэхүйн утга учир

Энэ байдлаар чөлөөт нийгмийн хүмүүс бусад хүмүүсийн үйлдэлтэй дасан зохицох ёстой болдог. Хүмүүс нэгэн нэгэнтэйгээ харьцахад хүлцэж тэвчих явдал маш чухал – энэ хүлцэхүйд үйлдэл болон амьдралын хэвмаягтай нь санал нийлэхгүй эсвэл бүр цочирдмоор хүмүүстэй харьцах явдал орно.

Чөлөөт нийгэмд бид хэн нэгэн хүнийг ямар нэг зүйлийг хийхийг нь бидэнд энэ нь таалагдахгүй байгаа учраас л зогсоох хориглох боломжгүй. Бид хэрэв тэдний үйлдэл бусдад хохирол гэмтэл учруулж буй бол эсвэл учруулах магадлалтай бол л хөндлөнгөөс оролцох боломжтой. Жон Стюарт Милл биет буюу бодит хохирол^[6] гэж үүнийг хэлсэн байдаг. Хэрэв гайхширч цочирдох, ёс суртахууны хувьд зэвүүцэх, эсвэл дургүй хүрэх

6 *physical harm*

зэргийг ‘хохироох гэмтээх явдал’-д багтаавал үйл нэг бүрийг хориглох боломжтой болж, энэ үед ерөөсөө ямар ч эрх чөлөө байхгүй болно. Аливаа тохиолдолд тухайн үйл хөдлөлийг нь хориглож зогсоохыг хүсэж буй ёс суртахууны эгдүүцэл нь зан үйлээ хийхээ хориулж, эрх чөлөөгөө хумиулж, эгдүүцэж бухимдаж буй тэр хүмүүсийн ёс суртахууны эгдүүцэлтэй тэнцүү байх болно. Тал нэг бүр нь хэр олуулаа эсвэл хэр их сэтгэл хөдлөлтэй байх боломжтой эсэхээс үл хамаарч тэдний алийг нь зөв гэж шийдэх объектив буюу хүнээс үл хамаарсан ямар ч шийдэл байхгүй ч байж болно. Нэгэнт л чөлөөт нийгэм маргааныг хүчээр шийдвэрлэхийг зөвшөөрдөггүй учраас тул маргааны тал нэг бүр нь бусдынхаа үзэл бодол, үйл хөдлөл, амьдралын хэвмаягийг зүгээр л хүлцэх хэрэгтэй болдог.

Энэ байдал бол ёс суртахууныг үл тоох^[7]той адилхан зүйл биш. Хүүхдийн муу зан авирыг засахыг оролддоггүй байсан эцэг эх хүлцэхүйн зарчмаар үйл хийж буй биш харин хүүхдийн ёс суртахууны боловсролыг үл тоож буй явдал юм. Хэрэв насанд хүрсэн хүмүүс бидний цочирдмоор гэж үздэг байдлаар биеэ авч явбал хэдийгээр ингэ тэг гэж албадахгүй ч гэлээ бид энэ нь цочирдмоор зүйл гэж хэлэх, үйлээ өөрөөр хий гэж ятгах нь буруу зүйл биш.

Бас хүлцэхүй нь ёс суртахууны релятивизм^[8]тэй адилхан байдаг – энэ үзэл санаанд хүмүүс ёс суртахуунт байдлын талаар санал нийлдэггүй, тэдгээрийн дундаас сонгох объектив арга зам байдаггүй учраас бүх ёс суртахуунт байдал ижил тэнцүү хүчинтэй гэж үздэг. Бид бидний ёс суртахууны эсвэл шашны үйл хийх ёс бусад хүмүүсийнхээс илүү сайн гэж итгэх бүрэн эрхтэй – гэвч бид өөрсдийн үзэл санаагаа бусад хэн нэгэнд хүчээр тулгаж хүчлэх эрхгүй.

7 *moral indifference*

8 *moral relativism*-релятивизм гэдэг нь бүх зүйл ижилхэн зөв үздэг үзэл.

Хүлцэхүй, нийгмийн нэгэн жигд бус байдал^{9]}, сонголт

Хүн ам улам бүр л нэгэн жигд бус хэвшинжтэй болоход бусдыг хүлцэн тэвчих явдал хэцүү болж болох юм. Олон-улс-дамнасан аялал^{10]} илүү хялбар байх, цагаачлалын саад тотгор буурч буй байдал, даяаршиж буй эдийн засаг бол зарим улс орны хүн ам яагаад хэдхэн арван жилийн өмнөхөөсөө хамаагүй илүү олон янз байдалтай болсны зөвхөн хэдэн шалтгаан билээ.

Зарим хүмүүс сонголт улам их байх нь ондоо ондоо арьстан, соёл, үндэстэн, хэлний бүлэг эсвэл шашны бүлгийг улам илүү их салангид тусгаар болгож, хурцадмал байдлыг өсгөж, хүлцэхүйг ганхуулах явдал руу хүргэнэ гэж батлан өгүүлцгээдэг. Жишээлбэл эцэг эх хүүхдүүдээ ижилхэн арьстны хүүхдүүдтэй хамтад нь өсгөхийг хүсэж болох бөгөөд хэрэв тэд сургуулиа өөрсдөө сонгох боломжтой бол төр засгийн засаг захиргаанаас тогтоож заасан сургуульд явдаг байхаас илүү ихээр бусдаас ялгарах явдал тэнд илүү их гарах боломжтой ч байж болно.

Бодит байдал дээр нэгэнт л хүүхдүүд хамгийн ойрын сургуульдаа голдуу явдаг учраас төр засаг сургуулийн газрыг нь зааж оноож өгдөг байхад сургуульд угсаатны бүлгүүд бага л холилдсон байх болно. Нэгэнт л нэг ижил угсаатны бүлэг хүмүүс нэг дор амьдрах хандлагатай байдаг тул сургуулийн хүн ам ч энэхүү үл холилдсон байдлын тусгал байдаг. Гэвч хэрэв эцэг эх сургуулиа сонгох боломжтой бол тэд өөр хөрш зэргэлдээ газрын сургуулийг сонгох эсвэл зарим нь угсаатнаас илүү шинжлэх ухаан, хөгжим, эсвэл хэл ярианы чадвар зэрэг тэдний үнэлдэг бусад шинж чанартай зарим нэг сургуулийг илүүтэй сонгох болно.

Угсаатны ялгарал нилээд жам ёсны зүйл бөгөөд хүмүүс нэгэн ижил ийм бүлэг дотроосоо найз нөхөд болон ажлынхаа хамтрагч нараа сонгох хандлагатай байдаг. Гэвч энэ байдал болон бусад хүмүүсийн хүрээллийг үл хүлцэхийн хооронд ялгаа

9 *heterogeneity*

10 *international travel*

бий. Угсаатны хоорондох хамгийн хүнд хурцадмал байдал зарим бүлэгт нь эрхийг үгүйсгэж бусдад нь давуу эрх олгодог газарт байдаг – өөрөөр хэлбэл чөлөөт нийгмийн үндсэн зарчим алдагдсан газарт ийм зүйл гардаг ажээ.

Хүлцэхүйд учирдаг суурь аюул занал

Бусадтай харьцах хүлцэхүйд учирдаг хамгийн том аюул занал бол ёс суртахуун, идеологи, эсвэл шашны суурь үзэл буюу фундаментализм^[11] юм. Шашны хатуу үзэл бодолтой олон хүн хомосексуал байдал эсвэл гэрлэлтийн өмнө сексийн харилцааг ой гутам, гутамшигтай, цочирдмоор эсвэл ёс суртахуунгүй зүйл гэж үзэх боломжтой. Ариун зүйлийг гутаан доромжлох, бурхны дүрийг зурах^[12], шашны ном сургаалыг үгүйсгэх, шашны ёс суртахууны зан үйлийг дагахгүй байх, эсвэл бусад зарим шашинд орох зэргийг тэд ерөөсөө шуудхан нүгэл гэж үзэх боломжтой. Энэ байдлыг тэд иймэрхүү үйл хөдлөлийг хууль бус гэж үзэж шийтгэхэд хангалттай үндэслэл гэж ойлгох болно.

Гэвч бусдад тухайн хүний үйл ямар ч ой гутам эсвэл цочирдмоор байсан ч, хэдий шашны итгэлээр харвал хамгийн муу нүгэл гэж үнэлж болох байсан ч чөлөөт нийгэмд хэн ч тэр хүний үйлийг хэрэв энэ нь бусдыг бодитоор хохироох эсвэл хохироохоор заналхийлээгүй л бол хориглох эрх байхгүй. Дахиад хэлэхэд энэ байдал нь шашны бүлгийн гишүүд энэ үйлийг шүүмжлэх, тэдгээрийн эсрэг гаргалгаа гаргаж мэтгэлцэх явдлыг зогсоохгүй эсвэл тэр зан үйлчнийг шашныхаа бүлгээс гаргахыг нь ч хориглохгүй – энэ нь эргээд хэн ч мөрдөн мөшгөх явдалд өртөхгүй эсвэл бодит аюул орохгүй байх хэрэгтэй. Иймэрхүү үзэл бодол, үйлдлийн төлөө аливаа хүн эсвэл бүлэг хүмүүсийг үзэл санааг нь шүүлтүүрлэж хориглох, баривчлах, хорих, эрүүдэн шүүх, гэмтээх, цөлөх, эсвэл цаазлах боломжийг хэнд ч, үүн дотроо төр засагт ч олгохыг зөвшөөрөх ёсгүй.

11 *fundamentalism*

12 *making images of the deity*

Хэдийгээр зарим тохиолдолд засаг захиргаа нь өөрийнхөө зорилгодоо нийцүүлэн ондоогоор тайлж уншсан байдаг ч гэсэн дэлхий-дэхний олон шашны суурь сургаалд бусдыг хүлцэхүйн талаар магтаж сайшаасан байдаг. Газар нутаг эзлэн авсан харийн гүрэн ёс суртахууны болон шүүхийн код^[13]ыг нь захиран сууж буй явдлыг нь зөвтгөх, бас түүнд үйлчилдэг болгож гажуудуулан бас шашныг нь эзлэн түрэмгийлдэг ажээ. Зарим нэг тоталитарич төр засаг түүнийг өөрийн идеологи болон эрх мэдлийн дайсан гэж ойлгодгоосоо болж шашныг бүхэлд л дарангуйлж үгүйсгэдэг. Гэвч чөлөөт нийгэмд анхаарч буй фундаментализм^[14] нь шашных эсвэл идеологийнх байх нь хамаагүй. Ийм нийгэмд үйлдэл, ёс суртахуунт байдал, шашин, эсвэл идеологи нь ондоо байдаг хүмүүсийг албадах эрх засаг захиргаанд мөн л өгөхгүй.

Улстөрийн-хувьд зөв өнцөг^[15]

Хүлцэхүйд учирдаг өөр нэг илүү үл анзаарагдам занал аюул бий: энэ бол улстөрийн-хувьд зөв өнцөг юм. Энэ нь хувь хүнийг зарим нэг давамгайлж буй элитүүдийн дотоод санаа, итгэл, болон үзэл бодлыг хүлээн зөвшөөрүүлэх гэсэн нийгмийн болон улстөрийн дарамт шахалт ажээ. Дийлэнхидээ давамгайлж буй бодол санаатай санал нийлдэггүй хүмүүсийг гажиг эсвэл галзуу гэж шогчилж зурахын зорилго бол тэдний үзэл бодлыг мөн л гажиг эсвэл галзуу зүйл гэж гоочлох муучлах зорилготой байдаг. Энэ нь эдгээр бодол санааг хэлэлцүүлэгт оруулж мэтгэлцэх гэхээсээ илүүтэй өөрт таатайгаар алгасах боломж давамгайлж буй хүмүүст олгодог. Мөн энэ нь элитүүд буюу дээд ангийн үзэл бодол байгаагаасаа илүү үндэстэй гэж харуулна.

Ондоо бодол санааг маш ихээр гоочилж муутгаснаар тэдгээр нь нийгэмд тархах явдлыг хэцүү хүнд болгодог албадлагын үл мэдэгдэм хэлбэрт энэхүү үйл явц тулгуурладаг. Жишээлбэл

13 *moral and judicial codes*

14 *fundamentalism*

15 *Political correctness*

уур амьсгалын хүнээс-үүссэн гэх өөрчлөлтийн нотолгоонд эргэлзсэн эрдэмтдийг их сургуульд ажилд авахгүй эсвэл албан тушаал дэвшүүлэхгүй байх явдал байна. Чөлөөт нийгэмд ажил олгогч мэдээж өөртэй нь санал нийлэхгүй хүмүүсээ ажилд авах үүрэггүй; бас хэвлэл мэдээлэл дотооддоо зөрчилтэй маргаантай онолын тухай сурвалжилж мэдээлэх ч үүрэггүй. Гэвч боловсролын институт эсвэл хэвлэл төр засгийн монополь эсвэл бараг монополь эрхтэй газар байдаг газарт цөөнхи болсон үзэл бодолтой хүмүүсийг ингэж хавчиж гадуурхах явдал жинхэнэ албадлагын хэлбэртэй байдаг.

Хүлцэхүй, үнэний эрэл

Чөлөөт нийгмийн хүлцэхүй бол шашны эсвэл идеологийн ялгаатай байдлыг хүлцэн тэвчихээс ч өргөн зүйл юм. Жишээлбэл түүнд үзэл бодлоо илэрхийлэх^[16], үг хэлэх, бичгээр илэрхийлэх, нэвтрүүлгээр эсвэл бусад орчин ашиглаж илэрхийлэх эрх чөлөө ордог нь эргээд тэнд утга санааны шүүлтүүр буюу цэнзүр байхгүй байгааг харуулдаг.

Зарим хүмүүс утга санааны шүүлтүүргүй ертөнцийг маш аюултай аймаар зүйл гэж үзэж байж болох юм. Олон хүн ийм чөлөөт нийгэмд гаргаж тавих боломжтой үг, дүрс зураг, гаргалгаа нотолгоо, үзэл санаанд гүн цочирддог байх боломжтой. Чөлөөт нийгэмд бүр хэрэв бид бараг бүгдээрээ юу хэлж буйтай нь санал нийлүүлэхгүй байсан ч, түүнийг нь дайрч доромжилсон эсвэл ёс суртахуунгүй зүйл гэж итгэдэг байсан ч гэсэн бид үг хэлэх эрх чөлөөг хазаарлах, хүмүүсийн бодол санааг хориглох зогсоох эрх байхгүй.

Мэдээжээр бусдад аюул учруулахаар, кинотеатрт “Гал гарлаа!” гэж орилох зэрэг зүйл хэлэх мэтэд бол үг чөлөөтэй хэлэх эрх чөлөө^[17]г зарим нэг байдлаар хязгаарлах зүйл гарна. Бид ийм байдлаар бусдыг гэмтээж хохироохоор бодлогогүй

16 *freedom of expression-свободу выражения мнений*

17 *free speech*

эрсдэл гаргасан хэн нэгнийг шийтгэх нь хуульзүйн дагуух зүйл байх болно. Үүнтэй адилаар тэднийг бурууд татна^[18] гэж бидний итгэсэн тэр үг эсвэл дүрс зургаас бид хүүхдүүдээ хамгаалдаг. Бид жишээлбэл хар тамхины илэрхий тод ойлгомжтой зар сурталчилгаа сургуулийн орчмын зарын самбарт гаргахыг зөвшөөрөхгүй байж болно. Хүмүүст тэдний сэтгэлийг нь түгшээх ямар нэг зүйлээр санамсаргүй цочирдуулахгүй гэж уран сайхны киноны ангилал зэрэг мэдээлэл хүмүүст өгөх хэрэгтэй тухай үндэслэлтэй шалтгаан ч бий.

Энэ явдал бол ил тод цензүр буюу утга санааны шүүлтүүрээс маш ондоо зүйл юм – ийм шүүлтүүрээр тодорхой үг, дүрс зураг, гаргалгаа нотолгоо, үзэл санааг ерөөсөө өргөн нэвтрүүлгээр хүмүүст харуулахаас сэргийлдэг. Жинхэнэ чөлөөт нийгэмд иймэрхүү цензүр байх боломжгүй. Учир нь чөлөөт нийгэм нээлттэй байдал болон сонголтод суурилдаг. Хүмүүс хэрэв ирээдүйн амьдралыг нь сайжруулах боломжтой шинэ санааг рационал байдлаар сонгож авч турших гэж буй бол тэд бэлэн байгаа сонголтуудыг мэдэж байх ёстой. Цензүрдэх явдал тэдгээр сонголт, хувилбарыг хаадаг, үүнээс болоод бидний хөгжиж дэвжих явдлыг хорьж саатуулдаг.

Бас бид утга санааны ийм шүүлтүүрт итгэх ёсгүй. Үнэн болон засаг захиргаа хоёр тэс өөр зүйл юм. Эрх мэдэлтэй байгаа хүмүүст өөрийн гэсэн, жишээлбэл тодорхой үзэл санааг нийтийн нэвтрүүлгээр цацахыг хориглоход өөрийгөө-хамгаалж үлдэх гэсэн шалтгаан байж ч болох юм. Гэвч бүр хэрэв жинхэнээсээ сэтгэл зүрхнээсээ олон нийтийн ашиг сонирхолд тухайн цензүр буюу утга санааны шүүлтүүр нийцэж байсан ч гэсэн тэдгээр шүүлтүүрээс алдаа гарах боломжтой. Тэр цензүрт цэцэн ухаан юу болох тухай шийдэх монополь байдал ч, юу үнэн болох талаар тусгай мэдлэг ч гэж байхгүй. Зөвхөн хэлэлцүүлэг мэтгэлцээн, гаргалгаа нотолгоо, туршлага л үнэн гэж юу болохыг тодорхойлно. Утга санааны шүүлтүүр зүгээр л алдаа хийн үнэнийг дарж үгүй хийх боломжтой. Аажимдаа үнэн зөв байх

18 corrupt them

боломжтойгоо батлах үзэл санааг цензүрээр хорьж дарж буйгаа хэзээ ч мэдэж чадахгүй. Зарим үзэл санаа дийлэнхидээ буруу байж болох ч гэлээ энэ нь гаргалгаа нотолгоогоор батлагдах боломжтой зарим нэг үнэнийг агуулж байдаг. Бусад үзэл санааны үнэн нь зөвхөн цаг хугацаа өнгөрөхийн хэрээр илэрхий болдог ч байж болно.

Зөв болон хэрэгтэй үзэл санааг дарж хаахгүй байх явдлыг бататгадаг арга зам бол хэлэлцүүлэг мэтгэлцээнээр ач тус эсвэл муу тал нь ил гарах болно гэсэн итгэлээр бүх үзэл санаа нийтэд зориулан өргөн нэвтрүүлгээр түгээх явдал юм. Энэ нь бүр олонхи нь маш тодорхой ойлгомжтой гэж үздэг хэрэг явдлын талаар ч гэсэн хүмүүс өөрийн үзэл санаагаа батлан өгүүлэх боломж олгоно гэсэн үг билээ. Үнэнийг зөвхөн иймэрхүү өрсөлдөөн уралдаанаар л бататгаж бэхжүүлэх боломжтой. Энэ учир шалтгааны улмаас 1587-оос 1983 он хүртэл Ромын Католик Сүм гэгээнтэн болохоор нэр дэвшсэн хүмүүсийн эсрэг үүсгэсэн хэрэгт цэг тавихын тулд “чөтгөрийн өмгөөлөгч”-^[19]ийг томилж ирсэн байдаг. Бат итгэлдээ эргэлзэж үзэх нь хэрэгтэй зүйл юм. Хэрэв бид бусад хүмүүс үзэл бодолдоо алдсан гэж итгэж байвал тэр үзэл бодлыг дарж дуугүй болгох биш харин санаа бодлоо хэлж үгүйсгэх л хэрэгтэй.

Сократаас энэ хүрсэн түүхэнд хүмүүс үзэл бодлынхоо төлөө мөрдөгдөж мөшгөгдөж байсан жишээ элбэг бий. Хэдийгээр тэр үзэл санаа нь хожим нь зөвтөгдөх байсан ч гэсэн хүмүүсийг иймэрхүү байдлаар мөрдөж мөшгөн хүчээр дуугүй болгож байсан билээ. Ромын Католик Сүмийн уур хилэнгээс айсан Никол Коперник гараг эрхэс Нарыг тойрон эргэдэг тухай хувьсгал-гаргасан онолоо 1543 онд үхэх хүртлээ хэвлүүлж чадаагүй. Түүний шавь Галилео Галилейг Залхаан Цээрлүүлэх Шүүх^[20]ээр хэлэлцэж, тэрбээр гэрийн хорионд үлдсэн амьдралаа өнгөрүүлсэн байдаг. Иймэрхүү мөрдлөг хавчлага үнэнийг, мөн хэлэлцүүлэг мэтгэлцээн, хөгжил дэвшлийг дарж хавчина.

19 'devil's advocate'-

20 *Inquisition*

Энэ явдал нийгмийг ч, мөн мөрдөгдөж мөшгөгдөж буй тэрс үзэлтн^[21]ийг хохироож гэмтээдэг.

Бид зүгээр л ямар нэг мэтгэлцээнгүйгээр давамгайлж буй үзэл санааг хүлээн авчихсан чинь тэр үзэл санаа маш хэврэг үндэслэл дээр тулгуурладаг ч байж болно. Тэдгээрийг хүлээн зөвшөөрөх явдал ямар нэг шүүмжлэлгүй өрнөнө. Тэр үзэл санаа утга учиртай үнэн гэхээсээ илүүтэй чалчаа хоосон яриа болно. Тэгээд шинэ үзэл санаа аажмаар түрэн гарч ирэхэд энэ явц хурц ширүүн, сүйрэл дагуулахуйц байх боломжтой.

Хүмүүс бид зарчмын хувьд санал нийлдэггүй зүйлийг ярьж хэлэх, бид буруу гэж бат итгэдэг үзэл санааг илэрхийлэхэд, бид цочирдмоор зүйл гэж үздэг зүйлийг хийхэд эсвэл бүр бидний ёс суртахуун болон шашны итгэл үнэмшлийг гутаах доромжлоход энэ нь бидэнд тавгүй хэцүү санагдах боломжтой. Гэвч эдгээр зүйлийг бид хүлцэн тэвчиж буй явдал бидний эрх чөлөөнд хувь нэмэр оруулж буй байдлыг минь, мөн өөр өөр үзэл санааг дарж хорих гэхээсээ илүүтэй хэлэлцэж мэтгэлцэх явдлыг зөвшөөрснөөр бид илүү их хөгжил дэвшил гаргаж, шинэ үнэнийг илүү хурдан олж нээх болно гэсэн итгэл үнэмшлийг маань харуулдаг.

Хориглох явдал

Бид хэрэв өдөр тутмын амьдралдаа таашааж эдэлдэг олон зүйлийг маань хориглочихвол тун их бухимдаж уурлах болно. Харамсалтай нь тэдгээрийн олныг нь аль хэдийнээ хориглочихжээ.^[22]

Үл хохироох зарчим бидэнд бусдын үйлийг хэрэв тэдгээр нь бусад хүмүүсийг хохироох эсвэл хохироох эрсдэлд оруулаагүй бол хориглох зогсоох эрхгүй гэдгийг заадаг. Гэвч олон үйлийг

21 *heretics*

22 *Хориглох хэрэг явдлын талаар маш сайн тайлбарыг дараахь бүтээлээс үзнэ үү: John Meadowcroft (ed.), Prohibitions, Institute of Economic Affairs, London, 2008.-БАТЛЕП*

тэр үйлийг хийж буй хүмүүст хохиролтой гэсэн үндэслэлээр хоригложээ. Энэ байдал бол хар тамхи хэрэглэх, тамхи татах, архи уух өөр олон зүйлийг хориглодог цаад учир шалтгаан юм. Өөрсдийгөө хохироохоос хүмүүсийг сэргийлэх явдлыг зөвтгөх нь аливаа өөр бусад үйл ажиллагааг хориглох боломжийг шуудхан л олгодог учраас түгшүүртэй зүйл. Хүмүүс чихэрлэг ундаа уух, тос ихтэй хоол идэх, аюултай спортод оролцох, биеэ үнэлэх эсвэл хомосексуал байх, өөр шашинтай болох эсвэл засаг захиргаанд эргэлзэх зэргээр өөрсдийгөө хохироодог эсвэл эрсдэлд оруулдаг гэж батлах өгүүлэх нь хэт хялбар зүйл байж болох юм. Яг эдгээр зүйлийн төлөө маргаж мэтгэлцдэг хүний тоог харвал энэхүү зарчим нэгэнт үгүй болоход бид эрх чөлөөгөө хаалгаж дарлуулахад нэг их удахгүй дэг ээ.

Хориглох явдал ерөөсөө сүйрэл дагуулсан үр дүнд л мөн хүрдэг. Тодорхой юмс үзэгдлийг нууц далд хэлбэрт орохыг шаардах явдлыг өдөөснөөр тэдгээрийг хянах, шалгахад улам л хэцүү болж эрүүгийн хэрэгтнүүд эдгээр хориотой зүйлийг [зах зээл рүү] нийлүүлж хангахаар орж ирэх болно. Жишээлбэл Америкийн Нэгдсэн Улсад зуун гаруй жилийн өмнө байсан [Архины] Хорионы цаг үед согтууруулах ундаа нийлүүлэх нь гэмт хэрэг байсан тэр цаг үед эрх мэдэл нь өсөж томорсон эрүүгийн мафи оршин байгаа явдлаас өнөө ч гэсэн хохирсоор л байна. АНУ-ын ихэнхи хэсэгт мөрийтэй тоглоом болон биеэ үнэлэх явдал хууль бус зүйл байсаар байгаа нь эрэлт хэрэгцээг хангаж эдгээр үйлчилгээг үзүүлэхдээ тун дуртай байдаг иймэрхүү эрүүгийн элементүүдийг урамшуулж дэмжсээр л байна.

Хорио тогтоож хориглох явдал^[23] мөн л хүмүүст өөрийнхөө үйл хөдлөлийн үр нөлөөг ухаж ойлгох явдлыг улам л хэцүү болгодог. Хүмүүс одоо ч хар тамхи [татахыг] хүссээр байгаа боловч хар тамхи хууль бус байсаар байвал тэдгээрийн аюулын талаар сайн мэдээлэл олж авах явдал илүү бэрхшээлтэй байсаар байна. Мөн худалдаж авч буй зүйлийнхээ чанарыг хэрэглэгчид шалгах аргагүй болгодог. Хар тамхинаас хамааралтай болсон

Асуулт: Бид хүмүүсийг өөрсдөөс нь хамгаалах ёстой юу?

Үгүй. Та нар өөрөөсөө “хамгаалагдсан” байхыг хүсдэг гэж үү? Эсвэл та нар хэрхэн амьдрахаа өөрөө шийддэг байх ёстой гэж бодож байна уу? Төр засагт бидэнд юу сайн юу муу болохыг шийдвэрлэх боломж өгөх нь үр ашиггүй зүйл: Бид алс холын эрх мэдэлтнээс илүү сайн бидэнд ямар эрсдэл байгааг мэдэх байр суурьтай байдаг. Төрд ийм зүйл өгөх нь аюултай: төр засаг эхлээд хүн бүрийг хохироодог аюултай зүйлийг хориглохоос ажлаа эхлэх ч гэлээ нэгэнт уг зарчим хүлээн зөвшөөрөгдмөгц бүх зүйлийг хориглож эхлэх болно.

Кокайн хамраараа татах, тамхи татах, согтууруулах ундаа уух, тослог хоол идэх, эсвэл чихэрлэг ундаанд татагдахаас биднийг сэргийлэх ёстой юу? Биднийг хуулиар дасгал хөдөлгөөн хийлгэхээр албадах, мөн аюултай спорт хийхийг болиулах, сүмд очуулах ёстой юу? Биднийг “аюултай” ном уншихаас маань хориглох сэргийлэх, эсвэл биднийг удирдагчдаа шүүмжлэхийг маань хориглох ёстой юу? Чөлөөт нийгэмд үүний хариулт үгүй л байх болно. Хэрэв хүмүүс бидний ёс суртахууныг дайрч доромжилж эсвэл ямар нэг аюултай зүйл хийж байвал бид тэдэнд энэ тухай нь хэлэх ёстой. Гэвч аливаа бусад хүнд хохирол учруулахгүй байсаар байх хүртэл бидэнд тэднийг ингэхийг нь зогсоох эрх байхгүй.

хүмүүсийн хувьд эмнэлгийн эсвэл нийгмийн тусламж авах явдал хэцүү болдог. Учир нь ингэх гэвэл тэд гэмт хэрэг үйлдсэнээ зөвшөөрч буй хэрэг болно. Хүмүүс ариутгаагүй тариур зэргээр дамжсан ДОХ-ийн аюул зэрэг бусад эрсдэлд өртөж байна. Учир нь хар тамхины хэрэглээг хууль бус болгосон нь түүнийг аюулгүй орчинд хэрэглэх аргагүй болгожээ. Үр дүнд нь тухайн хар тамхинаас учирдаг ихэнхи хор хохирол биш юмаа гэхэд

нилээд нь тэр хар тамхи хууль бус байдаг гэсэн бодит байдлаас үүсэж гардаг ажээ.^[24]

Эдгээр шиг хорио тогтоох, хориглох явдал аль нь ч бусад хүмүүсийг ерөөсөө хохироодоггүй гэж ойлгодог эмчилгээний хар тамхи^[25] хэрэглэдэг, эсвэл мөрийтэй тоглодог, эсвэл гэртээ найзуудтай архи уух гэсэн нэр төртэй хууль сахидаг хүмүүсийг эрүүгийн хэрэгтэн болгодог. Бага гэмтэй гэмт хэрэг үйлдэж хууль зөрчсөн хүн илүү онцтой, бусдыг хохироох боломжтой эрсдэл рүү орж ч болох юм.

Хорио тогтоох, хориглох явдал хэзээ ч зорьсондоо хүрч байгаагүй. Америкийн Нэгдсэн Улсад согтууруулах ундааг хориглосон явдал^[26] зөвхөн л архи уух явдлыг далд нууц үйл болгож, хянах боломжгүй болгосон. Дэлхий даяар хэрэгжүүлж буй хар тамхины хатуу чанга хууль, их хэмжээний торгууль хэдэн зуун тэрбум доллароор үнэлэгддэг түүний арилжааг зогсоосонгүй, бас түүнээс сэргийлж чадсангүй.

Дэмий шахуу үйл хөдлөлийг хорьж цагдахыг оролдох нь хий хоосон зүйл. Энэ явдал бол бас эрх чөлөөний аюул занал билээ. Учир нь хэрэв ерөөсөө ямар нэг байдлаар хорьж цагдах явдлыг үр нөлөөтэй болгоход шаардлагатай зүйл нь бүхнийг хамарсан хяналт, албадан хэрэгжүүлэх бүтэц байдаг. Энэ байдал нь жинхэнээсээ хор хохиролтой гэмт хэргийг мөрдөн шалгах, таслан зогсоох, мөрдөн шийдвэрлэх хууль сахиулах байгууллагын нөөц баялгийг хэрэггүй өөр тийш явуулдаг. Мөн энэ нь цагдаа болон шүүхэд байгаа хүмүүст авилгал авах боломж нээж өгдөг; хэдийгээр мөрийтэй тоглох эсвэл хар тамхи хэрэглэх явдлаас багахан эсвэл ямар ч хохирол бусдад учирдаггүй байсан ч торгууль шийтгэл нь их байж болох явдал албан тушаалтнууд

24 Энэ санааг дараахь бүтээлд гарамтгай илэрхийлсэн байдаг: Milton Friedman and Rose Friedman, *Capitalism and Freedom*, Chicago University Press, Chicago, IL, 1962-БАТЛЕП

25 recreational drugs

26 Alcohol prohibition

тэр хэрэгт оролцсон хүмүүсээс их хэмжээний авилга авах боломж үүсгэдэг.

Олон нийтийн болон хувийн үйл хөдлөл

Чөлөөт нийгмийн ёс журам олон нийтийн үйл хөдлөл^[27]ийг л, хэрхэн хувь хүмүүс хэрхэн бусадтай харилцахдаа биеэ авч явахыг л удирдаж залдаг. Гэвч зөвхөн тухайн хувь хүнд л хамаатай хувийн үйл хөдлөл^[28] хувийнх нь оронзайд л болно. Хэрэв энэ нь бусад нэгнийг хохироосон бол энэ нь хуульзүйн хэрэг явдал болно.

Гэлээ гээд чөлөөт нийгэмд бодит хохирол эсвэл хохирол гарах эрсдэл жинхэнэ эсэх тухайд маш няхуур үздэг. Хүмүүс чөлөөтэй хор зарах нь зөвшөөрөгдсөн зүйл байх ёстой юу? Тухайн хор нь хүмүүнд хоргүй байх өөр олон хэрэглээтэй байдаг гэдгээс харвал тэдгээрийн борлуулалтыг хориглох явдлаас түүнийг нь зөвшөөрөхөөс илүү их аюул занал гарах боломжтой ажээ. Хор худалдаж буй болон худалдан авч буй хүмүүсийн нэрийг бичих явдал нь хордуулагч этгээд баригдах магадлалтай гэдгээ мэдэх болж илүү тустай ч хэрэг байж болох юм; гэвч ийм зүйл цөөхөн тохиолдоно.^[29]

Олон нийтийн газар архидан согтуурах явдл^[30]ын эсрэг дүрэм журам байх ёстой юу? Эсвэл янхны газар эсвэл мөрийтэй тоглоомын газрын үйл ажиллагааг эсэргүүцэх үү? Хэрэв энэ нь хүчирхийллийн шалтгаан болбол тэгж болно. Гэхдээ энэ шалтгаанаар олон улс оронд эдгээрийг лицензжүүлдэг. Гэвч ихэнхи тохиолдолд эдгээр үйл ажиллагаа зөвхөн түүнийг сонирхож буй хүмүүст л нөлөөлдөг. Бусад хүмүүст тэдгээрийн талаар бодох нь ой гутам муухай зүйл байх боломжтой байдаг ч

27 *public behaviour*

28 *private behaviour*

29 Энэ санаа болон бусад зүйлийг дараахь бүтээлд сайн тайлбарлажээ: John Stuart Mill, *On Liberty*, 1859, in John Stuart Mill, *On Liberty and other Essays*, Oxford University Press, Oxford, 2008. -БАТЛЕР

30 *public drunkenness*

гэлээ хэрэв бид бусдад учруулсан бодит хохирлоос өөр ямар ч хамаагүй зүйлд үндэслэн үйл ажиллагааг нь хориглох зөвшөөрөл өгвөл моралистууд^[31]ын халдлагаас хамгаалагдсан хүмүүний ямар ч үйл ажиллагаа үлдэхгүй.

Ариун өдрүүдээр хүмүүст арилжаа наймаа хийхийг зөвшөөрөх ёстой юу? Эсвэл олон эхнэртэй байхыг зөвшөөрөх ёстой юу? Энэ бол тэдний хэрэг харин биднийх биш; энэ явдал өөр хэнийг ч үл хохироодог. Чөлөөт нийгмийн хууль хувь хүмүүсийн эрх чөлөөг өргөжүүлж тэлэх гэж оршдог болохоос зарим нэг хүн бусдадаа ёс суртахуунт байдал тулгах явдлыг дэмжих гэж оршдоггүй.

Гэсэн хэдий ч чөлөөт нийгэм дэх хүмүүс өөрийн өмчийнхөө тухайд өөрийн гэсэн дүрэм журам гаргахыг нь хэрэв энэ нь үл хохироох зарчмыг зөрчөөгүй байвал зөвшөөрдөг. Олон улс оронд зарим олон нийтийн оронзай (их дэлгүүр зэрэг)-г улстөрийн засаг захиргаа биш харин хувийнхан өмчилсөн байдаг. Тийм учраас 2005 онд зүүн урд Английн Блүүвотер их дэлгүүрт хараалын үг хэлэх, тамхи татах, зарын хуудас тараах, нүүрээ халхалсан (толгойгоо халхлах малгайтай цамц зэрэг) хувцас өмсөхийг хоригложээ. Шоколад үйлдвэрлэгч Жорж Кэдбарийн байгуулсан, одоо хүртэл өөрийн зарчимдаа үнэнч байж ирсэн хувийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сайн удирдаж буй үйлдвэр хот болох Төв Английн Бөөрнвиллд согтууруулах ундааг ил зарахыг зөвшөөрдөггүй. Нэгэнт Блүүвотер болон Бөөрнвилл хувийн өмч тул тэр дотроо өмчлөгчид нь ингэх бүрэн эрхтэй.

Алтруизмын зовлон бэрхшээл

Олон хүн чөлөөт нийгэм болон чөлөөт зах зээл тэдгээрт оролцож буй хүмүүсийн өөрийн-тусыг бодох явдалд үндэслэж ажилладаг гэж бодохдоо сэтгэл нь тавгүй болцгоодог. Тэр хүмүүс алтруизмд хөтлөгдсөн ертөнцийг илүүд үзэх болно – алтруизм бол бусад хүмүүсийн ашиг сонирхол болон сайн сайхан байдалд өөрийгөө үл бодож анхаарал тавих явдал юм. Гэвч энэ байдал асуудал

31 *moralist-Ёс суртахуун номлогч хүн*

шийдвэрлэх гэхээсээ улам л илүү их бэрхшээл зовлонд хүргэдэг ажээ.^[32]

Бусдад туслах явдалд ямар ч дүрэм байдаггүй

Юуны түрүүнд бид бусад хүмүүсийн ашиг сонирхол юу болохыг ер нь мэдэж чадах уу? Бид тэдний ухаан санаа болон үнэт зүйлийг мэдэж чадахгүй. Хэрэв бид тэдний ашиг сонирхолд нийцсэн гэж үзсэн зүйлээ хийсэн байсан ч гэсэн бид заавал том алдаа гаргах л болно. Ерөөсөө тохиромжгүй бэлэг авч байсан хүн бүр гэр бүлийнхэн болон найз нөхөд нь хүний хүсэл таашаалыг үнэлж мэдэхдээ маш муу байх боломжтой гэдгийг мэддэг. Нийт нийгмийг удирдах явдлыг бэлэглэх соёлд үндэслэн явуулах үр ашиггүй зүйл болох нь харагддаг.

Бусад хүмүүс бидэнд өгч буй зүйлд шүүмжлэлтэй хандах явдал бас л хэцүү ажил^[33]. Бид бүр түүнд нь дургүй байсан ч гэсэн бэлгийг хүндэтгэлтэйгээр баяр хөөртэй мэт хүлээн авдаг. Энэ байдал нь алтруист нийгэм дэх хүмүүс хэзээ ч бусад хүмүүс яг юу хүсэж буйг мэдэхэд суралцаж чадахгүй гэсэн үг юм. Энэ нь хэрэв хэрэглэгч яг хүссэн зүйлээ нийлүүлэгчээсээ аваагүй бол тэд үүнийг тэр нийлүүлэгчид хэлчихээд өөр бизнесээс үүнийг авах болно гэж заналхийлдэг, өөрийн-тусыг бодох явдалд үндэслэдэг эдийн засгаас эрс ялгаатай. Өөрийн-тусыг бодох явдал л нийлүүлэгчдийг хүмүүст яг таарсан бүтээгдэхүүнийг аль болох хямдаар өгөхөд гол анхаарлаа хандуулахад хүргэдэг.

Алтруизм зөрчил тэмцэл үүсгэдэг

Хэрэв бусдад туслахаар зориуд оролдох явдлаар бизнесийн хэлцэл сэдэлжиж явагдаж буй бол худалдан авагч болон худалдагч талын хооронд өөрийн-тусыг боддог өнөөгийн ертөнц

32 Үүний бүрэн тайлбарыг дараахь бүтээлээс үзнэ үү: Mao Yushi, 'The paradox of morality', in Tom G. Palmer, *The Morality of Capitalism*, Students for Liberty and Atlas Foundation, Arlington, VA, 2011.-БАТЛЕР

33 бэлгийн морины шүдийг үл харна.

байдаг шиг маш их хурцадмал байдал гарах болно. Худалдан авагч нь худалдагчдынхаа ашиг тусын төлөө өөрөө илүү их төлбөр төлөхөөр улайрах болно. Худалдагч тал нь худалдан авагчийнхаа ашиг тусыг хамгийн их байлгахын тулд үнээ аль болох бууруулах болно. Энэ байдал бол өнөөдөр болж буй зүйлийн эсрэг толин тусгал юм.

Зах зээлийн эдийн засагт өөрийн-тусыг бодсон хүмүүс нэг нэгтэйгээ зөрчилдөж байдаг боловч тэд зөрчлөө наймаалалцах замаар шийдвэрлэх боломжтой. Хэрэв цор ганц сэдэл нь бусдад туслах явдал байвал тэнд зөрчлийг шийдвэрлэх ямар ч арга зам байхгүй. Алтруист хүн бүр л бусдыг илүү сайн болгох гэж шаргуу зүтгэх болно. Нэгэнт аль нь ч хэлцлээс ашиг олохыг хүсэхгүй тул тэдний хэрэгцээ хэр яаралтай байх нь тэднийг санал нэгдэхэд нь тус бас болохгүй.

Өөрийн-тусыг бодох, зардал ашиг

Өөрийн-тусыг бодох явдал нийлүүлэгчдийг ч мөн хэрэглэгчдийг ч хэлцлийн ашиг тус нь зардлаасаа давсан байх явдлыг бататгахад анхаарлыг нь хандуулдаг. Ямар ч шан харамж авахгүй ажилладаг алтруист нийлүүлэгч маш буруу алдаатай дохиог хүн бүрд илгээх болно – тэр дохио нь тэдний [зарцуулах] цаг хугацаа болон нарийн туршлага нь тэг үнэ цэнэтэй байгаа тухай дохио юм. Энэ дохионд итгэсэн^[34] хэрэглэгчид удалгүй нийлүүлэгчдийг эрэлтээр дарна. Нийлүүлэгчид хэдийгээр үр өгөөж нь хязгаарын эсвэл зардлаа давахгүй байсан ч эдгээр үйлчилгээг үзүүлэхээс татгалзах ямар ч арга байхгүй.

Жишээлбэл савхин-эдлэл янзалдаг хүн бараа бүтээгдэхүүнээ засуулж янзлуулах гэсэн хүмүүсийн эцэс төгсгөлгүй цуваатай учрах болно. Өөрийн-тусыг боддог зах зээлийн эдийн засагт иймэрхүү наймаачин хүмүүст хэрэв бараа бүтээгдэхүүнийг засварлах хэрэгцээгүй байвал энэ тухай нь шулуухан л хэлэх

34 taking this signal at face value

Асуулт: Ядуу хүмүүсийг юм худалдаж авах боломжтой байлгахын тулд бид үнийг хянах ёстой биш гэж үү?

Үгүй. Үнэ ховор байдлын дохио байдаг. Үнэ бидэнд хаана илүүдэл, хаана хомсдол буйг хэлдэг. Үнэ үйлдвэрлэгчид илүү их бүтээгдэхүүн хэрэгтэй байгааг, хэрэглэгчдэд тэд хэмнэх ёстой эсвэл өөр хувилбар эрж хайх болсныг хэлдэг. Үнийн хяналт эдгээр дохиог дарж үгүй хийх бөгөөд үүнээс болж эрэлт нь нийлүүлэлтээс хоцорч тэнд хомсдол үүсдэг. Энэ байдлаас голдуу л ховор бараа бүтээгдэхүүнийг нормчилж олгох явдал гарахад хүрдэг. Энэ бол бүр л илүү үр дүн муутай арга юм.

Үүний жишээ бол орон сууцыг хүртээмжтэй, хэрэглэж чадахуйц байлгах гэж зохиомжилж гаргасан түрээсийн хяналт ажээ. Үүнээс болж өмчлөгч нь түүний авч буй түрээс үнэ цэнэгүй болсон гэж үзэн, түрээсийн зах зээлээс өмчөө татаж авахаар шийдсэнээр үнэндээ орон сууц түрээслэх нь улам л хэцүү болж эсвэл олдохгүй болдог. Хэрэв зарим хүмүүс амин чухал зүйлээ худалдаж авч чадахгүй байгаа бол хамгийн зөв шийдэл зах зээлийн үйл ажиллагаа руу хөндлөнгөөс оролцох биш харин тэдэнд хувийн буяны сан эсвэл татвараар санхүүжүүлдэг хамгийн бага орлогын бүтцээр дамжуулж мөнгө өгөх явдал юм. Тэр үед тэд хүн бүрийн адилаар ижилхэн үр ашигтай, өрсөлдөөнтэй зах зээлээс эдгээр зүйлээс сонгож худалдан авах боломжтой болно.

болно^[35]; эсвэл хэрэглэгчид энэ бүтээгдэхүүнээ засуулах тухай бодож төвдөхгүй байхаар тэд үнээ тийм их болгох болно. Зах зээл эрэлтийг удирдан залдаг, мөн хүчин чармайлтыг жинхэнээсээ хэрэгцээтэй үнэ цэнэтэй зүйл рүү төвлөрүүлдэг.

Алтруистч ертөнцөд хүмүүс хөршүүддээ ямар ч хамаагүй зорилгоор, жишээлбэл байшин барихад нь туслахаар яаравчлах болно. Гэвч оновчтой зохистой, үр ашигтай байдл^[36]ын утгаар уг хөрш нь зах зээл дээр очиж мэргэжлийн байшин барьдаг хөлслөх нь найз нөхдийнхөө мэргэжлээгүй хөдөлмөр ашиглахад найдахаас илүү сайн зүйл байх ч боломжтой. Ингэж хийхийн алдагдал хэрэв тэр хөршүүд нь ур чадвараа өөр төрлийн ажилд илүү үр бүтээлтэй хэрэглэх байсан бол бүр ч илүү өснө. Зах зээл хүмүүсийг цаг хугацаа болон хүчин чармайлтаа хамгийн их үнэлж цэгнэдэг зүйлдээ зарцуулах явдлыг л тэтгэж дэмждэг.

Зах зээлийн ёс суртахуунт байдал

Чөлөөт зах зээлийн эдийн засаг өөрийн-тусыг бодох явдалд үндэслэдэг гэсэн бодит байдал түүнийг ёс суртахуунгүй зүйл болгодоггүй. Зах зээлд хүмүүс бусдын хүссэн зүйлийг нь нийлүүлж, нэг нэгтэйгээ хамтран ажиллах замаар л хөгжиж цэцэглэх боломжтой. Нийгмийн эсрэг үйл хөдлөлийг шийтгэдэг: бизнес хийхийг хүссэн санаа сэтгэл нийлэх хар мянган хүмүүс байхад яагаад бүдүүлэг мизантроп буюу хүмүүнийг-үзэн ядагч^[37]тай арилжаа наймаа хийх ёстой гэж?

Албадлагагүйгээр зах зээлийг зогсолтгүй жигд ажиллуулдаг ёс журам гэж бас бий. Гэвч албан ёсны дүрэм журам бүх онцгой тохиолдлыг шийдэж чадахгүй. Зах зээл гарцаагүй итгэл дээр суурилдаг бөгөөд итгэл даадаг, найдвартай байснаар нэр төртэй болсон хүмүүсийг зах зээл шагнаж урамшуулдаг. Бүр хэдийгээр хөдөлгөгч хүч нь өөрийн-тусыг бодох явдал байдаг ч гэсэн зах зээл харилцан ашигтай ёс суртахуунт байдлыг тэтгэдэг ажээ.

³⁶ *practical and cost-effectiveness*

³⁷ *misanthrope* - хүмүүн төрөлтөнд дургүй, хүмүүний нийгмээс зайлсхийдэг хүнийг хэлнэ.

Байгууллагын нийгмийн хариуцлага

Олон хүн бизнесүүдийг илүү ёс суртахуунтай үйл хийхийг шаардаж, “корпорацийн нийгмийн хариуцлага”^[38] гэгчийг дэмждэг. Олон-улсын олон том бизнесийн байгууллага одоо жил бүр тэд сайн иргэд байх гэж ямар зүйл хийснээ тайлбарлаж тайлан хэвлүүлцгээж байна.

Гэвч зөвхөн хувь хүмүүс л хариуцлагатай эсвэл хариуцлагагүй, ёс суртахуунтай эсвэл ёс суртахуунгүй байх боломжтой. Бүлэг хүнд өөрийн гэсэн бие даасан тусдаа ёс суртахуунт байдал гэж байдаггүй. Улс орон, хот, арьстан, овог отог, клуб, эсвэл компани ёс суртахуунтай эсвэл ёс суртахуунгүй байх боломжгүй, харин зөвхөн хувь гишүүд нь ийм байх боломжтой. Мэдээжээр бид бизнесийн лидер өөрийн байгууллагад ёс суртахууны соёл бүтээхэд бид дуртай байх болно. Гэвч ёс суртахуунт байдал болон хариуцлага үйлдлээс л харагддаг бөгөөд үйлдлийг зөвхөн бүлэг хүмүүс биш харин хувь хүмүүс л үйлддэг.

Корпорацийн нийгмийн хариуцлагын тухай хөдөлгөөн бол үнэндээ иргэний болон халамжийн хөтөлбөрийн зардлыг бизнесийн байгууллагад дамжуулах гэсэн оролдлого юм. Бизнесийн байгууллага орон нутгийн сургууль, нийгмийн бүлэг зэргийг санхүүжүүлж хэр хариуцлагатай байгаагаа харуулахыг оролдох болно. Энэ нь тэдгээрийн хувьд ингэж хийх нь бизнесийн утгаараа сайн байж болох юм: эцсийн эцэст тэдгээр байгууллага орон нутгийн сургуулиас ажилтан элсүүлэх болоход тэдгээрийн сайн харилцаа нь ажилд авах явцыг хялбар болгох боломжтой. Гэвч энэ нь ямар нэг угсаатны нэрээр тэдэнд ингэхийг нь албадсан биш харин гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчдийн сайн дураараа гаргасан шийдвэр байх ёстой.

Хэрэв бизнес зохистой өрсөлдөөнтэй байсан сан бол ямар ч тохиолдолд уг бизнесийн арилжааны хэтийн төлөвт үйлчилдэггүй орон нутгийн төслийг дэмжихэд зориулсан бэлэн мөнгө байх ёсгүй. Хэрэв уг пүүст ийм төсөлд зарцуулах илүү нөөц мөнгө

38 ‘corporate social responsibility’

байвал энэ нь зах зээл ажиллахгүй байгаагийн илэрхийлэл байх болно (жишээлбэл төр засаг зарим компаниудыг өрсөлдөөнөөс дүрэм журмаар хамгаалсан байдаг). Жинхэнээсээ өрсөлдөөнтэй зах зээлд тэдгээр пүүс шилэн хоргоны үзүүлэнд тавих орон нутгийн төсөлд мөнгө зарцуулахаасаа татгалздаг, үр дүнд нь гарсан ашгаа өгөхөөс татгалздаг пүүсүүддээ ялагдах болно.

Бас бизнесийн хүмүүс үнэндээ тухайн хүмүүсийн хүрээлэлд зориулсан төслийн мөнгийг нь хий дэмий зарцуулахгүй байх явдалд анхаарал тавихдаа тийм ч сайн байдаггүй. Тэд хүмүүс жинхэнээсээ хүсэж буй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг нийлүүлэх замаар ашиг олох үндсэн үүрэгтээ анхаарал хандуулах нь тэдний хувьд тустай зүйл байх болно – энэ явдал эргээд филантропи буюу буяны үйлс хийхийг боломжтой болгодог, нийт олны эд баялгийг бүтээх болно.

8 ХУВЬЧЛАЛ, ДАЯАРЧЛАЛ

Цагаачлал, технологи

Дэлхий ертөнц нээлттэй болж байна

Манай гарагийн нэгэнтээ алс бөглүү байсан газар одоо тийм байхаа больжээ. Зурагт, радио, интернэт, бусад харилцаан холбооны зүйлс бусад соёл, амьдралын хэвмаяг, арьстан, хүмүүс, төр засгийн тогтолцоог бидэнд ойртуулав. Агаарын тээвэр, газрын хурдтай тээвэр олон газрыг хурдан түргэн яваад очих газар болгов.

Энэ байдлаас болж төр засаг алдаа дутагдлаа нуух улам бүр хэцүү боллоо. Төр засаг улс орныхоо дутагдалтай хоцрогдсон байдлаа иргэдээсээ хаах гэсэн итгэлээр нутаг дэвсгэрээ тойруулан хана барих ямар боломжгүй цаг үед иржээ. Нийгмийн сүлжээгээр өдөр бүр дэлхийн үлдсэн хэсэгтээ өдөр тутам холбоо барьж буй эсвэл тавган антенаар дамжуулан гадаадын телевиз үзэж буй тэдгээр иргэд магадгүй аль хэдийнээ хаа нэгтээ гарсан гайхамшигтай ололт амжилтын талаар ухаж мэдчихсэн байгаа биз ээ.

Үр дүнд нь олон улс орон дэлхийгээс хаалттай хэвээр үлдэх гэсэн оролдлогоосоо ухрах хэрэгтэй болсон. Тэдгээр улс одоо аялагч нарт болон бусад зочлон ирэгч нарт үүд хаалгаа нээж байна. Сүүлийн хэдэн арван жилд Орос, Хятад, Вьетнам, Балба (Мянмар) зэрэг голлох улсууд болон бусад олон улс орон олон-улсын нийгэмлэгт хамаагүй илүү нээлттэй болов. Өнөөдөр Афганистаны хүн амын хорин хувь амьдралынхаа ямар нэг хэсгийг гадаадад амьдарч өнгөрүүлж байна.

Үзэл санааны солилцоо

Энэхүү шинэ ертөнцөд зөвхөн хүмүүс аялж зугаалцгаадаггүй – мөн тэдэнтэй цуг үзэл санаа хамт явдаг. Жуулчид хүмүүс нь үйл хийх, бодох, ярих эрх чөлөөтэй байдаг маш өөр ертөнцийн тухай ярьж хэлж ирдэг. Тухайн нутгийн хүмүүс гадагшаа явж, уг жуулчны хэлсэн ярьсан түүх үнэн болохыг олж мэдэн гайхширдаг. Хэрэв хүмүүс интернетэд эсвэл сансрын телевизэд холбогдох боломжтой бол тэдний ярьсан зүйл дэлгэцээс харсан зүйлээр нь батлагдах болно.

Арилжаа мөн л адилхан нөлөөтэй. Нэгэнт улс орон олон-улсын арилжаа худалдаанд нээлттэй болбол иргэд нь өөр соёлтой хүмүүстэй бизнес эрхлэх, тэдэнтэй найз нөхөд болж чадах бөгөөд амьдран суух өөр арга замын талаар ухаж ойлгодог.

Энэ байдал төр засагт түүнийг бүр л нээлттэй болгохоор ирэх дарамт шахалтыг улам бүр хүчтэй болгодог. Жинхэнээсээ эрх чөлөөг ойлгодог, мэдэрч эдэлдэг хүмүүс шуудхан л түүнд хөгжил дэвшлийг тэтгэх, хөгжил цэцэглэлтийг тархааж түгээх асар их хүч чадал байгааг ухаж ойлгодог. Тэд өөрсдөдөө энэ хөгжил дэвшил болон хөгжил цэцэглэлтийн заримыг нь авахыг хүснэ. Технологи, худалдаа, цагаачлал, аялал жуулчлал, дэлхийн-дэхний зах зээл бол бүгдээрээ чөлөөт нийгмийг дэмжигч элчин төлөөлөгч юм.

Өсөж томорч буй чөлөөт нийгэм

Дээрээс доош хэрэгждэггүй капитализм^[1]

Өмнө нь ер байгаагүй чөлөөт нийгэм бүтээх явдал хэцүү ажил. Шинэ төр засаг болон олон-улсын тусламжийн байгууллага голдуу л захиргааны захиргаадалтын нийт бүтцийг өөрчлөх, эсвэл төр засгийн том үйлдвэрийг хувьчлах зэрэг өргөн хүрээтэй, гайхалтай сайхан өөрчлөлтийг л эрж хайдаг.

1 Not top-down capitalism

Голдуу иймэрхүү хандлага сүйрэл дагуулна. Хувийн давуу талын төлөө эрх мэдлээ ашиглах соёлтой байсан, мөн зах зээл болон өрсөлдөөний талаархи тухайн орон нутгийн ойлголт байхгүй байсан тул хувьчлалын олон санаачилга (1980-аад оны Мексик дахь хувьчлал зэрэг) зүгээр л төрийн монополийг амин найзуудын компаниудад дамжуулж өгчээ. Олон нийтийн хувьд энэхүү амин найзуудын капитализм^[2] нь өмнө явж ирсэн төрийн кронизм^[3]ээс ялгаагүй мэт ойлгогдоно. Нэгэнт шүүхийн тогтолцоог өөрчлөх шинэчлэх ажил олон арван жил үргэлжлэн явах боломжтой тул иймэрхүү кронизм шүүхийн зүгээс ирэх эсэргүүцэлгүйгээр өрнөж болно. Тиймээс хүмүүс хувийн-аж ахуйн шийдэл гэх зүйлийг өмнө нь байсан төрийн-хяналтын зовлонтой адилхан муу зүйл гэж зүгээр л үл итгэхэд хүрдэг. Элитүүдэд гэхээсээ илүүтэй олон нийтэд илүү ашиг тустай байх боломжтой шинэ хандлагыг зөвхөн хэт ширүүн үзэлтэн буюу радикалууд, хувьсгалчид л санал болгох болно гэдэгт олон хүн итгэдэг болж ч болох юм.

Дороос дээшлэх эрх чөлөөний хөдөлгөгч хүч

‘Дээрээс-доош хэрэгжих капитализм’-ын хандлага тэдгээрийг бүтээдэг, дэмждэг, суурь дотоод сэтгэл, үйлдэл, санаачилгыг өөрчлөхгүйгээр нийгмийн институтүүдийн харагдах байдлыг өөрчлөхөөр оролддог учраас бүтэлтэй болдоггүй.

Хүмүүс чөлөөтэй хамтдаа хэрхэн амьдрах, хамтран ажиллахыг тодорхойлдог хуульзүйн болон ёс суртахууны ёс журмын загвар хэлбэрээс чөлөөт нийгмийн бүтээлч байдал болон хөгжил дэвшил ургаж гардаг. Хэрэв үйлдлийн ёс журмын иймэрхүү загварыг нэвтрүүлээд хүмүүсийг тэдгээр ёс журмын хүрээнд амьдралынхаа үйлээ чөлөөтэй явуулдаг болгож чадвал тэр үед нийт нийгмийн амин эрчим, амбиц зүйтогтолжсон өөрчлөлтийг өдөөх болно.

2 *crony capitalism*

3 *state cronyism*

Жишээлбэл хүмүүс шинэ бизнес эхлэх, итгэлтэйгээр бизнесээ өмчлөх, эрхэлж явуулах, өмч өмчлөх явдлыг баталгаатай болгох, бүтээлч хөрөнгийг бүтээх бүрдүүлэх, чөлөөтэй арилжаа худалдаа хийх явдлыг бид хялбар болголоо гэж төсөөлцгөөе. Ингэж чадсанаар бид удалгүй эдийн засгийн өсөлтийг бий болгох, нийгмийн зүйтогтолжсон шинэчлэлийг тэтгэх ёс журам болон санаачилгыг бүтээх болно. Хүмүүс жижиг бизнес эхэлцгээж, бизнес хэрхэн явуулдагт суралцаж, зөвхөн санхүүгийн ашиг үр өгөөжтэй болоод зогсохгүй мөн өөртөө-асар их итгэлтэй болж хөгжиж дэвжих болно. Өөртөө илүү их итгэлтэй нийгэм захиргаадалтын бүтэц^[4] болон төр засгийн үйлдвэрлэл зэргийг өөрчилж шинэчлэх зэрэг институтцийн хэмжээний том асуудлыг давж гарах илүү их боломжтой болдог.

Тиймээс бид нийт төрийн инсититүцүүдийг макро төвшинд өөрчилж шинэчлэхээр оролдохоос ажлаа эхлэх хэрэггүй. Бид нийтийн институтцийн дотоод бүтцээр^[5] дамжин өрнөх зүйтогтолжсон өөрчлөлтийг өдөөх санаачилгыг суллаж тавих замаар л ажлаа эхлэх хэрэгтэй.^[6]

Ажиллаж буй өмчийн эрх

Перү дэх өмчийн эрх

Перү дэх өмчийн эрхийн шинэчлэлийн хамгийн сонирхолтой жишээг 1990-ээд оны эхээр эдийн засагч Хернандо де Сото голчлон өдөөн эхлүүлжээ. Де Сото Перүгийн захиргаалтын бүтэц болон авилгын үр дүнд шинэ бизнес бүртгүүлэхэд бараг жил шаардагдах боломжтой гэж гомдоллож байв. Үүнтэй адилаар өмч өмчлөх явдал хэцүү байжээ. Үр дүн нь жижиг хэмжээтэй бизнес эрхэлдэг ажил хэрэгч хүмүүс сая саяараа өөрийн пүүс, жижиг бизнес эсвэл гэр орноо хууль бус байдлаар өмчилдөг

4 *bureaucracy*

5 *institutional fabric*

6 Энэ санааны талаар мэргэжлийн гүн мэдлэгт нь Адам Смит Интернейшнлийн Петер, Ёнг, Стефен Ж. Мэсти нарт талархая. -БАТЛЕР

байсан ажээ. Энэ байдал тэднийг аж ахуйгаа өргөжүүлэх гэж зээл авахыг хэцүү болгосон. Тэр хүмүүс гэр орноо эсвэл бизнесээ зарах ч боломжгүй байв. Тэд өмч эсвэл бизнесийнхээ маргааныг шүүхээр шийдүүлж чаддаггүй байжээ.

Үнэндээ Перүд хоёр эдийн засаг байсны нэг нь хуулийн хүрээнд байж хуульзүйн дагуухь байдал^[7] болон хуульзүйн хамгаалалтын эдийн засгийн бүх ашиг тусыг хүртдэг байсан бол ядууралд гинжлэгдсэн сая сая ажил хэрэгч хүмүүсээс бүрддэг нөгөө нэг нь тэдний гэр орон, бизнес нь хуульзүйн хүрээнд оршдоггүй учраас ядуурлаас гарч чадсангүй. Төр засаг хуулийн гаднахь жижиг бизнест хүрч очих эсвэл татвар цуглуулах боломжгүй байсан учраас орлогоо алдав. Хуульзүйн хамгаалалт байхгүй тул тэдгээр ажил хэрэгч хүмүүсийг эрүүгийн хэрэгтнүүд болон коммунист Гэрэлтэх Замын гуеррилла буюу партизан^[8]ууд хялбар мөлжиж ашигласаар иржээ.

Де Сото болон бусад хүмүүсийн хэрэглэсэн шийдэл нь шинэ бизнесийг бүртгэхэд оролцдог захиргаалалтын зохицуулалт буюу дүрэм журам, бизнесээ эрхлэхэд авах хэрэгтэй зөвшөөрөл, лицензийн дийлэнхийг нь устгах явдал байсан. Мөн Перүгийн саяас илүү гэр бүл анх удаагаа газрын эрхээ хүлээн зөвшөөрүүлж авсан, газрын тэрхүү шинэчлэлийг мөн хийжээ. Үр дүнд нь нэгэнт өмчлөгч нар нь өргөжин тэлэх гэж зээл авах, өмч худалдан авах зарах боломжтой болсон тул жижиг бизнесийн үр өгөөж өсжээ. Хүмүүс хөрөнгөтэй болж, хадгаламж буюу хадгалж хураах зүйлтэй болсноор орон сууцны байдал сайжирч, эцэг эхчүүд нь хүүхдүүдийнхээ боловсролд илүү ихийг зарцуулж эхэлсэн байдаг.

Энэхүү шинэчлэл шүүмжлэлгүйгээр өрнөсөнгүй. Зарим хүмүүс газрын эрх буюу газар өмчлөх эрх^[9] түүгээр нь хэн юуг албан бусаар “өмчилж” буйг тогтооход хэцүү байсан учраас

7 *legitimacy-легитимность*

8 *Shining Path guerrillas-партизаны тактик хэрэглэж, харгис хэрцгий аллага үйлддэг; Маоизмд автсан, Перүгийн хувьсгалч байгууллага*

9 *land titling*

шударга бус байсан гэж батлан өгүүлж байлаа. Бусад нь газрын эрх эзэмших явдлаас ядуу, бага хэмжээтэй газартай хүмүүсээсээ илүүтэй том хэмжээний газартай кваттерүүд буюу хууль бус газрын эзэд^[10] л ашиг тус хүртсэн; энэхүү эрх эзэмших явдал хамгийн ядуу фермерүүдийн амьдрал хамаардаг байсан нийтийн газрыг ч мөн идсэн; эсвэл эрх эзэмших явдал хэдий хууль бус байсан ч жинхэнээсээ тэнд сайн ажиллаж байсан гэрээний зохицуулалт^[11]ыг энэ нь муутгаж сулруулсан гэж мэдэгдэж байв. Үлдсэн нь газрын шинэчлэл ‘мөнгөн сум’^[12] буюу илбийн юм шиг шийдэл байж чадсангүй, мөн эдийн засгийн хөгжлийн хамгийн том саад бол хүмүүс соёлоороо хүчин чармайлтаа хазаарладаг байсан тэр хориг саад юм гэж батлан өгүүлцгээж байлаа.

Өмнө нь ямар ч ийм зүйл оршиж байгаагүй байхад сайн-ажилладаг зах зээлийг үүсгэж тогтоох нь хэзээ ч хялбар байдаггүй. Аквариумын загасаар шөл хийх хялбархан ч загасны шөлнөөс аквариум бүтээх амаргүй. Гэлээ гээд Перүгийн шинэчлэлийг хуулбарлах гэж бусад улс оролдсон бөгөөд Де Сото өөрөө Латин Америк болон Африкийн олон улсад зөвлөгөө өгчээ.

Шинэчлэлийг дэмжих

Гэвч сайн ажилладаг өмчийн эрх амин чухал зүйл байх ч гэлээ түүнийг дэмжих бусад шинэчлэл явуулах мөн л мэдээж чухал байдаг. Жишээлбэл зүдэргээтэй дүрэм журам буюу зохицуулалт, захиргаадалтын бүтцээр хялбархан дарж боомилох боломжтой, зээллэгийн болон бичил зээлийн ажилладаг зах зээл ч хэрэгтэй. (Бичил зээллэгийн сонирхолтой жишээ бол Бангладешийн Грамээн Банк^[13] юм. Энэ банк жижиг зээл алслагдмал газрын

10 squatters-хаягдсан эсвэл эзэнгүй газарт дураараа сууж, байшин барьсан хууль бус газрын эзэд

11 tenure arrangements

12 silver bullet-нарийн төвөгтэй асуудлын энгийн, үл мэдэгдэм илбийн юм шиг шийдэл.

13 Grameen Bank-Энэ банкйг Бангладешийн Читтагонгийн Их Сургуулийн Профессер Мухаммад Юнүсийн 1976 онд хийсэн банкны үйлчилгээг

бизнест олгодог – энэ зээллэгт нь газаргүй эмэгтэй ажил хэрэгч хүн зөөврийн үүрэн утас ашиглаж төлбөртэй утасны үйлчилгээ ажиллуулах боломжтой зээл ч ордог.)

Мөн хүмүүс маргаанаа хурдан шуурхай, итгэл төгс шийдвэрлүүлэх боломжтой байхаар тийм *итгэл төрөхүйц, үр өгөөжтэй хуульзүйн тогтолцоо* байх хэрэгтэй. Бид хууль тогтоогч нар төрийн хуульзүйн тогтолцоонд тодорхой шинэчлэлийг бодож олж хэрэгжүүлэх хүртэл нь хүлээх ёсгүй. Салангид тусдаа хэргүүдээс бүрдэж бүрэлддэг нийтийн хууль хамаагүй шуурхай байдаг бөгөөд тухайн нутгийн хүмүүсийн шударга ёсны талаархи мэдрэмжтэй таарч нийцсэн, үүсэж тогтсон жишээ хэргийн бүтэц^[14]тэйгээр орон нутгийн хуульзүйн тогтолцоо оршдог байж болох юм. Гэвч бид өмчлөгчдийн бүтэц, хувь хүний хариуцлага, хувьцаа өмчлөгчийн эрх^[15], дампуурлын зохицуулалт^[16] зэрэг *бизнес хэрхэн ажиллах тухай суурь ёс журмыг* тогтоож гаргасан байх шаардлагатай.

Мөн бидэнд шинэ үзэл санаа тархаж түгэх боломж олгохын тулд зах зээл рүү нэвтрэн орох явдлыг хорьж саатуулдаг дүрэм журам буюу зохицуулалтыг бууруулах бас багасгах хэрэгтэй. Жишээлбэл 1950-аад оноос өмнө гадаад ертөнцөөс маш ихээр тусгаарлагдмал байсан Непалын эрх баригчид хүмүүс түүнийг нь хувийн компани удирдан авч явах болно гэсэн үзэл санаанаас айж түгших болно гэсэн үндэслэлээр газрын утсан харилцааны тогтолцоогоо шууд зарахаас татгалзаж байв. Гэвч тэд шинэ тоглогч нар орж ирэхийг зөвшөөрсөн шинэ лиценз буюу зөвшөөрөл гаргахыг зөвшөөрчээ. Эдгээр шинээр орж ирэгсэд нь маш амжилттай байсан учраас өнөөдөр Балба улс харилцаа

алслагдмал газарт нэвтрүүлэх зээллэг олгох тогтолцоог хэрхэн зохиомжилж гаргах вэ гэсэн ажлаар үүсэж гарчээ. Одоо энэ банк баян улсуудад ч гэсэн ажилладаг болж өргөжжээ.

14 *established precedent*

15 *shareholder rights-*

16 *bankruptcy arrangements*

холбооны атаархмаар сүүлийн үеийн тогтолцоотой болсон байна.

Жижиг бизнес болон зах зээл рүү шинээр орж буй оролцогчид өсөж томрон, ажлын байр бүтээж, хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлэн, хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулж байгаа, мөн илүү олон хүн орлого болон эд баялаг бүтээх эрх чөлөөний асар их бололцоог хүмүүс ухаж ойлгох болсон тухай илүү олон жишээ бий. Эрх чөлөөг тэтгэдэг дэмжлэг илүү ихээр цугларч бөөгнөрөх тусам радикал буюу хурц ширүүн ч эцсийн эцэст албадлагын шийдлийг улам цөөн хүн хүсэцгээх болно.

Хөдөө аж ахуйн шинэчлэл

Ажиллаж буй өмчийн эрхийн хүч чадлын жишээ бол Зөвлөлт Орос, Хятад, Вьетнам дахь хөдөө аж ахуйн шинэчлэл юм. Эдгээр улсын коммунист төр засаг нь фермийн хамтралын өмчлөл^[17]д үндэслэсэн газар болон хөдөө аж ахуйн салбар байгуулсан. Эдгээр хамтрал газар ашиглах болон газар дээр ажиллах эрхийг хянадаг байсан бөгөөд тэндээ эгалитарич хуваарилалтын тогтолцоог тулгаж хэрэглэжээ. Тэр нь жинхэнэ сүйрэл болов. Тэр хамтралууд нь маш том хэмжээтэй, хөшүүн удаан, захиргаадалтын шинжтэй байлаа. Хүчин чармайлтынхаа үр шимийг өөр олон хүнтэй хувь хүмүүс хуваалцах болсон учраас тэдэнд илүү шаргуу, эсвэл илүү үр бүтээлтэй ажиллах санаачилга бага байсан.

Хэдийгээр хамтралын өмчлөлийн зарчмаасаа ухрах дургүй байсан ч Хятад 1970-аад оны сүүлээр энэхүү Зөвлөлтийн гамшиг дагуулсан загварыг задалж эвдэв. Гэр бүлүүд газрын тодорхой хэсэгт ажилладаг ‘өрхийн хариуцлагын тогтолцоо’^[18]-г үүний оронд нэвтрүүллээ. Энэ явдал хүч хөдөлмөр болон шан урамшууллын хоорондохь холбоосыг сэргээв. Хятадын хөдөө аж ахуй цэцэглэж эхэлсэн. Фермийн буюу хөдөө аж ахуйн салбарын гарц буюу бүтээмж 1980-аад онд хурдтай өсөж, үр тариа нь

17 communal ownership

18 household responsibility system

жилд бараг 5 хувиар, хөвөн жилийн 8 хувиар, тосны ургамал 14 хувиар өсөж байжээ.^[19]

Гэвч энэхүү эхэн үеийн хөгжил дэвшил удаан үргэлжилсэнгүй. Уг тогтолцоо бас л гажигтай байсаар байв. Газрын чанарын ялгааг тэнцвэржүүлнэ гэж найдан засаг захиргаа гэр бүлүүдэд нэг том газрын хэсгийг өгөхөөс илүүтэй олон жижиг газрын энд тэндхийн хэсгийг өгсөн байдаг. Гэр бүл нэг бүрийн хүчин чармайлт тав эсвэл зургаан тариалангийн талбайд тархсан байгаа явдал илүү сайн арга зам ажилдаа нэвтрүүлэх аргагүй болгожээ. Тарианы талбайн хоорондох зам тариалах бүс нутгийн ихээхэн хэсгийг эзэлж байлаа. Хуваарилалтын энэ тогтолцоонд гэр бүлүүдийн бүтээлч байдлыг тооцож үзсэнгүй.

Тиймээс газар өмчлөх техникийн-чанартай өмчлөл^[20]ийг өөрчлөлгүй хэвээр үлдээгээд газар-ашиглах эрхийн тогтолцоог нэвтрүүлжээ – өрхүүдэд газар дээр ажиллах, ургацын нь авах, түүнээсээ орлого олох, мөн эрхээ бусдад дамжуулж өгөх удаан хугацааны эрх өгчээ.

Дахиад хэлэхэд энэ тогтолцоо чөлөөт-зах зээл эсвэл өмчийн эрхийн үзэл санаанаас дэндүү хол байв. Төрийн худалдан авалт, үнэ тогтмол барих тогтолцоо фермерүүдийн өөрөө шийдвэр гаргах боломжийг хорьж, өөрийн хөдөлмөрийн бүх үр шимээ таашаан эдлэх явдлыг нь хязгаарладаг. Газрын бодит зах зээлгүйгээр жижиг тариалангийн талбай [үр ашиг-муутай байхаар] хэт жижгэрсэн байв. Гэвч аажмаар газрын хэрэглээний зах зээл маягийн юм үүсэж гарчээ.

Хойд Гуйжоу дахь Мейтан^[21] гүнлэгт жишээлбэл тосгоны иргэд болон албан тушаалтнууд хорин жилийн хугацаатай газар ашиглах гэрээг байгуулсан нь гэр бүл өрхүүдэд удаан хугацааны төлөвлөгөө гаргах боломж олгож тус болжээ. Фермерүүдэд

19 Илүү дэлгэрэнгүйг дараахь бүтээлээс үзнэ үү: Wolfgang Kasper, 'The Sichuan experiment', *Australian Journal of Chinese Affairs*, 7, February 1981, pp. 163–72.-БАТЛЕР

20 technical ownership

21 Meitan in northern Guizhou

эзэмшил газр^[22]аа өв залгамжлуулах, солилцох, газрын хэсгүүд^[23]ээ нийлүүлэх эрх мэдэл өгөв. Мөн үр тариа тариагүй атар газар ашиглах санаачилга ч үүнд багтжээ. Үр дүнд нь газар тариаланд улам л их газар ашиглах болж, газрын чанар гэр бүл, өрхүүд тэдгээрийг илүү сайн арчлах болсон, орчин үеийн тоног төхөөрөмж хэрэглэдэг болсон зэргээс болж сайжирсан байна. 1995 онд төв засгийн газар бусад тосгодыг Мейтаны жишээг дагахыг уриалсан бөгөөд газрын өмчийн-эрхийн тогтолцоотой адилхан зүйл үүсэж хөгжиж, тархаж эхэлжээ.

Усны эрх

Ус бол төр засгаас илүүтэй өмчийн эрхээр илүү сайн хуваарилж түгээх боломжтой ховор нөөц баялаг юм. Америкийн Нэгдсэн Улсын хуурай өрнөд хэсэгт нэгэнтээ ган гачиг их болдог байв – энэ нь ус байхгүй учраас биш харин усыг хуваарилж түгээх маш их зохицуулалттай тогтолцоо оршиж байсан учраас тохиолдож байжээ. Тухайн голын эхэнд бусдаас түрүүнд ус татаж авч буй хүн жишээлбэл сүүлд нь ус авч буй бүх хүмүүсээс давуу эрхтэй байлаа; гэвч энэхүү эрхээ хадгалж үлдэх гэж ус бүр тэдэнд бараг хэрэгцээгүй байхад ч гэсэн усаа өөр рүүгээ урсгаж авсаар байдаг байжээ.

1990-ээд оны эхээр Монтана, Аризона зэрэг муж-улсууд хүмүүсийг усны эрхээ арилжиж наймаалалцах боломж олгож эхэлжээ. Энэ зах зээлийг саатуулж хорьж буй олон дүрэм журам зохицуулалт байсаар байгаа ч гэсэн энэ явдал ус хамгийн их үнэ цэнэтэй хэрэглээ рүүгээ очих байдлыг бататгажээ. Нэгэнт усны нөөц баялгийн эрхийг зарах, худалдаж авах боломжтой болсноос хойш хязгаарын ашигтай буюу маш бага ашигтай хэрэглэгчид^[24] (хэн бага ус ашиглах боломжтой эсвэл ус дахин ашиглах боломжтой) одоо цэнгэг ус олборлох эрхээ илүү

22 *tenures*

23 *land parcels*

24 *marginal users*

яаралтай хэрэгцээтэй хэн нэгэнд дамжуулах боломжтой болжээ. Энэхүү системийн ашиг тус бол усны эрхийн зах зээл одоо Америкийн Нэгдсэн Улсын өрнөд хэсэг даяар тархсан явдал юм.

Хувьчлалын механик явц

Төрөөс-хянадаг үйлдвэрлэл хэрэглэгчид ямар ч сонголт өгдөггүй, голдуу л монополь эрхтэй байдаг. Тиймээс тэдгээр үйлдвэрлэл муу чанартай бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнийхээ төлөө илүү их мөнгө нэхэж чадна, бас нэхдэг. Бүр хэрэв тэдгээр үйлдвэрлэл удирдагчдынхаа ойрхон оршиж, тэдгээрийг ямар нэг агентлаг яам удирдаж чиглүүлдэг байсан ч гэсэн эдгээр үйлдвэрлэлийг эрх барьж буй элитүүд эсвэл тэдний найз нөхөд л ихэвчлэн хянасаар байдаг.

Жишээлбэл Ираны боняд буюу сан^[25] бол Ираны эдийн засгийн тавны нэгийг, барилгын салбар, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, усан тээврийг хянадаг буяны гэгдэх итгэмжлэгдсэн сан юм. Ираны Шах анх үүсгэн байгуулсан тэдгээр байгууллагыг жинхэнээсээ буяны сан биш харин тухайн засаг захиргааны ивээл болон ашиг тусад зориулсан машин болсон гэж өргөнөөр шүүмжилцгээдэг. Гэлээ гээд 1979 оны хувьсгалын дараагаар гарч ирсэн төр засаг тэднийг бусдад өгөхөд хэт үр өгөөжтэй зүйл гэдгийг мэджээ. Тиймээс тэд татварын тусгай хөнгөлөлт, төр засгийн татаас авч одоо ч оршсоор байдаг: үнэндээ хураан авсан хувийн өмчийг тэдгээр санд нэмсэн байна. Тэдгээр нь ядуусын ашиг тусын төлөө оршдог гэж гэсэн утгатай ч тэдний гол эзэмшигч бол төр засаг, засаг захиргаанд байдаг хүмүүс юм.

Төр-ажиллуулдаг бизнесүүдийг хувьчлахад хувийн өмч өмчлөх явдлын динамик нөлөө гарч, мөн захиргаадальтын монополь салбарт өрсөлдөөн нэвтэрч, бас авилгалыг арилжааны нээлттэй байдлаар солих явдал гарах ёстой. Энэ явдал эдгээр үйлдвэрлэлийн хөрөнгийг олон нийт рүү буцан очиход дэм болох боломжтой. Гэвч энэ бүгдэд хүрэхэд алсын хараа, тэсвэр

25 *bonyads-Перс хэлээр сан гэсэн утгатай*

тэвчээр, нарийн тодорхой нягт байдлаар бодлогоо томьёолж гаргах явдал хэрэг болно.

Хувьчлал явуулах ямар нэг цор ганц механизм гэж байдаггүй. Төр-ажиллуулдаг бизнесийг хувьчлах явдал бол улстөрийн ч эдийн засгийн ч хэрэг явдал байдаг. Үйлдвэрлэл нэг бүр хоорондоо ондоо, хувьчлахад нь өөр өөр хандлага шаардлагатай. Ондоо ондоо төрлийн, янз бүрийн хэмжээтэй үйлдвэрлэл байдаг бөгөөд өөр өөр ашиг сонирхлын бүлэг шинэчлэлийг нь зогсооно бас саатуулна. Тиймээс л нийт хүн амд нөлөөтэй, ус эсвэл цахилгаан эрчим хүч зэрэг хотын үйлчилгээ^[26]нд зориулан хэрэгжүүлэх арга барил нь харьцангуй цөөхөн хүнд нөлөөлдөг эд юм үйлдвэрлэдэг компанид зориулснаас нилээд ондоо байдаг.

Жижиг хэмжээтэй аж ахуйн тохиолдолд түүнийг арилжааны оператор, ялангуяа шинэ санаа, хөрөнгөтэй байх магадлалтай гаднаас ирсэн нэгэнд зарах нь илүү зохимжтой байж болох юм. Гэвч төрийн компанийг гадаадуудад зарах нь маргаантай зүйл болох ч боломжтой.

Том аж ахуйн нэгжийн хувьд өмчлөлийг нь хувьцааг нь зарах замаар олон нийтийн дунд тараах нь хэрэгтэй зүйл байх боломжтой байдаг. Гэвч энэ ажилд хувьцааны бүдүүн бараг зах зээл л оршдог, мөн ихэнхи хүмүүс нь хувьцаа гэж юу болохыг мэдэхгүй байгаа учраас боловсрол олгох өргөн хүрээний арга хэмжээ авах шаардлага гарч болох юм. Зөвлөлт дэглэм нуран унасны дараа Орос улс олон нийтэд төрийн аж ахуйн нэгжийн хувьцааг бүхэлд нь өгөн, үүнийгээ “хувьчлалын эрхийн бичиг”-ээр хэрэгжүүлсэн. Гэвч олон хүмүүс эдгээр хувьцаагаа хямдхан зарсан нь эцэст нь бизнесийн “олигархи” гэсэн шинэ элит ангийнхны гарт хяналт нь шилжсэнээр төгссөн билээ.

Зах зээлийн зарчмыг таниулж нэвтрүүлэх

Хувьчлалын үйл явцын нэг хэсэг болгож монополь байдлыг задлах явдал амин чухал байдаг. Төр засаг бизнесийг монополь

²⁶ utilities-опос. коммунальные услуги

эрх дархын хамтаар зарвал илүү их орлого болох болно гэж боддог бол энэхүү монополь эрх дарх нийт өргөн олны хувьд муу нөлөөтэй хэвээр үлдэх болно. Хэрэв төрийн монополь үйлдвэрлэлийг хоорондоо өрсөлддөг элемент болгож задалбал урт хугацаандаа төр засаг болон хүмүүс хоёулаа ашиг тус хүртэнэ. Тэр шинэ аж ахуйн нэгжүүд нь түүний өмнөх монополь байгууллагаа бодвол илүү бат суурьтай, динамик шинжтэй, шинэчлэгдэмхий байх болно.

Гватемалын утсан харилцааны тогтолцоог хувьчилсан 1996 оны хувьчлалаас энэхүү үйл явцад өрсөлдөөн чухал болох нь харагддаг. Тэнд харилцаа холбооны зах зээл харилцаа холбооны монополь эрх мэдлийг хувьчлахын өмнө өрсөлдөөнд нээлттэй болчихсон байжээ. Агаарын долгионыг мөн л хувьчлан шинэ харилцаа холбооны компаниуд түүнийг хялбархан худалдаж авах, хэрэглэх боломжтой, цахилгаансоронзон спектрийн өмчийн эрхийг үр ашигтай бүтээжээ. Үр дүн нь өрсөлдөөн маш их өргөн дэлгэр болж, илүү олон сонголт гарч ирж, хамрах сүлжээ илүү өргөн болсон. Үнэ Латин Америкдаа хамгийн бага болж буурсан бөгөөд үүрэн утасны хэрэглэгчдийн тоо арав гаруй жилд хэдэн зуу дахин нэмэгджээ.^[27]

Зөв хэрэгжүүлэх

Шинэчлэгчдэд хувьчлалын зөв бодлого болон механизмыг сонгож авахад туслах боломжтой олон-улсын туршлага болон нарийн мэдлэг зөндөө бий.

Үүний гол зүйл бол энэхүү үйл явц бүрэн нээлттэй, мөн түүнд олон нийт оролцох хэрэгтэй байдаг явдал юм. Үүнээс ондоо байвал энэхүү шинэчлэлийг нийт-олноороо хүлээн зөвшөөрөхгүй. Жишээлбэл Африк дахь зарим нэг төр засаг ус, банкны үйлчилгээ зэрэг хотын хангамжийн үйлдвэрлэл^[28]ийг

27 Wayne A. Leighton, 'Getting privatisation right: a case study', *Institute of Economic Affairs blog*, London, 2013 гэсэн бүтээлийг үзнэ үү.-БАТЛЕП

28 *utility industries*

гадаадын хөрөнгө оруулагчдыг урьж ирэн хувьчилсан боловч орон нутгийн хүн амдаа өмчлөх ямар ч боломж олгосонгүй. Энэ явдал бол улстөрийн хувьд гэнэн байгаад зогсохгүй бүгдтэй ижилхэн харьцана гэсэн чөлөөт нийгмийн зарчмын эсрэг зүйл юм.

Цаашилбал хэрэв өмчлөлийг өргөн тархаалгүй илүү хязгаарлагдмал явцуу байлгавал хувьчилсан үйлдвэрлэл төр засагт байгаа хүмүүсийн амин найзуудын бизнесийн хяналтад буцаж орох аюул хэвээр байдаг. Энэ явдал хувьчлалын үзэл санааг улам бүр хордуулж муутгах бөгөөд энэ нь төр засгийн эзэмшдэг эрхэлдэг бусад салбарт зах зээлийн зарчим нэвтрүүлэх явдлыг хойшлуулж арагш татах болно. Олон нийт шинэ бүтэц авилгажсан элитүүдэд бус харин хэрэглэгчдэд л үйлчлэх болно гэдэгт бат итгэлтэй болсон байх хэрэгтэй. Аль болох илүү их өрсөлдөөн нэвтрүүлэх нь сайн зүйл гэдэг нь ойлгомжтой зүйл билээ.

Төр засгийн оролцоогүй нийгмийн үйлчилгээ^[29]

Олон нийтийн үйлчилгээг зөвхөн төр засаг үзүүлэх боломжтой гэсэн хэвшмэл санаа бодол^[30] бий – ялангуяа “хүмүүн”-ий эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйлчилгээг төр л үзүүлэх боломжтой гэнэ.

Зарим хүмүүс иймэрхүү амин хэрэгцээтэй үйлчилгээг зах зээлд үлдээх аргагүй маш чухал зүйл гэж хэлдэг. Үнэндээ тэдгээр нь засгийн газарт үлдээхэд хэт чухал зүйл юм. Үйлчилгээ үзүүлэгч хүмүүс татвараар санхүүжүүлдэг байхад хоорондоо өрсөлддөг хувийн нийлүүлэгчид хийх ёстой байдаг шигээр амьдрахын тулд хэрэглэгчдээ бөөцийлж тал засах хэрэг тэдэнд байдаггүй. Төсвөө улам их болгох тэдний арга зам улстөрчдийг лоббидох эсвэл тэдний шаардлагыг биелүүлэхгүй бол үйлчилгээгээ тасалдуулна

29 Human services-programs or facilities for meeting basic health, welfare, and other needs of a society or group, as of the poor, sick, or elderly

30 presumption

гэж айлгаж сүрдүүлэх л явдал байдаг. Тэдний анхаарал тавьдаг зүйл бол олон нийт биш харин төр засаг юм.

Хувийн пүүсүүд голдуу л төр засгийн эрхэлдэг үйлчилгээнд тохиолддоогоос хамаагүй илүү их өрсөлдөөн дунд оршдог. Төр засгийн үйлчилгээтэй өрсөлдөж буй үйлчилгээ голдуу хууль бус байдаг. Тийм учраас төр салбарын нийлүүлэгчид үйлчлүүлэгчдэд нь өөр очих газар байдаггүй учраас шинэчлэл хийх эсвэл бүр үйлчилгээгээ өнөө цагт нийцүүлэх ч шаардлага байхгүй.

Гэвч хэдий төр засаг олон нийтийн үйлчилгээг өөрсдөө явуулахыг хүсэж байсан ч гэсэн хүмүүс үргэлж төр монополь байдлыг нь тойрч гарах арга зам олчихсон байдаг. Дэлхийн даяар төр засгийн бус, албан бус нийлүүлэгчид эдгээр чухал үйлчилгээг төр засгаас илүү сайн үзүүлдэг жишээ дэндүү их бий.

Төр засгийн оролцоогүй боловсрол

Жишээ болгож хэдүүлээ боловсролыг авч үзэцгээе. Олон хүн хувийн боловсрол бол зөвхөн баячуудад зориулсан зүйл гэж төсөөлцгөөдөг. Гэвч Профессор Жэймс Тоолийгийн Энэтхэг, Гана, Нигер, Кенид явуулсан хоёр-жилийн судалгаанаас эсрэг зүйл гарчээ. Эдгээр улсын хамгийн ядуу хэсэгт сургуулийн насны ихэнхи хүүхэд төрийн бус сургуульд явцгааж байв. Хайдерабад, Аккра, Лагосын хамгийн ядуу хэсэгт сургуулийн зөвхөн гурваны нэг эсвэл түүнээс цөөн нь улсынх байсан байна. Сургуулийн хүүхдүүдийн гурваны хоёр эсвэл түүнээс олон нь төр засгаас заримыг хүлээн зөвшөөрөөгүй хууль бус буюу албан бус хувийн сургуульд явж байжээ. Хувийн өмчлөгч нар эдгээр төрийн-бус сургуулиудыг эрхэлж явуулцгаана. Маш цөөхөн нь сайн санааны буюу буяны үйлсийн дэмжлэг авдаг, төрийн санхүүжилт ерөөсөө авдаггүй байв – маш бага хэмжээтэй байдаг эцэг эхчүүдийн төлбөр л голдуу тэдгээрийн цорын ганц орлого нь байсан.^[31]

31 James Tooley, *The Beautiful Tree: A Personal Journey into How the World's Poorest People Are Educating Themselves*, Cato Institute, Washington, DC, 2009. гэсэн бүтээлийг үзнэ үү-БАТЛЕР

Тэгээд бүр Түүлий хувийн сургуульд сурлагын амжилт нь мэдэгдэхүйц сайн байсныг олж мэджээ. Хэдийгээр хувийн салбарын багшийн цалингийн зардал засгийн газрынхаас 25-50 хувиар бага байсан гэсэн бодит байдал байсан ч гэсэн ч Хайдерабадад математикийн дундаж оноо нь улсын буюу төрийн сургуулиас тавны нэг буюу 20% орчмоор өндөр байв. Бусад стандартууд ч гэсэн хувийн сургуульд үүнтэй адил илүү дээр байжээ. Түүлий улсын сургуулийн багш нар ширээнийхээ ард унтацгаадаг гэдгийг олж мэдэв. Багш нар ажилдаа ирэхгүй байх явдал^[32] улсын сургуульд аймшигтай газар авсан байсан. Хувийн сургууль нь самбар, тоглоомын талбай, ширээ сандал, уух ус, жорлонгоор илүү сайн хангагдсан байлаа. (Хувийн сургуулийн 96 эсвэл түүнээс их хувь нь жорлонтой байхад зөвхөн улсын сургуулийн хагас нь л жорлонтой байв.) Сурагч–багшийн харьцаа нь улсын сургуулийнхаас бараг л 50 хувь бага байжээ.

Төр засаг ядуу хэсэгт байгаа хувийн боловсрол олгох явдлын асар их ач холбогдлыг анзаардаггүй бас ойлгодоггүй гэж харагддаг. Хятадын төрийн бүртгэлд Гансу гэж уулархаг мужид зөвхөн 44 хувийн сургууль бүртгэгдсэн байсан ч гэсэн Түүлийгийн судлаачид 696 хувийн сургууль, үүнээс 593 нь хамгийн алслагдмал тосгонд 61 000 хүүхэдтэй байсныг олж гаргажээ. Дийлэнхи олонхийг нь эцэг эх, тосгоны иргэд нь эрхэлж явуулдаг байв. Гансуд жилийн орлого нь дөнгөж \$150 байсан ч гэсэн хувийн сургууль цэцэглэж байлаа. Бүр 750 000 орчим хүн амтай, Сахарын өмнөд хэсгийн Африкийн хамгийн том ядуусын дүүрэг болох Кенийн Кибераас Түүлий 12 000 сурагчтай 76 хувийн сургууль олжээ.

Бүр дэлхийн хамгийн ядуу зарим нэг газарт ч гэсэн хувийн санаачилга төрийг бодвол илүү сайн стандарттай боловсрол олгох боломжтой, бас боловсрол олгодог гэдэг нь илэрхий байна. Энэ сургуулийн төлбөр ядуу хүмүүс төлж чадахуйц боломжийн бага байсан. Боловсрол олгох явдалд ерөөсөө төр засгийн хэрэгцээ шаардлага байхгүй гэдэг нь эндээс харагддаг.

32 *absenteeism*

Төрөөс-эрхлэн явуулдаг сургуулийн өргөн хүрээний хөтөлбөртэй голдуу байдаг баян улсуудад боловсрол олгох явдалд зарим нэг өрсөлдөөн нэвтрүүлэх, эцэг эхийн сонголт оруулах сонирхолтой байдагт гайхах зүйлгүй. 1991 онд Швед сургууль эрхлэх үндсэн суурь зардлыг үргэлжлүүлэн төлөх нөхцөлтэй эдгээр санхүүжилтийг элсүүлсэн сурагчдынхаа тоонд үндэслэж олж авахын тулд өөрийн гэсэн сургуулиудыг хувийн ашгийн бус болон ашгийн төлөөхь бүлгүүд үүсгэн байгуулахад хүргэсэн, шинэ тогтолцоо нэвтрүүлжээ. Бүр анхнаасаа энэхүү шинэчлэлийг эсэргүүцэж байсан, багш нарын эвлэл^[33] зэрэг шүүмжлэгч нар ч одоо үүнийг нь дэмждэг болсон нь үүнээс болж хэдэн мянган шинэ сургууль үүсгэн байгуулж, ялангуяа хамгийн хол хэцүү, ядуу дүүргүүдэд үүсгэн байгуулж үр ашигтай байдал, шинэчлэл, чанар нь нэмэгдсэн учраас тэр ажээ. Одоо бусад улс орон үүнтэй адилхан загвар нэвтрүүлж байна.

Төр засгийн оролцоогүй эрүүлмэндийн үйлчилгээ

Эрүүлмэндийн үйлчилгээ бол олон улс оронд төр засгийн хяналт давамгайлдаг, голдуу хуульзүйн давуу эрх, татвараас-санхүүжүүлдэг татаас, зохицуулалт буюу дүрэм журмаар өрсөлдөөнөөс хамгаалагдсан өөр нэг амин чухал үйлчилгээ юм. Дахиад хэлэхэд энэ байдлаас болж төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд өвчтөндөө илүү сайн үйлчилгээ үзүүлэх гэхээсээ илүүтэй аль болох их мөнгө, илүү их хөнгөлөлт буюу давуу эрх төр засгаас авахад л анхаарлаа хандуулдаг.

Америкийн Нэгдсэн Улсыг “чөлөөт зах зээлийн” гэх эрүүлмэндийн тогтолцооных нь асар их зардлаас нь болж шүүмжилцгээдэг. Энэ үйлчилгээ мэдээжээр зардал ихтэй; гэвч үнэндээ [АНУ-ын] энэ тогтолцоо дэлхийн дээрх хамгийн их дүрэм журамжиж зохицуулалтаар боомилогдсон тогтолцооны нэг бөгөөд энэ улсад эрүүлмэндийн үйлчилгээнд зарцуулж буй нэг хүнд ногдох төр засгийн зардал нь дэлхийд хамгийн их

33 teachers' unions

зардалтай (Норвеги, Лүксенбүргийн ард)-гаараа гуравт ордог. Татвар болон зохицуулалтын дүрэм журмаар эрүүлмэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэх явдл^[34]ыг ажлын байртай холбосон байдаг – энэ явдал хүмүүсийг ажлаасаа гарч ажилгүй байх хооронд даатгалгүй үлдээдэг. Үүний хажуугаар ажилчид гарах зардал нь өөрсдөөс нь гэхээсээ илүүтэй ажил олгогчид цаанаасаа оногдсон байдаг учраас жинхэнээсээ бол хэрэгцээгүй (эмч нар өдөөж турхирсан) шинжилгээ, үйлчилгээ авахыг хүсэцгээдэг. Зохицуулалт буюу дүрэм журмаар мөн л эрүүлмэндийн даатгалын гэрээнд юуг оруулах ёстойг, бас хэрхэн үүнийгээ зарцуулах боломжтой болохыг шууд зааж тушаадаг (жишээлбэл даатгал олгогч нарыг зөвхөн өөрийн муж улсдаа л ажиллахаар хязгаарлаж, ингэснээр ашигтай байхын тулд хэмжээгээ томруулах^[35] боломжоо баттай эдлэх аргагүй болгодог). Үүнтэй адилаар эмч нар ихэвчлэн өөрсдөдөө зориулан зохиомжилсон, энэ эмч гэсэн мэргэжилд эмчийн орон тоог нийлүүлэлтийг хязгаарлах боломж, шан урамшууллаа их байлгах боломж тус тус олгодог, лицензжүүлэх шалгуураар эрүүлмэндийн үйлчилгээ үзүүлэх эмчлэх ажлыг захирч хянадаг ажээ. АНУ-ын эрүүлмэндийн үйлчилгээний зардалд энэ бүх (бас үүнээс олон) зохицуулалт, дүрэм журам зардал л нэмдэг.

Үүнээс ялгаатай нь АНУ-ыг бодвол жинхэнээсээ баян жижиг улс болох Сингапур нь төрөөс-санхүүжүүлдэг эрүүлмэндийн хөтөлбөртөө зарцуулдаг Америкийн нэг хүнд ногдох зардлын зургааны нэг буюу 16 гаруй хувьтай тэнцэх л зардал үүнд гаргадаг ажээ. Тэнд гэр бүл буюу өрх ирээдүйн эрүүлмэндийн үйлчилгээ, тэтгэвэр, орон сууцны зардал^[36]даа орлогынхоо тавны нэгийг буюу 20 хувиа хадгалж хураахыг л зөвхөн шаарддаг (хэдийгээр эмнэлгийн асар зардалтай хэрэгцээг нь төрөөс-санхүүжүүлдэг хөтөлбөр байдаг ч гэсэн). Хүмүүс өөрийн мөнгөө өөрийн эрүүлмэндийн үйлчилгээний дансандаа хадгалдаг гэсэн бодит

34 *supply of health insurance*

35 *economies of scale*

36 *housing costs*

байдал тэднийг үүгээрээ илүү сайн үнэ цэнэтэй зүйл авамтгай болгож, харин хувийн эмч болон эмнэлэг үйлчлүүлэгчээ болгох гэж тэдний төлөө хоорондоо өрсөлдөхөд хүргэжээ.

Швейцарт төрөөс эрхлэн явуулдаг даатгал гэж байдаггүй: хүмүүс даатгал болон эмнэлгийн үйлчилгээг хувийн нийлүүлэгч буюу үйлчилгээ үзүүлэгчдээс худалдаж авдаг. Татаасаа тэр үйлчилгээ үзүүлэгчдэд биш харин өөрсдөө эрүүлмэндийн суурь үйлчилгээг төлөх чадваргүй эмчлүүлэгчид л өгөхөөр тэндхийн төр засгийн үүрэг хязгаарлагдана. Тиймээс дахиад л Америктай адилгүйгээр [баян ядуу] Швейцарчууд эрүүлмэндийн үйлчилгээндээ зарцуулж буй мөнгөнийхөө төлөө илүү их үнэ цэнэтэй зүйл авах хандлагатай байдаг. Олон Европчууд Швейцарын эрүүлмэндийн нилээд сайн чөлөөт зах зээлийн тогтолцоог дэлхийн хамгийн сайн эрүүлмэндийн тогтолцоо гэж үзэцгээдэг ажээ.

Төр засгийн оролцоогүй халамжийн үйлчилгээ

Ядуу хүнд зориулсан халамжийн хамгийн сайн хэлбэр бол цалинтай ажил билээ. Гэвч төрөөс-эрхлэн явуулдаг халамжийн тогтолцоо ажлын байрыг устгадаг. Европын ихэнхид 'нийгмийн даатгал'^[37]-ыг ажил хийдэг хүмүүст тусгай татвар оногдуулах замаар санхүүжүүлдэг. Энэ нь ажил оллогчийн зардлыг өсгөдөг бөгөөд шинэ ажилтан авах явдлыг нь илүү төвөгтэй болгодог. Энэ байдал нь энэ халамжийг цаашид санхүүжүүлэхийн тулд татвар нэмэхэд, ингэснээр улам л цөөн хүн ажилтай болоход хүргэж, илүү олон хүн ажилгүйдлийн тэтгэмжээс сорно гэсэн үг юм. Энэ бол уруудаж буй спирал буюу тойрог зам билээ.

Швед хорьдугаар зууны дунд хүртэл эрх чөлөөтэй, багатаатвартай, хөгжиж цэцэглэсэн улс байлаа. Дараагаар нь 1970 оноос хойш хорин жилийн дотор энэ улс өргөн хүрээг хамруулсан халамжийн хөтөлбөрөө санхүүжүүлэхийн тулд маш өндөр татвар оногдуулах болсон. (Үнэндээ 1976 онд нэг Швед

37 *social insurance*

зохиолч тэр бүсгүйн төлөх татварын хязгаарын хэмжээ^[38] 102 хувьд хүрлээ гэж гомдоллож байв шүү!) Эдгээр их татвар ажил эрхлэх, аж ахуйн нэгжийн гол саад тогтор болов. Энэ татвар бол 1990 оноос ийм бодлогоосоо эргэж буцах хүртэл гарч байсан, Шведийн хорин жилийн эдийн засгийн бага өсөлтийн гол буруутан юм.

Чөлөөт улсууд илүү баян байх хандлагатай байдаг; баян улс орнуудад тусламж хэрэгтэй хүмүүст үзүүлэх сайн санааны буюу буяны дэмжлэгт илүү их мөнгө зарцууламтгай байх хандлагатай. Энэ байдал бол төр засаг татвараар дамжуулан хүмүүсээс мөнгийг нь авч өөрийн зохиомжилсон халамжийн хөтөлбөртөө зарцуулдаг явдлаас ёс суртахууны хувьд илүү эрүүл зүйл юм – төр засаг өөрийн найз нөхдөдөө ашиг тус хүртээж харин дайснууддаа татвар ногдуулдаг. Жинхэнэ буяны үйлс бол хэн нэгэн бие хүн өөр нэг хүн рүү нь хэн ч албадаагүй байхад юм өгөх явдал билээ.

Төрийн халамжийн хөтөлбөрийн өөр нэг зовлон бол үүнээс нь бусдаас хамааралтай байх соёл бий болдог байдал юм. Данхар бүтэцтэй, нийтийн албаны ажилчид эрхлэн явуулдаг тул төрийн халамж нь жинхэнэ сайн санааны үйл явагддаг шигээр хэрэгцээ шаардлагаа өөрөө үнэлж цэгнэх, хүлээн авагчийн боломжид суурилдаг байхаас илүүтэй зайлшгүй дүрэм журамд үндэслэж ажиллах болдог. Энэ байдал өөрсдөө тэр шалгуурт нь тэнцэхийн төлөө “дүрд орж тоглох”-од хүмүүсийг түлхдэг. Заримдаа ядуу өрхүүд зориудаар илүү их халамж хүртэхийн тулд нөхцөл байдлаа ихээр муутгадаг – энэ явдал бол бидний хүрэхийг зорьж буй зүйлээс тэс өөр зүйл юм. Нэгдсэн Хаан Улс зэрэг хамгийн эртний, хамгийн данхар халамжийн төртэй улсуудад албан тушаалтнууд нь одоо гурван үеэрээ бусдаас хамааралтай амьдарч байгаа үеийнхн^[39]ийг харах болжээ – эх эцэг нь, эмээ өвөө нь өмнө хийдэг байсанчлан хүүхдүүдийнх нь гэр бүлүүд халамжид найдан амьдарч байна.

38 *marginal tax rate*

39 *third-generation dependency*

Хувийн буяны байгууллагын дэмжлэгтэй өөртөө-туслах явдал бол илүү хүмүүнлэг, илүү сэдэлжүүлдэг, илүү үр дүнтэй халамжийн өөр нэг хувилбар юм. НХУ^[40] 1940-өөд оноос өмнө халамжийн төр нь тэр үед үгүй хийсэн, ажилчин-ангийн халамжийн цэцэглэн хөгжиж буй тогтолцоотой байсан. Эдгээр нь гишүүд нь ажилгүйдлийн тэтгэмж, эмнэлгийн даатгал, бүр оршуулгын зардал зэрэг халамж оронд нь хүртэх гэж долоохоног тутмын татвар хураамж төлдөг эв найртай нийгэмлэг байжээ. Эдгээр байгууллага тодорхой мэргэжилд анхаарал голдуу хандуулж ингэснээр тэдгээр ажилчны тусгай хэрэгцээг нь хангадаг байв. Сая сая өрх буюу гэр бүл, ялангуяа ядуу өрх эдгээр байгууллагын аль нэгнийх нь гишүүн болохоо өөрсдөө сонгодог байжээ. Төр засгийн оролцоогүйгээр бүх хүнд зориулж халамж үзүүлэх явдал мэдээжээр биелэх хэрэгжих боломжтой.

Буяны үйлсийн салбарыг дахин амилуулах

Төрийн нарийн-хөгжсөн халамжийн тогтолцоотой улсад амьдардаг хүмүүс хувийн буяны байгууллага болон буяны үйлс^[41] татвараар-санхүүждэг нийгмийн халамж болон тэтгэврийн өгөөмөр байдлыг орлох боломжгүй гэж батлан өгүүлцгээдэг. Мэдээжээр төр засгийн хувьд бусад хүний мөнгөөр “өгөөмөр” байх нь маш хялбар байх бөгөөд одоо төрөөгүй байгаа үеийнхэн л эцэст нь төлөх болно гэдгийг мэдсээр байж гайхалтай сайхан халамж амлах бүх шалтгаан өнөө цагийн улстөрчдөд бий. Энэ байдал бол улстөрчдийг нийгмийн халамжаас хол байлгах хангалттай сайн шалтгаан юм. Гэвч хэрэв төрийн халамж^[42] их бол өрхүүд амьжиргаагаа залгуулах, хувь хүмүүс халамжаар амьдрахаасаа илүүтэй ажил эрж хайх санал санаачилга бага болно – үүнээс гадна хэрэв ажил хийдэг хүмүүс халамжийн ийм тогтолцоог санхүүжүүлэхийн тулд их татвар төлөх ёстой болдог.

40 UK-Урьд нь Нэгдсэн Вант Улс гэдэг байв.

41 private charity and philanthropy

42 state benefits

Хэдийгээр ийм халамж сайн санаагаар эхэлдэг ч гэсэн эцсийн дүндээ хүмүүсээс итгэл найдвар, алсын бодлыг сорон үгүй хийж, бусдаас хамааралтай амьдралд нь тэднийг гинжилдэг.

Эрх чөлөө рүү явахыг хүсэж буй улс орнууд төрийн халамжийн асар данхар тогтолцоогоо илүү жижиг, илүү орон нутгийн байдалтай тогтолцоо болгож задлахаас эхлэх ёстой. Энэ тогтолцоог хувийн дансны ямар нэг төрөл рүү оруулж “хувь хүнжүүлэх”^[43] ч боломжтой. Энэ байдал гэр бүлүүдийг хариуцлагаа ойлгож мэдэхэд нь, мөн тэднийг зарим нэг сарниж тархсан “тогтолцоо”^[44] биш харин жинхэнэ татвар төлөгчид л дэмждэг болохыг ухаж мэдэхэд нь туслах боломжтой ажээ. Энэ байдлаар тухайн тогтолцоог задлах явдал түүнийг нь илүү үр өгөөжтэйгээр хувийн салбарын үйлчилгээ үзүүлэгчид удирдаж залах боломж олгодог.

Үүний жишээ бол Чилийн тэтгэврийн тогтолцоо юм. 1981 онд энэ улс өөрийн бүтэл муутай, шударга бус тэтгэврийн тогтолцоогоо хувийн дансны тогтолцоо болгож задалжээ. Ажилчид тэтгэвэрт гарахдаа зориулж хадгаламж үүсгэх үүрэг хүлээсэн ч тэдний мөнгөн санг удирдаж чиглүүлэх хэд хэдэн хувийн үйлчилгээ үзүүлэгчдийн дундаас өөрсдөө сонгох боломжтой болжээ. Энэхүү тогтолцоо эргээд ажилчдад илүү их ашиг авчирдаг хадгалж хураах хувийн хариуцлагыг нь хөхиүлэн дэмждэг бөгөөд үүнээс хойш энэ тогтолцоог нь хэдэн тивд хэд хэдэн улсад хуулан хэрэглэсэн.

Өөр нэг жишээ бол өөрийн эрүүлмэндийн үйлчилгээ болон бусад хэрэгцээгээ өөрөө хангах явдлыг нь дэмжиж тэтгэн хувь хүмүүс, өрхөд мэдэгдэхүйц хариуцлага оногдуулдаг Сингапурын эрүүлмэндийн хадгаламжийн дансны тогтолцоо (өмнөхийг үзнэ үү) юм. Нэгдсэн Хаант Улсын хуучны эв найртай нийгэмлэг бол мөн л төрийн халамжийг хувь хүний, хувийн дансны тогтолцоо^[45]

43 ‘individuated’

44 diffuse ‘system’

45 personal, private accounts

руу хувааж дахин хялбархаан бүтээх боломжтой өөр нэг загвар юм.

Төрийн дэмжлэгийн ажилладаггүй бүтцийг иймэрхүү байдлаар шинэчлэн өөрчлөхөд хувь хүмүүс ажил хайх, төрийн дэмжлэгт гэхээсээ илүүтэй өөрийн хүч хөдөлмөртөө найдах санаачилга асар их болно. Тэнд хувийн сайн санааны болон буяны үйлс хэрэгтэй байсаар байх ч гэсэн энэ нь илүү удирдаж залахуйц хэмжээ^[46]тэй байх болно. Бидний харсанчлан эрх чөлөө, бага татвар хүмүүст өгөөмөр байх хүсэл болон эд баялаг өгөх сайн арга зам билээ. Энэ санаачилга бол данхар төр, өндөр татварыг устгадаг сэдэл юм.

Даяарчлал, арилжаа худалдаа

Даяарчлалын ач тус

Непал буюу Балба шиг олон улс хэрхэн улам бүр даяарчлагдаж буй зах зээл тэдэнд нөлөөлөх бол гэдэгт ихээхэн санаа зовцгоодог. Гэвч энэхүү зовнилын ихэнхи нь буруу бөгөөд даяарчлал болон арилжаанаас олох эерэг ашиг тус мэдэгдэхүйц их.

Бид бүх дэлхий даяар хүмүүс одоо шууд болон дам байдлаар хоорондоо арилжаа наймаа хийх болсон явдал зах зээлийн үнийн механизмын ач тус гэдгийг мэдэж байгууштай. Бидний өмсөж буй хувцас, иддэг хоол хүнс, гэр, албан байр, үйлдвэрт байгаа тоног төхөөрөмж бүгдээрээ алс хол буй гайхмаар олон улсын бараа бүтээгдэхүүн байдаг.

Гэвч зах зээлийн даяарчлал хоёр тал руугаа үйлчилдэг. Энэ нь баян улсуудад нийт дэлхий даяараас эд зүйл худалдан авах боломж зөвхөн олгохоор зогсдоггүй. Мөн энэ нь алс бөглүү холын улсуудын хүмүүст ирээдүйн төлөвөө өөрийн бараа бүтээгдэхүүнээ зарахын төлөө олон-улсын зах зээл рүү нэгдэж холбогдох замаар сайжруулах боломж олгодог. Жишээлбэл ямар тариа ногоо орон нутгийн фермер тарих хэрэгтэй вэ? Өмнө

46 *manageable proportions*

нь тариа ногооны үнийн талаархи цор ганц үүсгүүр эх сурвалж нь өөрийн гэсэн ашиг сонирхолтой тухайн нутгийн наймаачид эсвэл төрийн агентлаг байв. Тухайн газар нутгийн үнэ, цаг агаар зэрэг хүчин зүйлээс хамаарч их хэмжээгээр савлах боломжтой. Тухайн нутгийн зах зээл үргэлж сайн зохион байгуулалтад орсон байдаггүй. Өнөөдөр фермер гар утсаа авч зах зээлийн үнэ дэлхий даяар орших тоо томшгүй зах зээл дээрхи бараг бүх тариа ногооны, үүн дотроо ирээдүйн үнийг жагсаан бичдэг олон вэбхуудасны аль нэгнээс үнийн саналыг нь шалгаж харах боломжтой. Хаа газрын фермерүүд одоо зохион байгуулалтад орсон, олон-улсын зах зээл рүү бараагаа урьдаас таамаглахуйц үнээр зарах боломжтой болжээ.

Шинэ Зиланд нээлттэй болсон нь

Шинэ Зиланд бол арилжаа худалдааны тухай зохицуулалтыг үгүй болгож буцаж зөв замдаа орсон улсын жишээ юм. 1980-аад оны эхээр энэ улс эдийн засгийн маш дарамттай, хэцүү нөхцөлд байсан нь иймэрхүү дүрэм журам буюу зохицуулалтаас болсон байжээ. Гэвч 1984 оноос эхлэн протекционизмоос татгалзаж, олон-улсын худалдаагаа либералчлан чөлөөлж, дэлхийн өрсөлдөөнд зах зээлээ нээсэн байна. Үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйд өгдөг татаасаа устгалаа. Дотоодын зах зээлээ, үүнд дотроо маш их дүрэм журамжсан байсан хөдөлмөрийн зах зээлээ дүрэм журамгүй буюу зохицуулалтгүй болгов: хөдөлмөрийн эвлэлийн гишүүнчлэлийг сайн дурынх болгож, хөдөлмөрийн гэрээг нь ажилтан болон босс хоорондоо хэлэлцдэг зүйл болгож орхижээ.

Энэхүү зохицуулалтаас татгалзах явдлаас болж “хөлслөх өрөөний эдийн засаг”^[47] бий болно гэсэн лоббичид, эрдэмтэд, шашны удирдагчид, хөдөлмөрийн эвлэлийн албан тушаалтнуудын аймшигтай зөгнөл таамаглал буруу байсан гэдэг нь хожмоо батлагдав. Дундаж цалин өсөв. Цалингийн гэрээ илүү хурдан байгуулдаг болов. Ажил хаялт бараг тэг

47 ‘sweatshop economy’

болов. Ажилгүйдэл буурав – Маоричууд, цагаачид, бусад ядуу эсвэл гадуурхагдсан хүмүүсийн бүлг^[48]ийн дунд ажилгүйдэл бүр хурдан буурав. Шинэ Зиланд дэлхийн хамгийн эрх чөлөөтэй, өрсөлдөх чадвартай улсын нэг болов.^[49]

Соёлын ялгарах шинж^[50]

Зарим хүмүүс зах зээл даяарчлагдах явдал улс орнуудаас тэдгээрийн давтагдашгүй ялгарах шинж болон соёлыг нь булаан авах боломжтой гэдэгт санаа зовцгоодог. Ялангуяа Америк брэндүүд хаа сайгүй тархах явдал нэгэнтээ бусдаас ялгардаг байсан улс орнууд хоорондоо маш адилхан харагдаж эхлэх болно, мөн Өрнөдийн бараа бүтээгдэхүүн, дотоод итгэл^[51] нь бусад улсуудынхыг өөртөө залгих болно, бас дэлхийн хамгийн дээд соёл ямар нэг доод төвшний оруулагч соёлд дарлагдах болно гэсэн зовнил төрүүлдэг.

Мэдээжээр эдийн засаг болон нийгмийн соёл өөрчлөгдөж буй билээ. Нэгэнтээ тодорхой улсад л ганцхан байдаг асан бүтээгдэхүүнийг бүх улсын төв гудмаас одоо олох боломжтой болсон. Энэ байдал нь сонголт хийх, нэр төрөл олшрох явдал алга болж устаж буй гэсэн үг биш. Үүний эсрэгээр энэ байдал нь улс бүрийн хүмүүс өмнө нь хэзээ ч тэдэнд байгаагүй илүү их сонголттой өнөөдөр болсон гэсэн үг юм. Жишээлбэл Нэгдсэн Хаант Улсын иргэд нэгэнтээ улс нь үүгээрээ алдартай байсан, цэвэр^[52], хэт болгосон хоол хүнсээ идэх гэж тэвчээр гаргах хэрэггүй болжээ. Одоо тэд Энэтхэг, Вьетнам, Латин Америк, Иран, Монгол, Польш гээд тоо томшгүй олон өөр төрлийн

48 *disadvantaged groups*-ялгаварлан гадуурхагдах, ядууралд өртөх, боломжтой хүмүүсийн бүлгийг хэлдэг ажээ.

49 *Эдгээр шинэчлэлийг архитекторын бичсэн ерөнхий тайлбарыг дараахь бүтээлээс үзнэ үү: Roger Douglas, Toward Prosperity, David Bateman, Auckland, NZ, 1987.-БАТЛЕП*

50 *cultural identity*

51 *attitudes*

52 *bland*

хоолоор үйлчилдэг зардаг ресторан, хоолоо авч явдаг мухлаг, супермаркет орох боломжтой болсон. Дэлхий даяар хаа сайгүй иймэрхүү сонголт эдлэн таашаал хүртэцгээж байна – энэ сонголт бол нэгэнтээ аялахад хангалттай баян хэдхэн хүн л эдэлж асан тийм сонголт юм. Энэ бол соёл устаж буй хэрэг биш; харин илүүтэй соёл хүн бүр тэрийг нь эдэлж хэрэглэх боломжтой болж тархан түгж буй нь илрэл юм.

Даяарчлалын нөлөөнөөс түүнийг хамгаална гэж хүсдэг хүмүүсийн боддог шигээр соёл хэзээ ч зогсонги хөдөлгөөнгүй, өөрчлөгддөггүй зүйл байгаагүй. Улс орны соёл бүхий л үед өөрчлөгдөж байсан бөгөөд соёл нь илүү тод өнгөтэй, амьд байх тусам түүнээс улам л их шинэ санаа төрж, тэр хэрээрээ өөрчлөгддөг. Өнөөдрийн хамгийн өнгөлөг тод улсуудын урлаг, хөгжим, утга зохиол, амьдралын хэвмаяг, амт таашаал, хувцасны загвар дөнгөж зуун жилийн өмнө амьдарч асан хүмүүст танигдаагүй байсан тийм зүйлс байдаг.

Соёл бусад соёлтой нүүр тулахдаа хүмүүст өөрийн амьдралцаг үедээ хамгийн тохиромжтой элементийг нь сонгож авах боломж олгож үүнээсээ үр шим хүртэнэ. Олон-улсын худалдаагаар дамжуулан бид гаднаас ирсэн, өөрийн болгож хүлээн авахад хэрэгтэй гэж үзсэн соёлын элементийг олж харж, ухаж ойлгодог. Гэвч өөрчлөлтийн энэ үйл явц хүн бүр даяарчлалын тухайн ярьдаг болохоос хамаагүй өмнө болдог л байсан зүйл юм.

Бидний хамгийн их хүндэлдэг өөрчлөлтийн дийлэнхи нь, мөн бидний соёлын хамгийн өнгөлөг үзэсгэлэнтэй хэсгээ алдах явдал бол гаднаас ирж буй соёлын аливаа империализмээс болдоггүй харин зүгээр л орчин үежих явцын жирийн нөлөө билээ. Эртний зан үйл, уламжлал, үндэстний хувцас даяарчлалаас болж биш харин амьдрал өөрөө өөрчлөгдөж буй учраас л алга болж байна. Тодорхой улиралд тэмдэглэдэг баяр наадам тариалан эрхэлдэг хүмүүсийн хүрээлэлд нэгэнтээ чухал байсан бол одоо энэ нь

Асуулт: Баян улсууд дэлхийн эд баялгийн хэт дийлэнхийг өөртөө булаан авдаггүй гэж үү?

Үгүй. Эд баялаг бол ур чадвар, ажил хэрэгч байдал, эрч хүч, хүчин чармайлт буюу хүч хөдөлмөр, зохион байгуулалт, хөрөнгө оруулалтаар дамжуулан бүтээдэг тийм зүйл юм. Мэдээжээр баян улсууд эд баялаг хэрэглэдэг ч гэсэн тэр улсууд мөн эд баялаг бас бүтээдэг. Энэ эд баялаг зөвхөн тэдэнд зориулагдсан байдаггүй: тэд хүн бүрийн, ялангуяа манай гарагийн хамгийн ядуу хүмүүсийн зарим нэгнийх нь амьдралыг сайжруулдаг амин чухал бараа бүтээгдэхүүн, үйл явцыг олж нээн, хөгжүүлж гаргадаг.

Жишээлбэл эмийн салбарт гарсан дэвшил сүрьеэ, хумхаа [халуун орны өвчин] зэрэг дэлхийн хамгийн аюултай зарим өвчнийг устгахад тус болдог. Генетикийн технологи будаа болон иштэй бусад үр тарианы гарц болон шавжид тэсвэр байдлыг нь улам их сайжруулахад дэм болсон. Шинэ материал буюу хэрэглэгдэхүүн ч барилгыг илүү хямд, аюулгүй болгож байна.

Баян улсууд нь шударга бусаар ихийг нь булаан авдаг эд баялгийн тийм тогтмол тогтчихсон нийлүүлэлт гэж байдаггүй. Үүний эсрэгээр баян улсын гүн нарийн мэдлэг туршлага бусад улсад шинэ бололцоо бүтээж байна.

бидний тэн хагас нь хотод амьдардаг болсон дэлхийд маш бага хүрээнд үлдэж нөлөөтэй хоцров.^[53]

Магадгүй соёл өөрчлөгдөх нь зүгээр л сайн зүйл байж болох юм. Дэлхийн олон соёлыг тухайн хүмүүст эзлэн түрэмгийлж буй улс нь хүчээр тулгасан байдаг бөгөөд хамгийн бага эрх чөлөөтэй

53 Эдгээр санааг дараахь бүтээлээс үзнэ үү: Mario Vargas Llosa, 'The culture of liberty', in Tom G. Palmer, *The Morality of Capitalism, Students for Liberty and Atlas Foundation, Arlington, VA, 2011.-БАТЛЕР*

улсуудын соёлын ихэнхи нь жинхэнээсээ хортой хохироосон зүйл байдаг. Хялбар хүртээмжтэй болсон аялал жуулчлал, илүү өргөн хүрээтэй эргэцүүлж мэтгэлцэх явдлаас болж улс орнууд зарим бүлгээ байнга хясаж хавчдаг, дарж дарангуйлдаг эсвэл ялгаварлан гадуурхдаг соёлоо хадгалж үлдэх аргагүй болжээ гэсэн бодит байдлыг бид таашаах зөвтгөх ёстой.

Эв найрын ач холбогдол

Нэгэнтээ Адам Смит дараахь зүйлийг бичиж байжээ. Үүнд: ‘Улс орныг хамгийн дорд бүдүүлэг байдлаас нь элбэг дэлбэг байдлын хамгийн дээд төвшин хүртэл өндийлгөхөд эв найр, бага татвар, шударга ёсыг хүлцэхүйц байдлаар хэрэгжүүлэх явдлаас өөр юу л хэрэгтэй байв гэж...’^[54] гэсэн байдаг.

Дотооддоо болон гадна талдаа эв найртай байх явдал хөгжиж цэцэглэж буй чөлөөт нийгмийн тов тодорхой шаардлага юм. Хүмүүс хэрэв тэд эд баялаг нь дайсагнагч зэвсэгт этгээд эсвэл дайран түрэмгийлж буй арми хулгайлж булаан авах магадлалтай гэж итгэвэл аж ахуйн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах, бүтээлч хөрөнгө бүтээж бий болгохгүй. Иргэд нь бусад улсын иргэдтэй арилжаа наймаа хийх ажил эрхэлдэг улс тэр улсуудтай нь зөрчилдөхийг эрэлхийлэхгүй байх магадлал хамаагүй их байна. Арванесдүгээр зууны Францын эдийн засагч, улстөрч Фредерик Бастиагийн үгээр хэлбэл: ‘Хэрэв бараа таваар хил даван арилжаалагдахгүй бол түүнийг арми л давах болно.’^[55]

Эв найрын ач тус эдийн засаг болон соёлд хоёуланд нь бий. Эв найр хүч хөдөлмөр болон нөөц баялгийг эвдлэн сүйтгэх үйлээс илүүтэй бүтээлч үйл ажиллагаанд төвлөрөх боломж олгодог.

54 1755 оны лекцэд хэлсэн гэж дараахь бүтээлд эшлэсэн байдаг: *Duguld Stewart, Account of the Life and Writings of Adam Smith LLD, Section IV, 25-БАТЛЕР*

55 Энэ үгийг Бастиа жинхэнээсээ хэлсэн гэсэн баталгаа байдаггүй ч энэ нь түүний санааг хураангуйлсан байдаг. *Frédéric Bastiat, Bastiat's 'The Law', Institute of Economic Affairs, London, 2001 [1850] гэсэн бүтээлийг үзнэ үү.- БАТЛЕР*

Энэ нь хөрөнгө бүтээх, мөн хөгжиж цэцэглэж буй чөлөөт эдийн засаг бий болох нөхцөлийг бүрэлдүүлдэг. Эв найр хүмүүст өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ ирээдүйг зураглах боломж олгодог. Энэ нь соёл болон боловсрол олгох үйл ажиллагаа явуулах ажилд оролцох цаг хугацаа, хөрөнгө чинээ, итгэлтэй байдлыг өгдөг. Эв найр хүмүүс бараа бүтээгдэхүүн, үзэл санаа, юмсын талаархи ойлголт, хөгжил цэцэглэлт, шинэчлэлийг түгээж тархаан чөлөөтэй шилжиж нүүх боломж олгодог.

Адам Смитийн өөр нэг гүнзгий мэдлэг бол бид өөрсдөө баян болохын тулд өөр бусад улсыг ядуу болгох ёсгүй гэсэн санаа юм. Бидний үйлчлүүлэгч ядуу гэхээсээ илүүтэй баян байх нь л бидэнд хамгийн сайн зүйл юм.^[56] Үүнтэй адилаар хүчтэй чадалтай байхын тулд бусдыг сул дорой болгох хэрэггүй. Эв найрын ашиг тусыг хоёр тал хоёулаа хүртэнэ.

Эв найрын төлөө үе үе тэмцэж байх ёстой. Өмч болон хүмүүсээ хамгаалдаг байх ёстой. Шаардлагатай нөөц баялгийг дайчлан гаргах^[57]ад (хязгаарлагдмал-эрх мэдэлтэй) төр засгийн оролцоо хэрэгтэй байж болно. Гэвч томорч данхайдаг төр засаг мөн л дайнч шинжтэй болдог – магадгүй үндэстний аюулгүй байдалд золиос хэрэгтэй, зорилгын нэгдмэл байдал, цэргийн хүч чадал хэрэгтэй гэдгийг санал болгох замаар улс оронд нь хөгжил цэцэглэлт, эрх чөлөө дутуу байгаагаа нуух арга эрэлхийлж байж болох юм. Чөлөөт нийгмийн хүмүүс улс орондоо бусдаас дутуугүй үнэнч байдаг; гэвч тэд нээлттэй, чөлөөт нийгэмд мөн гэр бүл, найз нөхөд, хэрэглэгчид, сайн дурын эвлэлдсэн байгууллагад үнэнч байдаг ч харин дарангуйлагч, туг, эсвэл зарим нэг үндсэрхэг мөрөөдөлд үнэнч байдаггүй.

Зарим хүмүүс эв найрыг тогтоох явдал бол бүх үндэстний дээр орших дэлхийн засгийн газр^[58]ын нэг тийм төрлийг

56 'As a rich man is likely to be a better customer to the industrious people of his neighbourhood than a poor, so likewise is a rich nation.' Adam Smith, *The Wealth of Nations*, 1776, Book IV, ch. III, Part II. -БАТЛЕП

57 *And marshalling*

58 *supranational world government*

байгуулах явдал юм гэж төсөөлцгөөдөг. Ялгаатай саналаа олонд хэлэх, байж болох зөрчлөө намжаах олон-улсын форум буюу хэлэлцүүлэх газартай байх нь хэрэгтэй байдаг ч гэсэн дэлхийн засгийн газар^[59] бидний одоо байгаа үндэстний засгийн газраас илүү сайн байх болно гэж бид үздэг байх ёсгүй. Асар том данхар бүтэц, олон нийтээсээ улам бүр алслагдмал хөндий байх байдлаас нь харвал тэлж өргөжих, эрх мэдлээ урвуулан ашиглах гэсэн түүний хандлага мөн л асар их байх болно. Бас хэн ч дэлхийн өөр нэг хэсэг рүү нүүж шилжих замаар тэдгээрийн хавчлагаас зугтаах боломжгүй болно. Үгүй дээ, эв найрыг дэмжих хамгийн сайн арга зам бол төр засгаа данхар биш илүү жижиг, цомхон болгох, мөн эв найртай хамтран ажилладаг, харилцан биесийнхээ нөхцөлийг илүү сайн болгодог, хүмүүн төрөлтний төрөлхи хандлагад найдах явдал юм.

59 *world government.*

9 ГАРГАЛГАА НОТОЛГООГОО ТОВЧХОН ДУРДВААС

Эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоо

Эрх чөлөө хөгжил цэцэглэлтийг бүтээнэ. Эрх чөлөөг халуунаар хүлээн авсан нийгэм өөрөө баян болдог. Ингээгүй нийгэм ядуу хэвээр үлддэг ажээ.

Гэвч чөлөөт нийгэм материаллаг бус арга замаараа мөн л дээд зэрэгтэй байдаг. Чөлөөт нийгэм хувь хүмүүсийн харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны суурин дээр ажилладаг. Харин эрх мэдэл, албадлагын суурин дээр ажилладаггүй. Иргэд хоорондоо соёл, хувь хүний, ёс суртахууны гүн гүнзгий холбоотой байдаг. Тэд тэдэнд эдгээр ёс журмыг тулгаж хэрэглүүлсэн учраас биш харин харилцан ашигтай байхын төлөө хүмүүс-хоорондын үйл хөдлөлийн тухай ёс журмыг хүлээн зөвшөөрдөг. Тэдний төр засаг нь захирагдаж буй хүмүүсийнхээ зөвшөөрсөн саналаар үүсэж гардаг бөгөөд олонхи нь тэр хүмүүсийг ашиглаж мөлжихөөс сэргийлсэн ёс журамд төр засаг нь мөн захирагддаг ажээ.

Чөлөөт нийгэм хүмүүний авьяас, шинэ бүтээл, шинэ санааг суллан тавьдаг. Энэ явдал өмнө оршиж байгаагүй эд баялаг хөрөнгө бүтээх боломж олгодог. Чөлөөт нийгмийн хүмүүс баяжихдаа эрх чөлөө-илүү багатай улсуудын элитүүд шигээр бусдыг шулж мөлждөггүй. Тэд бусдыг ядуу болгож өөрсдөө баян болдоггүй. Тэр хүмүүс зөвхөн бусдад тэдний хүсэж байгаа зүйлийг нийлүүлэх, бусад хүмүүсийн амьдралыг илүү сайн болгох замаар л баян болдог ажээ.

Хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг

Ихэнхи хүмүүс шударга ёсыг хэрэгжүүлэх, мөн хувь хүмүүс дангаараа шийдвэрлэх боломжгүй зүйлийн талаар шийдвэр гаргах зэрэг зорилгод л төр засаг хэрэгтэй гэдэгт санал нийлдэг. Гэвч бараг хүн бүр төр засгийн эрх мэдэл хязгаарлагдмал байх ёстой гэдэгт бас санал нийлцгээдэг.

Чөлөөт нийгмийн төр засаг иргэдээ аюулд орж, хохирохоос сэргийлэх гэж л оршдог. Ийм төр засаг шударга ёсыг сахин хамгаалж, бас албан хэрэгжүүлдэг – шударга ёс бол хүмүүн төрөлхтөн хамтдаа эв найртай хамтран ажиллах боломж олгодог жам ёсны ёс журам юм. Чөлөөт нийгмийн төр засгийг хууль ёс^[1]оор хязгаарладаг. Энэ төр засгийн хууль хүн бүгд ижил тэгш үйлчилдэг. Удирдагчид нь өөрийн тусын төлөө иргэдээ тонон дээрэмдэх, найз нөхдөдөө ашиг тус хүртээх, эсвэл дайснуудынхаа эсрэг эрх мэдлээ ашиглаж чадахгүй. Тэдгээр удирдагчдын эрх мэдэл, албан тушаалд байх хугацааг нь хоёулыг нь эрх мэдэлтнээс үргэлж үүсэж гардаг авилгыг бууруулахын төлөө хязгаарладаг. Чөлөөт, нээлттэй сонгууль, үг хэлэх эрх чөлөө^[2], төлөөлөгчдийн [сонгогдох болон томилогдох] хугацааны хязгаар, үндсэн хуулийн ёс журам зэрэг ардчилсан институт бүгдээрээ улстөрийн удирдагчийн эрх мэдэлд хязгаар тавьдаг ажээ.

Илүү их тэгш байдал

Чөлөөт нийгмийн эдийн засгийн динамизмийн гол ашиг хүртэгчид нь ядуус байдаг. Чөлөөт нийгэм эдийн засгийн хувьд чөлөөт бус нийгмээсээ илүү их тэгш байдалтай байдаг. Хамгийн их эрх чөлөөтэй улсын ядуу хүн дөнгөж хэдхэн жилийн өмнө л мөрөөдөж ч чадахгүй байсан, мөн чөлөөт бус нийгмийн эрх барьж буй элитүүд л эдэлдэг тансаглалыг таашаан эдэлдэг.

1 rule of law

2 free speech-бас freedom of speech

Чөлөөт нийгэм материаллаг тэгш бус байдлыг тулгаж бий болгох гэж оролддоггүй. Чөлөөт нийгэмд эд хөрөнгө эсвэл орлогыг тэгшитгэх гэсэн оролдлого эсрэг үр дүнтэй байх болно гэдгийг ялгаж таньсан байдаг. Ийм оролдлого өөрийгөө хөгжүүлэх, шаргуу ажиллах, ажил хэрэгч байх санаачилгыг устгадаг. Ийм оролдлого нийт нийгмийн үр бүтээлч байдлыг цэцэглүүлдэг хөрөнгө бүтээж бий болгох гэж хүмүүс чармайх урам зориггүй болгодог. Ийм оролдлого хувь хүмүүс шинэ эд хөрөнгө, шинэ үнэ цэнэ бүтээх явдлыг хорьдог.

Гэвч чөлөөт нийгэм чөлөөт бус нийгэмд байдаггүй бүр илүү чухал тэгш байдлыг таашаан эдэлдэг. Хүмүүсийн ёс суртахууны тэгш байдлыг хүлээн зөвшөөрдөг: хүмүүний амь нэг бүрийг үнэ цэнэтэй, хамгаалах ёстой зүйл гэж үздэг. Хуулийн өмнөх тэгш байдал мөн байдаг: шүүхийн шийдвэр таны хэн байхад биш харин тухай хэргийн баримт нотолгооноос хамаардаг. Иргэд нь улстөрийн тэгш байдалтай байдаг: тэр хүмүүс бүгдээрээ засаг захиргаанд энэ нь хэдий хэр тохиромжгүй байхаас үл хамаарч санал өгөх, сонгуульд оролцох, улстөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй байдаг. Хүмүүс нь боломжийн тэгш байдалтай байдаг: иргэд нь ажлын байранд эсвэл боловсролоороо ялгаварлан гадуурхагддаггүй, мөн арьсны өнгө, шашин, угсаатан, эсвэл бусад өвөрмөц шинжээсээ үл хамаарч өөрсдийгөө хөгжүүлэх боломжтой байдаг.

Чөлөөт эдийн засаг

Чөлөөт нийгэмд нийгмийн болон хувийн сонголтоо чөлөөтэй хийх боломж хүмүүст олгодгийнхоо адилаар бас эдийн засгийн өөрийн сонголтоо хийх эрх чөлөө өгдөг. Чөлөөт нийгмийн хүмүүс сайн дурын солилцоогоор дамжуулан үнэ цэнэ бүтээдэг. Чөлөөт солилцооноос хоёр тал хоёулаа ашиг тус хүртэнэ: ийм зүйл байхгүй бол солилцоо болохгүй.

Хувь хүмүүс бусадтайгаа хамтран ажиллаж, тэдний хүссэн зүйлийг нийлүүлж, эргээд оронд нь ямар нэг хүссэн зүйлээ олж

авах замаар хөгжиж цэцэглэдэг. Ашгийн ирээдүйтэй байдал ажил хэрэгч хүмүүсийг бусад хүн юу хүсэж байгааг эрж олон түүнийг нь нийлүүлэх явдалд хөтөлдөг. Үнэ хомсдол болон илүүдлийн талаар мэдээллийг хүн бүрд юу үйлдвэрлэх хэрэгтэй, юуг хадгалж үлдэх хэрэгтэй болохыг нь хэлж өгөн дамжуулж түгээдэг. Энэ арга замаар цаг хугацаа, хүчин чармайлт буюу хүч хөдөлмөр, ур чадвар, хөрөнгө, бусад нөөц баялгийг ач холбогдол арай багатай хэрэглээнээс холдуулан авч эрэлт нь хамгийн яаралтай хэрэгтэй байгаа газар руу автоматаар татан аваачдаг ажээ. Төр засаг энд хүмүүст юу хийхийг нь хэлэх хэрэгцээ байхгүй.

Чөлөөт нийгэм ажилладаг байхын тулд хүмүүс хэрхэн хамтран ажиллах тухай хүлээн зөвшөөрөгдсөн ёс журмын хүрээ бүтэц л зөвхөн хэрэгтэй. Эдгээр ёс журамд өмч өмчлөх, дамжуулах ёс журам, гэрээг хүндэтгэж биелүүлэхийг хүчилдэг гэрээний ёс журам ордог. Хэрэв хүмүүс бизнесээ бүтээх, бараа таваараа солилцох бол хувийн өмч шаардлагатай. Гээд бас бусад эрх чөлөөг мөн хүндэлдэг байх нь амин чухал билээ. Хэрэв засаг захиргаа бүх өмчийг хянадаг бол улстөрийн үйл ажиллагаа, нээлттэй хэлэлцүүлэг мэтгэлцээн байх боломжгүй зүйл болдог.

Шударга ёс, хууль ёс

Шударга ёс бол хууль тогтоогчоос зааж тулгах боломжтой ямар нэг зүйл биш юм. Шударга ёсны ёс журам бол хүмүүний шинж байдлын нэг хэсэг ажээ – энэ бол хувь хүмүүсийн хоорондох эв найртай хамтын ажиллагааг дэмждэг, бидний амин чухал нэг хэсэг юм.

Чөлөөт нийгмийн хүмүүс хүмүүнлэг чанар^[3]ынхаа үнэ цэнээрээ энэхүү жам ёсны шударга ёсыг эдлэх эрхтэй байдаг. Жам ёсны шударга ёсонд хууль ойлгомжтой, тодорхой байх, хуулиар хүмүүстэй ижил тэгш харьцах, хуулиар боломжгүй зүйлийг шаарддаггүй байх, хуулийг буцаан хэрэглэдэггүй байх, шийтгэл нь урьдаас таамаглахуйц байх, шийтгэл нь гэмтэйгээ

3 *humanity*

харьцуулахуйц байх ёстой гэдгийг баримталдаг. Бүх тохиолдолд хуулийн зохих үйл ажиллагаа^[4]гаар шударгаар шүүлгэх ёстой бөгөөд шүүхийн шийдвэргүйгээр удаан хугацаанд хүмүүсийг хорьдоггүй байх ёстой. Гэмт хэрэгт буруутгагдсан хүмүүсийг гэм нь батлагдах хүртэл гэмгүй гэж харьцах ёстой бөгөөд хувь хүмүүсийг нэг ижил хэргийн төлөө олон удаа шийтгэж ялгаварлан гадуурхдаггүй байх ёстой. Иймэрхүү зарчмыг улс, соёл, арьсны өнгө эсвэл шашнаас үл хамаарч бараг бүх хүмүүс хүлээн зөвшөөрдөг.

Энэ жам ёсны шударга ёсыг бататгах, хууль ёсыг бэхжүүлэхэд улстөрийн удирдагч нөлөөлөх боломжгүй бие даасан шүүхийн тогтолцоо шаардлагатай. Үүнтэй адилаар цагдаа бие даасан байх ёстой. Хэрэв эрх чөлөөг давамгайлдаг болгох гэвэл авилга хээл хахуул^[5]ийг цагдаа болон шүүх байгууллага хүлцэн тэвчих ёсгүй.

Өөрөө-бүрэлддэг нийгэм

Чөлөөт нийгэм бол өөрөө-бүрэлддэг нийгэм юм. Энэ нь эв найртай хамтын ажиллагааг тэтгэдэг ёс журмыг дагаж мөрддөг хувь хүмүүсийн үйлдлээс бүрэлдэж бий болдог. Энэ бол улстөрийн засаг захиргаа дээрээс тулгаж хүлээлгэдэггүй зүйл юм.

Харилцан ашигтай хамтран ажиллахын тулд хүмүүс бүх зүйл дээр санал нэгдээд байдаггүй. Бараа таваараа солилцож буй хүмүүс наймаалалцах үнийнхээ талаар зөвхөн санал нэгдэх хэрэгтэй. Гэвч хамтын ажиллагаа нь хамгийн үр өгөөжтэй байхын тулд хувь хүмүүс бусдынхаа үзэл бодол болон үйлдлийг хүлцэн тэвчих ёстой. Чөлөөт нийгэмд хувь хүмүүс эсвэл төр засаг зөвхөн бодит аюул хохирлоос л сэргийлэх гэж л бусад хүмүүсийн үйлдэлд хөндлөнгөөс оролцох боломжтой. Бид тэдний үйл хөдлөлтэй санал нийлэхгүй эсвэл дайрч доромжилсон гэж үзсэн учраас л хүмүүсийн эрх чөлөөг хязгаарлах нь хүн бүрийн эрх

4 *due process of law*

5 *Bribes and corruption*

чөлөөг өөрсдийгөө ёс суртахууны хувьд дээд төвшний хүн гэж боддог хүмүүс хорьж цагдахаас хамгаалдаг аливаа саад хorigийг үгүй хийх болно.

Бусад хүмүүсийн үзэл санаа болон амьдралын хэвмаягийг хүлцэх явдал нийтэд ач тустай байдаг. Үнэн үргэлж илэрхий тод байдаггүй; энэ нь үзэл санааны тулаан дундаас үүсэж гардаг ажээ. Бид зөвхөн буруу үзэл санааг л дарж дарангуйлдаг гэх [утга санааны] шүүлтүүр буюу цензүрт итгэх ёсгүй. Ийм шүүлтүүр ирээдүйд нийгэм ашиг тусыг асар ихээр хүртэж болох үзэл санааг буруу ойлгон дарж хорьж ч байж болох юм.

Эрх чөлөөний ертөнц

Авторитари төр засаг үйлдлээ дэлхийн үлдсэн хэсгээс халхалж нуухад улам л хэцүү болсоор байна. Үр дүнд нь улам бүр л олон улс орон арилжаа худалдаа, аялал жуулчлалд нээлттэй болж, шинэ үзэл санаа тархаж түгсээр байна. Илүү олон хүн эдийн засаг болон нийгмийн эрх чөлөөний ашиг тусыг ойлгодог болж, эдгээрийг шаарддаг болжээ.

Эрх чөлөө оршдоггүй газарт чөлөөт нийгмийн ёс суртахуунт байдал бий болгох, мөн институтүүдийг байгуулахад хэцүү. Эдгээрийг нэг дор бөөнөөр тулгаж хэрэгжүүлэхийг оролдох гэхээсээ илүүтэй бичил төвшинд хүмүүс чөлөөтэй үйл хийх нөхцөлийг бүрэлдүүлж чөлөөт нийгмийг тэдний үйлдлээр дамжуулан бүтээх нь илүү дээр ажээ. Энэ бүгдийн гол цөм хэсэг нь өмчийн эрхийн институт бөгөөд хүмүүс өмчийг нь хураан авахгүй гэдэг итгэлтэйгээр бизнесээ босгож, арилжаа худалдаа эрхэлдэг.

Шинэчлэлээр крони буюу амин найзуудын капитализм^[6] биш харин жинхэнэ эдийн засгийн эрх чөлөөг авчрах ёстой. Төрийн үйлдвэрүүдээ хувьчлахаар мэдэгдэж байсан хэт олон төр засаг үнэндээ тэдгээрийн өмчлөлийг өөрийн найз нөхөд хамаатнууддаа зүгээр л шилжүүлчихсэн. Жинхэнэ өөрчлөлт

6 *crony capitalism.*

гаргах гэж буй бол эдийн засгийн өөрчилж шинэчлэх үйл явцад нийт хүн амыг оролцуулах хэрэгтэй.

Олон-улсын худалдаанд нээлттэй болох явдлаас улс орнууд алддаггүй. Өрсөлдөөнөөс дотоодын үйлдвэрлэгчдээ хамгаална гэдэг нь зүгээр л дотоодын хэрэглэгчид их үнэтэй, чанар муутай бүтээгдэхүүн хэрэглэнэ л гэсэн үг юм. Олон-улсын худалдааны хүрээллийн нэг хэсэг байх нь орон нутгийн ажил хэрэгч хүмүүст шинэ зах зээл, бололцоог өгдөг. Сүүлийн гучин жилийн хугацаанд худалдаа наймаанд нээлттэй болсноор үгээгүй ядуу байдлаас ойролцоогоор тэрбум гаруй хүн гарчээ. Эрх чөлөө бол хүмүүний түүхэнд байсан хамгийн өгөөмөр, бүтээлч хүчний нэг юм.

СОНГОЖ АВСАН НОМЗУЙ

- Ashford, N. (2003), *Principles for a Free Society*, Stockholm: Jarl Hjalmarson Foundation. Thorough, short exposition of the principles on which a free society and free economy are built.
- Bastiat, F. (2001 [1850]), *Bastiat's 'The Law'*, London: Institute of Economic Affairs. Classic statement of liberal ideas from the French politician and political thinker.
- Benn, E. (1964), *Why Freedom Works*, London: Sir Ernest Benn Ltd. Dated but enlightening defence of free markets by a leading UK businessman.
- Butler, E. (2009), *The Best Book on the Market: How to Stop Worrying and Love the Free Economy*, Oxford: Capstone Books. Simple outline of how markets and trade really work.
- Butler, E. (2012), *Public Choice – a Primer*, London: Institute of Economic Affairs. Simple explanation of government failure and the problems of self-interest in democratic systems.
- Butler, E. (2012), *Friedrich Hayek: The Ideas and Influence of the Libertarian Economist*, Petersfield: Harriman House. Easy introduction to the liberal political scientist who developed much of the modern thinking on the spontaneous society.
- Friedman, M. with R. Friedman (1962), *Capitalism and Freedom*, Chicago, IL: University of Chicago Press. Classic outline of the case for a free society and free economy by the US Nobel laureate in Economics.
- Friedman, M. and R. Friedman (1980), *Free to Choose*, New York: Harcourt Brace Jovanovich. Engaging case for the free society, based on the television series of the same name.

- Hayek, F. A. (1944), *The Road to Serfdom*, London: Routledge. Classic wartime exposition of the dangers of central planning and unrestrained governments.
- Hayek, F. A. (1960), *The Constitution of Liberty*, London: Routledge. Large book tracing the origins of liberal ideas and the principles on which a free society must be founded.
- Meadowcroft, J. (ed.) (2008), *Prohibitions*, London: Institute of Economic Affairs. Powerful set of arguments against government controls on many different lifestyle choices.
- Mill, J. S. (1859), *On Liberty*, in J. S. Mill (2008), *On Liberty and Other Essays*, Oxford: Oxford University Press. *On Liberty* is a classic text on the case for freedom, the no-harm principle, limited government, natural justice and tolerance.
- Norberg, J. (2003), *In Defense of Global Capitalism*, Washington, DC: Cato Institute. An instructive survey of the benefits delivered, to the poor in particular, by international capitalism.
- Palmer, T. G. (ed.) (2011), *The Morality of Capitalism*, Arlington, VA: Students for Liberty and Atlas Foundation. Interesting collection of essays on morality, cooperation, equality, progress, globalisation and culture.
- Pirie, M. (2008), *Freedom 101*, London: Adam Smith Institute. One hundred and one arguments against the free economy, knocked down in a page each.
- Wellings, R. (ed.) (2009), *A Beginner's Guide to Liberty*, London: Adam Smith Research Trust. Straightforward explanations of markets, property rights, liberty, government failure, prohibitions and welfare without the state.

ЭЗХЯХ-ГИЙН ТУХАЙ

Энэ хүрээлэн бол хязгаарлагдмал санхүүжилттэй, судалгаа болон боловсролын буяны байгууллага (No. CC 235 351) юм. Түүний алсын зорилго чөлөөт нийгмийн суурь институтүүдийн талаархи ухаарац мэдлэгийг эдийн засаг болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх зах зээлийн үүрэг нөлөөг шинжлэх, түгээн дэлгэрүүлэх замаар сайжруулах явдал юм.

ЭЗХЯХ хэтийн зорилгодоо дараахь арга замаар хүрнэ:

- хэвлэн нийтлэх сайн чанартай хөтөлбөр
- бага хурал, семинар, лекц, бусад үйл ажиллагаа
- дунд сургууль, коллежийн оюутнуудад хүрч ажиллах
- хэвлэл мэдээллийн танилцуулга бэлдэх, нэвтрүүлэг ярилцлаганд орох

1955 онд Эрхэм Энтони Фишер үүсгэн байгуулсан ЭЗХЯХ бол улстөрийн байгууллага биш харин боловсролын буяны байгууллага юм. Энэ байгууллага аливаа улстөрийн нам эсвэл бүлгээс ангид байдаг бөгөөд ямар нэг сонгууль эсвэл олон нийтийн саналасуулгын үеэр эсвэл хэзээ хаана ч аливаа улстөрийн нам эсвэл түүний нэр дэвшигчийг дэмжихэд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаггүй. ЭЗХЯХ ном хэвлэлийнхээ борлуулалт, бага хурлын хураамж, сайн дурын хандиваар санхүүждэг.

Гол цуврал ном товхимлоосоо гадна ЭЗХЯХ мөн улирал тутмын Economic Affairs гэсэн сэтгүүл хэвлүүлдэг.

ЭЗХЯХ-гийн ажилд олон-улсын нэр хүндтэй Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөл [анг. Academic Advisory Council], мөн олонд алдартай Хүндэт Гишүүд [Honorary Fellows]-ийн бүлэг туслалцаа үзүүлдэг. Бусад эрдэмтдийн хамтаар энэ улс ЭЗХЯХ-гийн ирээдүйд гарах ном товхимлыг хянуулах, тэдний тайлбар

санамжийг зохиогчид нь нэргүйгээр дамжуулж өгдөг. ЭЗХЯХ-гийн бүх ном зохиол тиймээс шинжлэх ухааны тэргүүлэх сэтгүүл гаргахад ашигладаг бие даасан, хатуу чанга хянаж шалгах үйл явцыг давж гардаг.

ЭЗХЯХ-гийн ном товхимлыг өргөн хэмжээгээр дунд сургууль, их сургуулиудад хичээлд ашигладаг. Эдгээр бүтээлийг дэлхий даяар борлуулдаг бөгөөд ихэвчлэн л орчуулж дахин-хэвлэн түгээдэг.

ЭЗХЯХ 1974 оноос хойш дэлхийн 70 улсад ижил төстэй 100 институтын дэлхий-дэхний сүлжээг бүтээлцсэн билээ. Тэдгээр нь бүгд бие даасан байгууллага ч гэлээ ЭЗХЯХ-гийн хэтийн зорилготой зорилго дүйдэг.

ЭЗХЯХ-гийн ном товхимолд илэрхийлсэн үзэл санаа бол (корпорацын үзэлгүй) уг Хүрээлэн, түүний Удирдлагын Итгэмжлэгдсэн Баг, Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөлийн гишүүд эсвэл ахлах ажилтнуудынх биш харин зохиогчдынх нь үзэл санаа юм.

Тухайн Хүрээлэнгийн Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөл, Хүндэт Гишүүд, Итгэмжлэгдсэн Баг, Ажилтны багийн гишүүдийг арын хуудсанд жагсаан бичлээ.

Манай хүрээлэн Алек болон Берил Воррен агсан нарт бидний хэвлэлийн хөтөлбөр болон бусад ажлыг санхүүжүүлсэн өгөөмөр дэмжлэгт гүнээ талархаж байна.

Director General & Ralph Harris Fellow Mark Littlewood

Editorial Director

Professor Philip Booth

Managing Trustees

Chairman: Professor D R Myddelton
Kevin Bell
Robert Boyd
Neil Record
Sir Michael Hintze
Professor Patrick Minford

Professor Mark Pennington
Bruno Prior
Michael Fisher
Professor Martin Ricketts
Linda Whetstone

Academic Advisory Council

Chairman: Professor Martin Ricketts
Graham Bannock
Graham Bannock
Dr Eileen Marshall
Dr Roger Bate
Professor Antonio Martino
Professor Alberto Benegas-
Lynch, Jr
Dr John Meadowcroft
Professor Donald J Boudreaux
Dr Anja Merz
Professor John Burton
Julian Morris
Professor Forrest Capie
Professor Alan Morrison
Professor Steven N S Cheung
Paul Ormerod
Professor Tim Congdon
Professor David Parker
Professor N F R Crafts

Professor Victoria Curzon Price
Professor David de Meza
Professor Colin Robinson
Professor Kevin Dowd
Professor Pascal Salin
Professor Richard A Epstein
Dr Razeen Sally
Nigel Essex
Professor Pedro Schwartz
Professor David Greenaway
Professor J R Shackleton
Dr Ingrid A Gregg Jane S Shaw
Walter E Grinder
Professor W Stanley Siebert
Professor Steve H Hanke
Dr Elaine Sternberg
Professor Keith Hartley
Professor James Tooley
Professor David Henderson
Professor Nicola Tynan

Professor Peter M Jackson
Professor Roland Vaubel
Dr Jerry Jordan
Dr Cento Veljanovski
Dr Lynne Kiesling
Professor Lawrence H White
Professor Daniel B Klein
Professor Walter E Williams
Professor Chandran Kukathas
Professor Geoffrey E Wood
Professor Stephen C Littlechild

Honorary Fellows

Professor Michael Beenstock	Professor Chiaki Nishiyama
Professor Sir Alan Peacock	Professor Basil S Yamey
Sir Samuel Brittan	
Professor Vernon L Smith	
Professor David Laidler	
Professor Gordon Tullock	

ЭЗХЯХ-ГЭЭС САЯХАН ХЭВЛҮҮЛСЭН БУСАД НОМ ТОВХИМОЛ:

Taxation and Red Tape

The Cost to British Business of Complying with the UK Tax System
Francis Chittenden, Hilary Foster & Brian Sloan
Research Monograph 64; ISBN 978 0 255 36612 0; £12.50

Ludwig von Mises – A Primer

Eamonn Butler
Occasional Paper 143; ISBN 978 0 255 36629 8; £7.50

Does Britain Need a Financial Regulator?

Statutory Regulation, Private Regulation and Financial Markets
Terry Arthur & Philip Booth
Hobart Paper 169; ISBN 978 0 255 36593 2; £12.50

Hayek's The Constitution of Liberty

An Account of Its Argument
Eugene F. Miller
Occasional Paper 144; ISBN 978 0 255 36637 3; £12.50

Fair Trade Without the Froth

A Dispassionate Economic Analysis of 'Fair Trade'

Sushil Mohan

Hobart Paper 170; ISBN 978 0 255 36645 8; £10.00

A New Understanding of Poverty

Poverty Measurement and Policy Implications

Kristian Niemietz

Research Monograph 65; ISBN 978 0 255 36638 0; £12.50

The Challenge of Immigration A Radical Solution

Gary S. Becker

Occasional Paper 145; ISBN 978 0 255 36613 7; £7.50

Sharper Axes, Lower Taxes

Big Steps to a Smaller State

Edited by Philip Booth

Hobart Paperback 38; ISBN 978 0 255 36648 9; £12.50

Self-employment, Small Firms and Enterprise

Peter Urwin

Research Monograph 66; ISBN 978 0 255 36610 6; £12.50

Crises of Governments

The Ongoing Global Financial Crisis and Recession

Robert Barro

Occasional Paper 146; ISBN 978 0 255 36657 1; £7.50

... and the Pursuit of Happiness

Wellbeing and the Role of Government

Edited by Philip Booth

Readings 64; ISBN 978 0 255 36656 4; £12.50

Public Choice – A Primer

Eamonn Butler

Occasional Paper 147; ISBN 978 0 255 36650 2; £10.00

The Profit Motive in Education: Continuing the Revolution

Edited by James B. Stanfield

Readings 65; ISBN 978 0 255 36646 5; £12.50

Which Road Ahead – Government or Market?

Oliver Knipping & Richard Wellings

Hobart Paper 171; ISBN 978 0 255 36619 9; £10.00

The Future of the Commons

Beyond Market Failure and Government Regulation

Elinor Ostrom et al.

Occasional Paper 148; ISBN 978 0 255 36653 3; £10.00

Redefining the Poverty Debate

Why a War on Markets is No Substitute for a War on Poverty

Kristian Niemietz

Research Monograph 67; ISBN 978 0 255 36652 6; £12.50

The Euro – the Beginning, the Middle ... and the End?

Edited by Philip Booth

Hobart Paperback 39; ISBN 978 0 255 36680 9; £12.50

The Shadow Economy

Friedrich Schneider & Colin C. Williams

Hobart Paper 172; ISBN 978 0 255 36674 8; £12.50

Quack Policy

Abusing Science in the Cause of Paternalism

Jamie Whyte

Hobart Paper 173; ISBN 978 0 255 36673 1; £10.00

ЭЗХЯХ-гийн бусад ном товхимол

ЭЗХЯХ-гийн бүтээл болон бусад ном хэвлэлийн талаархи мэдээллийг www.ica.org.uk гэсэн сайтаас үзэх боломжтой. Аливаа ном товхимол захиалахыг хүсвэл мэдээллийг нь дороос үзнэ үү.

Хувь хэрэглэгчид

Хувь хэрэглэгчид захиалгаа ЭЗХЯХ-д өгөхдөө дор хаягаар хандах хэрэгтэй:

Clare Rusbridge

IEA

2 Lord North Street

freepost lon10168

London sw1p 3yz

Tel: 020 7799 8907. Fax: 020 7799 2137

Email: crusbridge@ica.org.uk

Арилжааны хэрэглэгчид

Арилжааны номын бүх захиалгыг өгөхдөө ЭЗХЯХ-гийн дистрибютерүүд рүү дараахь хаягаар хандах хэрэгтэй:

Gazelle Book Services Ltd (IEA Orders)

freepost rlys-eahu-yscz

White Cross Mills

Hightown

Lancaster la1 4xs

Tel: 01524 68765. Fax: 01524 53232

Email: sales@gazellebooks.co.uk

ЭЗХЯХ-гийн товхимолын захиалга

ЭЗХЯХ-гээс мөн тогтмол хэвлэлийн захиалга авдаг. Жилийн нэг удаагийн төлбөр (одоогоор £42.00, НХУ) төлж тус Хүрээлэнгээс хэвлүүлсэн монограф бүрийг захиалагч хүлээн авах болно. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг холбоо барих мэдээлэлд дурдсан хүнтэй холбоо барина уу:

Clare Rusbridge

Subscriptions

IEA

2 Lord North Street


freepost lon10168

London sw1p 3yz

Tel: 020 7799 8907. Fax: 020 7799 2137

Email: crusbridge@iea.org.uk


УНШИГЧДАДАА САНАЛ БОЛГОЖ БУЙ БҮТЭЭЛҮҮД:



Зохиогч:
Мильтон
Фридман,
Рөүз
Фридман

Нүүрний тоо:
265
НЭПКО


2001 он,
Орчуулсан: Баабар, Д. Амарсанаа



Зохиогч:
Фредерик
Бастиа

Нүүрний тоо:
106


2001 он,
Орчуулсан: Н. Баярбаатар



Зохиогч:
Мильтон
Фридман

Нүүрний тоо:
265


2003 он,
Орчуулсан: Баабар, Д. Амарсанаа



Зохиогч:
Людвиг фон
Мизэс

Нүүрний тоо:
210


2004 он,
Орчуулсан: П. Чойжил



Зохиогч:
Эрнандо дэ
Сато

Нүүрний тоо:
250

2004 он,
Орчуулсан: Д. Энхзаяа



Зохиогч:
Ф.А. Хаек

Нүүрний тоо:
193

2004 он,
Орчуулсан: Н. Баярбаатар

УНШИГЧДАДАА САНАЛ БОЛГОЖ БУЙ БҮТЭЭЛҮҮД:



Зохиогч:
Д. Боаз

Нүүрний тоо:
392


2005 он,
Орчуулсан: Б. Батчулуун



Зохиогч:
Эйн Рэнд

Нүүрний тоо:
40

2005 он,
Орчуулсан: Д. Энхзаяа



Зохиогч:
Дэвид
Бергланд

Нүүрний тоо:
230

2006 он,
Орчуулсан: Б. Батчулуун



Зохиогч:
Айн Рэнд

Нүүрний тоо:
383

2005 он,
Орчуулсан: Ж. Нэргүй



Зохиогч:
Кэн Скуланд

Нүүрний тоо:
314

2007 он,
Орчуулсан: Б. Батчулуун



Зохиогч:
Б. Батчулуун

Нүүрний тоо:
40

2006 он,

УНШИГЧДАДАА САНАЛ БОЛГОЖ БҮЙ БҮТЭЭЛҮҮД:



Зохиогч:
Ч.
Баянжаргал

Нүүрний тоо:
132


2006 он



Зохиогч:
Ж. Нормберг

Нүүрний тоо:
296

2008 он,
Орчуулсан: Б. Батчулуун



Зохиогч:
Фредерик
Бастиа

Нүүрний тоо:
194


2014 он,
Орчуулсан: Ж. Нэргүй



Зохиогч:
Хэнри
Хаазлит

Нүүрний тоо:
178


2014 он,
Орчуулсан: Б. Батчулуун, Б. Батбуян



Зохиогч:
Милтон
Фридман

Нүүрний тоо:
207

2014 он,
Орчуулсан: Т. Ариунсанаа




Зохиогч:
Хантер Лэвис

Нүүрний тоо:
266

2015 он,
Орчуулсан: Б. Оюунчимэг


УНШИГЧДАДАА САНАЛ БОЛГОЖ БУЙ БҮТЭЭЛҮҮД:



Зохиогч:
Стив Форвэс,
Элизабет
Эймс

Нүүрний тоо:
417

2016 он,
Орчуулсан: Т. Баттулга



Зохиогч:
Людвиг фон
Мизэс

Нүүрний тоо:
109

2016 он,
Орчуулсан: Б. Оюунчимэг



Зохиогч:
Ярон Брүүк,
Дон Ваткинс

Нүүрний тоо:
265

2017 он,
Орчуулсан: Т. Ариунсанаа



Зохиогч:
Людвиг фон
Мизэс

Нүүрний тоо:
167

2018 он,
Орчуулсан: Н. Хасар



Зохиогч:
Айн Рэнд

Нүүрний тоо:
330

2018 он,
Орчуулсан: Т. Ариунсанаа



Зохиогч:
Айн Рэнд

Нүүрний тоо:
181

2019 он,
Орчуулсан: Т. Ариунсанаа

УНШИГЧДАДАА САНАЛ БОЛГОЖ БҮЙ БҮТЭЭЛҮҮД:

ВАЦЛАВ
КЛАУС

КОМПАНИЙН
НҮГДЭН УНШАСНЫ
30 ХАТГАЛЫН
ОДОН ДЭРЖИЛЭВ

СУПЕРМАРКЕТААС Ч
**ИЛҮҮГ
ХҮССЭН
ЮМСАН**

НИРКО

Зохиогч:
Вацлав Клаус

Нүүрний тоо:
76

2019 он,
Орчуулсан: Ж. Сайханзаяа



Зохиогч:
Иэн Плаймер

Нүүрний тоо:
250


2020 он,
Орчуулсан: Н. Хасар



Зохиогч:
Витезслав
Кремлик

Нүүрний тоо:
340

2022 он,
Орчуулсан: Г. Ганбаяр



Зохиогч:
Доналд Ж.
Бүүдрөү

Нүүрний тоо:
96

2022 он,
Орчуулсан: Н. Жаргал



Зохиогч:
Людвиг фон
Мизэс

Нүүрний тоо:
50

2022 он,
Орчуулсан: Н. Жаргал



Эмхэтгэсэн:
Беттина Биен
Грийвс

Нүүрний тоо:
121

2022 он,
Орчуулсан: Н. Жаргал

УНШИГЧДАДАА САНАЛ БОЛГОЖ БУЙ БҮТЭЭЛҮҮД:



Зохиогч:
Фредерик
Бастиа

Нүүрний тоо:
96

2023 он,
Орчуулсан: Н. Жаргал

